

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ "ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ" ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ /2016-2019/

2019.11.22

Булган аймаг

Д/д	Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	Арга хэмжээний дэс дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ эх үүсвэр/		Хэрэгжилтийн хувь
							Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин үр дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	
1.1. Боловсрол:									
Иргэдийн сурч боловсрох, хөгжих эрхээ эдлэхэд нь дэмжлэг үзүүлж, суралцах, хөгжих таатай орчныг бүрдүүлэн багшийн мэргэжлийн үнэлэмж, ур чадварыг дээшлүүлж, оюунлаг, бүтээлч иргэдийг төлөвшүүлнэ.									
		1	1.1.1.1. Сургууль, цэцэрлэгийн багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх, ажлын үр дүнг дэмжих, сурагчдын сурах идэвхийг өрнүүлэх зорилгоор "Амжилтын галт тэрэг" хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх	2016-2020	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	Багш нарын идэвх, санаачилга, хариуцлага сайжирч, ажлын үр дүн бодитоор нэмэгдсэн байна.	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 135 дугаар тогтоолоор "Амжилтын галт тэрэг" дэд хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр боловсруулан бүх сургууль, цэцэрлэгт хүргүүлэн, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллалаа. Тус хөтөлбөрийн хүрээнд "Элсэлтийн ерөнхий шалгалт болон улсын төрөлжсөн олимпиадад амжилт гаргасан багш сурагчдыг урамшуулах" журам, "Хичээлийн судлагдахуун бүрээр сургалтын чанарыг дээшлүүлэе" жилийн аян, "Бүтээлч багш" шалгаруулах уралдааны болзол, "Багш нарыг сонгон шалгаруулах" журмыг тус тус шинээр боловсруулан батлуулж, хэрэгжүүлж байна. Улсын олимпиадад амжилт гаргасан 1 багш, 2 сурагч, элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан 3 сурагчид журмын дагуу шагнал олголоо. Сургууль, цэцэрлэгийн багш нарын ур чадварыг нэмэгдүүлэх, ажлын үр дүнг дэмжих зорилгоор 100 гаруй удаагийн чадваржуулах сургалт, зөвлөгөөн, харилцан арга туршлага солилцох, судлах зэрэг ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 16425 багш, ажилтныг хамруулсан. Боловсролын чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, зөвлөгөө мэдээллийг цаасаар болон цахимаар 15306 иргэнд хүргэсэн. Эдгээр ажлын үр дүнд 2019 оны элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр улсын хэмжээнд 8 дугаар байранд орж, өнгөрсөн жилээс 12 байр урагшилсан. Тус дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр орон нутгийн төсвөөс 2018 онд 21.0, 2019 онд 25.0, нийт 46.0 сая төгрөгийн санхүүжилт олголоо.	100	
		2	1.1.1.2. Ур чадвар, ажлын амжилтаараа тэргүүлж байгаа багш, удирдах ажилтныг гадаад, дотоодын урт, дунд, богино хугацаанд мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулах, Боловсролын салбарын удирдах ажилтныг бэлтгэх	2016-2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	Мэргэжил дээшлүүлсэн багш, удирдах ажилтны тоо өссөн байна. Боловсролын салбарын удирдах ажилтны залгамж халаа бэлтгэгдсэн байна.	Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер, багш нарын бүрэлдэхүүнтэй 10 хүнийг Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөх хот, Ордос, Бугат хотод, Булган сумын 2-р цэцэрлэгийн эрхлэгчийг Япон улсад, 4-р цэцэрлэгийн арга зүйчийг Солонгос улсад туршлага судлах сургалтад хамрууллаа. 2017 онд 43 төрлийн сургалтад 2388, 2018 онд 37 төрлийн сургалтад 3184, 2019 онд 32 удаагийн сургалтад 3420 багш, ажилтныг оролцуулж, нийт 112 удаагийн сургалтад 8992 багш, удирдах ажилтанг хамруулсан байна. Боловсрол, соёл, урлагийн газраас жилд дунджаар 535 цагийн хичээлд сууж, 1315 багш, удирдлагуудад зөвлөгөө өгсөн ба нийт 3 жилийн хугацаанд 1500 гаруй цагийн хичээлд сууж, 4500 хүнд зөвлөн тусалжээ. Боловсролын салбарын удирдах ажилтан бэлтгэх судалгааг гарган, мэргэжил дээшлүүлэх сургалтад шат дараатайгаар хамруулж, эхний модуль болох Удирдлагын академид 21 хүн, Монголын хүний нөөцийн хөгжлийн ассоциацийн сургалтад Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн, сургуулийн захирал, сургалтын менежер нийт 75 хүнийг хамрууллаа. Сүүлийн 3 жилд боловсролын салбарын багш, удирдах ажилтнууд жилд дунджаар 3-4 удаагийн сургалт, уулзалт, зөвлөгөөнд хамрагджээ. 2019 онд мэргэжил дээшлүүлсэн багш, удирдах ажилтны тоо 2016 оны дүнтэй харьцуулахад 1032-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	100	

1	1.1.1. Боловсролын салбарын удирдах ажилтан, багш сурган хүмүүжүүлэгчдийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, заах аргыг сайжруулах замаар боловсролын салбарын хүний нөөцийг бэхжүүлнэ.	3	1.1.1.3. Анги удирдсан болон ахмад, залуу багш нарын зөвлөгөөнийг зохион байгуулах, "Ахмад багш нарын зөвлөх үйлчилгээ"-г ХХҮГ-тай хамтран зохион байгуулах	2016-2020	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг		"Ахмад багш нарын зөвлөх үйлчилгээ"-г Ахмадын зөвлөх үйлчилгээ хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлж, сум бүр "Ахмад багш нарын зөвлөх үйлчилгээ"-ний багтай болсон байна.	2016 онд Залуу багш нарын зөвлөгөөнийг Япон улсын Жайка төсөлтэй хамтран зохион байгуулж, "Залуу багш нарт зориулсан гарын урлага"-ыг 200 хувь хэвлэн түгээсэн. Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтнүүд арга зүйн зөвлөлдөө 1-2 ахмад багшийг оруулж, хамтран ажиллаж байна. 2018 онд анги удирдсан багш нарын зөвлөгөөнийг Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр суманд бүсчлэн зохион байгуулж, 480 багшийг хамруулсан. Энэ үеэр анги удирдсан багшийн арга зүй, багшийн үйл ажиллагаанд хэрэглэгддэг хууль, тогтоомжийн заалтууд, тэдэнд зориулсан зөвлөмжийг эмхэтгэл болгон 500 хувь хэвлэн түгээлээ. 2019 онд Монгол улсын ардын болон гавьяат багш нарын дурсамж уулзалтыг зохион байгуулж, Булган сумын болон зарим сумдын залуу багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх, арга туршлагаас нь хуваалцах "Арга билэг" номыг эрхлэн гаргаж, 500 ширхэгийг хэвлэн түгээсэн. Жил бүр цэцэрлэг, сургуулиуд "Ахмад багш нарын зөвлөх үйлчилгээ", "Ахмадаасаа суралцъя", "Өвлөн суралцаж зөвлөн туслая" зэрэг аяныг зохион байгуулж 1-3 ахмад багш нарын арга туршлага, ур чадварыг түгээн дэлгэрүүлж байна. "Ахмад багш нарын зөвлөх үйлчилгээ"-г Булган сумын 1, 2, 3 дугаар сургууль, Баяннуур, Бугат, Бүрэгхангай, Дашинчилэн, Орхон, Сайхан, Сэлэнгэ, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгоны сургууль авч ажилласан байна.	100
		4	1.1.1.4. СӨБ, ЕБС-иудыг мэргэжлийн багшаар бүрэн хангах, мэргэжлийн ур чадвар сайтай багш нарыг татан ажиллуулах ажлыг зохион байгуулах, хөрш орнуудад сургаж бэлтгэх	2016-2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг		Боловсролын байгууллага мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан байна.	Булган сумын ерөнхий боловсролын 3-р сургууль шинээр ашиглалтад орсонтой холбогдуулан мэргэжлийн ур чадвар сайтай багш нарыг нээлттэй сонгон шалгаруулж авсан. Булган сумын 7-р цэцэрлэгт Хутаг-Өндөр сумын багш Гэрэлчимэг, Булган сумын 2-р цэцэрлэгт Хялганат тосгоны багш Чанцалдуламыг ажиллуулж, тэдний арга, туршлагыг түгээн дэлгэрүүлж байна. Оросын Холбооны Улс, Өвөр Монголын Өөртөө Засах Оронд туршлага судлуулахын зэрэгцээ сургуулийн өмнөх боловсролд 4 аймгийн багш солилцоог явуулж, "Хамтдаа хөгжье" үйл ажиллагааг зохион байгууллаа. Оросын Холбооны Улсын Буриад Улсын багшийн коллежид дуу хөгжмийн багш мэргэжлээр 4 дэх жилдээ оюутан сургаж, тус сургуулийг төгссөн 6 хүнийг сургууль, соёлын төвүүдэд ажиллуулж байна. Булган сумын "Эрдмийн өргөө" цогцолбор сургуулийн Орос хэлний багшийг Эрхүү хотод мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрууллаа. Булган сумын 1, 2 дугаар сургуульд химийн, Орхон суманд байгалийн ухааны, Бугат суманд дизайн технологийн зэрэг аймгийн хэмжээнд нийт 11 мэргэжлийн багш дутагдалтай байна. Монгол Улсын Багшийн Их Сургуулийн сургалтын албатай хамтран Булган аймгийн харьяат төгсөгчдийн судалгааг гарган, оюутнуудтай уулзалт зохион байгуулсны дүнд Булган сумын 1 дүгээр сургуульд 1 багш ажиллах болсон. Мөн сурлагын голч 3 буюу түүнээс дээш оноотой оюутнуудыг урилгаар ажиллуулах тухай албан бичгийг хүргүүлсэн. Гурванбулаг, Орхон, Сайхан, Хишиг-Өндөр сум, Хялганат тосгоны сургуульд дутагдалтай байсан хими, биологийн мэргэжлийн багш нартай болсон. Гурванбулаг, Сайхан, Сэлэнгэ сум болон Булган сумын Эрдмийн өргөө цогцолбор сургууль дутагдалтай байсан мэргэжлийн багш нараар хангагдсан. Мэргэжлийн багшийн хангалт 94.7 хувьтай болж 2016 оноос 2.7 хувиар өслөө.	100
		5	1.1.1.5. Сургууль, багш, БСУГ харилцан зөвшилцсөний үндсэн дээр сургуулийн удирдлага, багш нарыг солилцох, сэлгэн ажиллуулах, хөрш болон бусад орнуудын сургуулиудтай багш солилцох ажлыг зохион байгуулах	2016-2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг		Шинэ арга барил, менежментээр шинэчлэн удирдах нөхцөл бүрдүүлнэ.	Бугат, Сэлэнгэ, Хангал сум, Хялганат тосгон, Спортын дунд сургуулийн захирлууд болон Булган сумын бүх цэцэрлэгийн эрхлэгч нарыг сэлгэн ажиллуулж байна. 2018 онд "Хамтдаа хөгжье" арга хэмжээний хүрээнд Орхон, Дархан-Уул аймагт 65 багшийг багш солилцоонд хамруулсан. Булган сумын сургуулиудын дүрслэх урлаг, дизайн технологийн багш нарыг урд бүсийн сургуулиудад туршлага судлуулж, хамтарсан болон үзүүлэх хичээл заалгаж, туршлага солилцууллаа. Байгалийн ухааны чиглэлээр Орхон аймгийн Боловсрол, соёл урлагийн газартай хамтран химийн 2, биологийн 2 багшийг багш солилцоонд хамруулсан. Хялганат тосгоны сургууль Улаанбаатар хотын 20 дугаар сургуультай харилцан туршлага судалсан. Мөн цэцэрлэгийн 10 эрхлэгчийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Манжуур хотод туршлага судлах аялалд хамруулсан. Байгалийн ухаан, түүх нийгэм, газарзүйн нийт 5 судлагдахууны мэргэжил, ур чадвараараа тэргүүний багш нарыг Дорнод, Хэнтий аймгаас туршлага судлуулж, цаашид хамтран ажиллахаар болсон. Эдгээр ажлын үр дүнд тухайн байгууллагын ажилд тодорхой ахиц гарч байгаагийн нэг илрэл нь элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээгээр улсад 8 байрт орсон явдал болно.	100

2	1.1.2. Бүх шатны боловсролын сургалтын чанар, үр дүн, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	6	1.1.2.1. Сурагчдын сурлагын чанар, үр дүн, сэтгэн бодох чадвар, оюуны спортыг дэмжих зорилгоор “Оюунлаг Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2016-2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	Дунд, ахлах ангийн сурагчдын сургалтын чанар нэмэгдсэн байна.	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 34 дүгээр тогтоолоор “Оюунлаг Булган” дэд хөтөлбөрийг Шатар, Ном, Мэтгэлцээн, Ой тогтоолт гэсэн үндсэн дэд хэсгүүдтэйгээр батлуулан бүх сургууль, цэцэрлэгүүдэд хүргүүлэн, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна. Бүх сургуульд мэтгэлцээн, ой тогтоолт, шатрын клубууд байгуулагдан үйл ажиллагаа нь тогтмолжлоо. “Ой тогтоолт”-ын сургагч багш нарыг чадавхжуулах 3 удаагийн сургалтыг зохион байгуулж, 100 гаруй багшийг хамруулсан. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд 19 сургуулийн 500 багш, 7, 8, 11, 12 дугаар ангийн 4120 сурагч, 22 цэцэрлэгийн 150 багш, 2500 эцэг эх, нийтдээ 7270 хүн хамрагдаж, амжилттай хэрэгжиж байна. “Мэтгэлцээн” хөтөлбөрт 20 сургуулийн 292 сурагч, шатрын сургалтад 1489 хүүхэд хамрагдаж, жил дунджаар 469 хүүхэд шинээр шатар тоглож сурч байна. Сургууль бүрт номын фонд баяжилтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, ном унших арга зүй, аргачлалаар зөвлөмж гарын авлага бэлтгэн сургалт, сурталчилгаа хийх, уншсан номынхоо талаар харилцан ярилцах, номын хямдралтай худалдаа, ном сонирхогч залуусын дунд номын клуб байгуулж “Номоор нөхөрлөө” зэрэг ажлыг тогтмол зохион байгуулж байна. “Оюунлаг Булган” хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ирлээ. Аймгийн хэмжээнд “Ой тогтоолтын аварга-2018” тэмцээнийг анх удаагаа зохион байгуулж, 17 сургуулийн 150 гаруй сурагч ахлах, дунд анги гэсэн 2 ангиллаар оролцон, 60 багц медалийн төлөө өрсөлдсөн. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын үр дүнд улсын төрөлжсөн олимпиад, анги нийтийн масс олимпиад болон элсэлтийн ерөнхий шалгалтаар 800 оноо авсан хүүхдийн тоо өсөж, сургалтын чанарт ахиц гарч байна. “Оюунлаг Булган” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр орон нутгийн төсвөөс 2017 онд 32.0, 2018 онд 21.0, 2019 онд 25.0, нийт 78.0 сая төгрөгийн санхүүжилт олголоо.	100
		7	1.1.2.2. Сургууль, цэцэрлэг бүрт хүүхдийн хөгжлийн танхим ажиллуулах, хүүхэд багачуудын авьяас чадвар, бие бялдар, урлаг гоо зүйн мэдрэмж, техник сэтгэлгээг нээн хөгжүүлэх хичээлээс гадуурх сургалт, дугуйлан, секцийн үйл ажиллагааг чанартай зохион байгуулах	2016-2020	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн 80-аас доошгүй хувь нь дугуйлан, секцийн үйл ажиллагаанд хамрагдсан байна.	Сурагчдын хэрэгцээ сонирхолд тулгуурлан цаасан урлал, шатар, мэтгэлцээн, хайчилбар, уран зураг, англи хэл, сэтгэх чадвар, гандбол, сагсан бөмбөг, уран өд, бийрэн бичиг зэрэг 300 дугуйлан 20 сургуульд хичээллэж, давхардсан тоогоор 6350 сурагч хамрагдаж байгаа нь нийт сурагчийн 56.3 хувийг эзэлж байна. Цэцэрлэгүүдэд 4-11 төрлийн дугуйлан хичээллэж, 2750 хүүхэд буюу нийт хүүхдийн 63.7 хувь нь хамрагдаж байна. 2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын асуудлыг иргэний оролцоогоор шийдвэрлэх “Иргэн төсөл” аргачлалыг Булган сумын 1-р сургууль, 3-р сургууль, Спортын сургууль, “Эрдмийн өргөө цогцолбор” сургууль, Бугат, Бүрэгхангай, Орхон, Сайхан, Тэшиг, Хангал, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгоны сургууль дээр хэрэгжүүлсэн. Үндэсний шалгаруулалтад оролцсон Хангал сумын ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчид тэргүүн байрыг эзэлж, Ерөнхийлөгчийн Тамгын газраас 1.0 сая төгрөгийн шагнал хүртсэн.	70
		8	1.1.2.3. Улсын “Математикийн олимпиад”-ыг зохион байгуулах	2017	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	Олимпиадын бэлтгэл ажлыг хангаж, чанартай зохион байгуулах, Математик сургалтын чанар нэмэгдэж, мэргэжлийн багш нарын заах арга, ур чадвар сайжирсан байна.	2017 онд “Монголын Математикийн 53 дугаар олимпиад”-ыг Булган аймгийн Бугат сумын уугуул Монгол улсын гавьяат багш Д.Шагдарын нэрэмжит болгон амжилттай зохион байгуулж, тус олимпиадад 21 аймаг, 9 дүүргийн 42 баг, 162 сурагч, 66 багш, нийт 228 оролцогч оролцож, Булган аймаг багийн дүнгээр 12-р байранд шалгарсан.	100

9	1.1.2.4. Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд иргэд, олон нийт, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэг, сургалтын төв байгуулах үүсгэл санаачилгыг дэмжих	2016-2020	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	Иргэд, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагын оролцоо дээшилсэн хамтын ажиллагааны түвшин ахисан байна.	Монгол улсын гавьяат багш Ц.Гомбожав, Ш.Энхтуяа нарын нэрэмжит 3-р ангийн унших, 5-р ангийн математик, Булган аймгийн төр нийгмийн зүтгэлтэн, Монгол хэлний багш Ц.Бадралын нэрэмжит 8-р ангийн Монгол хэл, Булган сумын Засаг дарга Д.Наранбаярын нэрэмжит 9-р ангийн Монгол хэлний анги нийтийн олимпиад, Ардын боловсролын тэргүүний ажилтан Ё.Дарьсүрэнгийн нэрэмжит Хими, Н.Дашдэлгэр, Бадамсэд багш нарын нэрэмжит Математикийн олимпиадыг тэдний үр хүүхэд, шавь нартай хамтран тогтмол зохион байгуулж, сурагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд хувь хүний болон анги хамт олны оролцоог нэмэгдүүлж байна. Мөн "Булган нэг үе клуб" төрийн бус байгууллага, Булган аймгийн "Илтгэгч мэтгэлцэгчид"-ийн холбоотой хамтран математик, байгалийн ухааны багш нарт сургалт зохион байгуулж, мэтгэлцээний сургагч багш нарыг бэлтгэлээ. "Нээлттэй тархи" төрийн бус байгууллагатай хамтран "Оюунлаг Булган" дэд хөтөлбөрийн "Ой тогтоолт" дэд хэсгийг, "Илтгэгч, мэтгэлцэгчдийн холбоо"-той хамтран "Мэтгэлцээн" дэд хэсгийг, "Шатрын холбоо"-той хамтран "Шатар" дэд хэсгийг, Номын дэлгүүрүүдтэй хамтран "Ном" дэд хэсгийг тус тус хэрэгжүүлж байна. Мөн Ахмад багш Цэрэнцогзолмаа багшийн нэрэмжит шатрын тэмцээнийг цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулж хэвшлээ. Мөн сургууль, цэцэрлэгүүд эцэг эх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагатай сургалтын орчныг сайжруулах, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх талаар идэвхтэй хамтран ажиллаж байна. Ингэснээр сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эх, иргэдийн оролцоо нэмэгдсэн.	100
10	1.1.2.5. Аймгийн тэргүүлэх чиглэлийн судлагдахууныг тодорхойлж, орон нутгийн онцлогийг тусгасан чиглэлийг хэрэгжүүлэх	2016-2020	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	Математик, Гадаад хэл, Монгол хэл, Байгалийн ухааны хичээл тус бүрээр чиглэл боловсруулж хэрэгжүүлсэн байна.	Математик, байгалийн ухаан, гадаад хэлийг тэргүүлэх чиглэл болгон жил бүр тухайн судлагдахууны сургалтын чанарыг сайжруулах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж байна. 2017 онд Математикийн улсын 53 дугаар олимпиадыг угтан сургууль бүрээс 5-6 сурагчийг сонгон Хануйн "Багш" амралтад сургалтад хамруулснаас гадна математикийн багш нарыг сар бүр сургалтад хамруулсан. 2019 оныг Монгол хэлний сургалтыг дээшлүүлэхэд анхаарч багш, сурагчдад зориулсан олон арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн. 2019 оны элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгээр монгол хэл, математикийн хичээлийн хэмжээст оноо өсөж, 6-8 байраар урагшилсан байна. 2020 оныг Байгалийн ухаан, Гадаад хэлний сургалтын чанарыг дээшлүүлэх зорилт тавин багш нарыг хөгжүүлэхээр төлөвлөж байна.	70
11	1.1.2.6. Орон нутгийн онцлогийг тусгасан сурах бичиг бэлтгэх, сургалтанд нэвтрүүлэх	2016-2020	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	Сурах бичиг хэвлэгдэж, сургалтанд нэвтэрсэн байна.	Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн 3, 4, 5 дугаар ангийн сурагчдад зориулсан "Анхдагч Булган" орон нутгийн сурах бичгийг зохион сургалтад нэвтрүүллээ. Тус сурах бичгийг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагт судалж байна.	100
12	1.1.3.1. Сургууль, цэцэрлэгт хамрагдаагүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, бүх шатны боловсролд хамруулах талаар дэмжлэг үзүүлэх	2016-2020	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	Судалгаанд байгаа Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд бүрэн хамруулсан байна.	Сумдын эрүүл мэндийн төвөөс авсан хөгжлийн бэрхшээлтэй хүний судалгаанд нийт цэцэрлэг, сургуулийн насны 249 хүүхэд бүртгэлтэй байна. 2017 онд ерөнхий боловсролын сургуульд өдрөөр 133, дүйцсэн хөтөлбөрөөр 23, 2018 онд өдрөөр 102, дүйцсэн хөтөлбөрт 28, 2019 онд өдрөөр 90, дүйцсэн хөтөлбөрөөр 23 хүүхэд тус тус суралцаж, бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшиж байна. Сургуулийн өмнөх боловсролд 2017 онд 24, 2018 онд 15, 2019 онд 11 хүүхэд хамрагдлаа.	70

3	1.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийг бүх шатны боловсролд хамруулах, насан туршийн боловсролын бүтэц, үйл ажиллагааг шинэчилж, иргэдийн хэрэгцээнд нийцсэн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулна.	13	1.1.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарыг бэлтгэх	2016-2020	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	Сум тус бүрээс Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарыг бэлтгэнэ.	2017 онд цэцэрлэгийн 22 багшийг "Тусгай хэрэгцээт боловсрол олгох чиглэл"-ээр сургасан. 2018-2019 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын таатай орчинг бүрдүүлэх, тэгш хамруулах, сургах, ажиллах хүний нөөцийг бэлтгэх тухай зөвлөмжийг сургууль, цэцэрлэгийн удирдлагуудад хүргүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчидтай ажиллаж буй арга туршлагаараа Хишиг-Өндөр сумын багш Б.Одонтунгага, захирал Ж.Бямбасүрэн нар "Хүүхдийн хөгжил хичээлийн судалгаа" үндэсний эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж хэлэлцүүлэн "Батламж" авсан. 2019 онд Жайка олон улсын байгууллагаас зохион байгуулсан "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн сургалтад 3 хүн, Нэгдсэн үндэсний байгууллагын "Хүүхдийн сан"-тай хамтран зохион байгуулсан бүсийн сургалтад 1 багш, Тэгш хамруулан сургах боловсролын арга зүйн 3 өдрийн сургалтад сумын Насан туршийн боловсролын төвийн 15 багш тус тус хамрагдсан. Сум тус бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багш нарыг бэлтгэхээр шат дараалан сургалтад хамруулж байгаа ба 8 суманд багш бэлтгээд байна.	70
		14	1.1.3.3. Насан туршийн боловсролын төвийг байгуулж, үйл ажиллагааг өргөтгөх, иргэдийн хэрэгцээнд нийцсэн сургалт зохион байгуулах	2016-2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль	Насан туршийн боловсролын төвийг байгуулж, сум бүр салбар төвтэй болсон байна.	Насан туршийн боловсролын төвийг 2017 онд 3 хүний орон тоотойгоор, шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган Боловсрол, соёл, урлагийн газрын дэргэд байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн. 2018 онд 93 төрлийн сургалтад давхардсан тоогоор 2056 иргэн, 2019 онд сургалтын 5 чиглэлээр 381 төрлийн сургалтад 2782 иргэнийг тус тус хамруулан сургалаа. Мөн бичиг үсгийн боловсролын сургалтыг Орхон аймгийн Мааньт багийн нутагт үйл ажиллагаа явуулдаг хорих ангийн 20 хүмүүжигч хоригдолд анхан шатны сургалт явууллаа. Насан туршийн боловсролын төвийн багш нар "Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр", "Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Сум бүрт Насан туршийн боловсрол олгох нэгж ажиллаж байна.	100
	15	1.1.4.1. Хүүхдийн бие бялдар, оюун ухааныг хөгжүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай, төхөөрөмжөөр сургууль, цэцэрлэгүүдийг үе шаттайгаар хангах	2016-2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	Сургууль, цэцэрлэгийн 70.0-аас доошгүй хувь нь сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	Сургууль, цэцэрлэгийн хүүхдийг хөгжүүлэх сургалтын хэрэглэгдэхүүн тоглоом наадгай, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх ажлыг шат дараатайгаар зохион байгуулж, 2017 онд боловсрол, соёлын байгууллагуудын төсөвт 964.4 сая төгрөгийн зохицуулалт хийж, сургууль, цэцэрлэгүүд сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай, тоног төхөөрөмж авч, салбарын байгууллагуудын тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн. "Оюунлаг Булган" дэд хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын 19 сургуульд хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх гарын авлага, дүрстэй самбар, түргэн ерөлтийн аяга, мэдээллийн самбар, ном зэргийг нийлүүлж, сургалтад ашиглаж байна. Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрт 17 сургууль хамрагдаж, 87.4 сая, "STEM" хөтөлбөрт 21 сургууль хамрагдаж, 106.7 сая төгрөгийн 432 багц хэрэглэгдэхүүн авсан. Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 208.1 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. 2019 онд Дэлхийн банк, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас хэрэгжүүлж буй "Боловсролын чанарын шинэчлэл" төслийн хүрээнд 8 сургуульд 103.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Мөн бүх сургуулиудад байгалийн ухааны кабинет, бүх цэцэрлэгүүдэд үндсэн багшийн тоогоор сургалтын компьютероор хангах ажлыг зохион байгууллаа. Үүний үр дүнд сургууль, цэцэрлэгийн 85 хувийг сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай, тоног төхөөрөмжөөр хангалаа.	100	

4	1.1.4. Сургууль, цэцэрлэгийн сургалтын орчныг тохижуулах, хүүхдэд ээлтэй сурах орчин бүрдүүлж, "Цахим сургууль-Цахим сургалт" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	16	1.1.4.2. Сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, Ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байрыг халуун устай болгож амьдрах орчин нөхцөлийг сайжруулах	2016-2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль	Сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг ээлж дараагаар шийдвэрлэсэн байна.	Орон нутгийн төсвөөс 28.0 сая төгрөг, "Өвсний үндэс" хөтөлбөрөөс 161.1 сая төгрөгийг гарган Тэшиг сумын сургуулийн дотуур байрны их засвар, ариун цэврийн байгууламжийг сайжрууллаа. Хутаг-Өндөр сумын сургуулийн дотуур байранд 140.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж боловсон ОО, халуун усны асуудлыг шийдэж сурагчдын амьдрах таатай орчныг бүрдүүлсэн. Хишиг-Өндөр сумын сургууль дотуур байрандаа өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан халуун устай болсноос гадна Булган сумын "Эрдмийн өргөө" цогцолбор сургуулийн ариун цэврийн байгууламжийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэлээ. Сэлэнгэ, Рашаант, Хишиг-Өндөр сумын сургуулийн ариун цэврийн байгууламжийг сайжруулахаар аймгийн төсөв, Дэлхийн зөн, Мобиком корпорацитай хамтран хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, Сайхан сумын цэцэрлэгт 15.0 сая төгрөгийг олгож, цэвэр, бохир усны системтэй болгосон. 2019 онд орон нутгийн төсвийн 300.0 сая төгрөгөөр Дашинчилэн, Гурванбулаг, Хишиг-Өндөр, Булган сумын 3 дугаар цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийг шинээр ашиглалтад оруулж, хүртээмжийг нэмэгдүүлээ.	100
		17	1.1.4.3. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, хичээлийн хэрэглэгдэхүүн, багш сурагчдын бүтээл, шилдэг тэргүүний арга, туршлагыг багтаасан нэгдсэн цахим сан бий болгох	2016-2020	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	Сургууль тус бүр багш сурагчдын бүтээл, шилдэг тэргүүний арга, туршлагыг багтаасан нэгдсэн цахим сантай болсон байна.	"Тэргүүлэх" зэрэгтэй 130 багшийн шилдэг арга зүйн цахим санг бүрдүүлэх зорилгоор CD-д буулгасан. Бага боловсролын багш нарын тэргүүн туршлага бүхий 122 хичээлийг CD-д хуулж, "Булган аймгийн Боловсрол, соёл урлагийн газар" гэсэн нүүр хуудсанд байршуулсан. Анги удирдсан багш нарт холбогдох эрх зүйн акт, тэргүүн туршлага зэргийг эмхэтгэн гарын авлага боловсруулж, 500 хувийг хэвлэн тараасан. Боловсрол, соёл урлагийн газарт ахмад, залуу багш, сурагчдын бүтээл, шилдэг тэргүүний арга, туршлагыг багтаасан нэгдсэн цахим санг үүсгэн, ашиглаж байна. 2018 онд сургуулиудын мэдээлэл зүйн багш нарыг цахим сургалтын сургагч багшаар бэлтгэх сургалтыг "Боловсролын чанарын шинэчлэл төсөл"-өөс 16.0 сая төгрөгийн санхүүжилтээр хийсэн. "Булган аймгийн Боловсрол, соёл урлагийн газар" гэсэн нүүр болон мэргэжилтэн бүрийн судлагдахууны нүүр хуудсанд сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, мэдээ, мэдээллийг тогтмол байршуулан ажиллаж байна.	100
		18	1.1.4.4. Бүх сургууль, цэцэрлэгийг өндөр хурдны интернетэд холбох, сургуулийн дотуур байруудыг камержуулах, багш нарыг цахим сургалтын арга зүйд сургах	2016-2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	Сургууль, цэцэрлэгийг өндөр хурдны интернетэд бүрэн холбосон байна.	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 22 сургууль, 22 цэцэрлэгийг өндөр хурдны интернетэд холбож, цахим статистикийн үйл ажиллагаа жигдрээд байна. Мөн сургуулиудын дотуур байрыг бүрэн камержуулсан. Багш нарыг цахим сургалтын арга зүй олгох сургалтад хамрууллаа. 2018 онд сургуулиудын мэдээлэл зүйн багшийг цахим сургалтын сургагч багшаар бэлтгэх сургалтыг Боловсролын чанарын шинэчлэл төслийн 16.0 сая төгрөгийн санхүүжилтээр зохион байгууллаа.	100
		19	1.1.5.1. Боловсролын салбарын дуусаагүй барилгуудыг ашиглалтад оруулах	2016-2020	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	Дуусаагүй барилгууд ашиглалтад орсон байна.	2016 онд Гурванбулаг сумын сургуулийн өргөтгөлийн барилга, 2017 онд Булган сумын 150 хүүхдийн цэцэрлэг, 2018, 2019 онд 1280 суудалтай сургуулийн 2 шинэ барилгын ажлыг дуусгаж ашиглалтад хүлээн авлаа. Сайхан сумын сургуулийн 100 хүүхдийн хоолны заал, 50 ортой дотуур байрны өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулсан. Тэшиг сумын сургуулийн 240 хүүхдийн суудалтай хичээлийн байрны өргөтгөлийн барилга угсралтын ажлыг дуусгахаар 2020 оны улсын төсөвт 821.0 сая төгрөг тусгалаа.	70
		20	1.1.5.2. Бүрэгхангай, Гурванбулаг, Сэлэнгэ, Тэшиг сумдын болон Булган сумын 3-р цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих	2016-2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	Цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн зураг төсөв хийгдэж, барилга ашиглалтад орсон байна.	Бүрэгхангай сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилга улсын төсвөөс 572.7 сая төгрөгөөр батлагдаж, Улаанбаатар хотын "И ЭС МОН" ХХК шалгарч, ажлын гүйцэтгэл 95.0 хувьтай, Тэшиг сумын 120 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн ажилд 2019 оны орон нутгийн төсөвт 350.0 сая төгрөг тусгаж, "Бурхууд" ХХК шалгарч, ажлын гүйцэтгэл 40.0 хувьтай, Сэлэнгэ сумын 75 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн ажилд "Манхан уст" ХХК шалгарч, ажлын гүйцэтгэл 60 хувьтай байна. Булган сумын 3-р цэцэрлэг, Гурванбулаг сумын цэцэрлэгийн барилгын өргөтгөл барихаар 2020 оны улсын төсөвт 800.0 сая төгрөг тусгаж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	70

1.1.5. Боловсролын салбарын байгууллагуудын барилгын өргөтгөл барих, их засвар хийх, хатуу, зөөлөн эдлэлээр хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

21	1.1.5.3. Бугат сумын сургуулийн барилгыг шинээр барих	2016-2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг		Сургуулийн барилгын зураг төсөв хийгдэж, барилга ээлж дараалалтайгаар ашиглалтад орсон байна.	2018 оны улсын төсөвт 980.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тусгагдан, барилгын ажлыг Улаанбаатар хотын "Кенжикү" ХХК гүйцэтгэж байна. 2019 оны улсын төсөвт 1.1 тэрбум төгрөг, 2020 онд 303.5 сая төгрөг тусгагдсан. Нийт 2.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 180 хүүхдийн хичээлийн байр, спорт заал, 50 хүүхдийн дотуур байрны барилга барьж байгаа ба 2019 оны 11 дүгээр сард багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна.	100
22	1.1.5.4. Дашинчилэн, Рашаант сумдын сургуулийн дотуур байрыг шинээр барих, Хялганат тосгоны сургуулийн дотуур байранд өргөтгөл хийх	2016-2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль		Сургуулийн дотуур байрны барилгын зураг төсөв хийгдэж барилга ээлж дараалалтайгаар ашиглалтад орсон байна.	Дашинчилэн, Рашаант сум, Хялганат тосгоны сургуулийн дотуур байрны өргөтгөлийн зураг төсвийг боловсруулсан. 2019 оны улсын төсөвт Рашаант сумын сургуулийн 150 хүүхдийн ортой дотуур байр шинээр барих 2298.9 сая төгрөг батлагдан, "Их Азар" ХХК шалгарч, 2019 оны 8 дугаар сараас барилгын ажлыг эхлүүлж, 2020 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.	40
23	1.1.5.5. Сайхан, Сэлэнгэ, Баян-Агт, Гурванбулаг, Дашинчилэн, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Орхон сумын сургуулийн барилгад их засвар хийх	2016-2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль		Сургуулийн барилгын засварын ажлыг хийж, ашиглалтад орсон байна	Хутаг-Өндөр сумын 240 хүүхдийн суудалтай хичээлийн байр 2019 оны улсын төсөвт 1.5 тэрбум төгрөгөөр батлагдаж, Улаанбаатар хотын "Алтайн бумбат өргөө" ХХК шалгарч, 2019 оны 10 дугаар сараас ажлаа эхлүүлж, гүйцэтгэл 20 хувьтай байгаа ба 2020 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Орхон сумын сургуулийн спорт заалны барилга шинээр барихаар орон нутгийн төсөвт 2019 онд 250.0 сая төгрөгийн хөрөнгө тусгагдан, ажлын гүйцэтгэл 90 хувьтай байна. Хишиг-Өндөр сумын сургуульд 50.0 сая, Сайхан сумын сургуулийн спорт зааланд 15.0 сая төгрөгөөр тус тус засвар хийсэн. Сэлэнгэ сумын сургуульд улсын төсөв болон төсөл хөтөлбөр, 70 жилийн ойн хандив зэргээр хэсэгчлэн засвар хийсэн. Дашинчилэн сумын сургуулийн барилгын дээврийг 105.0 сая төгрөгөөр бүрэн шинэчилсэн. Баян-Агт, Гурванбулаг сумын хичээлийн байрны их засварын зураг төсвийг хийсэн, хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй байна.	70
24	1.1.5.6. Бугат, Рашаант сумдын болон Булган сумын 1-р багийн цэцэрлэгийн сүрлэн барилга, 4, 6-р цэцэрлэгийн барилгад их засвар хийх	2016-2020	НБХ, БСУГ, СЗДТГ, цэцэрлэг		Цэцэрлэгийн барилгын засварын ажлыг хийж, ашиглалтад орсон байна.	Рашаант сумын цэцэрлэгт 50 хүүхдийн өргөтгөлийн барилга барихаар Улаанбаатар хотын "Аслаан" ХХК-аар зураг төсвийг хийлгэсэн. Булган сумын 6-р цэцэрлэгт 2017 онд ТИКА байгууллагын хөрөнгөөр 84.6 сая төгрөгөөр, 2019 онд Баяннуур, Тэшиг сумын цэцэрлэгт улсын төсвийн 138.0 сая төгрөгөөр тус тус их засвар хийлээ. 2019 онд Рашаант сумын цэцэрлэгт 9.8 сая төгрөгөөр сантехникийн засвар хийсэн. Булган сумын 4 дүгээр цэцэрлэгийн барилгын их засварын зураг төсвийг хийлгэсэн боловч цэцэрлэгийн барилгыг дахин ашиглах боломжгүй гэсэн мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан тул 250 хүүхдийн шинэ барилгын зураг төсвийг хийлгэсэн, хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй байна.	70
25	1.1.5.7. Гурванбулаг, Сайхан, Бүрэгхангай сумдын сургуулийн дотуур байранд их засвар хийх	2016-2020	НБХ, БСУГ, СЗДТГ, Сургууль		Сургуулийн дотуур байранд их засвар хийж, ашиглалтад орсон байна.	2017 онд Сайхан сумын дотуур байрны гал тогооны барилгын их засвар, барилга угсралтын ажлыг орон нутгийн төсвийн 551.0 сая төгрөгөөр гүйцэтгэн хүлээлгэж өгсөн. 2018 онд Гурванбулаг сумын дотуур байранд орон нутгийн төсвийн 124.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар их засвар хийсэн. 2019 онд Бүрэгхангай сумын сургуулийн дотуур байрны өргөтгөлийн зураг төсвийг шинээр хийлгэж, 600.0 сая төгрөгийн өртөгтэй барилгын ажлыг "Эгшиглэнт прожект" ХХК хийж эхлээд байна. Барилгын ажилд аймгийн төсвөөс 200.0 сая, 400.0 сая төгрөгийг сумын нийгмийн хариуцлагын гэрээгээр гүйцэтгэхээр төлөвлөн ажиллаж байгаа ба ажлын явц 60 хувьтай байна.	100
26	1.1.5.8. Тэшиг сумын сургуульд спорт заал шинээр барих, Хангал, Баяннуур сумын сургуулийн спорт заалыг засварлах	2016-2020	БСУГ, СЗДТГ, Сургууль		Сургуулийн спорт заал ашиглалтад орсон байна.	Баяннуур, Хангал сумын сургуулийн спорт зааланд урсгал засвар хийхээр боловсролын салбарын төсөвт 30.0 сая төгрөгийн зохицуулалт хийж, ажлыг гүйцэтгэсэн. Баяннуур сумын сургуулийн их засварыг 2019 онд орон нутгийн төсвийн 156.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Булган барилга" ХХК гүйцэтгэж, хүлээлгэж өгсөн. Хишиг-Өндөр сумын болон Булган сумын Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн спорт зааланд 200.0 сая төгрөгөөр засвар хийснээс гадна Рашаант, Гурванбулаг сумын сургуулийн спорт заалны шалыг шинэчилж зориулалтын хурдаасаар бүрсэн. Тэшиг сумын сургуулийн спорт заалны зураг төсвийг хийлгэж байна.	70

	27	1.1.5.9. Сурагчдын дотуур байр, цэцэрлэгийн бүлгүүдийн хатуу, зөөлөн эдлэлийг ээлж дараалан шинэчлэх	2016-2020	БСУГ, СЗДТГ, Сургууль, цэцэрлэг	Хатуу зөөлөн эдлэлийн 80 хувийг шинэчилсэн байна.	Сургуулийн дотуур байр, цэцэрлэгүүдийн зөөлөн эдлэлийн нэг ээлжийг шинэчлэх ажлыг шат дараатайгаар хийж байна. 2018 онд аймгийн бүх цэцэрлэгүүдийн гал тогооны тоног төхөөрөмж, тоглоом, наадгай, 2018, 2019 онуудад аймгийн бүх сургуулийн дотуур байрны хатуу, зөөлөн эдлэлийг бүрэн шинэчилж, шалгуур үзүүлэлтээ хангасан.	100
1.2. Эрүүл мэнд:							
Эрүүл мэндийн салбарын удирдлага, менежментийг сайжруулан, нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг нотолгоонд суурилсан, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинэчилж, материаллаг бааз, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлэн, эрүүл амьдралын дадал хэвшлийг бий болгож, иргэдэд ээлтэй, эрүүл аюулгүй орчин бүрдүүлнэ.							
	28	1.2.1.1. “Эрүүл мэндийн боловсрол-Настны эрүүл мэнд хөтөлбөр”-ийг батлан, хэрэгжүүлэх	2016-2020	ЭМГ	Иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг тогтоох суурь судалгаатай болно. Иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг суурь түвшингээс жил бүр 5 хувиар нэмэгдүүлнэ.	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2017 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн хөтөч” дэд хөтөлбөрийн 5 зорилтын 68 арга хэмжээг хэрэгжүүлэх аймгийн нэгдсэн төлөвлөгөөг жил бүр шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шинэлэг хэлбэрээр сүүлийн 3 жилд 19 чиглэлээр 665 удаагийн сургалтыг зохион байгуулан давхардсан тоогоор 59417 иргэнийг хамруулсан. Сургалтын тоо 2016 оны түвшингээс 169, сургалт сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо 20.1 хувиар, иргэдийн эрүүл мэндийн боловсролын мэдлэгийн түвшин 15.1 хувиар өссөн байна. Эрүүл мэндийн мэдээлэл сурталчилгааны санамж, зурагт хуудас, сонины нийтлэл зэрэг давхардсан тоогоор 27 мянга гаруй гарын авлага материалаар хангаж, өнгөрсөн 3 жилд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ОНХС-аас 38.5 сая, улсын төсөв буюу Эрүүл мэндийг дэмжих сангаас 20.0 сая төгрөгийг зарцуулж, эрүүл мэндийн сургалт сурталчилгааг өргөжүүлэн ажилласнаар аймгийн хэмжээнд халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэг 15-20 хувиар нэмэгдэж аймгийн дэд хөтөлбөрийн зорилтот түвшинд хүрсэн.	100
	29	1.2.1.2. Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг нэмэгдүүлж, багийн Засаг дарга, багийн эмч нарын уялдаа холбоог сайжруулах	2016-2020	ЭМГ, ЭМБ-ууд	Эрт илрүүлэг үзлэгийн хамрагалтын түвшинг 2016 оныхоос 15 хувиар нэмэгдүүлнэ.	"Халдварт бус өвчнөөс сэргийлэх хянах үндэсний хөтөлбөр"-ийн зорилтуудыг орон нутгийн онцлогт тохируулан зохион байгуулж, аймгийн хэмжээнд эрт илрүүлгийн үзлэгт хамрагдвал зохих хүн амын 64.0 хувийг хамруулсан нь 2016 онтой харьцуулахад 16.0 хувиар өссөн байна. "Булган нэг үе клуб" ТББ-ын санаачилгаар "Хавдаргүй Булган" хөтөлбөрийг 2017 оноос эхлэн орон нутгийн Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, 2017 онд элэгний хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 25-аас дээш насны 11962, 2018 онд ходоодны хавдрыг эрт илрүүлгийн үзлэгт 25-аас дээш насны 8904 иргэд, 2019 онд хөх, умайн хүзүүний хавдрын илрүүлэг үзлэгт 20-с дээш насны 2500 гаруй эмэгтэйчүүдийг хамруулан, хөтөлбөрийн үйл ажиллагаанд ОНХС-гаас сүүлийн 3 жилийн хугацаанд 107.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Аймгийн Засаг дарга, сумын Засаг даргатай байгуулсан "Үр дүнгийн гэрээ" болон сумдын Засаг дарга, Эрүүл мэндийн байгууллагуудын дарга, Эрүүл мэндийн газрын дарга нарын "Хамтран ажиллах гурвалсан гэрээ"-нд халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийн хувийг нэмэгдүүлэх, зорилтот насны иргэдийг бүрэн хамруулах заалт тусган, хэрэгжилт үр дүнг тооцон ажиллаж байна. Эрт илрүүлгийн үзлэг аймгийн хэмжээнд сүүлийн 3 жилийн дунджаар 65.0 хувьд хүрсэн нь хөтөлбөрийн зорилтот түвшинг хангаад байна.	100

6	1.2.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тандан судалж, хяналтын тогтолцоог сайжруулан, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг шинэлэг хэлбэрээр зохион байгуулан, иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг дээшлүүлнэ.	30	1.2.1.3. “Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх үндэсний стратеги”-ийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлж, анхан шатны Эрүүл мэндийн байгууллагуудыг үзлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, урвалж бодисоор хангах	2016-2018	ЭМГ, ЭМБ-ууд	Эрт илрүүлэг үзлэгт жил бүр насанд хүрэгчдийн 20 хувийг хамруулна.	Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх орон нутгийн төлөвлөгөөг жил бүр шинэчлэн боловсруулж хэрэгжилтийг ханган ажилласнаар 2017 онд 40-65 насны, 2018-2019 онд 15-аас дээш насны иргэдийг В, С вирусын илрүүлэг шинжилгээнд хамруулсан. Хөтөлбөр хэрэгжсэнээс хойшхи хугацаанд илрүүлэг үзлэгт зорилтот бүлгийн 15-аас дээш насны 44013 иргэн хамрагдахаас С вирусын илрүүлэг үзлэгт 20382 буюу 46.2 хувь, В вирусын илрүүлэг үзлэгт 20382 иргэн буюу 46.2 хувь нь хамрагдсан. В, С вирусын илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдээс С вирус эерэг 1983, В вирус эерэг 1669 иргэн гарсан ба вирусын ачаалал тоолуулах шинжилгээнд 2789 иргэнийг хамруулж, эмчилгээнд хамрагдвал зохих 1016 иргэний 962 нь хамрагдаж, 625 иргэн эдгэрсэн. Аймгийн хэмжээнд 2016 онд элэгний хавдрын 44 тохиолдол шинээр бүртгэгдэж байсан бол 2017 онд 77, 2018 онд 41, 2019 оны эхний 9 сард 17 тохиолдол шинээр бүртгэгдэж, хорт хавдар өвчний эрт илрүүлгийн чанар сайжирсан. 2016 онд элэгний хорт хавдар нийт хавдрын 41.5 хувийг эзэлж байсан ба 2019 онд 35.4 хувийг эзэлж байгаа нь 2016 онтой харьцуулахад 6.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг илрүүлэг үзлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, урвалжаар бүрэн хангаж, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах 8 удаагийн сургалтад давхардсан тоогоор 340 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан. 2017-2018 онд Бугат, Тэшиг, 2019 оноос 14 сумын Эрүүл мэндийн байгууллагуудыг "Мобайл технологийн тоног төхөөрөмж"-өөр хангаж, сүүлийн 3 жилийн байдлаар алслагдсан багийн 5000 иргэдийг эрүүл мэндийн анхан шатны үзлэг, шинжилгээнд хамрууллаа.	70
		31	1.2.1.4. “Амны хөндийн эрүүл мэнд” аян зохион байгуулах	2016-2020	ЭМГ, ЭМБ-ууд	Амны хөндийн өвчлөлийг 2016 оны түвшингээс жил тутам 5 хувиар бууруулна.	Засгийн газрын 2018 оны 255 дугаар тогтоолоор “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийг 2019 оны 6 дугаар сараас аймгийн хэмжээнд зохион байгуулж, 2-12 насны 972 хүүхдийг үзлэгт хамруулж, 2239 шүдийг эмчлэн эрүүлжүүлсэн. 2017-2018 онд “Бадрал сан” ТББ-тай хамтран 16 суманд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шүд цооролтын эмчилгээг Бадрал сангийн 85.0 сая төгрөгийн санхүүжилтээр зохион байгуулж, 7252 иргэнийг нарийн мэргэжлийн эмчийн эмчилгээнд, 28200 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт, давхардсан тоогоор 12250 иргэнд шүд авах эмчилгээ хийсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт “Бадрал сан”-гийн 55.0 сая төгрөгийн санхүүжилтээр “Хүүхдийн шүдний кабинет”-ыг байгуулж, 15 ширхэг цогц багаж, тоног төхөөрөмж, их эмчээр ханган ажиллаж байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн шүдний кабинетаар 5934 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсны 2453 нь 0-16 насны хүүхэд эзэлж байна. Сургууль, цэцэрлэгийн багш болон эцэг, эхчүүдэд “Хүүхдийн шүдийг хэрхэн хамгаалах, яаж угаах” талаар сургалт зохион байгуулж, 5 нэр төрлийн 5600 гаруй гарын авлагаар хангасан. 2017 онд “Эрүүл шүд” аяныг зохион байгуулж эхлэх цаг хугацаанд амны хөндийн өвчлөл аймгийн хэмжээнд 91.6 хувьтай байсан бол 2019 оны 10 сарын байдлаар 77.5 хувь болж буурсан байна. Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр сумын сум дундын эмнэлэгт нарийн мэргэжлийн шүдний эмч ажиллаж байна.	70
		32	1.2.1.5. Нийгмийн эрүүл мэндийн олон талт арга хэмжээг шинэлэг хэлбэрээр зохион байгуулж, эрүүл мэндийг дэмжигч төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах	2017-2020	АЗДТГ, ЭМГ	Эрүүл мэндийг дэмжигч сум, баг, байгууллага, өрх гэр бүлийн тоог 2016 оны түвшингээс 2 дахин нэмэгдүүлнэ. “Эрүүл мэндийг дэмжигч байгууллагуудын холбоо”-ны үйл ажиллагаа тогтмолжино.	Аймгийн Засаг даргын захирамжаар жил бүр Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, өрх, иргэнийг шалгаруулан, сүүлийн 3 жилийн байдлаар эрүүл мэндийг дэмжигч улсын өргөмжлөлтэй 3, аймаг, орон нутгийн гэрчилгээтэй 184 байгууллага, Эрүүл мэндийг дэмжигч 11 ажлын байр, 560 өрх, 2182 иргэн байна. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд уулзалт ярилцлагыг 30 удаа, нэрэмжит сарын аяныг 46 удаа тус тус зохион байгуулж, 9250 иргэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. “Бадрал” сан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Оргил мээж” холбоо, “Эрүүл нийгэм-Гэрэлт ирээдүй” төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж байна. 2016 оны суурь түвшинтэй харьцуулахад эрүүл мэндийг дэмжигч аймаг, сумдын байгууллага, өрхийн тоо 2 дахин өссөн байна.	100

33	1.2.1.6. "Эх, хүүхдийн эрүүл мэнд стратегий"-ийг хэрэгжүүлэх	2016-2020	ЭМГ, АНЭ, сум, өрхийн ЭМТөв		Стратеги 90 хувиас дээш хэрэгжсэн байна. 1000 амьд төрөлтөд ноогдох нялхсын эндэгдлийн тохиолдлыг 2016 оны мөн үеэс 4 промиллээр, амьгүй төрөлтийн тохиолдлыг 25 хувь, гэрийн төрөлтийн тохиолдлын тоог 50 хувь бууруулна.	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Эх, нярайн эрүүл мэнд стратеги"-ийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжилтийг ханган ажиллаж эх, хүүхдийн чиглэлээр нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа төрөх эмэгтэйчүүд, нярайн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг шат дараатай мэргэшүүлэх сургалтад хамруулж, мэргэжлийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэн, нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган ажилласнаар аймгийн хэмжээнд эх, хүүхдийн тусламж үйлчилгээ сайжирлаа. Аймгийн хэмжээнд 2016 онд 1000 амьд төрөлтөд ноогдох нялхсын эндэгдэл 7.2 хувь, амьгүй төрөлт 2.8 хувь, гэрийн төрөлт 0.1 хувь, хоног болоогүй нас баралт 21.4 хувь байсан бол 2019 оны 10 сарын байдлаар 1000 амьд төрөлтөд ноогдох нялхсын эндэгдэл 10.5 хувь, амьгүй төрөлт 4.2 хувь, гэрийн төрөлт 0.4 хувь, хоног болоогүй нас баралт 52.9 хувь байна. Жирэмсний эрт үеийн хяналт 2017 онд 86.9, 2018 онд 87.3, 2019 оны 10 сарын байдлаар 89.0 хувьтай болж, 2016 оны мөн үеэс 4.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Эх, хүүхдэд үзүүлж буй тусламж үйлчилгээний чанар, хүртээмжид онцгой анхаарал хандуулан орон нутгийн Эрүүл мэндийн байгууллагуудад дэмжлэгт хяналтыг зохион байгуулан, зөвлөмж хүргүүлэн, Үндэсний төв, АШУУИС-ийн эх барихын тэнхимтэй хамтран үзлэг, сургалтуудыг, ажлын байрны сургалтыг 5 сумын ЭМБ-д зохион байгуулан, яаралтай тусламж үйлчилгээний бэлэн байдалд үнэлгээ хийсэн.	40
34	1.2.2.1. Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгийг шат дараатай зохион байгуулж, өвчлөлийн түвшинг бууруулах	2016-2020	ЭМГ, АНЭ		Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтыг 85 хувьд хүргэнэ. Эдгэрэлтийн түвшинг 2016 оныхоос 3 хувиар нэмэгдүүлнэ.	"Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн зорилтуудыг хэрэгжүүлэн халдварт өвчнөөс урьдчилэн сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд сүүлийн 3 жилийн байдлаар сүрьеэ өвчний 172 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх 4 жилийн өвчлөлөөс 53 тохиолдлоор буурч, 10000 хүн амд 6.8 промилль байна. Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх арга хэмжээг "Халдварт өвчин судлалын үндэсний төв"-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны алба, Монголын сумын эмч нарын холбоо, Сэлэнгэ, Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгууллаа. Сүрьеэ өвчний эрт илрүүлэг үзлэг, асуулга судалгааг 16 суманд зохион байгуулж, 2326 иргэнийг хамруулсан. Эрт илрүүлэг үзлэгт өвчлөлийн ойрын хавьтал гэр бүлийн 860 иргэнийг 100 хувь хамруулсан. Өвчлөлийг эрт илрүүлэх 948 сорьцыг онош баталгаажуулах шинжилгээнд илгээж, 0-16 насны 451 хүүхдийг туберкулины сорилд хамрууллаа. 2019 оны байдлаар өвчлөлийн эдгэрэлт 85.3 хувьд хүрч өмнөх оныхоос 4.2 хувиар өссөн. "Сүрьеэ өвчний өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаарх" мэдээллийг аймгийн Засаг даргын зөвлөл, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар 2 удаа хэлэлцүүлэн өвчлөлийг эрт илрүүлэх талаар сумдын ЗДТГ, ЭМБ-уудад үүрэг чиглэл өгч үр дүнг тооцон ажиллаж байна. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Сүрьеэгийн тандалт судалгааны албанаас сүүлийн 3 жилд 13, аймгийн ЭМГ, мэргэжлийн эмч нар орон нутагт 3 удаагийн хяналт, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 6 удаагийн сургалт зохион байгуулсан.	70

7	1.2.2 Халдварт өвчний тандалт сэргийлэлт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг сайжруулах	35	1.2.2.2. Бэлгийн замаар дамжих халдвар, нэн ялангуяа тэмбүү өвчнийг бууруулахад хавьтал судлалын ажлыг эрчимжүүлэх	2017-2020	ЭМГ	Нөхөн үржихүйн насны иргэдийн хамрагдалтыг 20 хувьд хүргэнэ.	"Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэн, халдварт өвчин, нэн ялангуяа тэмбүүгийн өвчлөлийг бууруулахад онцгой анхаарч, 2019 оноос "Тэмбүүг устгая" аяныг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж байна. Улсын хэмжээнд аяныг манай аймгаас эхлүүлж, Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран сумдын Засаг дарга, эрүүл мэндийн байгууллагуудын дарга нарыг үзлэг зохион байгуулах хэлэлцүүлэгт хамруулсан. Сүүлийн 3 жилд 15-55 насны 12736 иргэнийг БЗДХ-ын илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулсан нь нөхөн үржихүйн насны иргэдийн 38.6 хувийг эзэлж байна. Үзлэг, шинжилгээнд хамрагдсан иргэдээс БЗДХ-ын 515 тохиолдлыг шинээр илрүүлэн /Тэмбүү-157, Заг хүйтэн-103, Трихоминиаз-255/, хавьтлыг судалгаанд хамруулан, эмчлэн эрүүлжүүлсэн. Аяны хугацаанд 2019 онд 14 сумын 2319 иргэнийг ДОХ, Тэмбүүгийн илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулж, 36 эерэг тохиолдлыг илрүүлэн, хавьтлыг судалгаанд хамруулан эмчлэн эрүүлжүүлж байна. Давхардсан тоогоор 16000 гаруй иргэнд сургалт, мэдээлэл өгч сурталчилгааны материал, бэлгэвч тараан ажилласан байна. БЗДХ өвчний хавьтлыг илрүүлэх, үзлэг зохион байгуулах талаар орчин үеийн оношилгоо, эмчилгээний талаарх сургалтыг ХӨСҮТ, АШУҮИС-ийн багш нартай хамтран эмнэлгийн мэргэжилтнүүдэд 3 удаа зохион байгуулсан.	70
		36	1.2.2.3. "Нэг дэлхий-Нэг эрүүл мэнд" зарчмыг баримтлан, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэн, Зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээний бэлэн байдал, нөөц хангамжийг сайжруулах	2017-2020	АЗДТГ, ЭМГ	Жил бүр 2 суманд бэлэн байдлын үзүүлэх сургууль хийж, сум бүрт салбар дундын баг байгуулна.	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед авах хариу арга хэмжээний талаарх сургалт, мэдээлэл, зөвлөмжийг нийт ЭМБ-д хүргүүлэн, жил бүр аймгийн Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газартай хамтран 2 суманд бэлэн байдлын үзүүлэх сургалтыг зохион байгуулж хэвшүүлсэн. Сүүлийн 3 жилийн байдлаар Баяннуур, Дашинчилэн, Гурванбулаг, Могод, Бугат, Сайхан сумдад нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед авах арга хэмжээ, ажиллах ажлын хэсгийг байгуулан, сумдын Онцгой комиссын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, чадваржуулах ширээний дасгал сургуулалтыг зохион байгуулж хэвшүүлэн 450 гаруй албан хаагчдыг чадваржуулсан. "Нэг дэлхий-Нэг эрүүл мэнд" сургалтыг 3 удаа зохион байгуулан 6 салбарын 45 төрийн албан хаагчийг хамруулсан.	70
		37	1.2.2.4. Дамжуулагчаар дамжих халдварт өвчнөөс эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, голомттой бүс нутагт тандалт судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, өвчлөлийн талаарх эргэн мэдээллийн тогтолцоог сайжруулах	2016-2020	ЭМГ, АНЭ, сумын ЗДТГ	Голомттой бүс нутагт тандалт судалгаа хийгдсэн байна.	Голомтот бүс нутагт хийгдэх тандалт судалгааг Сэлэнгэ аймгийн Зооноз өвчин судлалын төвтэй хамтран 2 жил тутам зохион байгуулж хэвшүүлсэн. Хачигт халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг улирал угуулан зохион байгуулан, сүүлийн 3 жилд давхардсан тоогоор 48 удаагийн сургалт зохион байгуулж, 12000 гаруй иргэнийг хамруулсан. Аймгийн хэмжээнд голомтын бүсийн эрсдэлт бүлгийн иргэдийн 85.0 хувийг хачигт энцефалитын вакцинаар дархлаажуулсан. Дамжуулагчаар дамжих халдварт өвчнөөс эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний олон талт арга хэмжээг амжилттай зохион байгуулсны үр дүнд сүүлийн 3 жилийн байдлаар хачигт энцефалитын өвчлөл, нас баралт буурсан.	100
		38	1.2.2.5. Заавал хийх дархлаажуулалтад хамрагдсан иргэдийн дархлалын түвшинг үнэлж, дархлаажуулалт бүхий халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2017-2018	ЭМГ	Дархлаажуулалтад хамрагдсан иргэдийн дархлалын түвшин тогтоогдоно. ЭМБ-уудын хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж шинэчлэгдсэн байна.	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын алба, аймгийн Статистикийн хэлтэстэй хамтран "Улаанбурхан-Улаанууд" өвчний эсрэг дархлалын түвшин тогтоох судалгаанд сүүлийн 2 жилийн байдлаар 1-35 насны 96 иргэнийг хамруулж дархлалын түвшингийн титр 94.5 хувьтай гарсан нь дархлаажуулалтын чанарын түвшинг хангаж байна. Аймгийн хэмжээнд заавал хийх дархлаажуулалтын 19 нэгжийг вакцин биобэлдмэл хадгалах МК074 маркийн мөсөн ханатай хөргөгчөөр 100 хувь хангаж, орон нутгийн түвшинд вакцин тээвэрлэх журмыг шинэчлэн гаргаж, ЭМБ-ууд мөрдөн ажиллаж байна.	100

8	1.2.3. Өрх, сум, багийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт болон уламжлалт анагаах ухааны аргыг хослуулан хөгжүүлж, тоног төхөөрөмжийг сайжруулна.	39	1.2.3.1. “Сум, өрхийн Эрүүл мэндийн төвийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг хэрэгжүүлэх	2017-2020	ЭМГ	ИТХ-аар бодлогын баримт бичгийг шинэчлэн батлуулж хэрэгжүүлсэн байна.	Сум, өрхийн эрүүл мэндийн төвийг хөгжүүлэх стратегийг Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах 2017-2025 бодлогын зорилттой уялдуулан хэрэгжүүлж байна. Бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрт тусгагдсан сум, өрхийн ЭМБ-ын зорилтын түвшин 2019 оны байдлаар 85.0 хувьтай байна. Бодлогод тусгагдсанаар анхан шатны Эрүүл мэндийн байгууллагуудыг нэн шаардлагатай 33 эмнэлгийн мэргэжилтнээр хангаснаар хүний нөөцийн хангалт 94.0 хувьд хүрч, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын стандарт хангалт 2019 оны байдлаар 85.0 хувьд хүрсэн.	70
		40	1.2.3.2. Сум, багийн түвшинд “Аймгийн Засаг даргын нэрэмжит” нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг зохион байгуулах	2017-2020	АЗДТГ, ЭМГ, АНЭ	Жил бүр орон нутгийн хүн амын 20-иос доошгүй хувийг хамруулна.	Сүүлийн 3 жилийн байдлаар “Аймгийн Засаг даргын нэрэмжит” нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг орон нутгийн онцлог, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зохион байгуулж, 2017 онд 3501, 2018 онд 1456, 2019 онд 5392 нийт давхардсан тоогоор 10349 иргэнийг хамруулсан нь насанд хүрсэн хүн амын 5.0 хувийг эзэлж байна. 2019 онд Монголын сумын эмч нарын холбоо, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран 11 суманд нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг шинжилгээг зохион байгуулсан.	70
		41	1.2.3.3. Анхан шатны Эрүүл мэндийн байгууллагуудад уламжлалт анагаах ухааныг түгээн дэлгэрүүлж, мэргэжилтнүүдээр ханган, эмчилгээ, оношилгооны дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	2016-2020	Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд	Эмийн бус эмчилгээний чанар сайжирна. Эмийн эмчилгээний зардал буурна. Бүх сумдыг уламжлалт анагаах ухааны эмчээр хангана.	Уламжлалт анагаах ухааны талаар төрөөс баримтлах бодлогыг орон нутагт хэрэгжүүлэн, анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй 18 байгууллагын 13 байгууллага буюу 72.2 хувьд нь уламжлалт анагаах ухааны их эмч ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагууд эмийн бус эмчилгээ буюу халгайн ороолт, далан түрүүний ороолт, утлага, төөнүүр, хануур, зүү, бүтэн биеийн бариа, хэсгийн бариа, толгой хүүзүүний бариа, бумба, УВЧ, шивүүр, Искра зэрэг эмчилгээг давхардсан тоогоор 4500 гаруй иргэнд үзүүлсэн байна. 2019 онд Сайхан суманд “Уламжлалт анагаах сувилал”-ийг “Сайхан сэтгэл” ТББ-ын санхүүжилтээр засварлан, тохижуулж уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг үзүүлж байна. Уламжлалт анагаах ухааны чиглэлээр 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, 30 эмч мэргэжилтнийг хамруулсан.	70
		42	1.2.3.4. Сумдын Эрүүл мэндийн байгууллагуудын “Яаралтай тусламж”-ийн хэсгийг стандартын шаардлагад нийцүүлэн, цогц байдлаар иж бүрэн зохион байгуулж, эрсдлийн түвшинг бууруулах	2016-2020	НБХ, ЭМГ, АНЭ	Хоног болоогүй нас баралт буурна.	Сумдын эрүүл мэндийн байгууллагууд нь “Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа”-ны MNS5081:2013 стандартын 8.14-т зааснаар яаралтай тусламжийн хэсгийн үйл ажиллагааг тогтмолжуулан, түргэн тусламжийн автомашин, тоног төхөөрөмжөөр сүүлийн 3-н жилд дараах эх үүсвэрээс хангагдсан байна. Үүнд: Түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт улсын төсвөөс 592.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 91.0 сая төгрөг, хандив тусламжаас 210.0 сая төгрөг, нийт 893.3 сая төгрөгийн 24 ширхэг түргэн тусламжийн автомашинаар сумдын Эрүүл мэндийн байгууллагууд хангагдсан. Улсын төсвөөс 100.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 170.1 сая төгрөг, хандив тусламжаар 56.4 сая төгрөг, нийт 26 нэр төрлийн 327.4 сая төгрөгийн /мобайл, пульсоксиметр, хүчилтөрөгч өтгөрүүлэгч, хяналтын монитор, отсос, тариурын автомат шахуурга/ тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	70
		43	1.2.3.5. Хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллагуудын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх	2016-2020	НБХ, ЭМГ	Анхан шатны тусламж үйлчилгээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг оролцуулна.	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэлээр гарсан ЗГ-ын тогтоолыг хэрэгжүүлэн аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллагуудын үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэн 2019 оны байдлаар аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн ортой 4, үүдэн 5, эм хангамжийн 25 эрүүл мэндийн байгууллага эрүүл мэндийн болон эм зүйн тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Сүүлийн 3 жилд эм зүйн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 14, ариутгал халдваргүйтгэлийн чиглэлээр 1, рашаан сувиллын чиглэлээр 1, нийт 17 эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон. Сүүлийн 3 жилийн байдлаар дотор, эмэгтэйчүүд, уламжлалт, хүүхэд, дүрс оношилгоо, мэдрэл, шүдний чиглэлээр нийт 15000 иргэн амбулаторийн үзлэгт, 3000 иргэн хэвтэн эмчлүүлсэн байна.	100

44	1.2.4.1. Хоёр дахь шатлалын эмнэлгийн стандартын түвшинд мэргэжлийн байгууллагатай хамтран үнэлгээ хийж, нэн шаардлагатай тоног төхөөрөмж, эмч, эмнэлгийн мэргэжилтнээр шат дараатай хангах	2016-2020	ЭМЯ, ЭМГ	Стандартын хэрэгжилт 2016 оныхоос нэмэгдсэн байна. Нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнээр 100 хувь хангагдсан байна.	Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Цус судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн мэргэжлийн багтай хамтран аймгийн Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны MNS 5095:2017 стандартад үнэлгээ хийж, мэргэжлийн байгууллагуудын хүний нөөц, лаборатори, сүрьеэ, цусны үйл ажиллагааны талаарх зөвлөмжийг хүргүүлэн ажиллаж байна. Үнэлгээний үзүүлэлтээр 2017 онд хүний нөөцийн хангалт 72.0 хувь, тоног төхөөрөмжийн хангалт 78.3 хувь байсан бол 2018 онд мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээ, эмэгтэйчүүд, гэмтэл, дуран, дүрс оношилгоо зэрэг нарийн мэргэжлийн 6 эмчийн орон тоог нэмэгдүүлснээр хүний нөөцийн хангалт 97.1 хувь, нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 82.0 хувь, 2019 онд батлагдсан орон тоогоор хүний нөөцийн хангалт 95.0 хувьтай, зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 83.7 хувьтай байна. Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны MNS 5095:2017 стандартын хэрэгжилт 2019 оны 10 сарын байдлаар 82.1 хувьтай буюу 2016 онтой харьцуулахад 5.7 хувиар нэмэгдсэн байна.	70
45	1.2.4.2. “Яаралтай тусламжийн тасаг”-ийг стандартын түвшинд нийцүүлэн, нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг шат дараатай шийдвэрлэх	2016-2020	НБХ, ЭМГ, АНЭ	Хоног болоогүй нас баралт буурна.	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн “Яаралтай тусламжийн тасаг”-ийг улсын төсвийн 349.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нэн шаардлагатай 10 нэр төрлийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, амьлуулах тусламжийн иж бүрдлээр хангасан. Одоогийн байдлаар Яаралтай тусламжийн тасаг нь 16 орон тоо, 6 автомашинаар тусламж үйлчилгээг хүргэн, өрөө тасалгааг стандартын түвшинд нийцүүлэн тохижуулснаар стандартын хэрэгжилт 2018 онд 78.0 хувь, 2019 онд 79.0 хувьтай байна. 2019 онд Гэмтэл, согог судлалын чиглэлээр нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх хагалгааны өрөөг стандартын дагуу тохижуулсан. Яаралтай тусламжийн чиглэлээр эмнэлгийн мэргэжилтнүүдийг 3 удаагийн мэргэшүүлэх сургалтад хамруулсан.	70
46	1.2.4.3. Гемодиализын эмчилгээг нэвтрүүлэх	2016-2020	НБХ, ЭМГ, АНЭ	Иргэдийн сэтгэл ханамж дээшилж, чирэгдэл багасна.	Гемодиализ эмчилгээг 2016 оны 09 сараас NCU-18, PLUS-55 маркийн хоёр аппараттай эхлүүлэн, сүүлийн 3 жилд 30 өвчтөнд 1912 удаагийн сеанс эмчилгээг 7 хоногийн 5-6 өдөрт 7648 цаг хийсэн. Эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчдээс АВ фистултай 8, графт судастай 1, тунель гуурстай 1 өвчтөн хамрагдсан ба судасны хүндрэл гараагүй байна. 2019 оны 05 дугаар сараас эхлэн “Хэвлийн диализ” эмчилгээг эхлүүлж бөөрний аргаг дутагдалтай нэг хүнд гэрээр диализ эмчилгээг хийж байна. Гемодиализ эмчилгээг нэвтрүүлснээр иргэд орон нутагтаа нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ авч, иргэдийн сэтгэл ханамж дээшилсэн.	100
47	1.2.4.4. “Дурангийн кабинет”-ийн үйл ажиллагааг өргөжүүлэн, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийж, Дурангийн мэс заслыг нэвтрүүлэх	2016-2020	НБХ, ЭМГ, АНЭ	Нарийн мэргэжлийн эмчийн тусламж үйлчилгээний чанар сайжирна. Иргэдийн сэтгэл ханамж дээшилж, чирэгдэл багасна.	2017 онд “Дурангийн кабинет”-ийг нарийн мэргэжлийн эмчээр хангаж, үйл ажиллагааг өргөжүүлэн, улсын төсвийн 105.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар дурангийн мэс заслын аппарат, дуран угаах ариутгалын багаж болон шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан. Сүүлийн 2 жилийн хугацаанд тус кабинетаар 1258 иргэн үйлчлүүлж, ходоодны шарх 5, хавдар 10 тохиолдлыг шинээр илрүүлсэн. 2018 онд ажлын байрны сургалтыг Улсын Нэгдүгээр төв эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нартай хамтран зохион байгуулан 10 өвчтөнд, 2019 онд “Медипас” эмнэлгийн дурангийн эмч нартай хамтран 1 өвчтөнд дурангийн хагалгааг амжилттай хийсэн. Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуультай дурангийн хагалгааны чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.	100
48	1.2.4.5. “Цусны төв”-ийг байгуулах	2016-2020	ЭМГ, АНЭ	Цусны донорыг 2 хувьд хүргэнэ.	2017-2019 онд “Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр-5” төслийн санхүүжилтээр “Цусны төв”-ийг байгуулан, 64 нэр төрлийн 384.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан. “Цусны салбар төв”-ийн лаборатори нь MNS/ISO15189:2015 стандартыг мөрдөн ажиллаж, 8 нэр төрлийн 25.5 л буюу 162 нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 101 нэгж цус, цусан бүтээгдэхүүнийг эмчилгээнд хэрэглэсэн байна. Аймгийн хэмжээний нийт хүн амын 5.6 хувийг донорт элсүүлж, 75 донороос цус, цусан бүтээгдэхүүн 32765 гр-ыг бэлтгэж, 32045 гр бүтээгдэхүүнийг эмчилгээнд хэрэглэн, нөөцөд 40.190 гр цус, цусан бүтээгдэхүүн байна. Цуглуулсан цус, сийвэнгийн нэгж бүрийг ариун чанарын болон чанарын хяналтын шинжилгээнд 100 хувь хамруулсан.	100

9

1.2.4. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэн, эмчилгээ оношилгооны шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлж, иргэдэд сэтгэлд нийцсэн үйлчилгээ үзүүлнэ.

49	1.2.4.6. Донорын эгнээг өргөтгөх сайн үйлсийн аянг зохион байгуулж, хэвшүүлэх	2017-2020	АЗДТГ, ЭМГ Төрийн болон төрийн бус байгууллага	Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирна.	Донорын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэн аймгийн Улаан Загалмайн Нийгэмлэгтэй хамтран донорын эгнээг өргөжүүлэх сайн үйлсийн аяныг зохион байгуулж, сумдын Эрүүл мэндийн байгууллагууд, орон нутгийн албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн төрийн албан хаагчдыг донорт элсүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна. Мөн сар бүрийн 3-ныг "Цусаа бэлэглэх өдөр" болгон, олон улсын "Донорын өдөр"-ийг жил бүр тэмдэглэн, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулан, цус цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлсэн. Жил бүр "Аюулгүй цус сэлбэлтийн талаар" эрүүл мэндийн байгууллагуудын эмч, сувилагч, эх баригч нарт сургалтыг тогтмол зохион байгуулж, 50 гаруй эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Аймгийн хэмжээнд 27 байгууллага, аж ахуйн нэгж "ДОНОР ХАМТ ОЛОН" болзлыг хангасан.	100
50	1.2.4.7. Эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайны оношилгоог нэвтрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах	2016-2020	НБХ, ЭМГ, АНЭ	Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумдын СДЭ-үүдэд алсын зайн оношилгоог нэвтрүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулсан байна.	Сумдын Эрүүл мэндийн байгууллагууд "Мобайл тоног төхөөрөмж /зөөврийн ЭКГ, ЭХО, цусны даралт хэмжигч, хурдавчилсан оношлуур, ухаалаг таблет гэх мэт/-ийг нэвтрүүлж, иргэдэд анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэн, алсын зайн сургалтыг цахимаар хийж, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношилгоог таблетаар дамжуулан, аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй мэдээлэл солилцон ажиллаж байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэг алсын зайн оношилгоог зүрх судас, эх нярай, мэс засал, дотрын чиглэлээр нэвтрүүлэн, үндэсний нарийн мэргэжлийн клиникүүдтэй хамтран ажиллаж, 47 өвчтөнийг оношлуулан зөвлөгөө авч, 26 хүнийг зүрхний шигдээсийн хагалгаанд, 3 үйлчлүүлэгчийг зүрхний хавхлаг солиулах, стиент тавиулах хагалгаанд оруулж, ургийн гаж хөгжлийн 3 тохиолдлыг онлайнаар илрүүлсэн. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн Амын Сангийн төслийн 10.0 сая төгрөгийн санхүүжилтээр төрөх эмэгтэйчүүдийн тасгийг сургалтын болон Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Төвтэй шууд холбогдох зайн оношилгооны цахим тоног төхөөрөмжөөр хангасан.	70
51	1.2.4.8. "Эмчилгээний хоолны газар"-ыг байгуулах	2017-2020	ЭМГ, АНЭ	Эмчилгээний хоол үйлдвэрлэлийн стандарт хангагдана.	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн гал тогоонд 2017 онд Туркийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн "ТІКА" хөтөлбөрийн 74.0 сая төгрөгийн засвар хийгдэж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаснаар Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартын хоол үйлдвэрлэл, үйлчилгээ хэсгийн хангалт 80.0 хувьтай байна. Сүүлийн 3 жилийн байдлаар эмчилгээний хоолыг 15 нэр төрлөөр, талх нарийн боовыг 11 нэр төрлөөр нэмэгдүүлж, эмчилгээний 37 нэр төрлийн хоол, 15 нэр төрлийн талх нарийн боовоор хэвтэн эмчлүүлэгчдэд үйлчилж байна. Чихрийн шижин өвчний үеийн хоол 1152, зүрх судасны өвчний үеийн хоол 6965, бөөрний өвчний үеийн хоол 522, таргалалтын үеийн хоол 1596, элэг, цөсний өвчний үеийн хоол 612, ходоодны өвчний үеийн хоол 522, нойр булчирхайн өвчний үеийн хоол 64, бөөрний өвчлөлийн үеийн хоол 6112, нийт бүх өвчний эдгэрэлтийн үеийн эмчилгээний хоолоор давхардсан тоогоор 50560 иргэнд үйлчилсэн байна. Хоолны илчлэгийг тооцох шинжилгээг 12 удаа аймгийн Мэргэжлийн хяналтын газраар хийлгэж, дундаж илчлэг 3300-3800 ккал-тай гарсан.	100
52	1.2.4.9. "Уламжлалт анагаах ухааны төв"-ийг байгуулж, уламжлалт болон сэргээн засах тусламж үйлчилгээг өргөжүүлэх	2016-2020	Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд	Эмийн эмчилгээний зардал буурна. Нөхөн сэргээх эмчилгээний үр дүн сайжирна.	Уламжлалт анагаах ухаан, нөхөн сэргээх эмчилгээний тасаг нь тусламж үйлчилгээний 21 стандарт, 1 удирдамжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Хэвтүүлэн эмчлэх 6 ор бүхий тасагт жилд дунджаар 200 гаруй иргэдийг хэвтүүлэн, 20-иод төрлийн уламжлалт болон сэргээн засах эмчилгээ, үйлчилгээг хийн, 50 гаруй нэр төрлийн уламжлалт эмийг эмчилгээнд хэрэглэж байна. Тус тасгийг 2017 онд орон нутгийн төсвийн санхүүжилтээр нэн шаардлагатай 8 нэр төрлийн тоног төхөөрөмж, хэрэгслээр ханган, үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлж тохижуулан, үйлчлүүлэгчдийн биеийн байдлыг эмчилгээний өмнө ба дараа тогтмол хянан, иргэдийн сэтгэлд нийцсэн тусламж үйлчилгээ үзүүлэн эмчилгээнийхээ нэр төрлийг нэмэгдүүлсэн. Нийт уламжлалт эмийн зардалд 1.8 сая төгрөгийг зарцуулсан ба 1 эмчлүүлэгчийн уламжлалт эмийн дундаж зардал 9118.3 төгрөг байна. 2018 онд настнуудад үзүүлэх сэргээн засах тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор мэдрэл болон гэмтлийн дараах сэргээн засах тусламж үйлчилгээний чиглэлээр 4 сувилагчийг орон нутгийн төсвийн санхүүжилтээр богино хугацааны сургалтад хамрууллаа. 2019 онд тус тасгийн үйл ажиллагааг өргөжүүлэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах өрөөтэй болсон.	70

53	1.2.4.10. “Эрэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх кабинет”-ийг байгуулж, эрчүүдийн дунд тохиолдож буй өвчлөл, эндэгдлийг бууруулах	2016-2020	Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-д		Эрэгтэйчүүдийн өвчлөл, эндэгдлийн түвшинг 2016 оныхоос бууруулна.	<p>Эрүүл мэндийн сайдын 2013 оны 74 тоот тушаалаар жил бүрийн 3 дугаар сарыг "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих сар" болгон тэмдэглэж, "Тэнгэрлэг эрчүүдээ хайрлая" арга хэмжээгээр эрүүл мэндийн үзлэг, сургалтыг зохион байгуулж хэвшүүлсэн. Сүүлийн 3 жилийн байдлаар аймгийн хэмжээнд бүртгэгдсэн нийт өвчлөлийг насны бүтэц, хүйсийн байдлаар авч үзвэл 37.0-39.2 хувийг эрэгтэйчүүдийн өвчлөл эзэлж, эмчид хандаж байгаа нийт иргэдийн 3 хүн тутмын 1 нь эрэгтэйчүүд байна. Эрэгтэйчүүдийн өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаанд амьсгалын, хоол шингээх, цусны эргэлтийн, шээс бэлгийн, мэдрэлийн тогтолцооны өвчлөлүүд орж байна. Мөн сүүлийн 4 жилийн байдлаар нийт нас баралтын 56.1-71.3 хувийг эрэгтэйчүүдийн нас баралт эзэлж байгаа нь нас барсан 3 хүн тутмын 2 нь эрэгтэй хүн байна. Ялангуяа осол гэмтлийн нас баралтын 69.4-93.3 хувийг эрэгтэйчүүдийн осол гэмтэл эзэлж байна. 2019 онд Медипас эмнэлэг, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн багш нартай хамтран эрэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг зохион байгуулан 300 гаруй эрэгтэйчүүдийг хамруулсан. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2019 оны 10 сараас "Эрэгтэйчүүдийн кабинет" байгуулж, нарийн мэргэжлийн эмчээр ханган, бөөр шээсний замын мэс заслын чиглэлээр 14 хоногийн сургалтад хамруулсан.</p>	70
54	1.2.4.11. Лабораторийн чадавхийг сайжруулах	2017-2018	АЗДТГ, ЭМГ		Стандартын хэрэгжилт сайжирна.	<p>Лабораторийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулан биохими, гематологи, иммунологи, серологи, цитологи, коагулаграмм, бактериологи, гистологи шинжилгээний 8 төрлөөр хоёрдугаар шатлалын эмнэлэгт хийгдэх шаардлагатай шинжилгээнүүдийн 90.0 хувийг хийж байна. Шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн улсын хэмжээнд хийгддэг өндөр өртөг бүхий шинжилгээнүүдийг орон нутагт хийж байна. 2019 онд элэгний хавдрын 6 тохиолдол, эмэгтэйчүүдийн өндгөвчний хавдрын 2 тохиолдол, бамбайн эмгэг өөрчлөлт бүхий 4 тохиолдлыг шинээр илрүүлсэн. Элэгний В, С вирусны эм ууж буй болон вирус шинээр илэрч буй 28 хүнд элэгний хавдрын маркерыг тодорхойлсон. Лабораторийн чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор өрхийн Эрүүл мэндийн төвүүдтэй хамтран ажиллаж цусны шинжилгээний сорьцыг өрхийн Эрүүл мэндийн төв дээр авч, стандарт, дүрэм журмыг баримтлан ажиллаж байна. Биохимийн гадаад хяналтад сар бүр хамрагдан 96.2 хувийн үнэлгээ авсан. Серологи шинжилгээнд 8 сорьцонд гадаад хяналт хийгдэж, 6 шинжилгээ 100 хувь батлагдсан. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр урьдчилан сэргийлэх багцын үзлэг, шинжилгээнд 200 иргэнийг хамруулсан.</p>	70
55	1.2.5.1. Эрүүл мэндийн байгууллагуудад сувилгаа, асаргааны шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	2016-2018	Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-д		Сувилахуйн тусламж үйлчилгээнд жил бүр 2-3 шинэ технологийг нэвтрүүлнэ.	<p>Аймгийн хэмжээний Эрүүл мэндийн байгууллагуудад хөтөлгөдөг “Сувилгааны түүх хөтлөх журам”, “Сувилгааны оношийн тэмдэглэл”, “Нярайн өдөр тутмын сувилгааны тэмдэглэл”-ийг Эрүүл мэндийн газрын даргын 2017 оны А/24 тоот тушаалаар баталгаажуулан тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн. Эрүүл мэндийн сайд, Эрүүл мэндийн газрын даргын тушаалуудыг эмхэтгэн “Сувилгааны түүх хөтлөлтөд ашиглах эрх зүйн акт, удирдамж” гарын авлага, номоор сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг хангасан. Мөн Эрүүл мэндийн байгууллагуудад мөрдөгдөх асаргаа, сувилгааны гардан үйлдлийн 36 нэр төрлийн хяналтын хуудас, Эрүүл мэндийн сайд, аймгийн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар батлагдсан 56 хяналтын хуудсыг эмнэлгийн тусламж үйлчилгээний дотоодын хяналт, ижил мэргэжилтний үзлэг, аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн нь үр дүнтэй арга болсон. Сүүлийн 3 жилд 16 сувилахуйн постыг компьютержүүлж дотоод сүлжээнд холбон, сувилахуйн тусламж үйлчилгээнд хөтөлгөдөг 2-11 маягыг цахимжуулсан. “Дуут дохиолол” системийг Бүрэгхангай, Дашинчилэн, Рашаант, Сэлэнгэ, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгоны Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн Мэдрэл сэтгэц, Дотор арьсны тасагт нэвтрүүлж, яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангасан.</p>	70

1.2.5. Сувилахуйн тусламж үйлчилгээ,

10	сувилагчийн мэргэжлийн цогц үйл ажиллагаанд орчин үеийн шинэлэг аргуудыг нэвтрүүлнэ.	56	1.2.5.2. “Туслах сувилагч”-ийг бэлтгэн, сэтгэлд нийцсэн хөнгөвчлөх, сэргээн засах, уламжлалт сувилгааг өргөжүүлэх	2016-2018	Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-д	Туслах сувилагчийн тоог 50 хувиар нэмэгдүүлнэ. Хөнгөвчлөх эмчилгээний удирдамжийн хэрэгжилтийг 90 хувьд хүргэнэ.	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах ухааны сургуультай хамтран 2018-2019 онд 9 эрүүл мэндийн байгууллагын 10 үйлчлэгчийг, 2019-2020 оны хичээлийн жилд 9 үйлчлэгчийг туслах сувилагчаар бэлтгэснээр туслах сувилагчийн тоо 19-өөр нэмэгдлээ. Баян-Агт, Сэлэнгэ сумын Эрүүл мэндийн төв нь туслах сувилагчийг орон тоогоор нь ажиллуулж эхэлсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Хавдрын кабинетаар амбулаторийн үзлэгийг 1651 иргэнд, идэвхтэй үзлэгийг 1296 иргэнд хийсэн. Сүүлийн 3 жилд 298 өвчтөнг хэвтүүлэн эмчилсэн ба 60 өвчтөнд хими эмчилгээ, 238 өвчтөнд хөнгөвчлөх тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний удирдамжийн хэрэгжилт 88.0 хувьтай байна.	70
		57	1.2.5.3. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа сувилгаа, зөвлөгөө өгөх “Өдрийн эмчилгээний төв”-ийг байгуулах	2016-2020	Улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-д	Өдрийн эмчилгээний төвтэй болсон байна.	Булган аймгийн хэмжээнд 442 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүртгэлтэй байгаагаас 156 буюу нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 35.3 хувь нь байнгын асаргаа шаардлагатай хүүхэд эзэлж байна. “Булган нэг үе” клубээс санаачлан Канадын сангийн төслөөр 42.0 сая төгрөгийн 15 төрлийн тоног төхөөрөмжөөр Нэгдсэн эмнэлгийн уламжлалтын тасагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа сувилгаа, зөвлөгөө өгөх өрөөг тохижуулж, эмнэлгийн тусламж үйлчилгээг гэрээр болон хөдөлгөөнт хэлбэрээр зохион байгуулж байна. 2019 оны эхний 10 сарын байдлаар тархины саатай 15 хүүхэд хөдөлгөөн засал эмчилгээнд хамрагдаж, гэрээр хийгдэх дасгал хөдөлгөөн, асаргааг зааж, зөвлөгөө дэмжлэг үзүүлээ.	100
11	1.2.6 Эм зүйн шинжлэх ухааны шинэ аргуудыг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны эмчилгээнд нэвтрүүлнэ.	58	1.2.6.1. Эрүүл мэндийн байгууллагуудад эм зүйн тусламж үйлчилгээний хүрээг өргөтгөн, эм зүйн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2016-2020	ЭМГ, ЭМБ, ЭХБ	Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 90 хувьд хүрсэн байна.	“Төрөөс эмийн талаар баримтлах бодлого”-ыг орон нутагт хэрэгжүүлэн Эрүүл мэндийн байгууллагуудыг зайлшгүй шаардлагатай эмээр тасралтгүй ханган эм зүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүллээ. Сүүлийн 3 жилийн байдлаар “Эмийн зохистой хэрэглээ”-ний талаар 8 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 360 гаруй мэргэжилтнийг хамруулсан. Эмийн сангуудын цахим жорын программыг шинэчилж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн ханган, стандартын хэрэгжилт 95.0 хувьд хүрлээ. Эм зүйн албаны менежментийн чиглэлээр 1, клиник эм зүйчээр 1 мэргэжилтнийг сургаж мэргэшүүлсэн. Жил бүр эрүүл мэндийн байгууллагуудад нэн шаардлагатай эмийн тендерийг зохион байгуулснаар эмийн хангамж, хүртээмж сайжирч, Нэгдсэн эмнэлгийн эмийн хангамж 90.0 хувь, сумдын түвшинд 86.0 хувьтай байгаа ба аймгийн хэмжээнд 88.0 хувьтай байна. Эмийн хангамж, хүртээмж 2016 онтой харьцуулахад 0.2 хувиар нэмэгдсэнээр эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар дээшилсэн.	70
		59	1.2.6.2. Эм зүйн тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэн, “Уламжлалт анагаах ухааны эмчилгээний эмийн сан”-г шинээр байгуулах	2016-2020	ЭМГ, ЭМБ, ЭХБ	Эм зүйн тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэнэ.	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 22 эмийн сан уламжлалт эмийн тасаг ажиллуулан эм зүйн тусламж үйлчилгээг иргэдэд үзүүлж ирсэн. 2019 онд Булган сумын “Монос Булган” эмийн сан, Хишиг-Өндөр сумын “Хульж Очир” ХХК-ийн “Очир” эмийн санд уламжлалт эмээр үйлчилж байна. Уламжлалт эмээр үйлчлэх эмийн сангийн тоо нэмэгдсэнээр эмийн нэр төрөл нэмэгдсэн.	100
		60	1.2.6.3. Орон нутагт хувийн хэвшлийн эмийн сангуудыг шинээр байгуулахад дэмжлэг үзүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг бий болгох	2016-2020	НБХ, ЭМГ	Эм зүйн тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэнэ.	“Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”-ыг орон нутагт хэрэгжүүлэн хүн амд эм зүйн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэх зорилгоор 2016 онд Дашинчилэн сумын “Зуун наст фарм” эмийн сан, Тэшиг сумын “Эгийн хишиг” эмийн сан, 2017 онд Булган сумын “Эмийн багваахай” эмийн сан, 2018 онд Баяннуур сумын “Юмка фарм”, Дашинчилэн сумын “Шижүд фарм”, Хангал сумын “Хангал бамбай” эмийн санд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг шинээр олгосон. 2019 онд Булган суманд “БЭРШ ФАРМ” ХХК-ийн 24 цагийн үйлчилгээтэй хувийн хэвшлийн эмийн сан, Хутаг-Өндөр суманд “Мөнхийн агар фарм” ХХК-ийн эмийн сан, Хишиг-Өндөр суманд “Хульж Очир” ХХК-ийн “Очир” эмийн сан, Булган суманд “Монос Булган” ХХК-ийн эмийн санд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгож, хувийн хэвшлийн эм хангамжийн байгууллагуудын өрсөлдөөнийг нэмэгдүүлсэн. 2016 онтой харьцуулахад хувийн хэвшлийн 10 эмийн сан шинээр үйлчилгээ үзүүлж байна.	100

12	1.2.7. Эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, давтан сургах хүний нөөцийн хөгжлийн аймгийн бодлогыг тодорхойлж, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэн, залгамж халааг бэлтгэнэ.	61	1.2.7.1. “Булган аймгийн Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлого”-ыг хэрэгжүүлэх	2017-2020	АЗДТГ, ЭМГ	Эмч, эмнэлгийн мэргэжилтний хангалтыг 95.0 хувьд хүргэнэ.	Булган аймгийн “Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2017-2020 онд хөгжүүлэх бодлого”-ын зорилтыг хэрэгжүүлэн сүүлийн 3 жилийн байдлаар төгсөлтийн дараах төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалтад 26, мэргэжил дээшлүүлэх сургалтад 30 эмч, үндсэн мэргэжлийн сургалтад 45 эмнэлгийн мэргэжилтэн, богино хугацааны 210 төрлийн сургалтад 320, ажлын байрны болон багц цагийн 57 төрлийн сургалтад давхардсан тоогоор 2800, 135 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 344 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамрууллаа. Аймгийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос “ЭМЯ-ны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо”-той хамтран 19 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 1100 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан нь нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний 91.4 хувийг эзэлж байна. Эрүүл мэндийн байгууллагуудад дутагдалтай байгаа орон тооны мэдээллийг хүлээн авч нэгтгэн Эрүүл мэндийн хөгжлийн төв, Анагаахын боловсрол олгох их дээд сургууль, нийгэмлэгүүдэд хүргүүлэн байгууллагын вэб сайтад байршуулж, 25 Эрүүл мэндийн байгууллагыг нэн шаардлагатай 40 эмнэлгийн мэргэжилтнээр хангасан ба нийт Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн хангалт 94.0 хувьтай байна.	70
		62	1.2.7.2. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн төгсөлтийн дараах сургалтын чиглэлээр гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх	2017-2020	АЗДТГ, ЭМГ, ЭМБ-ууд	Жилд 1-ээс доошгүй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж, дадлагдажуулна.	Аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан чиглэл, эрүүл мэндийн байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг өндөр хөгжилтэй орнуудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний онцлог, төрөл, тусламж үйлчилгээний соёлыг таниулах, туршлага судлуулах зорилгоор 18 чиглэлээр Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос улс, Бүгд Найрамдах Филиппин улс, Сингапур, Тайланд, Япон зэрэг оронд 20 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж, дадлагдажуулсан.	100
13	1.2.8. Эрүүл мэндийн байгууллагуудын орчин нөхцлийг сайжруулан, мэдээллийн технологийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	63	1.2.8.1. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасаг, Баян-Агт, Баяннуур, Дашинчилэн, Хялганат, Гурванбулаг сумын ЭМТ-ийн барилгад их засвар хийх	2017-2020	АЗДТГ, ЭМГ	Иргэдэд ээлтэй орчин бүрдэж, сэтгэл ханамж дээшилнэ.	Сүүлийн 3 жилд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хишиг-Өндөр сумын сум дундын эмнэлгийн Яаралтай тусламжийн барилгын засвар, Эрүүл мэндийн газрын конторын барилгын засвар, аймгийн Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын тасгийн барилгын засвар, Гурванбулаг сумын ЭМТ-ийн барилгын засвар, Хутаг-Өндөр сумын Хантай багийн эмнэлгийн барилгын засвар, Рашаант сумын ЭМТ-ийн сантехникийн засвар, Хангал сумын ЭМТ-ийн цахилгаан хангамж, Сэлэнгэ сумын халаалтын тогоо солих ажлууд нийт 229.2 сая төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн 50 ортой төрөх эмнэлгийн барилгын дээврийн засвар, Нэгдсэн эмнэлгийн гэмтлийн тасгийн барилгын засвар, Нэгдсэн эмнэлгийн моргын барилгын дээврийн засвар, Баян-Агт сумын ЭМТ-ийн барилгын засвар, Хялганат тосгоны ЭМТ-ийн барилгын засвар, Могод сумын ЭМТ-ийн барилгын засвар, Халдварт сүрьеэгийн эмнэлгийн барилгын бохирын шугамын засвар, Өрхийн эрүүл мэндийн төвийн халаалтын тогоо солих ажил, Баяннуур сумын ЭМТ-ийн барилгын дээврийн засварт нийт 854.5 сая төгрөг, хандив тусламжаар Сайхан сумын Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилгын засвар 240.0 сая төгрөг, “ТИКА” теслийн санхүүжилтээр аймгийн Нэгдсэн эмнэлгийн гал тогооны засвар 74.0 сая төгрөгөөр хийгдэж, дэд бүтцийн ажлуудыг эмнэлгийн барилгын стандартад нийцүүлэн ашиглалтад оруулсан. 2020 онд аймгийн Нэгдсэн эмнэлгийн ариутгалын барилгын дээврийн засвар, Баяннуур сумын ЭМТ-ийн барилгын их засвар, Дашинчилэн сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засваруудыг улсын төсвийн 555.9 сая төгрөгийн санхүүжилтээр шийдвэрлүүлсэн.	70
		64	1.2.8.2. Булган суманд 30 ортой халдварт Сүрьеэгийн тасаг, Орхон, Могод сумын Эрүүл мэндийн төвийн 10 ортой эмнэлгийн барилгыг шинээр барих	2016-2020	АЗДТГ, ГХБХБГ	Стандартын шаардлага хангасан эмнэлгийн барилгын тоо нэмэгдэнэ.	2018-2019 онд улсын төсвийн 2.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн Халдварт, сүрьеэгийн тасгийн 30 ортой шинэ эмнэлгийн барилга, 2019 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Хишиг-Өндөр сумын СДЭ-ийн барилгыг хуучин эмнэлэгтэй хүзүүвчээр холбох холболтын барилгын ажилд 30.0 сая төгрөг, Сайхан сумын ЭМТ-ийн түргэн тусламжийн автомашины граж 15.0 сая төгрөгөөр барьж ашиглалтад оруулсан байна. Орхон суманд барих 10 ортой шинэ эмнэлгийн барилгын саналыг 2020 оны улсын төсөвт санал хүргүүлсэн.	40

65	1.2.8.3. Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагад нийцсэн орчин үеийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг шат дараатай шийдвэрлэх	2017-2020	АЗДТГ, ЭМГ		Эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдэнэ.	Сүүлийн 3 жилд Эрүүл мэндийн байгууллагуудыг улсын төсвийн 2361.5 сая төгрөг, орон нутгийн төсвийн 536.2 сая төгрөг, төсөл, хөтөлбөр, хандив тусламжийн 653.9 сая төгрөгийн нэн шаардлагатай тоног төхөөрөмж, эмчилгээ, оношилгооны багаж хэрэгслээр хангаж, эмнэлгийн анхан болон нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, стандарт хангалтын түвшинг 2016 онтой харьцуулахад 7.8 хувиар нэмэгдүүлээд байна.	100
66	1.2.8.4. Бугат, Сэлэнгэ, Баян-Агт, Бүрэгхангай, Могод сум, Хялганат тосгоны эрүүл мэндийн төв, Хишиг-Өндөр сумын сум дундын эмнэлэг, аймгийн Нэгдсэн эмнэлгийг яаралтай түргэн тусламжийн автомашинаар үе шаттай хангах	2017-2020	АЗДТГ, ЭМГ		Түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлтийг 100 хувьд хүргэнэ.	2016-2019 онд аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газар, 14 сумын Эрүүл мэндийн төв, 2 сумын Сум дундын эмнэлэгт түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийж, нийт 27 автомашинаар хангагдсанаас улсын төсвөөс 914.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 116.0 сая төгрөг, хандив тусламжаар 210.0 сая төгрөг, нийт 1240.3 сая төгрөг зарцуулж автомашины парк шинэчлэлт 100 хувь хийгдсэн.	100

1.3 Нийтийн биеийн тамир, спорт

Үндэсний спортын өв, соёл, эрүүл амьдралын дадал хэвшлийг дэлгэрүүлж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, спортыг бүх нийтийн үйл хэрэг болгоно.

67	1.3.1.1. Тамирчдын уралдаан тэмцээн, шагнал урамшуулал болон спортыг дэмжигч Аж ахуйн нэгж, холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, НБХ БТСГ, СЗДТГ		Тамирчид, багш, дасгалжуулагчдын идэвх санаачилга дээшилж, амжилтын тоо ахисан байна.	2016-2018 онуудад улс, олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс медаль хүртсэн тамирчдад мөнгөн урамшуулал олгуулахаар тамирчдын материалыг бүрдүүлэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2016 онд алт 32, мөнгө 22, хүрэл 19 нийт 73 медальд 13.8 сая, 2017 онд алт 67, мөнгөн 28, хүрэл 42 нийт 137 медальд 15.9 сая, 2018 онд алт 74, мөнгө 36, хүрэл 84 нийт 194 медальд 20.0 сая, нийт 404 медальд 48.3 сая төгрөгийн урамшуулал олгон тамирчид, багш, дасгалжуулагчдын идэвх санаачлага дээшилж, амжилтын тоо ахисан үзүүлэлттэй байна. Монгол нум сум хөтөлбөрийн хүрээнд 15.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	100
68	1.3.1.2. Хүүхдийн, Ахмадын, Үндэсний спортын, Бүх ард түмний спортын наадмуудыг зохион байгуулах, улсын тэмцээнд тамирчдыг оролцуулахад дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, НБХ БТСГ, СЗДТГ		Хүмүүсийн оролцоо нэмэгдэж амжилт сайжирсан байна.	2016 онд Монголын Бүх ард түмний спортын XIV их наадамд спортын 11 төрлөөр оролцож, 5 медаль авсан. 2018 онд Үндэсний спортын VI их наадмын Өвлийн спортын төрөл мөсний шагай, мөсний сурын харвааг аймгийн хэмжээнд 02 дугаар сард зохион байгуулж, шалгарсан тамирчид шигшээ тэмцээнд амжилттай оролцсон. Зуны төрлийг спортын 10 /Үндэсний сурын харваа, Буриад сурын харваа, Уламжлалт сурын харваа, Урианхай сурын харваа, Үндэсний бөх, шагайн харваа, ширээний шагай, хурдан морины уралдаан, Жороо морины уралдаан, Уран уургач, бугуйлч, эмнэг булгиулагч/ төрлөөр зохион байгууллаа. Монголын Үндэсний спортын VI их наадмын шигшээ тэмцээнд Булган аймгаас нийт 56 тамирчин амжилттай оролцож, Үндэсний сурын харваанд спортын мастерын болзлыг 2, Шагайн харваагаар МУ-ын мэргэн цолыг 6 харваач хүртэж, нийт 12 медаль хүртлээ. 2019 онд Хэнтий аймагт зохион байгуулагдсан ахмадын спортын наадамд спортын 6 төрлөөр оролцож 1 алтан медаль хүртлээ. 2019 онд Монголын хүүхдийн спортын VI их наадмын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 15 төрлөөр зохион байгуулан 1815 тамирчид хамрагдаж, тэмцээнээс шалгарсан баг тамирчид шигшээ тэмцээнд оролцон Булган аймгийн баг тамирчид 27 Алт, 21 Мөнгө, 17 Хүрэл медаль хүртэж багийн дүнгээр улсад Тэргүүн байр эзэллээ. Хүүхдийн спортын наадамд оролцох аймгийн тамирчдад аймгаас 11.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 2019 оны Насанд хүрэгчдийн волейболын улсын аварга шалгаруулах тэмцээнийг аймагтаа зохион байгуулж шагналын мөнгө 10.0 сая төгрөг шийдвэрлэж, улсын тэмцээнд тамирчдыг оролцуулахад дэмжлэг үзүүлээ. 2019 онд спортын уралдаан тэмцээнд оролцох тамирчид, тэмцээн уралдааны зохион байгуулалтад 50 гаруй сая төгрөгийн дэмжлэг аймгийн зүгээс үзүүлсэн байна.	100

14	хөгжих, уралдаан тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлэхэд анхаарч, амжилт гаргах, алдаршуулахад бодлогоор дэмжиж ажиллана.	69	1.3.1.3. Үндэсний бөх, хурдан морь, сур, шагайн спортыг дэмжиж, улсын алдар цолтой хүмүүсийн нэрэмжит тэмцээнийг уламжлал болгон тогтмолжуулах, сурталчлах ажлыг үе шаттайгаар хийх	2016-2020	АЗДТГ, НБХ БТСГ, Спортын холбоод	Алдартнуудаа сурталчилж үндэсний спортоор хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байна.	Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Хангинахын шугуйн шагайн тойром”-ыг сэргээснээс хойш 2016 онд 31 багийн 300, 2017 онд 28 багийн 200, 2018 онд 35 багийн 307, 2019 онд 23 багийн 300 гаруй харваачид Булган, Өвөрхангай, Дорноговь, Хөвсгөл, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хот, Хангал, Тэшиг, Хутаг-Өндөр, Сайхан сумаас ирж оролцсон байна. 2016 онд Монгол улсын арслан Б.Жамъяндоржийн нэрэмжит өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах барилдааныг Сэлэнгэ суманд, Монгол улсын Дархан аварга Б.Түвдэндоржийн 100 жилийн ойд зориулсан хүчит 256 бөхийн барилдааныг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгууллаа. 2016-2019 онуудад Монгол улсын арслан Б.Жамъяндоржийн нэрэмжит өсвөр үеийн үндэсний бөхийн аймгийн аварга шалгаруулах барилдааныг жил бүр уламжлал болгон зохион явууллаа. 2019 онд С.Цэрэн аваргын нэрэмжит үндэсний бөхийн барилдааныг 11 дүгээр сарын 07-08-ны өдрүүдэд зохион байгууллаа. Монгол нум сумыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг батлуулан жил бүр 15.0 сая төгрөг зарцуулж байна. 2019 оны Улсын баяр наадамд гуравдугаар байр эзэлж Улсын гоц харваач болсон Бүрэгхангай сумын харьяат спортын мастер, аймгийн мэргэн Б.Баярцэцэгийн цолны мялаалгын нэрэмжит тэмцээнийг Бүрэгхангай суманд 09 дүгээр сард зохион байгуулж, аймгаас 2.0 сая төгрөгийг шагнал урамшуулалд зарцууллаа.	100
		70	1.3.1.4. Ерөнхий боловсролын сургуулиудад Олимпийн сургалт, танхимуудыг байгуулан, үзүүлэн таниулах материалаар үе шаттай хангах	2016-2020	АЗДТГ, НБХ БТСГ, ЕБС, “Москва” олимпийн зөвлөл	Хүүхдүүдийн спорт Олимпизмийн мэдлэг зохих түвшинд дээшилсэн байна.	Аймгийн хэмжээнд “Москва” олимп судлалын төвийг шинээр байгуулж үйл ажиллагаагаа явуулж байна. Сум болон сургуулиудад Олимпийн танхимын үйл ажиллагааг идэвхжүүлж, хүүхэд багачуудад Олимпизмийн үзлийг сурталчлах чиглэл хүргүүлсний дагуу Булган сумын Эрдмийн өргөө цогцолбор сургууль, Спортын дунд сургууль, 1 дүгээр сургууль, Биеийн тамирын спортын газар, Гурванбулаг сум, Рашаант, Орхон зэрэг сум, Хялганат тосгонд өвөл, зуны Олимпийн самбаруудыг шинээр авч олимпийн танхимаа тохижуулан өргөжүүлсэн байна. 2017 онд “Олимпизм ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт уралдааныг аймгийн хэмжээнд зохион байгуулж, Булган аймгийн “Москва” олимпийн зөвлөл, Биеийн тамирын спортын газар, Боловсрол, соёл урлагийн газрын дарга нар хамтран ажиллах гэрээ байгуулан уралдааныг дүгнэж I байранд Хангал сумын Хялганат тосгоны “Сайханы Хульж” олимпийн танхим шалгарч, материалыг Монголын Үндэсний Олимпийн Хороонд хүргүүлсэн. Тус сургуулийн олимпийн танхим 2017 оны ажлын үзүүлэлт, өрөө танхимын тохижилт, сургалт сурталчилгааны ажлаараа Монголын Үндэсний Олимпийн Хорооны “Бэртэ чоно” шагналаар шагнагдсан байна. 2018 оны 3-р улирлаас Биеийн тамир спортын газарт Олимпийн танхим өрөө тасалгааг шинэчлэн үйл ажиллагаагаа сурталчлан ажиллаж байна. 2019 оны II дугаар улиралд Хялганат тосгоны Спорт цогцолборт олимпийн танхим шинээр байгуулсан бөгөөд 2019 оны байдлаар 16 сум, 1 тосгонд олимпийн танхимтай болж, сургуулийн сурагчдад сургалт сурталчилгааны ажлыг явуулж тодорхой үр дүнд хүрд хүрч байна.	100

15	1.3.2.Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх таатай орчин нөхцлийг бүрдүүлнэ.	71	1.3.2.1. Аймаг, сумын төвүүдийн гудамж, нийтийн эзэмшлийн талбайд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд залуучуудад зориулсан ногоон байгууламж бүхий гүйлт, дугуйн зам, спорт тоглоом, мөсөн гулгуурын талбай байгуулах ажлыг эхлүүлэх	2016-2020	АЗДТГ, НБХ, Булган СЗДТГ ГХБХБГ БТСГ	Ард иргэдийн нийтийн биеийн тамираар чөлөөтэй хичээллэх боломж бүрдсэн байна.	2016-2019 онуудад өвлийн спортын тэмцээний бэлтгэл хийхэд зориулан Төв цэнгэлдэх хүрээлэнд 400 метрийн мөсөн гулгуурын талбайг байгуулан мөс тавьж өвлийн спорт, мөсний шагайн харваа, хөл бөмбөг, хөнгөн атлетик, мөсний баяр зэрэг нийтийг хамарсан арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. 2018 онд аймгийн Төв цэнгэлдэх хүрээлэнд 4 замтай 400 метрийн гүйлтийн асфальтан зам, хөл бөмбөгийн талбайтай болж хүүхэд, залуучууд, ахмад настан, ард иргэдийн, биеийн тамир спортоор хичээллэх боломжийг бүрдүүлсэн томоохон бүтээн байгуулалт болсон. Хүүхэд, залуучууд, иргэд, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэмцээн уралдааныг зохион байгуулах тал дээр 14 сум ногоон байгууламж бүхий спорт тоглоомын гадаа талбайг шинээр болон хуучин талбайг засварлаж хэвийн үйл ажиллагаа явуулж байна. 1-р багт Дашчойнхорлон хийд, багийн Засаг даргатай хамтран сагсан бөмбөг, хүүхдийн тоглоомын талбайг байгуулсан. Биеийн тамир спортын газар нь Онцгой байдлын газартай хамтран мини хөл бөмбөгийн талбайг байгуулан Хөл бөмбөг, граунд гольфийн тэмцээнийг зохион байгууллаа. Мөн Эрдэнэт үйлдвэр Булган аймагтай хамтран ажиллах гэрээний дагуу 118.0 сая төгрөгөөр ЭӨЦС-ийн биеийн тамирын талбай байгуулах, Монголын хөл бөмбөгийн холбооноос 20*40 метрийн харьцаатай хөл бөмбөгийн талбайг байгуулах 100000\$-ын төсөвт өртөгтэй ажлууд хийгдэж эхлээд байна.	70
		72	1.3.2.2. Хүн амыг эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх, эрүүл амьдралын дадал, хэвшилд сургах чиглэл бүхий нийтийн биеийн тамирын сайн дурын танхим, клуб, хамтлагуудыг дэмжиж ажиллах	2016-2020	АЗДТГ, НБХ, БТСГ, Агентлагийн удирдлага, СЗДТГ	Албан байгууллагын ажиллагсдын идэвх санаачилга нэмэгдэж эрүүл амьдралын дадал, хэв маяг хэвшсэн байна.	2016 онд байгууллага аж ахуйн нэгжүүдэд спортын танхим хамтлаг, орон тооны бус арга зүйчдийг байгуулахаар албан бичгийг хүргүүлсэн. 2017 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамирын спортын газрын даргын А/82 дугаар тушаалаар шинэчлэгдсэн “Хамтлаг байгуулах дүрэм”-ийг сум, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэн мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлээ. 2017 онд 30 спортын хамтлаг, 2018 онд спортын хамтлаг 36, клуб 5, товчоо 1 нийт 42 хамтлаг, 2019 оны байдлаар Булган сумын төрийн ба төрийн бус байгууллагад 23 спортын хамтлаг, сумдад 15 спортын хамтлаг, 8-н клуб, нийт 46 хамтлаг клуб үйл ажиллагаагаа явуулж байна. Биеийн тамир, спортын хамтлаг нь байгууллагын ажиллагсдын эрүүл мэндэд чиглэсэн үйл ажиллагааг тогтмол явуулж, ажиллагсдыг хуваарийн дагуу зааланд тоглуулж, зохион байгуулагдаж байгаа тэмцээн уралдаанд идэвхтэй хамруулж хэвшлээ.	100
		73	1.3.3.1. Үндэсний наадгай сур харвааг хөгжүүлэх зорилгоор “Монгол нум сум” хөтөлбөр хэрэгжүүлэх	2016-2020	АЗДТГ, НБХ, БТСГ, БСУГ	Эрийн гурван наадмын нэг үндэсний наадгай сурын харвааг хөгжүүлж, хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байна.	“Монгол нум сум” дэд хөтөлбөрийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 19 дүгээр тогтоолоор батлуулан шаардагдах хөрөнгийг аймгийн төсөвт тусган хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд сургагч багш бэлтгэх анхан шатны сургалтыг 2017 оны 04 дүгээр сард зохион явуулж, 40 сургагч багшийг бэлтгэлээ. “Монгол нум сум” дэд хөтөлбөрийн хүрээнд бүх суманд ажлын хэсэг байгуулж, сургалт сурталчилгааны ажлыг зохион явуулахаас гадна үндэсний сурын бэлтгэлийг хийж тэмцээн уралдааныг зохион байгуулж ирлээ. 2017-2019 онд давхардсан тоогоор 938 хүн үндэсний сурын харваагаар хичээллэж байна. 2018 онд Соёл амралтын хүрээлэнд “Үндэсний сурын харваа”-ны стандартын талбай ашиглалтад орж тэмцээн, уралдаан, сургалт зохион байгуулах нөхцөл бүрдсэн. Булган аймгийн Үндэсний сурын холбооноос 14 суманд ажиллах төлөвлөгөө гарган сургалт хийж, нум 4 ш, сум 20 ш, агсуурга 2 ш, эрхийвч 5 ш, хасаа 1 ком, гарын авлага 4 ширхэгийг өгсөн. 2019 онд өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн дунд үндэсний сурын спортыг сурталчлан, сургалт болон тэмцээн уралдааныг аймгийн хэмжээнд зохион байгуулж 262 харваач оролцсон байна. Мөн үндэсний сурын нээлтийн ба отго харваа, сургалтыг жил бүр аймгийн хэмжээнд уламжлал болгон зохион явуулж хэвшлээ. Улсын баяр наадмын үндэсний сурын харваанд Булган аймгийн баг тамирчид оролцож, Улсын гоц мэргэн харваачийн болзлыг Бүрэгхангай сумын харьяат спортын мастер, аймгийн мэргэн Б.Баярцэцэг хангасан байна. Энэ жилийн баяр наадмаар 2 харваач аймгийн мэргэн, 2 харваач гарамгай харваач, 1 харваач аймгийн гоц харваачийн болзлыг хангасан. 2019 онд 543 харваач үндэсний сурын харваагаар хичээллэж байна. Бүх сумыг нум сумаар хангасан ба 12 дугаар сард 4.0 сая төгрөгөөр мэргэжлийн 5 нум, 25 сум авахаар гэрээ байгуулсан.	100

16	1.3.3. Спортын тодорхой төрлүүдийг /үндэсний сур, цана, тэшүүр, бөхийн төрлүүд, волейбол, хөнгөн атлетик, бокс, буудлага, таеквандо, сагсан бөмбөг г.м/ түлхүү хөгжүүлнэ.	74	1.3.3.2. Шагай харвааг хөгжүүлэхийн зэрэгцээ түгээн дэлгэрүүлэх холбоо, багуудыг дэмжиж ажиллах	2016-2020	АЗДТГ, НБХ, БТСГ, БСУГ	Шагай харвааг хөгжүүлж, хичээллэгсдийн тоог нэмэгдүүлж, Хангинахын шугуйн шагайн тойрмын хамрах хүрээг тэлж улмаар жуулчдын анхаарлыг татсан эвент арга хэмжээ болгосон байна	2016 оноос 400 жилийн түүхтэй Халхын 4 том тойрмын нэг "Хангинахын шугуйн шагайн тойром"-ыг сэргээснээр жил бүр уламжлал болгон зохиож 23-31 багийн 300 гаруй шагайчид тогтмол оролцдог болсон. Уг тойрмыг зохион байгуулах хөрөнгийг жил бүр орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байна. Биеийн тамирын спортын газрын "А" зааланд өрөө танхим гарган өгч "Шагайн харваа"-гаар хичээллэх, спортын тэмцээн уралдаан явуулах орчин нөхцөлийг нь бүрдүүлсэн. "Мөсний шагай"-н харвааг хөгжүүлэн, дэлгэрүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд "Мөсний шагай-2017, 2018" тэмцээнийг Тэшиг, Хутаг-Өндөр суманд зохион байгуулж, 20 багийн 40 харваачид тогтмол оролцож байна. 2019 онд аймгийн хэмжээнд 12 удаагийн шагайн харвааны тэмцээнийг зохион байгуулж, давхардсан тоогоор 3000 гаруй харваачид оролцсон. Аймгийн баяр наадмаар 8 харваач аймгийн Гоц мэргэн цолны болзол шинээр хангасан. Булган аймгийн Шагайн харвааны аварга шалгаруулах 28 дахь удаагийн тэмцээнд 22 багийн 180 гаруй харваач оролцлоо.	100
		75	1.3.3.3. Цана, тэшүүр, бөхийн төрлүүд /самбо, жудо, чөлөөт, үндэсний бөх г.м/ гар бөмбөг, сагсан бөмбөг, бокс, буудлага, хөнгөн атлетик, таеквандо, ширээний теннис зэрэг спортыг түлхүү хөгжүүлэх чиглэлээр дэмжих	2016-2020	АЗДТГ, НБХ, БТСГ, Спортын холбоод	Орон нутгийн брэнд төрлүүд болон хөгжсөн байна.	2017 оноос өсвөрийн шигшээ багийг аймгийн хэмжээнд цана, тэшүүр, волейбол, сагсан бөмбөг, бокс, хөнгөн атлетик, таеквандо зэрэг спортын төрлөөр байгуулан ажиллаж байгаагаас гадна мэргэжлийн дасгалжуулагч багш нар секц дугуйланг хичээллүүлж баг тамирчид нь Азийн аварга, олон улс, улс, бус, олон хотын тэмцээн уралдаанд амжилттай оролцож дараах амжилтыг үзүүлсэн байна. Үүнд: Цанын өсвөр үеийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд I баг багаараа 1-р, II баг багаараа 3-р, тэшүүрийн өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 3-р, Шорт трейкийн улсын аварга шалгаруулах тэмцээнд багаараа 1-р, Мини волейболын улсын аварга шалгаруулах тэмцээнд /охид/ 1-р, жудо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 3-р, Хөдөөгийн хүчтэн төвийн бүсийн үндэсний бөхийн барилдаанд багаараа 1-р, Боксын бага насны улсын аварга шалгаруулах тэмцээнд 1-р, Хөнгөн атлетикийн 4-н төрөлтийн улсын аварга шалгаруулах тэмцээнд багаараа 3-р байр тус тус эзэлсэн. Мөн сүүлийн жилүүдэд шинэ тутам хөгжиж байгаа пауэрлифтинг, гандболоор сонирхон хичээллэгчдийн тоо нэмэгдэж, Пауэрлифтингийн өсвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнд багаараа 1-р, гандболын идэрчүүдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 1-р, гандболын бага насны улсын аварга шалгаруулах тэмцээнд 3-р байрыг тус тус эзэлсэн амжилт гаргасан. 2018 онд Монгол улсын Ардын багш, Монгол улсын Гавьяат дасгалжуулагч, Академич, Профессор, Олон Улсын Хэмжээний Мастер Д.Банди агсны нэрэмжит бага насны боксчдын Улсын аварга шалгаруулах "Олимпийн Гараа" тэмцээнийг 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулж 39 багийн 363 өсвөрийн боксчид оролцлоо. 2019 онд Өсвөрийн шигшээ багийг спортын 12 төрлөөр байгуулахаар төсвийн төслийг боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, төсвийг жил бүрийн төсөвт тусгахаар шийдвэрлэсэн. Монголын волейболын залуучуудын холбооноос зохион байгуулсан "Зуны цом" 2019 U16 аварга шалгаруулах тэмцээнээс Булган аймгийн охидын шигшээ багийн тамирчид мөнгөн медаль, шилдэг довтлогч, шилдэг голын хаагч шагналуудыг хүртлээ. Мөн Бугат, Сэлэнгэ, Тэшиг сум өвлийн спортыг хөгжүүлэхэд Японы ОЙСКА байгууллагатай хамтран ажиллаж байна.	100
		76	1.3.4.1. Спортын шинэ ордны дээвэр, халаалтын иж бүрэн засварыг хийж гүйцэтгэх	2016-2020	БСШУСЯ АЗДТГ, НБХ, БТСГ	Улсын комисс хүлээн авсан акт гаргуулсан байна.	Спортын шинэ ордны дээвэр, халаалтын иж бүрэн засварыг 2018 онд улсын төсвийн 776.0 сая төгрөгөөр Орхон аймгийн "Борхууд" ХХК-аар гүйцэтгүүлэн ашиглалтад хүлээн авч спортын уралдаан тэмцээн явуулах таатай нөхцөлийг бүрдүүлсэн.	100
		77	1.3.4.2. Хялганат тосгоны спорт заалыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг хэвийн явуулах боломжоор хангах	2016-2020	АЗДТГ, НБХ, СЗДТГ	Хялганат тосгоны ард иргэд нийтийн биеийн тамираар хичээллэх таатай орчин нөхцөлтэй болсон байна.	Хангал сумын Хялганат тосгоны спорт цогцолборын барилгыг 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж, 2017 оны 12 дугаар сард ашиглалтад хүлээн авч, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 42 дугаар тогтоолоор Биеийн тамир, спортын газрын харьяанд шилжүүлж, 3 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Цогцолборт зураг төсвийн дагуу стандартын резинэн шал тавигдаж сагсан бөмбөг, мини волейбол, софт волейболын секц, шагайн харваа хичээллэж байна.	100

17	1.3.4. Спортын салбарын материаллаг баазыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.	78	1.3.4.3. Спортын ордны Б заалны их засварыг хийх	2016-2020	АЗДТГ, НБХ, СЗДТ	Орчин, нөхцөл сайжирсан байна.	2017 онд БТСГ-ын гадна талбайд 9.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинээр хайс хийн талбайг цементлэн Б заалны гадна, дотор пасад, заал, өрөөнүүдэд иж бүрэн засвар хийж, аймаг сум, албан байгууллагын томоохон арга хэмжээ болон спортын уралдаан тэмцээнийг тогтмол зохион байгуулан спортоор хичээллэгсдийн тоо нэмэгдлээ.	100
		79	1.3.4.4. Спортын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг үе шаттай нэмэгдүүлэх	2016-2020	АЗДТГ, НБХ, СЗДТ	Спортын секцүүдийн үйл ажиллагаа сайжирч, хичээллэгсдийн тоо өсөж, спортод гаргах амжилт ахисан байна.	2017 онд бокс, таеквондо, сагсан бөмбөг, волейбол, усан спорт, фитнес зэрэг спортын төрөлд шинээр 3.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, хэрэглэл материал нийлүүлж, тамирчдын хичээллэх орчин нөхцөлийг сайжруулсан. "Монгол нум сум" хөтөлбөрийн хүрээнд бүх сум, сургуульд 2 ширхэг нум сумыг хүлээлгэж өгсөн. Мөн Монголын үндэсний сурын холбооноос хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт Булган аймгийн Үндэсний сурын холбоо хамрагдаж, эхний 8-н суманд нум 4 ш, сум 20 ш, агсуурга 2 ш, эрхийвч 5 ш, хасаа 1 ком, гарын авлага 4 ш, нийт 1 суманд 1.3 сая төгрөг, нийт 8-н суманд 10.8 сая төгрөгийн хэрэглэл материал олгосон. 2018 онд Монголын сагсан бөмбөгийн холбооноос 30.0 сая төгрөгийн үнэ бүхий сагсан бөмбөгийн иж бүрэн самбарыг аймгийн Спортын ордонд суурилуулснаас гадна сум тус бүрт тоглолтын 10 ширхэг бөмбөг хандивласан. Таеквандогоор хичээллэгсдэд хандиваар өмсгөл хувцас 20 ш /тобо/, цана тэшүүрийн өвлийн гадуур хувцас /комбинзон/-ыг олголоо. 2019 онд Усан спорт сургалтын төвийн фитнес 7.5 сая төгрөгөөр хэвтээ шахалтын төхөөрөмж /мэргэжлийн/, тэмээ төхөөрөмж, боксын бэлтгэлийн угсардаг зөөврийн резинэн шалтай боллоо. Сумдад 500000 төгрөгийн үнэ бүхий сагс, волейбол, хөл бөмбөг, софт волейболын бөмбөгнүүд, волейболын тор, орс зэрэг спортын хэрэглэл материал олголоо. Булган аймгийн волейболын холбооноос аймгийн Биеийн тамирын спортын газарт 500000 төгрөгийн волейболын тор, 1.0 сая төгрөгийн шон, 240000 төгрөгийн тоглолтын 2 ширхэг бөмбөгийг хандивлалаа. Хүүхдийн спортын их наадамд оролцох баг тамирчдад 8.4 сая төгрөгийн бэлтгэлийн хувцсыг аймгийн төсвөөс авч өглөө.	100

1.4 Соёл, урлаг

Үндэсний өв уламжлал, орчин үеийн дэвшилтэт соёлыг шингээсэн иргэдийг төлөвшүүлж, урлаг, гоо зүйн боловсролыг дээшлүүлэн, соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжин өргөжүүлнэ.

14.1. Соёл урлагийг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, соёлын үйлчилгээний үзэсгэлэн гаргах	80	1.4.1.1. Аймгийн "Соёл, урлагийн бодлого"-ыг боловсруулж, хэрэгжүүлэх	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ	Соёл, урлагийн бодлого хэрэгжиж орон нутгийн түвшинд соёлын чиг хандлага тодорхойлогдож, соёл урлагийн үйлчилгээ шинэ шатанд хүрсэн байна	2016-2020 онд хэрэгжүүлэх "Соёлын бодлого"-ыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 45 дугаар тогтоолоор батлуулан, хэрэгжүүлж байна. 2017 оны 04 дүгээр сард Боловсрол, соёл урлагийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд Соёлын бодлогыг танилцуулан мэдээлэл хийж, баримт бичгийг бүх соёл урлагийн байгууллагад хүргүүлсэн. Соёл урлагийн байгууллагуудын боловсон хүчний хангалт 2016 онд 47 хувьтай байсан бол 2019 оны байдлаар 53 хувь болж өслөө. Аймгийн хэмжээнд 2016-2020 онд ардын уламжлалт урлагийг хөгжүүлэх, соёл урлагийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлийг баримтлан ажиллаж байна. Мөн мэргэжилтэй боловсон хүчний хангалтыг нэмэгдүүлэх чиглэл барьж, Оросын Холбооны Улсын Улан-Үдэ хотын урлагийн сургуульд хүүхдүүд сургаж, 2019 онд 35 хүүхэд суралцаж байна. Тус сургуульд суралцсан хүүхдүүдийн 2 дахь ээлжийн төгсөлт энэ оны хавар сургуулиа дүүргэж 6 мэргэжилтэй боловсон хүчин Булган сумын Соёлын ордон болон 3-р сургуульд ажиллаж эхэллээ.	70
	81	1.4.1.2. Сумдын соёл, урлагийн өдрүүдийг тогтмол зохион байгуулж, урлаг соёлын үйлчилгээ, эд өлгийн зүйл, сум орон нутгийн онцлогийг харуулсан үзэсгэлэн гаргах	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ Сумдын ЗДТГ	Сум, орон нутгийн бусдаасаа ялгарах онцлогийг харуулж, орон нутгаа сурталчлах, сумдын соёлын брэнд бүтээгдэхүүнийг тодорхойлно.	2017 онд Ардын урлагийн наадмыг зохион байгуулж нийт сумд өөрийн сумын онцлог бүтээл, эд өлгийн зүйлсээр үзэсгэлэн гаргасан. Аймгийн музейгээс 2018 онд нийт 5 удаагийн 205 дэсийн 409 ширхэг үзмэрээр үзэсгэлэн гаргаж, сурталчилсан бол 2019 онд Орхон сумын 60 жилийн ойн баяр, Тэшиг сумын "Эв модны наадам"-д 130 дэсийн 130 ширхэг, Улаанбаатар хотод Айрагны баярын үзэсгэлэнд 40 дэсийн 40 ширхэг, Сансар 36 дэсийн 47 ширхэг, МУГБ Д.Шагдарын 7 дэсийн 22 ширхэг, Ардын багш Д.Бандитай холбоотой 9 дэсийн 17 ширхэг үзэсгэлэнг тус тус гаргаж иргэдэд сурталчиллаа. Соёлын байгууллагуудын дарга эрхлэгч нарын "Соёлын довтолгоо" аялан тоглолт Булган аймгаа нар зөв тойрон 4500 иргэнд соёлын үйлчилгээ үзүүлсэн байна.	100

18	үйлчилгээг шинэ шатанд гаргаж, Соёл урлагийн ажилтнуудыг сургах, давтан сургах ажлыг ээлж дараатай зохион байгуулах, мэргэжлийн урлагийн байгууллагуудын мэргэжилтэй боловсон хүчнийг нэмэгдүүлнэ.	82	1.4.1.3. Аймгийн “Ардын урлагийн наадам”-ыг 2 жил тутам зохион байгуулж, шилдэг уран бүтээлүүдийг олон нийтийн хүртээл болгох	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ	Булган нутгийн уран бүтээлчдийн бүтээл олон нийтэд танигдсан байна.	Булган аймгийн Ардын урлагийн их наадмыг Хөгжимт жүжгийн театрын уран бүтээлчид, ажилчдын нийт 13 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2017 онд зохион байгуулж, нийт 16 сум, 1 тосгон 10 төрлөөр оролцсон. Наадмын Шилдэг уран бүтээлүүдийг олон нийтийн хүртээл болгосон ба тус наадмаас шалгарсан ардын авьяастнууд 2018 оны 8 дугаар сард “Нүүдэлчин Монгол” наадамд амжилттай оролцлоо. Ардын урлагийн наадмын уралдаанд нийт 350 гаруй хүн оролцож, 1500 гаруй үзэгчид үзсэн.	70
		83	1.4.1.4. Амьд хөгжмийг сурталчлах, дэлгэрүүлэх	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, Булган, СЗДТГ, Булган сумын Соёлын ордон	Амьд хөгжмөөр хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байна.	Амьд хөгжмийг сурталчлах, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор ятга, ёочин, морин хуур хөгжмийн сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. 2017-2019 онд нийт 50.0 сая төгрөгийн хөгжмийн зэмсгийг авсан. Үүнд: Жимбээ бөмбөр, төмөр хуур, хулсан хуур, товшуур, цуур, их хуур, хуучир, ёочин, гитар зэргийг нийлүүлсэн. Даралтад хөгжим, басс гитар, ритм гитарыг үндэсний цөөхүүл хөгжимтэй нийлүүлэн 9-10 бүтээл гаргасан. Булган сумын Соёлын ордны амьд хөгжим, төгөлдөр хуурын дугуйланд 20-30 хүүхэд тогтмол хамрагдаж байгаа ба Хишиг-Өндөр сумын сургуульд ритм гитар (юкелея) хөгжмийн дугуйлан хичээллэж байна. Мөн төсвийн зохицуулалтаар 7 суманд тус бүр 6, Баяннуур суманд 5.0 сая төгрөгөөр хөгжмийн зэмсэг авч өглөө.	70
		84	1.4.1.5. Гадаад улсын Элчин сайдын яамдтай хамтран, тухайн орны урлаг, соёл, кино өдрүүд зохион байгуулах	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, Булган, СЗДТГ Булган сумын Соёлын ордон	Соёлын үйлчилгээний төрөл, чанар нэмэгдэнэ.	Аймгийн Хөгжимт жүжгийн театр, Номын сан, Булган сумын Соёлын ордны ажилтнууд 2018 оны 09 дүгээр сард Оросын Холбооны Улсын Буриад улсын Улан-Үдэ хотын дуурийн театр, номын сан, соёлын сургуулиудад туршлага судалсан. “Ялалтын баяр”-г зориулсан “День победы” тоглолтыг Оросын Холбооны Улсын Буриад улсын Улаан-Үдэ хот, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул аймгаар аялан тоглолоо. Оросын Холбооны Улсын Буриад улсын Улан-Үдэ хотын соёлын сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд тус сургуульд сурч буй оюутан, багш нарын хамтарсан “Трубадор ба түүний нөхөд” дуулалт жүжгийг орос хэл дээр тавьж үзэгчдийн хүртээл болгосон. Буриад улсын Соёлын сайд, Засгийн газартай тохиролцсоны дагуу Тэшиг суманд 2019 оны 7 дугаар сарын 2-3-нд “Бага Алтаргана” болон “Эв мод”-ны наадмыг зохион байгуулж, Оросын Холбооны Улсын Буриад улс, Улаанбаатар хот, Булган, Хөвсгөл, Дорнод, Хэнтий аймгийн буриад ястан 700 гаруй хүн оролцлоо.	70
85	1.4.2.1. ХЖТ, аймгийн Төв номын сангийн шинэ барилгын асуудлыг шийдвэрлэх	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ	Аймгийн Хөгжимт жүжгийн театр, Номын сан орчин үеийн стандартад нийцсэн барилгатай болж, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэж, үйлчилгээнд чанарын ахиц гарсан байна.	Номын сангийн өргөтгөлийн барилгын зураг төсвийг Улаанбаатар хотын “Өрх” ХХК-иар 800000 төгрөгөөр шинэчлэн хийлгүүлсэн. Номын сангийн дээврийн төмрийг 3.4 сая төгрөгөөр шинэчилсэн. Аймгийн Хөгжимт жүжгийн театрын 40.0 сая төгрөгийн урсгал засвар хийгдсэн.	40		
					Хөгжимт жүжгийн театрын барилгын зураг төслийг “Кон инженерс” ХХК-аар 121.0 сая төгрөгөөр хийлгэхээр гэрээ байгуулж зураг төсөлд шаардлагатай цахилгаан, цэвэр бохир ус, дулаан дамжуулах шугам, холбоо, геологийн дүгнэлтүүдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудаар нь гаргуулж хургуулсан. Зураг төслийн ажлын гүйцэтгэл 97 хувьтай явагдаж байна.			
86	1.4.2.2. Аймгийн музейн барилгад өргөтгөл, шинэчлэл хийж, Баруун замын тусгай ангийн штаб-музейн барилга, Ардын Хатанбаатар С.Магсаржавын дуулгат бунхныг засварлаж, тохижуулах	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, Аймгийн музей	Музейн үйл ажиллагаа явуулахад таатай орчин бүрдэж үйлчлүүлэгчдийн тоо эрс нэмэгдсэн байна.	Музейн үзмэр дэглэлтийг шинэчлэх, барилгын дээвэр, хана таазны засварын ажлыг аймгийн төсвийн 105.0 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэлээ. Ардын Хатанбаатар С.Магсаржавын дуулгат бунхны хаалга цонхыг шинэчилж, будгийн ажил хийсэн. Баруун замын байлдааны штаб музейн засварын ажлын тооцоог гаргасан.	70		

19	1.4.2. Соёлын байгууллагуудын материаллаг баазыг сайжруулах, зарим сумдын Соёлын төвүүдийг шинээр барих, их засвар хийх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шат дараатай нэмэгдүүлнэ.	87	1.4.2.3. Баяннуур сумын "Шороон бумбагар"-ын бунхант булш, ханын зургийг хамгаалах сэргээн засварлах, Баян-Агт сумын Шивээт-Улааны түүхийн дурсгалт газрыг аялал жуулчлалын төв болгох	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, Аймгийн музей	Түүх соёлын үнэт олдворыг олон нийтэд таниулж, орон нутгаа сурталчилсан байна.	Баяннуур сумын Шороон бумбагарын дурсгалт газарт Соёлын өвийн төв, аймгийн музей, Баяннуур сумын соёлын төвтэй хамтран "Орон нутгийн иргэдэд соёлын өвийн хадгалалт хамгаалалтын талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан. Одоогоор тус байгууламжийг хамгаалахаар сэндвичэн барилга дээр нь барьсан бөгөөд цахилгааны шугам татаад байна. Тус байгууламжийг сэргээх, хадгалах технологи байхгүй тул ажил түр зогссон. Баян-Агт сумын Шивээт улааны цогцолборыг хамгаалалтад авах талаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд санал хүргүүлсэн.	40
		88	1.4.2.4. Хялганат тосгон, Баяннуур, Могод, Гурванбулаг, Хангал, Бугат, Хутаг-Өндөр сумдын соёлын төвд их засвар хийх	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ	Соёл, урлагийн үйлчилгээг таатай орчинд хүргэж, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн байна	2017 онд Могод сумын Соёлын төвийн барилгын их засварыг улсын төсвийн 140.0 сая, орон нутгийн 67.4 сая, нийт 207.4 сая төгрөгийн өртгөөр Улаанбаатар хотын "Элэг бүс" ХХК-иар гүйцэтгүүлж, ашиглалтад хүлээн авсан. Баяннуур, Гурванбулаг сумын соёлын төвийн дээврийн засварыг Боловсрол, соёл урлагийн газар болон орон нутгийн төсвөөс 23.7 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж гүйцэтгэсэн. Хутаг-Өндөр сумын соёлын төвийн халаалтын системийг 16.0 сая төгрөгөөр шинэчилсэн. Тус сумын удирдлага Нийгмийн хариуцлагын хүрээнд соёлын төвд засвар хийлгэхээр "Жигүүр гранд" ХХК-нд санал хүргүүлсэн. Хангал сумын соёлын төвд 2019 онд 271.0 сая төгрөгийн их засвар хийлээ.	70
		89	1.4.2.5. ХЖТ, Номын сан, Соёлын төвүүдийг камержуулах	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, АТНС	Аюулгүй орчинг бүрдүүлсэн байна.	2017 онд аймгийн Боловсрол, соёл урлагийн газрын хөрөнгө оруулалтаар 2.3 сая төгрөгөөр 8 ширхэг камер авч Хөгжимт жүжгийн театрыг бүрэн камержуулсан. Үүнд: Гадна 1, дотор 7 камер суурилуулсан байна. Мөн төв номын санд 1.6 сая төгрөгөөр 4 ширхэг камер, Хишиг-Өндөр сумын соёлын төвд 4 ширхэг камер суурилуулаад байна.	70
		90	1.4.2.6. Соёлын төвүүдийг шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр үе шаттайгаар хангах	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, СЗДТГ	Сумдын соёл, урлагийн үйлчилгээ чанаржиж, үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсэн байна.	"B sound" продакшны хандиваар Хутаг-Өндөр суманд өсгөгч 1 ш, тайзны гэрэлтүүлэг 3 ш, диффузер 2 ш, Могод суманд диффузер 2 ш, гэрэлтүүлэг 3 ш, нийт 8.0 сая төгрөгийн техник шинэчлэл хийлээ. Булган сумын соёлын төвд төгөлдөр хуур, Бүрэгхангай, Гурванбулаг, Могод, Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хутаг-Өндөр сумдад тус бүр 6.0 сая, Баяннуур сум 5.0 сая төгрөгөөр хөгжмийн зэмсэг авлаа. "Уртын дуу-Морин хуур" дэд хөтөлбөрийн хүрээнд 2018 онд аймгийн Хөгжимт жүжгийн театрт 7.9 сая төгрөгийн үндэсний хөгжмийн зэмсэг нийлүүлсэн.	70
		91	1.4.2.7. Сумын номын сангуудад интернэт үйлчилгээг нэвтрүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, СЗДТГ	Үйлчилгээний таатай орчин бүрдсэн байна.	Сумын номын сангуудад интернэт үйлчилгээг бүрэн нэвтрүүлж, шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байна.	100
		92	1.4.3.1. Түүхийн дурсгалт газар, хөшөө дурсгалууд, хиргисүүр, булш бунханы хадгалалт, хамгаалалт, тохижилтыг стандартын дагуу хийж гүйцэтгэн, байнгын арчилгаатай болгох	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, Аймгийн музей	Түүхийн дурсгалт газар, хөшөө дурсгалууд, хиргисүүр, булш бунханы хадгалалт, хамгаалалт сайжирсан байна.	2017 онд нийт суманд 31 ширхэг дурсгалыг хашаажуулж, тухайн дурсгалыг ойролцоо малчид, багийн дарга нарт гэрээгээр хүлээлгэн өгсөн. 2018 онд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт Баян-Агт сумын Цагаан олом, Булган сумын Зүүн түрүүний хүн чулуун хөшөө, Сайхан сумын Байширын бүрд хэмээх газарт орших буган чулуун хөшөөг хашаажуулах 8.0 сая төгрөгийн төсвийн тооцоо жагсаалтыг хүргүүлж, дурсгалын самбарыг англи, монгол тайлбартай босгосон. 2019 он Зэд хантай бүтээлийн нурууны дархан цаазат газартай хамтран тухайн нутаг дэвсгэрт орших хөшөө, дурсгал, булш хиргисүүрийг баталгаажууллаа. Орхон сумын 1-р багийн нутаг Хөшигийн ар хэмээх газарт иргэн н.Насанбатын мэдээллийн дагуу 4 ширхэг буган чулуун хөшөөг шинээр нээн илрүүлж гэрэл зурагжуулан авлаа.	100

20	1.4.3. Үндэсний уламжлал, өв соёлыг дэлгэрүүлж, музейн үзмэрийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх, түүх соёлын үл хөдлөх дурсгалын зүйлсийг хамгаалах, үзмэрийг гадаад, дотоодод сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулна.	93	1.4.3.2. “Уртын дуу, Морин хуур” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Уран нугаралт”-ыг сурталчлан, дэлгэрүүлэх	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, СЗДТГ	“Уртын дуу, Морин хуур” хөтөлбөр амжилттай хэрэгжиж хичээллэгсдийн тоо нэмэгдсэн байна. Уран нугаралтаар хичээллэгсэдтэй болсон байна.	“Уртын дуу-Морин хуур” хөтөлбөрийг батлуулан сургагч багшаар ХЖТ-ын дуучин МУСТА Н.Мөнгөнтуяа, Г.Долгорсүрэн Т.Янжинлхам нар ажиллаж байна. Хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаанд МУГЖ Ц.Түвшинжаргал, Ардын жүжигчин морин хуурч Ч.Батсайхан нар уригдан уртын дууны тайлбарт сургалтыг зохион байгуулсан. Булган Аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаанд 80 уртын дуучин, 80 морин хуурч оролцож, тус 160 хүнийг бүртгэл мэдээллийн санд бүртгэлээ. Булган аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг албан байгууллага, аж ахуйн нэгж, төрийн албан хаагчдын дунд 2 үе шаттайгаар 8 удаагийн сургалтыг зохион байгуулсан. 16 сумын 1 тосгоны морин хуурын сургагч багш нарын сургалтыг 2017-2018 онд зохион байгуулж, Булган аймгийн түүхт 80 жилийн ойд дуулагдах “Эртний сайхан дуу”-г тоглож суран баяр наадмын нээлтийн үйл ажиллагаанд 80 морин хуурчийг бэлтгэн оролцуулсан. Булган сум 2019 оны 06 дугаар сард уртын дуу-морин хуурын 5 хоногийн эрчимжүүлсэн сургалтыг өөрийн байрандаа зохион байгуулж, аймгийн баяр наадмын нээлтийн үйл ажиллагаанд монгол Ардын Уртын дуу “Эрхэм төр дууг 50 уртын дуучин дуулж 50 морин хуурчид нээлтийн үйл ажиллагаанд оролцсон байна. Өсвөрийн циркчдийн улсын 4-р уралдаан 2019 оны 10 дугаар сард Орхон аймагт зохион байгуулагдаж, Соёлын ордны дэргэдэх уран нугаралтын Цоморлиг хамтлаг 2 үзүүлбэрээр оролцон, Тусгай байрын шагнал хүртлээ. Тус тэмцээнд оролцох замын зардал 550.0 мянга, орчин үеийн хөлтэй ширээ авах зардал 400.0 мянган төгрөгийг “Уртын дуу, морин хуур” хөтөлбөрөөс санхүүжүүллээ. “Уртын дуу, Морин хуур хөтөлбөр”-т орон нутгийн төсвөөс 2017 18.9 сая, 2018 онд 21.0 сая, 2019 онд 15.0 сая төгрөг зарцууллаа.	100
		94	1.4.3.3. Сумдын орон нутаг судлалын танхим, ЕБС-ийн түүхийн танхимын үзмэр, эд өлгийн зүйлийг тоолж баталгаажуулах	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, Аймгийн Музей	Нэгдсэн санд бүртгэсэн байна.	Аймгийн Засаг даргын 2018 оны А/675 дугаар захирамжаар тооллого зохион байгуулах комисс байгуулан, орон нутаг судлах танхимын 768 дэсийн 1568 ширхэг үзмэрийг тоолж, нэгдсэн санд орууллаа.	100
		95	1.4.3.4. Аймгийн нутаг дэвсгэрт оршдог улс, аймгийн хамгаалалттай 36 дурсгалыг гадаад, дотоодод сурталчилсан ном, товхимол, газрын зураг, музейн танилцуулга /Монгол, Орос, Англи хэлээр/ хэвлэж сурталчлах	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, Аймгийн Музей	Түүх соёлоо олон улсад сурталчлах таатай боломж бүрдсэн байна.	2018 онд улс, аймгийн хамгаалалтад байгаа 36 үл хөдлөх дурсгалт зүйлийг харуулсан ном хэвлүүллээ. Булган аймгийн соёлын дурсгал, дурсгалт газруудын маршрутыг харуулсан нугалбар гаргасан. Улс, аймаг, сумын хамгаалалтад байдаг түүх соёлын үл хөдлөх дурсгалын талаарх тайлбарыг англи, орос хэлээр орчуулан эхийг бэлэн болгосон.	70
21	1.4.4. Номын фонд баяжилтыг нэмэгдүүлж, сумдын номын сангуудын орчин нөхцлийг сайжруулан үйл ажиллагааг өргөжүүлнэ.	96	1.4.4.1. Бүх нийтээр ном унших хөдөлгөөн өрнүүлэн, “Нүүдлийн номын сан”-гийн үйлчилгээг эрчимжүүлэх хөдөөгийн багт хувиараа номын сан байгуулах иргэдийг дэмжих	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, АТНС	Ард иргэдийг номтой нөхөрлүүлэх ажил эрчимжиж ном уншигчдын тоо нэмэгдсэн байна.	Иргэд, хүүхдүүдийг номтой нөхөрлүүлэх, ном унших хөдөлгөөн өрнүүлэх зорилгоор 2016-2019 онд 165 удаагийн ажил зохион байгуулж, 21903 хүн хамрагдаж, 12998 уншигч, 73751 ирэгсдэд 115403 номоор үйлчилсэн байна. Нүүдлийн номын сангийн үйлчилгээг сайжруулан 171 удаагийн явалтаар 3776 уншигч, 12406 ирэгсдэд 14460 номоор үйлчилжээ. Хүний хөгжлийн төвд номын сангийн салбарыг нээн ажиллуулж байна. Булган сумын Гангатад оршин суудаг ахмад багш Сүрэнтэй хамтран “Гэр” номын санг 2017 оноос ажиллуулж малчин ард иргэдэд зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэж байна.	100
		97	1.4.4.2. Аймаг, сумдын номын сангийн фонд баяжилтыг үе шаттайгаар хангах	2016-2020	АЗДТГ, НБХ, БСУГ, СЗДТГ	Уншигчдын тоо болон номын фонд баяжилтыг нэмэгдүүлсэн байна.	Номын сангийн фонд баяжилтад анхаарч 2016-2019 онд 25.5 сая төгрөгийн 1077 нэр төрлийн 2195 ширхэг номоор фонд баяжилт хийлээ. Түүнчлэн “Оюунлаг Булган” хөтөлбөрийн хүрээнд 2017 онд сум бүрт 250000, аймгийн Төв номын санд 750000, 2018 онд сум тус бүрт 100000, аймгийн Төв номын сан 300000 төгрөгөөр, нийт 7.0 сая төгрөгөөр фонд баяжилт хийсэн байна.	100

1.5 ХҮН АМ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвар, мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, нийгмийн халамж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, иргэдийн нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгоход бодлого, үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

1.5 Хүн амын хөдөлмөр эрхлэлт

22	1.5.1 Аймгийн нийгэм, эдийн засгийн бодлоготой уялдуулан шинэ залуу боловсон хүчнийг дэмжих, төгсөгчдийг ажлын байраар хангасан хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллана.	98	1.5.1.1. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч, МСҮТ, их дээд сургууль төгсөгчдийн судалгааг гарган, нэгтгэн мэдээллийн сан үүсгэх	2016-2020	АЗДТГ, НБХ, ХХҮГ, БСУГ, СЗДТГ	Мэдээллийн сан үүсгэн, салбар дундын хамтын ажиллагаанд ашигласан байна.	2016 онд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогч, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, их дээд сургууль төгсөгчдийн судалгааг 14 сум, 1 тосгоны 5050 иргэн, хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 11 аж ахуйн нэгж, нийтийн үйлчилгээний чиглэлийн 12 аж ахуйн нэгж, байгууллага, 2017 онд 2 сумаас авч мэдээллийн сан шинээр үүсгэсэн. Мөн аймгийн хэмжээнд их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв төгссөн оюутны судалгааг авч мэдээллийн санд орууллаа. Судалгаагаар их, дээд, сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг төгсөгч 558, суралцаж байгаа 1117 оюутан байна. Судалгаанд төрийн 122 байгууллагын 3131, 583 төрийн өмчит болон хувийн аж ахуйн нэгжийн 1157, хувийн хэвшил болон хувиараа хөдөлмөр эрхлэгч 1490, ажил олгогч байгууллагын 5174 ажиллагсдын ажлын байрны мэдээлэл бүртгэгдсэн байна.	70
		99	1.5.1.2. Ажилгүй болон эмзэг бүлгийн иргэдийг МСҮТ, бусад бизнесийн төвүүдтэй хамтран, мэргэжилтэй ажилтан бэлтгэх чиглэлээр сургах, ажилд зуучлах	2016-2020	ХХҮГ, МСҮТ, БСУГ, СЗДТГ	Ажил, мэргэжилгүй иргэдийн 80 гаруй хувийг тус чиглэлд хамруулан төгсөгчдийн 50-аас дээш хувийг ажлын байраар хангасан байна.	Булган аймагт үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд орон нутгийн хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан хөдөө аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, байгаль орчин, оффисийн ажилтан зэрэг 20 гаруй чиглэлээр сургалт явуулж, мэргэжилтэй ажилтан бэлтгэж байна. 2016-2019 онд мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг нийт 1185 оюутан суралцаж төгссөнөөс нийт төгсөгчдийн 59.0 хувь буюу 699 оюутан ажлын байраар хангагдаж үүнээс 45 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байна. 2016-2017 оны хичээлийн жилд 190 оюутан төгссөнөөс 68 хувь нь, 2017-2018 оны хичээлийн жилд 211 оюутан төгссөнөөс 44 хувь нь, 2018-2019 оны хичээлийн жилд 263 оюутан төгссөнөөс 43 хувь нь ажлын байраар хангагджээ. Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв нь хүлэмжийн аж ахуйн фермер, хүнсний ногооны фермер, ойжуулагч, сүү боловсруулах үйлдвэрлэлийн ажилтан, жимс жимсгэний аж ахуйн фермер, тракторын механик зэрэг 9 мэргэжлээр 361 мэргэжилтэй ажилтан бэлтгэснээс 37.3 хувь нь ажлын байраар хангагдсан байна.	70
		100	1.5.1.3. МСҮТ-д суралцагсдын үйлдвэр дээрх дадлага хийх боломжийг нэмэгдүүлэх, сургалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх, багш нарыг давтан сургах, сургалтын хөтөлбөрийг сайжруулах	2016-2020	ХХҮГ, МСҮТ, БСУГ, СЗДТГ	Дадлага хийх орчин нөхцөлийг сайжруулж, 2 МСҮТ-ийн зарим техник тоног төхөөрөмжийг шинэчилсэн байна.	2016-2019 онд улсын болон олон улсын төсөл хөтөлбөрийн шугамаар 578.4 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд нийлүүлээ. Азийн хөгжлийн банкны "Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх" төслийн хөрөнгө оруулалтаар малын асаргаа /санитор/, хүлэмжийн аж ахуйн фермер, хүнсний ногооны фермер мэргэжлээр ажилтан бэлтгэх сургалтын орчин сайжруулах зорилгоор 780.0 орчим сая төгрөгийн малын эмчийн лаборатори, онолын хичээлийн байрны засвар үйлчилгээ, иж бүрэн багаж тоног төхөөрөмж, 6х20 м хэмжээтэй өвлийн нарлаг хүлэмж нийлүүлэхээр төлөвлөж байна. 2017, 2018, 2019 онд 14 багш, 4 суралцагчийг гадаадын 5 оронд сургалтад хамруулж мэргэжил, мэдлэгийг нь дээшлүүлэн туршлага судлууллаа. Мөн ХНХЯ, Японы ОЙСКА байгууллага, бусад төсөл хөтөлбөрүүдтэй хамтран 149 багшийг цахим хэрэглэгдэхүүн бэлтгэх, сургалтын хөтөлбөр, гарын авлага бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадварыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах шинэ технологи нэвтрүүлэх, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох чадавхийг сайжруулах чиглэлээр мэргэжил дээшлүүлэх, давтан сургалтад хамрууллаа.	100

		101	1.5.1.4. Шинээр байнгын болон түр ажлын байр бий болгосон ажил олгогчдыг дэмжих, хамтран ажиллах	2016-2020	ХХҮГ, МСҮТ, БСУГ, СЗДТГ	Жилд 10-аас доошгүй ажил олгогчийг дэмжин урамшуулал олгосон байна. Төгсөгчдийн 70-аас доошгүй хувь нь ажлын байраар хангагдсан байна.	<p>Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тодорхойлох зорилготой судалгаанд хамрагдсан 48 аж ахуйн нэгж, албан байгууллагын судалгааны дүнгээс харахад 13 мэргэжлийн чиглэлээр 140 иргэнийг сургах хүсэлттэй байгаагийн 53.6 хувь нь барилгын засал чимэглэлч, өрлөгчин, мужаан, тогооч, худалдагч, гагнуурчин, сантехникч зэрэг мэргэжлээр ажилтан авах шаардлагатай гэсэн дүн гарсан. Байнгын болон түр ажлын байр болгосон 25 аж ахуйн нэгж байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p>2016 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангасан Баяннуур сумын "Хушт-Эрэг" ХХК-д ажил олгогчийн урамшуулал 2.3 сая, 2017 онд Сайхан сумын "Аргун номт" ХХК, Могод сумын "Эрхт түшиг" ХХК-д 5.6 сая, 2018 онд "Сайхан Атаат хайрхан" ХХК, "Мөнхийн тун" ХХК, "Насандэлгэрэх" ХХК, Булган сумын "Оргил мээж" ТББ-уудад 5.7 сая төгрөгийг тус тус олголоо.</p> <p>2017 онд ажил олоход хүндрэлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангасан "Өрнөх учралт" ХХК-д гэрээний дагуу ажил олгогчид олгох 2.3 сая төгрөгийн урамшууллыг олгосон.</p> <p>2019 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангасан 2 ажил олгогчтой ажил олгогчийн урамшууллын гэрээг байгуулсан. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд 4 малчин ажил олгогчтой гэрээ байгуулсан. Малчин ажил олгогчийн урамшууллыг 11 дүгээр сард олгохоор ажиллаж байна.</p> <p>1-р курсийн 31 суралцагч 10 аж ахуйн нэгж дээр танилцах, 1 жилийн 207 суралцагч 15 аж ахуйн нэгж дээр төгсөлтийн өмнөх, 2-р курсийн 31 суралцагч 15 аж ахуйн нэгж дээр үйлдвэрлэлийн, 2.5-р курсийн 21 суралцагч 11 аж ахуйн нэгж дээр төгсөлтийн өмнөх, 1 жилийн ангийн 275 оюутан үйлдвэрлэлийн дадлага хийж байна.</p>	70
		102	1.5.2.1. Жил бүр 1500-аас доошгүй ажлын байр бий болгох	2016-2020	ХХҮГ, МСҮТ, СЗДТГ	6000-аас доошгүй ажлын байрыг бий болгож, хүн амын ажилгүйдлийг бууруулсан байна.	<p>2016-2020 онд аймгийн хэмжээнд 6000-аас доошгүй ажлын байрыг бий болгох зорилт тавьж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлснээр 2016-2019 онд нийт 1714 ажил олгогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 5550 иргэнийг байнгын болон улирлын чанартай ажлын байранд зуучлан ажиллалаа. Ажлын байрыг төрлөөр нь ангилан үзвэл: байнгын ажлын байранд 2594, улирлын ажлын байранд 1459, түр ажлын байранд 1497 иргэн зуучлагдаж ажилтай орлоготой болсон байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хүрээнд 2770 ажлын байр бий болсноос, байнгын 775, улирлын 89, түр ажлын байр 1906 байна. Аймгийн хэмжээнд 2017-2019 онд нийт 8320 ажлын байр бий болсон байна. Үүнээс: байнгын 3369, улирлын 1548, түр 3403 болсон байна. Үүний үр дүнд хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2016 оны мөн үеэс 8.0 хувиар өсөж, ажилгүйдлийн түвшин 2.1 хувиар буурч 5.4 хувьд хүрлээ.</p>	100

103	1.5.2.2. Хоршоо, нөхөрлөл, фермерийн аж ахуй эрхлэх, хуримтлалын бүлэг байгуулахад дэмжлэг үзүүлэх	2016-2020	ХХҮГ, ХХААГ, СЗДТГ, бусад төсөл хөтөлбөрийн байгууллагууд	Хоршоо, нөхөрлөл, фермерийн аж ахуй эрхлэх, хуримтлалын бүлгүүдийн тоо, өрхийн амжиргаа, өрхийн орлого нэмэгдсэн байна.	2017 онд ХЭДС-ийн “Жижиг зээл олгох” арга хэмжээний хүрээнд иргэн Г.Цэрэн үхрийн фермийн аж ахуй эрхлэх төсөлд 20.0 сая, “Наран-Энх” ХХК-ийн тахианы аж ахуйн төсөлд 20.0 сая, 2018 онд Рашаант сумын “Хүрэл шанд”, “Хайлаастайн худаг” хоршооны төсөлд тус бүр 20.0, Бүрэгхангай, Хутаг-Өндөр, Булган сумын үхрийн фермер төсөлд 60.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. “Mercy corps” олон улсын байгууллагатай хамтран “Махны гинжин холбоог сайжруулах” хөтөлбөрийн хүрээнд Залуучуудын “Гарааны бизнес”-ийн сургалтад хамруулан, Start up арга хэмжээг зохион байгуулж шалгарсан Сэлэнгэ сумын Э.Ням-Осор ахлагчтай багийн “Үхрийн ангилж савласан мах” төсөлд 5.0 сая төгрөгийг /эргэн төлөгдөх нөхцөлгүй/ олгосон. 2016-2019 онд 28 иргэнд гахай, шувуу, зөгийний аж ахуй эрхлэх чиглэлээр 61.0 сая төгрөгийг олгосон бол Хоршоо нөхөрлөлийг дэмжих чиглэлээр 4 хоршоонд 80.0 сая, фермерийн аж ахуй эрхлэх чиглэлээр 4 аж ахуйн нэгжид 80.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Санхүүгийн дэмжлэгийн хүрээнд 54 шинэ ажлын байр бий болсон байна. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хүрээнд “Хүлэмжийн аж ахуй”, “Зөгийн аж ахуй”, “Тахианы аж ахуй” эрхлэх чиглэлээр 5.5 сая төгрөгөөр, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр” эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний “Шувууны аж ахуй”, “Хүлэмжийн аж ахуй” эрхлэх чиглэлээр 3 төслийг 4.5 сая төгрөгөөр тус тус дэмжин санхүүжилтийг олгох гэрээ байгуулан ажиллаж байна.	100
104	1.5.2.3. Орон нутгийн нөөц бололцоо, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн түр болон улирлын ажлын байраар хангах, ажилгүй болон ажил олоход хүндрэлтэй иргэдийг ажиллуулах, ажилд зуучлах	2016-2020	ХХҮГ, ХХААГ, СЗДТГ, бусад төсөл хөтөлбөрийн байгууллагууд	Ажилгүй иргэдийн 50-аас доошгүй хувийг нийтийг хамарсан ажилд оролцуулж өрхийн орлогыг нэмэгдүүлсэн байна.	2016-2019 онд нийт 2680 иргэнийг ажилд зуучлах зорилт тавин ажиллаж, өнөөдрийн байдлаар нийт 3743 иргэнийг ажилд зуучилсан байна. Нийт ажилд зуучлагдсан иргэдийн 61.0 хувь нь буюу 2307 иргэнийг байнгын ажлын байранд, 16.3 хувь буюу 612 иргэнийг улирлын ажлын байранд, 22 хувь буюу 824 иргэнийг түр ажлын байранд зуучлан оруулжээ. Мөн улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж буй бүтээн байгуулалтын ажилд зорилтот бүлгийн болон ажил идэвхтэй хайгч иргэдийг зуучлахад анхаарч, 78 тендерийн ажилд давхардсан тоогоор 1200 гаруй иргэнийг түр болон улирлын ажлын байраар хангасан байна.	70
105	1.5.2.4. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж худалдан авахад дэмжлэг үзүүлэх	2016-2020	ХХҮГ, ХХААГ, СЗДТГ, бусад төсөл хөтөлбөрийн байгууллагууд	Жижиг бизнес эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэн инкубатор төвийн тоог нэмэгдүүлсэн байна.	Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 2017 онд 55 иргэний төслийг 90.0 сая, 2018 онд 63 иргэний төслийг 114.0 сая, 2019 онд 47 иргэний төслийг 137.0 сая төгрөгөөр тус тус дэмжин, нийт 185 аж ахуйн нэгж, иргэнийг дэмжиж байнгын ажлын байрыг бий болголоо. Хөтөлбөрүүдийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хүрээнд 163 иргэнд 172.0 сая төгрөгийг олгосон. “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 12 төслийг шалгаруулан 30.0 сая төгрөгөөр дэмжиж, 13 байнгын шинэ ажлын байр бий болголоо. 2018 онд МСҮТ төгссөн залуучуудыг хувиараа хөдөлмөр эрхлэхэд нь зориулж 27.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 2017 онд 26 төслийг 33.0 сая төгрөгөөр дэмжин 28 байнгын ажлын байр, 2018 онд 396.7 сая төгрөгийн 88 төсөл ирснээс ажлын хэсгийн хурлаар 24 иргэний төслийг шалгаруулж 40.0 сая, 2019 онд 13 төслийг 32.0 сая төгрөгөөр дэмжин санхүүжилтийг олгосноор байнгын ажлын байр 55 бий болсон байна. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэдэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээл олгох арга хэмжээний хүрээнд 2017 онд 21 иргэн, аж ахуйн нэгжид үйлдвэрлэлээ өргөтгөхөд зориулж 300.0 сая, 2018 онд 51 иргэн аж ахуйн нэгжид 600.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосноор байнгын ажлын байр 148, түр ажлын байр 116-г бий болгосон. Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцсэн зорилтот төсөл шалгаруулах арга хэмжээнд ирсэн 24 төслөөс Булган сумын “Тунамал өгөөж” ХХК-ийн Их шүүдэргэний цай, Сэлэнгэ сумын иргэн Б.Батсайханы Бог будаан төслүүд шалгарч тус тус 50.0 сая төгрөгийн дэмжлэг авч байнгын 8, улирлын ажлын байр 40 бий болгох гэрээ байгуулан ажиллаж байна.	100

1.5.2 Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршоо, нөхөрлөл, өрхийн болон фермерийн аж ахуй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх замаар ажлын байр бий болгон ажилгүйдлийг бууруулна.

106	1.5.2.5. Нийгмийн зорилтот бүлгийн иргэдийг ногоон ажлын байраар хангах ажлыг зохион байгуулж, байгаль орчны чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрт хамруулах	2016-2020	ХХҮГ, ХХААГ, БОАЖГ, СЗДТГ, бусад төсөл хөтөлбөрийн байгууллагууд	Ойн нөхөрлөлийн тоо нэмэгдэж, орлого багатай өрхийн гишүүд ногоон ажлын байраар хангагдсан байна.	Нийтийг хамарсан ажлын хүрээнд 2017 онд 57 төслийг хэрэгжүүлэн 514 иргэнийг түр ажлын байраар хангаж ажлын хөлсөнд 118.6 сая, 2018 онд 55 төслийг хэрэгжүүлэн 551 иргэнийг түр ажлын байраар хангаж ажлын хөлсөнд 94.2 сая, 2019 онд 20 төслийг хэрэгжүүлэн 176 иргэнийг түр ажлын байраар хангаж ажлын хөлсөнд 32.4 сая, нийт 245.2 сая төгрөгийг олгож өрхийн орлогыг нэмэгдүүлсэн байна. Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд 2017 онд 4 сумын 40 иргэнийг 4.5, 2018 онд 4 сумын 40 иргэнийг бүлгийн зохион байгуулалтад оруулан 4.5 га-д, 2019 онд 5 сумын 41 иргэнийг бүлгийн зохион байгуулалтад оруулан төмс хүнсний ногоо тариалуулж нийт 121 иргэнийг улирлын ажлын байраар ханган өрхийн орлогыг нэмэгдүүллээ.	70
107	1.5.2.6. Баг бүрт 1.0-2.0 сая төгрөгийн "Бичил зээл"-ийн эргэлтийн санг нэмэгдүүлэх, өрхийн бичил бизнесийг дэмжих	2016-2020	ХХҮГ, ХХААГ, СЗДТГ	Багийн иргэдийн амьжиргаа дээшилж, өөрийн гэсэн эргэлтийн хөрөнгөтэй болсон байна.	Бичил зээлийн эргэлтийн сангаас 16 сум, 1 тосгоны хэмжээнд 302 иргэнд 150.0 сая төгрөгийн зээл олгосон байна. Зээлийн эргэн төлөлтийг сайжруулах зорилгоор хугацаа хэтэрсэн 90 иргэний 60.8 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлтийг Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангийн төслийн хэрэгжилт, эргэн төлөлтөд хяналт тавих ажилтай уялдуулан зохион байгуулж байна. Тус зээлийн хүрээнд гэрэээрээ өрхийн үйлдвэрлэл эрхэлж байгаа болон улирлын чанартай ажил хийж орлого олдог 300 гаруй иргэдэд дэмжлэг үзүүлсэн нь тухайн багийн иргэдийн амьжиргаа дээшлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.	70
108	1.5.2.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг хуулийн дагуу урамшуулах	2016-2020	ХХҮГ, ХХААГ, СЗДТГ	ХБИ-ийн орлого нэмэгдэж тэдний 40-50 хувь нь ажлын байраар хангагдсан байна.	2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байраар ханган ажиллуулж буй Баяннуур сумын "Хушт-Эрэг" ХХК-д 2.3, 2017 онд Сайхан сумын "Аргун номт" ХХК, Могод сумын "Эрхт түшиг" ХХК-д 2.8, 2018 онд Булган сумын "Оргил мээж" ХХК, Сайхан сумын "Атаат хайрхан" ХХК-д 5.8 сая төгрөгийг хуулийн дагуу ажил олгогчийн урамшуулалд олголоо. Үүний үр дүнд ХЭДС-2019 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг байнгын ажлын байраар хангасан 2 ажил олгогчтой ажил олгогчийн урамшууллын гэрээг байгуулан ажиллаж байна. Ажил олгогчийг дэмжих арга хэмжээний хүрээнд 9 ажил олгогчтой гэрээ байгуулан 9 иргэнийг байнгын ажлын байранд зуучлан өрхийн орлогыг нэмэгдүүлсэн. 2016-2019 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд нийт 109 иргэнийг санхүүгийн дэмжлэгт хамруулан өөрөө өөртөө ажлын байр бий болгоход нь дэмжлэг үзүүлсэн. Мөн ХБИ-ийг мэргэжилтэй болгоход зориулж сургалтын байгууллагатай хамтран 51 иргэнийг тогооч, гар урлалын чиглэлээр мэргэжил олгох сургалтад хамруулан мэргэжил эзэмшүүлж, 154 иргэнийг "Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл" сургалтад хамруулж хувиараа хөдөлмөр эрхлэх, төсөл хэрхэн бичих талаар мэдлэг олголоо.	70
109	1.5.2.8. Иргэдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор тэдний хийсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулж, худалдан борлуулах цэгийг байгуулах	2016-2020	ХХҮГ, ХХААГ, СЗДТГ	Бүтээгдэхүүнийг худалдан борлуулах цэг бий болж, үйл ажиллагаа нь эрчимжсэн байна.	Хөдөлмөр эрхлэх төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдан санхүүгийн дэмжлэг авсан болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн хийсэн бүтээгдэхүүнээс шимтгэл, байрны түрээсийг суутгалгүй анхны үнээр нь сурталчлах, худалдан борлуулах зорилгоор "Булганд үйлдвэрлэв" борлуулалтын цэгийг "Дэвшилт" ХХК-ийн байранд нээн ажиллуулж, хувиараа хөдөлмөр эрхлэгч 91 иргэний бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулж байна. Жил бүр "Намын ногоон өдрүүд", "Цагаан сар", "Халамжийг хөдөлмөр болгоё" сэдвийн дор үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид идэвхтэй оролцож ирсэн. 2019 онд "Айрагны баяр" арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгуулж, 8 сумын малчид оролцож, 54 тн айраг борлуулсан байна.	100

110	1.5.2.9. "40-өөс дээш болон ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх	2016-2020	ХХҮГ, СЗДТГ, ААХолбоо	Хөдөлмөр эрхлэх чадвартай ахмад настуудыг хамруулж, 30-аас доошгүй хувийг түр ажлын байраар ханган өрхийн амьжиргааг нь дэмжсэн байна.	2016 онд ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 60 ахмад хамрагдаж 12.0 сая, 2017 онд 51 төслийг дэмжиж 75 ахмадад 21.0 сая төгрөгөөр дэмжлэг үзүүлсэн. 2018 онд 26 ААНБ-ын захиалгаар 57 ахмад мэргэжилтнээр зөвлөгөө өгүүлж, ажлын хөлсөнд 15.9 сая төгрөг зарцууллаа. 2019 онд ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг байгууллага дээрээ авахаар 33 аж ахуйн нэгж, байгууллагаас хүсэлт ирүүлсний дагуу 44 ахмад мэргэжилтнийг ажиллуулахаар шийдвэрлэн гэрээ байгуулж, зөвлөх үйлчилгээ үзүүлж байна. 2016-2019 онд нийт 222 ахмад мэргэжилтнийг түр ажлын байраар ханган орлогыг нэмэгдүүлсэн бол 37 ахмадад тоног төхөөрөмж авах, эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа өргөтгөх, эхлэхэд нь зориулж 41.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж 37 байнгын ажлын байр бий болгосон байна. 2019 онд 33 төслийн 44 ахмадын зөвлөх үйлчилгээг 12.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр гэрээ байгуулж 9 дүгээр сарын байдлаар 29 ахмад мэргэжилтэн гэрээний дагуу зөвлөгөө мэдээллээ өгч, 8.3 сая төгрөгийн урамшуулал авлаа. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд хувиараа хөдөлмөр эрхлэгч 16 ахмадад тоног төхөөрөмж авах, эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа өргөтгөх, эхлэхэд нь зориулж 20.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон.	100
111	1.5.2.10. Ажлын байрны мэдээллийг олон нийтэд хүргэх, "Хөдөлмөрийн яармаг"-ийг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах	2016-2020	ХХҮГ, СЗДТГ	Ажилгүй иргэдийн 70-аас доошгүй хувийг ажлын байранд зуучлан бүсчилсэн хэлбэрээр "Хөдөлмөрийн яармаг"-ийг жил бүр зохион байгуулж хэвшсэн байна.	Аймгийн хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулах зорилгоор жилд 2-оос доошгүй удаа хөдөлмөрийн яармаг, үзэсгэлэн худалдааг уламжлал болгон зохион байгуулж хэвшээд байна. Тухайлбал: 2017 онд "Халамжийг хөдөлмөр болгоё" Хөдөлмөрийн яармаг, үзэсгэлэн худалдааг Булган суманд амжилттай зохион байгууллаа. Яармаг, үзэсгэлэн худалдаанд 16 сум, 1 тосгоны 122, Орхон, Хөвсгөл, Улаанбаатар зэрэг бусад аймаг хотоос 14, нийт 136 аж ахуйн нэгж, бүлэг, хоршоо, иргэдийн төлөөлөл, 120 гаруй нэр төрлийн 7053 ширхэг бараа бүтээгдэхүүнтэй оролцож, үүнээс 4599 ширхэг бараа бүтээгдэхүүнийг худалдаалж 36.2 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. 2018 оны 7, 10-р сард үзэсгэлэн яармаг зохион байгуулж, 11 сумын 112 нэр төрлийн бүтээл оролцож, 16.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. 2019 онд Цагаан сарын үзэсгэлэн худалдааг 1-р сард, "Намрын ногоон өдрүүд-Булганд үйлдвэрлэв" үзэсгэлэн яармаг арга хэмжээг 10-р сард тус тус зохион байгуулж нийт 12 сумын 50 гаруй аж ахуйн нэгж, 273 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 30.0 гаруй сая төгрөгийн борлуулалт хийжээ.	70
112	1.5.2.11. Сум бүрт орлого багатай 10-аас доошгүй малчин өрхийг жил бүр "Малжуулах төсөлд" хамруулах, малгүй иргэдийг туслах аж ахуй эрхлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах	2016-2020	ХХҮГ, СЗДТГ	Малчин өрхийг малжуулан, ажлын байраар хангасан байна.	Малжуулах арга хэмжээнд 2017 онд 42 малчин өрхийг хамруулж 2890 толгой малыг 190.0 сая, 2018 онд 49 өрхийг хамруулж, 4105 толгой малыг 224.0 сая төгрөгөөр худалдан авч өглөө. 2018 оноос аймгийн төсвөөс 25 малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хамруулж, нийт 2732 толгой малыг 125.0 сая төгрөгөөр авч өглөө. 2019 онд 16 сум, 1 тосгоны 45 малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хамруулж 201.0 сая төгрөгийн санхүүжилтээр адуу 19, үхэр 141, хонь 1740, ямаа 1290, нийт 3190 толгой мал олгожээ. 2017-2019 онд малжуулах хөтөлбөрийн хүрээнд 922.0 сая төгрөгөөр 15000 гаруй толгой мал худалдан авч 16 сум, 1 тосгоны 226 малчин өрх буюу 452 иргэнийг малжуулан өрхийн орлогыг нэмэгдүүлсэн байна. Эдгээр 452 залуу малчдад "Малчид бизнест бие даан суралцах нь" аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт, арга хэмжээг зохион байгуулж, мэдлэгийг дээшлүүлээ.	100

113	1.5.3.1. Ажил олгогчийг дэмжих чиглэлээр хамтран ажиллаж, уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулах	2016-2020	АЗДТГ, ХХҮГ, ХХААГ, АОЭХ, СЗДТГ		10-аас доошгүй аж ахуйн нэгж байгууллага, 20-оос доошгүй иргэнийг тус чиглэлд хамруулсан байна.	Ажил олгогчдыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраар дамжуулан ажилтан авдаг болгох зорилгоор 2017 онд Улаанбаатар хотын мэргэжлийн эрх бүхий байгууллагатай хамтран аймгийн хэмжээний уулзалт, сургалт зохион байгуулж, 54 ажил олгогчийг хамруулсан. Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны 30 жилийн ойн хүрээнд Аймгийн “Ажил олгогчийн зөвлөгөөн”-ийг 2020 онд зохион байгуулахаар талууд хамтран зөвшилцөж, төсөв төлөвлөгөөг боловсруулаад байна.	40
114	1.5.3.2. Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт хэлэлцээрийн хэрэгжилтийг сайжруулж, салбар хороодын үйл ажиллагааг эрчимжүүлэх, дэмжлэг тусалцаа үзүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХҮГ, ХХААГ, ЭМНДХ, АОЭХ, СЗДТГ		3 талт салбар хороонд тодорхой хэмжээний төсөв хөрөнгө батлагдаж, үйл ажиллагаа нь бэхжсэн байна.	“2017-2018 оны аймгийн хөдөлмөр нийгмийн зөвшлийн 3 талт хэлэлцээр”-ийг 84 хувьтай амжилттай хэрэгжүүллээ. Тус хэлэлцээрийн хүрээнд аймгийн хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт салбар хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, 150 төлөөлөгчийг хамрууллаа. 2017 онд ХНХЯ-аас санаачлан Дархан-Уул аймагт зохион байгуулсан хойд бүсийн чуулга уулзалтад аймгийн 3 талын 8 төлөөлөл, Сэлэнгэ аймагт зохион байгуулсан 5 аймгийн бүсийн зөвлөлдөх уулзалтад салбар хорооны 6 төлөөлөл оролцож, мэдлэг мэдээллээ дээшлүүллээ. 2018 онд аймгийн салбар хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж сум, байгууллагын 40 төлөөлөл хамрагдлаа. 2019 онд ХНХЯ, МАОЭНХ, МҮЭХ-той хамтран 5 аймгийн хойд бүсийн “Хөдөлмөр эрхлэлт-Нийгмийн түншлэл” зөвлөгөөнийг аймагтаа зохион байгууллаа. Зөвлөгөөнд аймгийн 3 талт салбар хорооны 11 гишүүн хамрагдаж, “Ажилгүйдэл ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр”, “Хөдөлмөр эрхлэлт-нийгмийн түншлэл”, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд ажилтны байгууллагуудын үүрэг оролцоо, цаашдын зорилт зэрэг сэдвүүдийн хүрээнд илтгэл, мэдээлэл сонслоо.	100
115	1.5.3.3. Хөдөлмөр эрхлэхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавихад төр, хувийн хэвшил, нийгмийн түншлэлийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулах, хөдөлмөр эрхлэх болон бусад чиглэлээр байгуулагдсан аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүнд ИНБ-ын төлөөлөл оролцуулан, хамтран ажиллах	2016-2020	АЗДТГ, ХХҮГ, ХХААГ, АОЭХ, СЗДТГ		Зөвлөлүүдийн бүрэлдэхүүнд төлөөлөл оролцуулан хамтран шийдвэр гаргана.	Аймгийн ХАБЭА-н зөвлөл болон хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг төр, ажил олгогч, үйлдвэрчний төлөөллийн бүрэлдэхүүнтэйгээр 2019 онд шинэчлэн байгууллаа. Жил бүрийн 4-р сард уламжлал болгон зохион байгуулагддаг ХАБЭА-н сарын аяны хүрээнд 3 талын төлөөлөл хамтран давхардсан тоогоор 600 гаруй аж ахуйн нэгж байгууллагад үзлэг шалгалт хийж, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авсан байна. 3 талт хэлэлцээрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 2019 онд 1,5 сая төгрөг төсөвлөн сургалт, мэдээлэл, туршлага судлах аяллыг зохион байгууллаа. 2019 онд хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн хуралдааныг 1 удаа, ХАБЭА-н аймгийн салбар зөвлөлийн хуралдааныг 2 удаа тус тус хуралдуулж, 2019-2020 онд хэрэгжих төсөл хөтөлбөрийн талаар болон ХАБЭА-н сарын аяны хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө, 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүллээ. ХАБЭА-н сарын аяны хүрээнд үзлэг, шалгалт, зөвлөн туслах чиглэлээр Баяннуур, Дашинчилэн суманд хамтран ажиллалаа.	100

1.5.3 Хөдөлмөрийн харилцааны хэрэгжилтийг ханган ажиллаж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэн нийгмийн түншлэлийг хөгжүүлнэ.

116	1.5.3.4. “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн аймгийн дэд хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, үзлэг шалгалтыг жил бүр зохион байгуулах, дүгнэх	2016-2020	АЗДТГ, НБХ, ХХҮГ, ЭМГ, МХГ, ЭМНДХ, АҮЭХ, АОЭХ, СЗДТГ		Үйлдэрлэлийн болон ажлын байран дахь осол гэмтлийн тоо буурч эрүүл аюулгүй ажлын байрны тоо нэмэгдэнэ.	<p>“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн аймгийн дэд хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үзлэг шалгалтыг жил бүр зохион байгуулж байна. ХАБЭА-н сарын аяны үйл ажиллагааг эрчимжүүлж, олон нийтэд ил тод хүртээмжтэй байх зорилгоор 2017 оноос аймгийн Засаг даргын захирамжаар холбогдох талуудын төлөөллийг оролцуулан “Мэргэжлийн баг”-ийг байгуулан сум, аж ахуйн нэгж байгууллагад 3 тал хамтран үзлэг шалгалтыг зохион байгуулж хэвшсэн. 2017 онд сарын аяны хүрээнд 6.0 сая төгрөг зарцуулан сургалт, мэдээлэл, хэлэлцүүлэг, үзүүлэх сургууль зэрэг арга хэмжээг зохион байгууллаа.</p> <p>2018 онд “Залуучуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдэвт сарын аяныг өрнүүлж, 180 гаруй аж ахуйн нэгж байгууллагад үзлэг шалгалт хийж хуулийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор илтгэлийн уралдаан, “Дэвжээ” тэмцээн, шилдэг байгууллага шалгаруулах зэрэг томоохон арга хэмжээг зохион байгууллаа. Үүнээс гадна аймгийн хэмжээнд хөнгөн үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байгаа ажиллагсдын ХАБЭА-н асуудалд үзлэг шалгалтыг гурван талын төлөөлөл хамтран зохион байгуулж, 21 аж ахуйн нэгж байгууллага, 7 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.</p> <p>2019 онд “Эрүүл, аюулгүй ирээдүйн хөдөлмөрийн төлөө” сэдэвт сарын аяныг явуулж Улаанбаатар хотын “МОШПА” Монголын мэргэшсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбоо ТББ-тай хамтран “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”-н сургалтыг зохион байгуулж, 60 ажилтныг хамруулж, мэдлэг мэдээллээр хангалаа.</p> <p>2016-2019 онд жил бүр 10,0 сая төгрөгөөр сургалт явуулах эрх бүхий ААНБ-тай хамтран ХАБЭА-н чиглэлээр Булган суманд 4 удаа, Бүрэгхангай, Хутаг-Өндөр суманд сургалт зохион байгуулж, нийт 700 гаруй даатгуулагч иргэн, тариаланч, бичил уурхай эрхлэгчийг хамрууллаа.</p> <p>Үйлдвэрлэлийн болон ажлын байран дахь осол гэмтлийн тоо аймгийн хэмжээнд 2017 онд 8 тохиолдол, 2018 онд 1 тохиолдол байна.</p> <p>2019 онд үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа хариуцсан байцаагч аймгийн төвийн ААН байгууллагын 70 хувьд буюу 2500 орчим даатгуулагчийг хамруулан сургалт зохион байгуулсан. Сургалтын үр дүнд ҮОМШӨ-ний тоо буурч, сангаас авах тэтгэвэр тэтгэмж буурсан үзүүлэлттэй байна.</p>	100
117	1.5.3.5. Байгууллага, аж ахуйн нэгжүүдэд “Бүтээмжийн хөдөлгөөн” өрнүүлж, шинэ санал, санаачлагыг дэмжиж ажиллах	2016-2020	АЗДТГ, НБХ, ХХҮГ, АОЭХ, СЗДТГ		Байгууллага, аж ахуйн нэгжүүдийн ажлын байрны эмх цэгц сайжирч, бүтээмж нэмэгдсэн байна.	<p>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад “Хөдөлмөрийн бүтээмж, түүнийг хэрэгжүүлэх тулгуур асуудлууд”, “Кайзен саналын систем”, “Бүтээмж чанарын дугуйлан”, “Бүтээмж-Инноваци”, “Байгууллагын инновацийн үйл ажиллагаа”, “Суралцагч байгууллага” зэрэг сэдвээр шат дараалсан сургалт, мэдээллийн ажлыг тогтмол зохион байгуулж, 2017-2019 онд нийт 10 сумын 26 байгууллагын давхардсан тоогоор 1658 ажилтнуудыг хамрууллаа.</p> <p>Баяннуур сум, ХАА-н МСҮТ, Эрүүл мэндийн газар, Булган сумын Соёлын ордон, УЦУОША зэрэг байгууллага бүтээмжийн хөдөлгөөнийг идэвхтэй өрнүүлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн үр дүнд хүрч байна.</p> <p>2018 онд бүтээмжийн хөдөлгөөнийг эрчимжүүлэх, байгууллагуудын санал санаачлагыг өрнүүлэх зорилгоор “Хангайн бүсийн бүтээмж, хөгжлийн төв”-тэй хамтран “Хөдөлмөрийн бүтээмж тооцох аргачлал” сэдвээр “Булган-Мээж” ХХК, “Булган-АЗЗА” ТӨХК-д сургалт зохион байгуулан 66 ажилтан албан хаагчийг хамрууллаа.</p> <p>2019 онд аймгийн хэмжээнд хөдөлмөрийн бүтээмжийн 2 сарын аяныг 09-11 дүгээр сард өрнүүлэн ажиллаж байна.</p>	70

		118	1.5.3.6. Аймгийн “Цалин хөлсний үзлэг”, ХАБЭА-н болон бусад үзлэг, шалгалт, зөвлөн туслах үйл ажиллагаа, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах	2016-2020	АЗДТГ, НБХ, ХХҮГ, ЭМГ, МХГ, НДХ, АҮЭХ, АОЭХ, СЗДТГ		Нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагуудад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй цалин хөлс олгож хэвшин, ажлын байрны эмх цэгц сайжирч ажиллах орчин эрүүл аюулгүй болсон байна.	Жил бүрийн 4 дүгээр сард аймгийн Засаг даргын захирамжаар ХАБЭА-н сарын аяныг уламжлал болгон зохион байгуулж, давхардсан тоогоор 600 гаруй аж ахуйн нэгж байгууллагад үзлэг шалгалт хийж, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авсан. Аяны хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, олон нийтэд ил тод хүртээмжтэй байх зорилгоор холбогдох талуудын төлөөллийг оролцуулан “Мэргэжлийн баг” байгуулан сум, аж ахуйн нэгж, байгууллагад 3 тал хамтран үзлэг шалгалтыг зохион байгуулж хэвшлээ. Үүний дүнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжих нөхцөл бүрдэж байна. 2018 онд ХАБЭА-н болон цалин хөлсний талаарх 11 асуулгын дагуу 186 аж ахуйн нэгж байгууллагад цалин хөлсний үзлэг зохион байгуулж, дүгнэлт гаргасан.	70
Нийгмийн халамж, хамгаалал, хүүхэд гэр бүл:									
		119	1.5.4.1. ХХҮГ-ын харьяа сувиллын яслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, шаардлагатай зарим техник, тоног төхөөрөмжөөр хангах	2016-2020	АЗДТГ, НБХ, ХХҮГ, СЗДТГ		Сувиллын яслийн үйлчилгээг өргөжүүлэн, зуны сургалт явуулах боломжийг бий болгосон байна. Яслийн зарим ангиудыг тоглоомоор хангасан байна.	Сувиллын яслид зорилтот бүлгийн 41 хүүхэд хүмүүжиж байгаа бөгөөд хүүхдийн нас, биеийн хөгжлийн онцлогт тохируулан чийрэгжилтийн ажлын төлөвлөгөөг боловсруулан, хүүхэд нэг бүрт хүрч ажиллаж байна. Яслийн ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангах зорилгоор 40 хүүхдийн хувцас хадгалах 1.1 сая төгрөгийн үнэ бүхий шүүгээ, гал тогоонд ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад нийцэхүйц ариутгалын тусгай хэрэгслийг 242.5 мянган төгрөгөөр авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн Орхон аймгийн улсын тэргүүний 7, 22 дугаар цэцэрлэгт багш ажилчдыг туршлага судлуулсан. Хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцүүлж, хүүхэд хөгжлийн 80 гаруй бүтээлийг шинээр хийж, сургалт хүмүүжлийн ажилд хэрэглэж байна. Хүүхдийн сурч хөгжих таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гаднах талбайг цутгаж, зам талбайг ашиглалтад орууллаа. 2017-2019 онд тус сувиллын үйл ажиллагааг дэмжин бүтээн байгуулалтын ажилд 13.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, тохижилтын ажлыг гүйцэтгэлээ.	100
		120	1.5.4.2. Асран хамгаалагчгүй, ганц бие өндөр настан, орон гэргүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг орон байраар хангах, төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах, амралт сувилалд хэвтэн эмчлүүлэхэд тусалцаа үзүүлэх	2016-2020	АЗДТГ, НБХ, ХХҮГ, СЗДТГ		Жилд 3-аас доошгүй иргэнийг нийгмийн асрамжийн төрөлжсөн үйлчилгээнд хамруулсан байна.	Нийгмийн халамжийн хуулийн дагуу зорилтот бүлгийн 2778 ахмад настныг амралт, рашаан сувилалд амраан сувилуулж, 467.1 сая төгрөгийн хөнгөлөлтийг цаг хугацаанд нь түргэн шуурхай олгосон байна. 2016-2018 онд төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн гараагүй. 2019 онд Булган, Могод сум, Хялганат тосгоны харж хандах үр хүүхэдгүй ганц бие 3 ахмад настныг Хөвсгөл аймгийн төрөлжсөн асрамжийн газарт хүргэх ажлыг зохион байгуулж, орон нутгаас 756.6 мянган төгрөг зарцуулсан. 2019 онд “Ахмадын хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын хүрээнд орон гэргүй зорилтот өрхийн 6 ахмад настны орон гэрийн нөхцөлийг сайжруулах, гэрээр хангах ажлыг зохион байгуулж орон нутгийн төсвөөс нийт 3.5 сая төгрөгийг зарцууллаа. Мөн 10 гаруй ахмад настныг амралт сувиллын газар үнэ төлбөргүй амраалаа.	100

1.5.4 Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн халамж, асрамжийн үйлчилгээг өргөжүүлэн, тэдэнд зориулсан үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

121	1.5.4.3. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын чиглэлээр эрх нь зөрчигдсөн иргэдийг хамгаалах “Хүчирхийллээс хамгаалах түр байр”-ны зардлыг шийдвэрлэж, дэмжлэг үзүүлэх	2016-2020	НБХ, ГБХЗХХ, СЗДТГ	Байрны урсгал зардлын асуудлыг шийдвэрлэж, дэмжлэг үзүүлэн иргэд ая тухтай үйлчлүүлэх орчин нөхцөлийг сайжруулсан байна.	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 06/07 тогтоолоор Хүчирхийллээс хамгаалах түр байранд ажиллах нийгмийн ажилтан 1, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх танхимд ажиллах сэтгэл зүйч 1, нийт 2 ажилтны цалин болох 13.0 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байранд 2016 онд 3 насанд хүрэгч, 5 хүүхэд, 99 ор хоног, 2017 онд 3 насанд хүрэгч, 16 хүүхэд 101 ор хоног, 2018 онд 6 насанд хүрэгч, 15 хүүхэд 121 ор хоног, 2019 оны 09 сарын байдлаар 3 насанд хүрэгч, 23 хүүхэд 127 ор хоногийн үйлчилгээ аваад байна. Түр хамгаалах байрны дэргэд үйлчлүүлэгч болон иргэдэд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх төвийг байгуулж, 2018 онд 34 хүүхэд, 55 насанд хүрэгчид 130 цагийн үйлчилгээ, 2019 оны 9 сарын байдлаар ганцаарчилсан зөвлөгөөг 34 үйлчлүүлэгчид 74 цаг, бүлгийн ярилцлагаар 115 хүүхдэд 12 цагийн үйлчилгээг хүргээд байна. Тус байрыг шинээр барих зорилгоор Австралийн элчин сайдын яамнаас зарласан бичил төслийн сонгон шалгаруулалтад оролцож, 18.8 мянган австрали долларын дэмжлэгийг авахаар боллоо. 2018-2019 онд тус хамгаалах байрны орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор ариун цэврийн өрөөг шинээр засан тохижуулж бойлуур, угаалгын машин шинээр авч үйлчлүүлэгчдийн эрүүл ахуйн нэн тэргүүний хэрэгцээг хангалаа.	100
122	1.5.4.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд зориулсан чөлөөт цагаа өнгөрөөх нийгэмшүүлэх, сэргээн засах эмчилгээ сувилгааны зориулалтаар “Хөгжлийн төв” байгуулах	2016-2020	ХХҮГ, АХБИХолбоо, СЗДТГ	“Хөгжлийн төв”-ийг байгуулж, 20-оос доошгүй байнгын асаргаа шаардлагатай хүүхдүүдийг хамруулсан өдөр өнжүүлэх ажиллаж, ХБИ-ийн 60-аас доошгүй хувь нь тус төвөөр үйлчлүүлж хэвшсэн байна.	“Дэлхийн Зөн” олон улсын байгууллагын санхүүжилтээр баригдсан Булган суманд байрлах “Хүний хөгжлийн төв”-ийн барилгыг засварлан, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд”-ийн нөхөн сэргээх, нийгэмшүүлэх өрөө танхимыг байгуулж, 12 хүүхэд тус төвөөр үйлчлүүлж байна. 2019 оны эхний улиралд хүүхдүүдийн асран хамгаалагч нартай 2 удаа уулзалт зохион байгуулж, үйл ажиллагааны талаар танилцуулж, санал хүсэлтийг сонсож үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр тус төвд хүмүүжиж байгаа 12 хүүхдэд аймгийн Засаг дарга гарын бэлэг гардуулж, 1.5 сая төгрөгийн тоглоом өгсөн. Булган аймгийн хэмжээнд байнгын асаргаа шаардлагатай 156 хүүхэд байна. 2019 онд 33 хүүхдийн байнгын асаргааны мөнгөн тэтгэмжийг сунгаж, шинээр 22 хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоон, 6 хүүхдийг СӨБ-д, 9 хүүхдийг ЕБС-ийн тусгай ангид суралцуулах талаар мэдээлэл арга зүйн зөвлөгөө өгсөн. Өмнөх онтой харьцуулахад байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн тоо 1.3%-иар буурсан үзүүлэлттэй байна.	100
123	1.5.4.5. Ахмадуудад зориулсан эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн цогц үйлчилгээний геронтологийн нэгжийг байгуулах	2016-2020	ХХҮГ, ААХолбоо, ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, СЗДТГ	“Геронтологийн нэгж”-ийг байгуулж, аймгийн ахмад наснуудын 80-аас дээш хувийг хамруулан үйлчилгээ үзүүлсэн байна.	Ахмадуудад зориулсан эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн цогц үйлчилгээний геронтологийн нэгжийг байгуулах зорилт тавин “Ахмадын өргөө” барихаар газрын асуудлыг шийдвэрлэн барилгын зураг төсвийг хийж бэлэн болголоо. Тус өргөөг барих хөрөнгийн эх үүсвэр 800.0 сая төгрөгийг 2020 оны улсын төсөвт тусууллаа.	70

124	1.5.4.6. Ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулж, амралт сувиллын хүчин чадлыг нэмэгдүүлэн засвар үйлчилгээг хийж, шаардлагатай зарим тоног төхөөрөмжөөр хангах	2016-2020	ХХҮГ, ААХолбоо, СЗДТГ	Ахмадын амралт сувиллын орны тоог 40-50 хувиар нэмэгдүүлж, сэргээн засах техник тоног төхөөрөмжөөр 70-аас дээш хувиар хангасан байна.	ХХҮГ-ын харьяа Ахмадын амралтын барилгад 19.6 сая төгрөгийн засвар үйлчилгээг хийж, ахмад настуудын амрах таатай орчин нөхцөлийг бүрдүүллээ. Тус амралтын үйлчилгээний чанар, хүртээмжид онцгой анхаарч жилдээ 500-550 амрагч хүлээн авах төлөвлөгөөтэй ажиллан амрагчийн тоо 2016 онтой харьцуулахад 38.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт 1795 ахмад настныг амраан сувилж, нийгмийн халамжийн сангаас 279.5 сая төгрөг төвлөрүүлсэн. 2018 онд амралтын хүчин чадлыг нэмэгдүүлж, нэг ээлжинд 40 хүртэлх хүн хүлээн авах нөхцөлийг бүрдүүлж, амралтын үйчилгээг сайжруулах зорилгоор хөдөлгөөн засал, бариа заслын тоног төхөөрөмжийг шинээр авч тохижуулсан. Амрагч ахмадуудын эрүүл мэнд, бие бялдарын онцлог хэрэгцээнд тулгуурлан чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх боломжийг нэмэгдүүлэн шинээр ширээний теннисний иж бүрэн хэрэгсэл, чийрэгжүүлэлтийн болон хаш чулуун эмчилгээний тоног төхөөрөмжтэй болгож эмчилгээ сувилгаа хийж байна. Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэгтэй хамтран амрагч ахмадуудад 3 удаагийн үзлэг оношилгоог хийж, эрүүл мэндийн чиглэлээр зөвлөгөө мэдээллээр хангах ажлыг зохион байгуулсан. 2019 онд "Ахмадын хөгжлийг дэмжих жил"-ийн ажлын хүрээнд 1.2 сая төгрөгийн санхүүжилтээр эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангалаа.	100
125	1.5.4.7. Ахмад настны нийгмийн хамгааллын хуулийн хэрэгжилтийг ханган, албан газар аж ахуйн нэгж байгууллага бүр ахмадын сан байгуулах, харьяалалгүй байгаа ахмад настуудыг албан байгууллага аж ахуйн нэгжүүдэд харьяалуулах ажлыг шат дараатайгаар зохион байгуулах	2016-2020	ХХҮГ, Холбогдох аж ахуйн нэгж байгууллагууд, ААХолбоо, СЗДТГ	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын 80-аас дээш хувь нь "Ахмадын сан"-тай болж ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор зарцуулж хэвшсэн байна. Аймгийн хэмжээнд харьяалалгүй байгаа нийт 400 гаруй ахмад настны 70-аас дээш хувийг албан байгууллагад харьяалуулсан байна.	Аймгийн хэмжээнд харьяалалгүй ахмад настны судалгааг /нийт 1071/ гаргаж, эдгээр ахмадын 70-аас доошгүй хувийг аль нэг байгууллагад харьяалуулах ажлыг зохион байгуулан холбогдох байгууллагуудад албан бичиг хүргүүлсэн. Жил бүрийн сар шинийн баярыг угтаж, харьяалалгүй ахмадуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулж, 2017-2019 онд давхардсан тоогоор 2700 гаруй ахмад настныг хүлээн авч хүндэтгэл үзүүлээ. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор "Ахмадын сан" байгуулах журам шинэчлэгдэн батлагдсантай холбоотой байгууллагын дарга, эрхлэгч, нягтлан бодогч нарт АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэстэй хамтран 119 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулан сургалт мэдээллийн ажлыг зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд 79 байгууллага ахмадын сан байгуулж, 85.8 сая төгрөгийг төвлөрүүлэн ахмад настуудынхаа нийгмийн хамгааллыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнд зарцуулж байна.	70
126	1.5.4.8. "Хүүхэд залуучуудын хөгжлийн төв"-ийг байгуулан, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн ажиллах	2016-2020	АЗДТГ, НБХ, ГБХЗХГ, СЗДТГ	"Залуучуудын хөгжлийн төв"-тэй болсон байна. Тус төвийн урсгал зардлыг шийдвэрлэн тогтмол хэвийн үйл ажиллагаатай болсон байна.	2016 онд ДЗМОУБ-аас "Хүний хөгжлийн төв"-ийн барилгыг хүлээн авч хүүхэд залуучуудын хөгжлийн төв болгосон. Барилгын тогтмол зардлыг 2018 оны улсын төсөвт тусгуулж тус оны 1 сараас үйл ажиллагааг нь эхлүүлээд байна. Ордны дотоод засварыг байгууллагын нөөцөд тулгуурлан 1.3 сая төгрөгөөр засварлаж, залуучуудын хөгжлийн төвийн сургалтын танхимыг 6.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангаж тохижууллаа. 2019 оны улсын төсвийн 57.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барилгын гадна пасад засвар, цонх солих ажлыг "Сувдан элс" ХХК-аар гэрээлэн гүйцэтгүүлж улсын комисс хүлээн аваад байна. 2018 онд тус төвийн хүүхдийн дугуйлангуудад 54 хүүхэд тогтмол хамрагдаж, төв номын сангийн салбараар 1713 уншигч үйлчлүүлж, залуучуудын хөгжлийн төв 7514 залуучуудад хүрч ажилласан бол 2019 онд тус ордонд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн "Итгэл" өдөр өнжүүлэх төв, дуу хөгжим, морин хуурын дугуйлан, хүүхдийн парламент, хичээлүүдийн гүнзгийрүүлсэн дамжаа зэрэг хүүхэд хөгжлийн үйл ажиллагаа тогтмол явагдаж байна.	100

26	1.5.5 Нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээг өргөжүүлж, мэдээллийн нэгдсэн системийг боловсронгуй болгон иргэдэд хүндрэл чирэгдэлгүй хөнгөн шуурхай үйлчлэх нөхцлийг бүрдүүлнэ.	127	1.5.5.1. Зорилтот бүлгийн иргэдэд хуулийн дагуу нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамжийн үйлчилгээнүүдэд хамруулж, цаг хугацаанд нь хөнгөн шуурхай үйлчлэх	2016-2020	АЗДТГ, ХХҮХГ, ЭМНДХ, СЗДТГ	Иргэдэд тэтгэвэр, тэтгэмжийг хөнгөн шуурхай олгож хэвшсэн байна.	Нийгмийн халамжийн сангаас нийт 89499 иргэнд 26.1 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламж үзүүлсэн байна. Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 2016 онтой харьцуулахад 36.9 хувиар өссөн нь Засгийн газрын 2017 оны 31 дүгээр тогтоолоор ахмад настнуудад насны хишиг олгох журам батлагдсан, Засгийн газрын 2017 оны 340 дүгээр тогтоолоор "Олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох журам" зэрэг хууль тогтоомжууд шинэчлэгдэн батлагдсантай холбоотой юм. Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/13 тоот тушаалаар хүнсний эрхийн бичгийн босго оноо сум орон нутагт 310.0 болж шинэчлэгдсэний дагуу халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдийн тоо болон төсөв өссөн үзүүлэлттэй байна. Сар бүрийн 15-ны өдрийн дотор тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт тусламжийг олгож хэвшсэн. Зорилтот бүлгийн иргэдийн эрүүл мэндийн даатгалын программ шинэчлэгдсэнтэй холбогдон иргэдийн мэдээллийн баазад регистрийн дугаараар хайн улирал бүр ЭМД-ыг ногдуулан баталгаажуулсан. Тус сангаас олгох тэтгэврийг сар бүрийн 1-ний өдөр олгож хэвшсэн. Жилд ойролцоогоор 9800 гаруй тэтгэвэр авагчид 28.5 тэрбум төгрөгийн тэтгэврийг олгоод байна. Тэтгэмжийг сар бүрийн 15, 25-ны өдрийн дотор олгож хэвшлээ. Нийт 1800 гаруй даатгуулагчдад дунджаар 980.0 сая төгрөгийн тэтгэмжийг зарцуулж байна. 2018 оноос эхлэн тэтгэвэр тогтоох процесст өөрчлөлт орж, тэтгэврийн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх байцаагч, олголт хариуцсан байцаагч гэсэн 2 орон тоотойгоор тэтгэвэр тогтоох үйл ажиллагааг явуулж байна. Ингэснээр тэтгэвэр тогтоолох хугацаа 5-14 хоног болж багассан.	100
		128	1.5.5.2. Малчид болон албан бус секторт хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлж, сургалт, мэдээллийн ажлыг тогтмолжуулах	2016-2020	ЭМНДХ, СЗДТГ	Сайн дурын даатгуулагчийн тоог аймгийн эдийн засгийн идэвхтэй хүн амын 20 хувьд хүргэх, малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг 30-35 хувьд хүргэх, ЭМД-д даатгуулагчийн тоог суурин хүн амын 90 хувьд хүргэх	2016 онд нийт 7639 даатгуулагчийн 9.5 тэрбум төгрөгийн сайн дурын даатгалын шимтгэлийг төвлөрүүлж, үүнээс 3129 даатгуулагчийг шинээр хамруулснаар өмнөх оноос 69.4 хувиар өссөн. 2017 онд нийт 5073 даатгуулагч сайн дурын даатгалд хамрагдаж 9.7 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлогыг бүрдүүлж, шинээр 708 иргэнийг сайн дурын даатгалд хамрууллаа. Үүнд: 2708 малчин, 598 хувиараа хөдөлмөр эрхлэгч даатгуулагч хамрагдсан байна. 2018 онд нийт 4442 сайн дурын даатгуулагчийн 9.4 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, 952 даатгуулагчийг шинээр хамруулсны 600 нь малчин, 352 нь хувиараа хөдөлмөр эрхлэгч байна. 2019 оны 3-р улирлын байдлаар 3941 даатгуулагч сайн дурын даатгалд хамрагдаж 8.5 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн. Үүнээс малчин 2107, хувиараа хөдөлмөр эрхлэгч 302 хамрагдсан байна. Сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор "Сайн дурын даатгалд хамруулах" аяныг зохион байгуулж, байцаагчдын дунд болзолт уралдаан зарлан ажиллалаа. Мөн Шүүхийн шийдвэрийн ерөнхий газар, НДЕГ-ын хамтарсан тушаалаар хоригдлуудыг сайн дурын даатгалд хамруулах зорилгоор 439 дүгээр Хаалттай хорих ангитай хамтран 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Эдгээр арга хэмжээний үр дүнд 2016-2019 онд аймгийн хэмжээнд сайн дурын даатгалд нийт 21095 иргэн хамрагдсан байна.	70
		129	1.5.5.3. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсдыг нийгмийн даатгалд бүрэн хамруулах	2016-2020	ЭМНДХ, СЗДТГ	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын ажиллагсдын 90-ээс доошгүй хувийг нийгмийн даатгалд хамруулах	2016 онд 730 ажил олгогч, 8480 даатгуулагчийг нийгмийн даатгалд хамруулж татварын албанд бүртгэлтэй нийт ААНБ-ын 75.7, 2017 онд 717 ажил олгогч, 8554 даатгуулагчийг хамруулж нийт ААНБ-ын 77.3, 2018 онд 716 ажил олгогч, 8911 даатгуулагчийг нийгмийн даатгалд хамруулж нийт ААНБ-ын 78.8 хувийг нийгмийн даатгалд хамрууллаа. 2019 оны эхний хагас жилийн байдлаар нийт 687 ажил олгогч, 8421 даатгуулагчийг нийгмийн даатгалд хамруулаад байна.	70

27	1.5.6 Гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийг эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан санал, санаачлагуудыг дэмжих	130	1.5.6.1. “Хүүхдэд ээлтэй орон нутаг”-ийн хүрээнд гаргасан санал санаачлагуудыг дэмжин ажиллах	2016-2020	НБХ, ГБХЗХХ, СЗДТГ	Хүүхдэд ээлтэй ажлын хандлага арга барил, ажил үйлчилгээ төлөвшин хөгжсөн байна.	2017-2019 онд аймгийн 16 сум, 1 тосгоны хамтарсан багийн гишүүд, хөдөө багийн иргэдэд Хүүхэд хамгааллын хууль, Хүүхдийн эрхийн хууль, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчлах “Хүүхдэд ээлтэй орон нутаг” сургалт, ЕБС-ийн суралцагчдад хүүхдийн эрх үүрэг, хамгаалал, гэмт үйлдлээс өөрийгөө хэрхэн хамгаалах цогц сургалтыг зохион байгуулж, 6765 эцэг эх, 5482 хүүхдийг хамрууллаа. 2019 онд “Хүрч үйлчилье” нэгдсэн арга хэмжээг 15 суманд зохион байгуулж, хүүхдийн эрх, хамгааллын хуулийн танилцуулгыг 47 төрийн байгууллага, 56 аж ахуйн нэгж, 651 иргэн, ЕБС-ийн 1171 сурагч, нийт 1822 хүнд хүргэлээ. Сургуулиудын дотуур байрны орчинд үнэлгээ хийж хүүхэд хөгжиж, хамгаалагдах нөхцөл бололцоогоор хангасан эсэхэд дүгнэлт хийж, зөвлөмж хүргүүлсэн. Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын асуудлаар ахлах ангийн сурагчидтай бүлгийн ярилцлага хийж, 15 сургуулийн ахлах бүлгийн 1038 сурагчаас хүүхэд хөгжлийн дугуйлан, секцийн хүрэлцээ, багш ажилчдын харилцаа хандлага, үе тэнгийн дарамт, асуудлаа хэрхэн шийдвэрлэдэг зэрэг тусгай асуулгаар судалгаа авч үр дүнг нэгтгэж, сургуулийн удирдлагад анхаарч ажиллах чиглэлээр зөвлөмж хүргүүлээ. “Хүүхдэд ээлтэй орон нутаг”, Хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжил оролцоог дэмжих асуудлаар 2016-2019 онд аймгийн Засаг даргын захирамж 13, аймгийн ХТЗ-ийн даргын албан бичиг 34 гарч, газрын даргын албан бичиг ажлын чиглэл, зөвлөмжийг сумдын Засаг дарга, ХТЗ-ийн дарга, холбогдох талуудад хүргүүлж, хүүхдийн өөрөө удирдах байгууллагуудын хүсэлтээр 200.0 мянган төгрөгийн өртөг бүхий 15 төслийн санхүүжилтийг шийдвэрлэсэн байна.	100
		131	1.5.6.2. Гэр бүлийн гишүүд, хүүхэд өсвөр үеийнхэнд гэр бүлийн боловсрол олгох, ахмад, залуучууд, хүүхдийн “Алтан хэлхээ” цуглалалтыг зохион байгуулах	2016-2020	НБХ, ГБХЗХХ, СЗДТГ	Гэр бүлийн гишүүд, хүүхэд өсвөр үеийн гэр бүлийн боловсрол дээшилж, харилцаа хандлага төлөвшиж, 3 үеийн залгамж чанар нэмэгдэж, гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол буурсан байна.	Залуу гэр бүлийн үнэ цэнэ, харилцаа хандлагыг төлөвшүүлэх зорилгоор 2017 онд залуу гэр бүлүүдэд зориулсан 6 удаагийн масс сургалтад 1241 гэр бүлийн гишүүдийг хамруулсан. 2018 онд зорилтот бүлгийн гэр бүлд хандсан гэр бүлийн боловсрол олгох 5 цуврал хичээлд сонгогдсон байгууллагуудын 18 өрхийг 1 сарын хугацаанд сургалтад хамрууллаа. Сургалтын төгсгөлд оролцогчдын гэр бүлдээ авчирч буй өөрчлөлтийг дүгнэж үзэхэд хоорондын харилцаа сайжирсан гэж 82.0 хувь нь, гэр бүлдээ зарцуулах цаг заваа нэмэгдүүлсэн гэж 70.0 хувь нь хариулсан байна. 2019 онд Гэр бүлийн боловсрол олгох цахим сургалтыг байгууллагын пэйж хуудсаар дамжуулан иргэдэд хүргэж эхэлсэн бөгөөд эхний 10 сарын байдлаар нийт 84 төрлийн цахим хичээлийг 61106 хүнд хүргэсэн байна. Гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, гэр бүлийн боловсрол олгох сургалтад 262 иргэнийг хамруулж сум, сургуулийн 45 нийгмийн ажилтанг “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сургалтын сургагч багшаар бэлтгэлээ. Хилийн цэргийн ангийн бие бүрэлдэхүүн, тэдний гэр бүлд төрийн үйлчилгээг хүргэх зорилгоор “Хилчдийн гэр бүлд” өдөрлөгийг Хялганат тосгоны усан цэргийн 0234 анги, Тэшиг сумын хилийн цэргийн 0286 дугаар ангид тус тус зохион байгуулж, гэр бүлийн боловсрол олгох сургалт, залуу гэр бүлүүдийн дунд өртөөчилсөн тэмцээнийг явуулж 112 албан хаагч тэдний гэр бүл, 56 хүүхэд, 28 залуу гэр бүл хамрагдсан байна. Монголын гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Аз жаргалтай гэр бүл” 14 хоногийн аяныг жил бүр тогтмол зохион байгуулж гэр бүлийн сургалт, хөгжөөнт тэмцээнд 2017 онд 3245, 2018 онд 5476, 2019 онд 6870 гэр бүлийн гишүүнийг хамруулжээ. Монгол улсад хүүхдийн байгууллага үүсэж хөгжсөний 90 жилийн ойн өдрийг тохиолдуулан хүүхдийн байгууллагын үе үеийн ахмадуудын төлөөлөл, хүүхдийн парламентын хүүхдүүд, мөн манай байгууллагын ахмад ажилчдын “Алтан хэлхээ” уулзалалтыг 2017 оноос жил бүр уламжлал болгон зохион байгуулж нийт 72 хүн оролцсон байна.	70

132	1.5.6.3. Хүүхдийн "Жаргалант" зуслангийн хэсэгчилсэн зураг, төсвийн хүрээнд зарим бүтээн байгуулалтын ажлыг хийж, зусланд "Хүүхэд солилцоо"-ны хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллах	2016-2020	НБХ, ГБХЗХХ, СЗДТГ	Бүтээн байгуулалтын зарим арга хэмжээг хэрэгжүүлэн, зусланд хүүхэд амрах нөхцөл боломж бүрдэж, хүүхэд солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.	Хүүхдийн Жаргалант зуслангийн ерөнхий төлөвлөгөөг 360 амрагч хүлээн авах 6 хотхон бүхий байдлаар гаргаж 2014 онд "Нарлаг хөхий" ХХК-аар хийлгэсэн. 2018 онд эхний ээлжийн захиргаа удирдлагын байрны 925.5 сая, 60 хүүхдийн Жаргалант хотхоны 770.2 сая төгрөгийн зураг төсвийг хийлгэлээ. 2020 оны улсын төсөвт саналаа хүргүүлж, 300.0 сая төгрөгөөр эхлүүлэхээр боллоо.	40
133	1.5.6.4. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын барилгын их засварыг хийж, орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	2016-2020	НБХ, ГБХЗХХ, СЗДТГ	Барилгад засвар хийж, зарим техник, тоног төхөөрөмжөөр хангасан байна.	2016 онд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын барилгын засварын ажлыг зураг төсвийн дагуу тендер зарлаж, 206.0 сая төгрөгийн санхүүжилтээр Орхон аймгийн "Сууц трейд" ХХК-аар гүйцэтгүүлсэн. 2018 онд кино танхимийн тоног төхөөрөмж нийлүүлэхээр "Онъ тэнгэрийн бичиг" ХХК-тай бараа материал нийлүүлэх гэрээ байгуулж, 45.8 сая төгрөгийн 100 ширхэг үзэгчдийн зориулалтын суудал, пулт, яригч, чадлын өсгөгч, зайны микрофон, компьютер зэрэг техник хэрэгслээр бүрэн хангагдаж үйл ажиллагаа хэвийн явуулж байна. 2019 онд Жаргалант кино театр 4 үзвэрийг 12 удаагийн гаралтаар 692 хүнд хүргэжээ.	100
134	1.5.6.5. Аймгийн Хүүхэд залуучуудын соёл, амралтын хүрээлэн /парк/-гийн тохижилтын ажлыг ерөнхий төлөвлөгөөний дагуу шат дараатайгаар хийж гүйцэтгэх /2-р шатны үйл ажиллагааны хэсэгчилсэн зураг төсөв хийх/	2016-2020	НБХ, ГБХЗХХ, ОНӨСАЦХ, СЗДТГ	Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг шат дараатайгаар хийж гүйцэтгэсэн байна.	2017 онд Соёл, амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажилд ОНХС-ийн 15.0 сая төгрөгийн хөрөнгөөр голын эргийн бэхэлгээг "Өрнөх хийморь" ХХК хийж гүйцэтгэлээ. Мөн аймгийн Засаг даргын захирамжаар тус хүрээлэнгийн үйл ажиллагаанд 1.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж тоглоомжуулсан байна. 2018 онд тус цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажилд орон нутгийн төсвөөс 240.0 төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдэж, явган зам, гэрэлтүүлэг, автомашины зогсоол, нийтийн ариун цэврийн байгууламжийг "Ай И Би" ХХК, "Баян-Өндөр Булаг" ХХК, "Цонхот" ХХК-ууд хийж гүйцэтгэлээ. Мөн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлын 2-р шатны зураг төсвийг боловсруулан бэлэн болгоод байна.	100

28	1.5.7 Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулж, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.	135	1.5.7.1. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь, оролцоог нэмэгдүүлж, аймаг, орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцуулах	2016-2020	АИТХ, АЗДТГ, НБХ, ГБХЗХГ, СЗДТГ, АЭХолбоо	Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь өмнөх оны мөн үеийнхээс 10-аас дээш хувиар нэмэгдэж, бусад чиглэлд эмэгтэйчүүдийн манлайлал оролцоо өсөн нэмэгдсэн байна.	Сүүлийн 3 жилийн судалгаанаас харахад 2017 онд нийт төрийн албан хаагчдын 62.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байсан бол 2019 оны байдлаар 69.2 хувь болж 6.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэвч шийдвэр гаргах түвшний удирдах албан тушаалтны хувьд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2017 онд 53.0 хувь байсан бол өнөөдрийн байдлаар 44.0 хувь болж 9 хувиар буурчээ. 2018-2019 онд аймаг орон нутгийн хэмжээнд эмэгтэйчүүдийн нийгэмд оролцох оролцоо, эрх үүргийг нэмэгдүүлэх зорилгоор дараах хэд хэдэн арга хэмжээг холбогдох төрийн болон ТББ-тай хамтран зохион байгууллаа. Тухайлбал: 2019 оны 1-р улиралд Төрийн албан дахь эмэгтэйчүүдийн манлайлах чадварыг дээшлүүлж, тэдний нийгэмд эзлэх байр суурь, үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, төр болон бусад оролцогч талуудтай санал бодлоо солилцож, ажлын байран дахь охид эмэгтэйчүүдийн хүчирхийлэл, жендэрийн тэгш байдлыг зөрчихөд хүргэж буй хүчин зүйлсийг олон нийтэд танилцуулан өргөнөөр хэлэлцүүлж, боломжит шийдлүүдийг эрэлхийлэн тодорхойлж, бодлогод нөлөөлөх зөвлөмжийг гаргах зорилгоор “ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХӨГЖИЛ-ОРОЛЦОО” аймгийн зөвлөгөөнийг 500 эмэгтэй төрийн албан хаагчдыг хамруулан 29.0 сая төгрөгийн дэмжлэгээр зохион байгууллаа. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд аймгийн Эмэгтэйчүүдийн холбоотой хамтран “Шилдэг 9 ээж”, “Бүсгүйчүүд” сэдэвт таван салбарын эмэгтэйчүүдийн уулзалт, ярилцлага, “Бүүвэй” урлагийн тоглолт зэрэг арга хэмжээг нийт 5.0 сая төгрөгөөр дэмжин 250 гаруй эмэгтэйчүүдийг хамруулан зохион байгуулсан Аймгийн “Монгол хатад гэрэлтүүлэхүй” ТББ-аас санаачлан “Эмэгтэйчүүд манлайллыг түүчээлнэ” сургалт, мэдээллийн арга хэмжээг зохион байгуулж “21 дарь эх дуулж байна” урлагийн тоглолт, “Байгууллагын соёл ба эмэгтэйчүүдийн манлайлал” лекц зэрэг арга хэмжээг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 500 гаруй эмэгтэйчүүд хамрагдсан байна. Мөн тус ТББ-аас санаачлан орон нутагт бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн хөгжил оролцоог дэмжин, бизнесийн шинэ санаа, шинэ боломж, тэдний хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор “Бизнесийн шинэ боломж” аймгийн эмэгтэйчүүдийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, сум орон нутгийн бизнес эрхлэгч 500 эмэгтэй оролцож бизнесийн шинэ санаа, шинэ боломжийг судлан, харилцан туршлага судаллаа.	100
		136	1.5.7.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийг ханган, жил бүр жендэрт суурилсан, жендэрийн мэдрэмжтэй судалгаа хийж, салбар дундын мэдээллийн санг бий болгох	2016-2020	АЗДТГ, НБХ, ГБХЗХГ, СЗДТГ, АЭХолбоо	Суурь судалгааг бүрэн хийж салбар дундын мэдээллийн санг үүсгэн эмхэтгэл гаргаж, /гарын авлага/ төрийн албан хаагчдын болон бусад чиглэлээр ашиглах боломжийг бүрдүүлсэн байна.	Аймгийн төрийн алба хаагчдын хүйсийн тэнцвэртэй байдлын судалгааг жил бүр шинэчлэн гаргаж, салбар дундын мэдээллийн санг бүрдүүлэн ашиглаж байна. 2020 онд төрийн албан хаагчдын хэрэгцээнд зориулан гарын авлага, эмхэтгэлийг хэвлэн гаргахаар төлөвлөж байна.	70

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

2.1 Эдийн засаг:

Эдийн засгийн өсөлтийг дэмжин, технологийн дэвшилд суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлж, баялгийг бүтээн орлогыг нэмэгдүүлж, сэтгэл хангалуун аз жаргалтай амьдралыг хамтдаа бүтээнэ.

29	2.1.1 Бизнесийн таатай орчинг бүрдүүлж, үйлдвэрлэлийг хөгжүүлж дотоодын нийт бүтээгдэхүүнийг жил бүр нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.	137	2.1.1.1. Эдийн засгийн хөгжлийн 2016-2020 оны үндсэн зорилтуудыг хэрэгжүүлж, аймгийн нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээг 25 хувиар нэмэгдүүлэх	2016-2020	АЗДТГ, Сумын ЗДТГ	Хүн амын амьжиргааны түвшин дээшилж, нэг хүнд ноогдох ДНБ-ийг 6.4 сая төгрөгт хүргэнэ.	2017 онд 285.5 тэрбум, 2018 онд 318.5 тэрбум, 2019 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 328.1 тэрбум төгрөг болж 2016 оноос 47.3 тэрбумаар, нэг хүнд ноогдох ДНБ 2017 онд 4.63 сая, 2018 онд 5.1 сая, 2019 онд 5.3 сая төгрөгт хүрч, 2016 оноос 800 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Салбараар нь авч үзвэл, хөдөө аж ахуйн салбарт ДНБ-ний 51.2 хувь буюу 167.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2016 оноос 12.1 тэрбум төгрөгөөр, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт 160 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь мөн оноос 35.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.	70
----	---	-----	---	-----------	-------------------	--	--	----

2.2 Хүнс, хөдөө аж ахуй:

Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг аймгийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл болгон, байгаль, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицсон, дэвшилтэт технологид суурилсан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, бэлчээр, тариалангийн талбайг нөхөн сэргээх, малын үүлдэр угсаа, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх ажлыг шинэ шатанд гаргана.

Мал аж ахуй:

		138	2.2.1.1. “Сэлэнгэ” үүлдрийн үхрийг сонгон үржүүлэх бүс нутагт үржлийн төв байгуулж, “Сэлэнгэ” үүлдрийн үхрийн удмын санг хамгаалж, өсгөн үржүүлж, ашиг шимийг нэмэгдүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Сэлэнгэ суманд үржлийн төв байгуулж, Сэлэнгэ үүлдрийн үхрийн махны гарц 50-60 кг-аар нэмэгдсэн байна.	УИХ-ын гишүүн Ж.Бат-Эрдэнийн санаачилсан “Шинэ хөдөө” төслийг дэмжин, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар “Шинэ хөдөө-Булган” дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж байна. Улс, орон нутгийн төсвөөс 2017-2019 онд нийт 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 2018 онд Тэшиг, Хутаг-Өндөр, Хангал, Бугат суманд “Сэлэнгэ” үүлдрийн 100 толгой бух, Сэлэнгэ суманд “Геррефорд” үүлдрийн 25 бух, 2019 онд Сэлэнгэ суманд Геррефорд үүлдрийн 15 бух, Хангал, Хутаг-Өндөр, Бугат, Тэшиг, Баян-Агт суманд “Сэлэнгэ” үхрийн 1-р үеийн эрлийз 35 бух, 16 сумын 44 багт “Сэлэнгэ” үүлдрийн 44 бухыг тус тус хүлээлгэн өгч, үржилд ашиглахаар бэлтгэл хангаж байна. Сэлэнгэ суманд хээлтүүлэгч малын тэжээлийн байр барьсан. “Сэлэнгэ” үүлдрийн үхрийн чанарыг сайжруулж ажилласнаар 2024 он гэхэд нийт үхэр сүргийн 16.5 хувьтай тэнцэхүйц хэмжээний өндөр ашиг шимт малтай болж, 1 үхрийн амьдын жинг дунджаар 60 орчим кг-аар нэмэгдүүлэхээр ажиллаж байна.	70
		139	2.2.1.2. “Хангай” үүлдрийн хонины удмын санг хамгаалж, өсгөн үржүүлж, ашиг шимийг нэмэгдүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Орхон, Бүрэгхангай сумдад өсгөн үржүүлж, ноосны гарц 300-500 гр-аар нэмэгдсэн байна.	2018 онд “Хангай” үүлдрийн хонийг үржүүлж эхэлсний 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсний дээр Бүрэгхангай сумаас 251 толгой “Хангай” үүлдрийн хонийг Сэлэнгэ сумын 4-р багт нүүлгэн шилжүүлж, сайжруулалт хийж ажилласнаар хонины тарга тэвээрэг, хээл авалт дээшилж, төл малын хорогдол багасаж, ноосны чанар, амьдын жин нэмэгдсэн зэрэг эерэг үр дүн гарч, 2019 онд ХХААХҮЯ-аас зохион байгуулсан “Шилмэл малын үзэсгэлэн худалдаа”-нд манай “Хангай” үүлдрийн хонь амьдын дундаж жин, ноосны чанар, гарцын үзүүлэлтээр “Алтан” медаль авлаа.	70
		140	2.2.1.3. Бог малын үржлийн ажлыг мэргэжлийн байгууллагад шилжүүлж, стандартын шаардлага хангасан хээлтүүлэгчээр хангах	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Бог малын үүлдэр угсаа, чанар сайжирч, стандартын шаардлага хангасан хээлтүүлэгчээр хангагдсан байна.	“Шинэ хөдөө Булган” төслийн хүрээнд 2018 онд “Эрчмийн хар” үүлдрийн 245 ухна, “Дархад” үүлдрийн 122 толгой хуцыг Хутаг-Өндөр сумын Уньт, Тээл багийн 72 малчин өрхтэй гэрээ байгуулан үржилд сайжруулагчаар ашиглуулж байгаа бөгөөд 2019 онд “Цагаан уул” үүлдрийн 120 толгой төлгөн хуцыг урд бүсийн 54 малчин өрхөд үржилд ашиглуулахаар гэрээ байгуулан олголоо. “Баяд” үүлдрийн 300 хуц, “Эрчмийн хар” үүлдрийн 50 ухныг худалдан авч, хойд бүсийн сумдад нийлүүлэх ажлыг зохион байгууллаа. Үүний үр дүнд өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувь 7-8 хувиар өсөж, нэг малаас авах ашиг шимийн үзүүлэлт нэмэгдэж, хонины махан ашиг шим 2-3 кг, ноосны гарц 200-320 гр, ямааны ноолуур 100-150 гр-аар нэмэгдэхээр байна.	70

2.2.1 Малын үржлийн ажил, үйлчилгээ, малын чанарыг сайжруулах замаар эдийн засгийн өсөлтийг хангана.

141	2.2.1.4. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлж, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослуулж, үхэр, хонины аж ахуйг махны чиглэлээр хөгжүүлж, мах экспортлох	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	5-аас доошгүй үхэр, хонины аж ахуй байгуулагдаж, малчин өрхийн орлого нэмэгдэнэ.	“Шинэ хөдөө Булган” төсвийн хүрээнд улс, орон нутгийн төсвөөс 2017-2019 онд нийт 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, Тэшиг, Хутаг-Өндөр, Хангал, Бугат, Баян-Агт суманд “Сэлэнгэ” үүлдрийн 1-р үеийн эрлийз 135 толгой бух, Сэлэнгэ суманд “Герефорд” үүлдрийн 40 бух, 16 сумын 44 багт “Сэлэнгэ” үүлдрийн 44 бухыг тус тус хүлээлгэн өглөө. “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”-гаас махны үхэр үржүүлэх чиглэлээр Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сум 102.0 сая, “Сум хөгжүүлэх сан”-гаас махны, мах-сүүний үхэр үржүүлэх, мах боловсруулах цех барих чиглэлээр Булган сумын 2 төсөлд 20.0 сая, Бугат сумын 4 төсөлд 26.0 сая, Дашинчилэн сумын 8 төсөлд 58.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлснээр аж ахуйнууд бизнесээ өргөжүүлэх, орлогоо нэмэгдүүлэх боломж бүрдсэн. Хутаг-Өндөр суманд үхрийн эрчимжсэн 3 аж ахуйн нэгж байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.	70
142	2.2.1.5. Эрчимжсэн мал аж ахуй болон гахай, шувуу, зөгийн аж ахуй эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжих	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Эрчимжсэн аж ахуй эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн тоо өсөж, 8-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгж хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байна.	2018 онд аймгийн “Зөгий үржүүлэгчдийн холбоо” байгуулагдаж, анхны зөвлөгөөнийг Сэлэнгэ суманд зохион байгуулж, 60 гаруй хүнийг хамруулсан. “Булган-Зөгий” дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлснээр 2019 оны байдлаар 102 өрх зөгийн аж ахуйтай болж, 1103 бүлээс 16.5 тн бал хураан авч, өрхийн орлогоо нэмэгдүүлсэн байна. Баян-Агт, Бугат, Булган, Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгоны 43 иргэнийг зөгийн аж ахуй эрхлэлтийн чадамж олгох сургалтад хамруулж, нийт 250 бүл зөгий, дагалдах хэрэгслээр дэмжлээ. Сэлэнгэ суманд Япон улсын “Тоёота Моторс” компанийн 154.0 сая төгрөгийн санхүүжилтээр “Зөгийн аж ахуйг дэмжих” төслийг “Ойска” ОУБ-ын Монгол дахь салбартай хамтран 2 жилийн хугацаатай хэрэгжүүлж, зөгийн аж ахуй эрхлэгчдэд сургалт, туршлага судлах аялал зохион байгуулж, 10 өрхөд эргэн төлөгдөх нөхцөлтэй 10 бүл зөгий олголоо. Аймгийн хэмжээнд 28 өрх 280 толгой гахай, 40 өрх 368 толгой тахиа, шувуу бүхий аж ахуй эрхэлж, өрхийн орлогоо нэмэгдүүлж байна. “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”-гаас махны үхэр үржүүлэх чиглэлээр Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сум 102.0 сая, “Сум хөгжүүлэх сан”-гаас махны, мах-сүүний үхэр үржүүлэх, мах боловсруулах цех барих чиглэлээр Булган сумын 2 төсөлд 20.0 сая, Бугат сумын 4 төсөлд 26.0 сая, Дашинчилэн сумын 8 төсөлд 58.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлснээр аж ахуйнууд бизнесээ өргөжүүлэх, орлогоо нэмэгдүүлэх боломж бүрдлээ.	100
143	2.2.1.6. Эрчимжсэн мал аж ахуй эрхэлж буй фермерүүдийг эзэмшлийн газартай болгож, мал аж ахуй, газар тариаланг хослон хөгжүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх тоо хэмжээ өсч, нэг малаас авах ашиг шимийн үзүүлэлт нэмэгдэнэ.	“Шинэ хөдөө Булган” төслийн хүрээнд улс, орон нутгийн төсвөөс 2017-2019 онд нийт 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, “Сэлэнгэ” үүлдрийн үхрийг бүс нутгийн хэмжээнд өсгөн үржүүлэх зорилготой ажиллаж байна. “Сэлэнгэ” үүлдрийн үхрийн чанарыг сайжруулж ажилласнаар 2024 он гэхэд нийт үхэр сүргийн 16.5 хувьтай тэнцэхүйц хэмжээний өндөр ашиг шимт малтай болж, 1 үхрийн амьдын жинг дунджаар 60 орчим кг-аар нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Мөн “Эрчмийн хар” үүлдрийн 245 ухна, “Дархад” үүлдрийн 122 толгой хуц, “Цагаан уул” үүлдрийн 120 толгой төлгөн хуц, “Баяд” үүлдрийн 300 хуц, “Эрчмийн хар” үүлдрийн 50 ухныг тус тус худалдан авч, сумдад нийлүүллээ. Үүний үр дүнд өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувь 7-8 хувиар өсөж, нэг малаас авах ашиг шимийн үзүүлэлт нэмэгдэж, хонины махан ашиг шим 2-3 кг, ноосны гарц 200-320 гр, ямааны ноолуур 100-150 гр-аар нэмэгдэнэ.	70
144	2.2.1.7. Малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, тэжээл үйлдвэрлэгчдийг нэг болон олон наст ургамлын үр, бага оврын техник тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Нэгжээс авах ургацын хэмжээ нэмэгдэж, техник тоног төхөөрөмжийн хангамж сайжирна.	Дашинчилэн сумын “Муку” ХХК-д хөнгөлттэй нөхцөлөөр бага оврын тэжээлийн үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлснээр орон нутгийн хэмжээнд тэжээл үйлдвэрлэж байна. Мөн “Мерси кор” ОУБ-аас Хангал сумын “Амуун далай” ХХК-д тэжээлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авахад 20.0 сая, Тэшиг сумын “Мөнх түрүү” ХХК-д малын тэжээл үйлдвэрлэх цех барих, тэжээл тариалах чиглэлээр 60 гаруй сая төгрөгийн дэмжлэг олголоо. Аймгийн хэмжээнд малын тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлж, 2018 онд 4410.5 га-д тариалж 2533 тн, 2019 онд 1113 га-д тариалж 5618.5 мянган тн ургац хураан авсан. Хутаг-Өндөр, Тэшиг, Булган, Бүрэгхангай, Орхон суманд малын тэжээл, төмс, хүнсний ногоо тариалах дундын техник олгов.	100

		145	2.2.1.8. Мал аж ахуйн мэргэжилтнүүдийг бэлтгэх, давтан сургах ажлыг тодорхой бодлого төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Мал аж ахуйн мэргэжилтнүүдийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар дээшилнэ.	БНХАУ-д “Экологийн өрсөлдөх чадвар” олон улсын чуулга уулзалт, мал аж ахуйн мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалтад сумдын МЭҮТ-ийн 2 мэргэжилтнийг 30 хоног хамруулсан. Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн, Мэргэжлийн хяналтын газартай хамтран зохион байгуулсан сургалтад 11 сумын удирдлага, МЭҮТ-ийн мэргэжилтэн, БОУБайцаагч, газрын даамал, багийн Засаг дарга, малчин нийт 100 гаруй, “Зах зээл бэлчээрийн удирдлага”-ын сургалтад 4, Дархан-Уул аймагт төвийн бүсийн аймгуудын “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаанд 20 төлөөллийг оролцуулав. Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлийн сургалтад мэргэжилтэн 8, эрчимжсэн аж ахуйн болон тэжээл үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжээс 17, нийт 25 хүнийг хамруулж, нарийн, нарийвтар ноост хонь үржүүлэгчдийн зөвлөгөөнд мэргэжилтэн 5, малчин 2, нийт 7 хүн оролцсон. Архангай аймагт зохион байгуулсан сарлаг үржүүлэгчдийн улсын зөвлөгөөнд 5 мэргэжилтэн, “Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо”, “Ногоон-Алт” төслөөс зохион байгуулсан сургалтад 11 мэргэжилтэн, 14 малчин оролцсон. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зохион байгуулсан “Малын генетик нөөц, төлөв байдлыг үнэлэх нь” төслийн хүрээнд зохион байгуулсан сургалтад 24 мэргэжилтнийг хамруулж, 16 суманд ажиллаж байгаа ХАА-н мэргэжилтнүүдэд 2-3 удаагийн сургалтаар мэргэжлийн мэдлэг олгож, ур чадварыг дээшлүүллээ.	100
		146	2.2.1.9. Бүх суманд малчдын сургалтын төв байгуулж, түүгээр дамжуулан танхимын, талбайн, өрхийн сургалтуудыг явуулах, тэргүүний сайн малчдын туршлагыг эзэмшүүлэх, дагалдуулах замаар мал маллагааны уламжлалт болон дэвшилтэт арга ажиллагаанд сургаж, мэргэшүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Зах зээлийн нөхцөлд аж ахуйгаа үр дүнтэй эрхлэн хөтлөх мэдлэг чадвартай болсон байна.	Хөдөлмөрийн ууган баатар З.Очирын нэрэмжит “Малчдын танхим”-ыг бүрэн тохижуулан сургалт зохион байгуулж байна. Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Рашаант, Хишиг-Өндөр сумтай гэрээ байгуулан, талбайн сургалтыг Дашинчилэн сумын Доргонт багт зохион байгууллаа. Сургалтад 60 гаруй хүн хамрагдсан. Нийт сумдад малчид, төлчид, залуу малчдын зөвлөгөөнийг хамтран зохион байгуулж, 3000 гаруй малчныг хамрууллаа. Малчдын зөвлөгөөнийг 2018 онд Дашинчилэн, Могод, Сэлэнгэ, Хутаг-Өндөр суманд бүсчилж, 2019 онд аймгийн төвд “Малын чанарыг сайжруулж, бэлчээрээ хайрлая” уриан дор зохион байгуулж, гарын авлага материалаар хангаж, малчдад хандсан зөвлөмжийг батлан хэрэгжүүлж байна. Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Ногоон алт-Малын эрүүл мэнд” төслийн хүрээнд Дашинчилэн, Могод, Орхон, Сайхан, Хишиг-Өндөр суманд бэлчээрийг зүй зохистой ашиглах, малчдын дундын сангийн хуримтлал бий болгох чиглэлээр 2-3 удаагийн сургалт зохион байгуулсны үр дүнд бэлчээр ашиглагчдын 24 хэсэг байгуулагдлаа.	100
2.2.2 Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх.		147	2.2.2.1. Бэлчээрийн ургамалд хор хөнөөл учруулж байгаа мэрэгч амьтан, шавжтай тэмцэх үйл ажиллагааг байгаль орчинд халгүй, дэвшилтэт арга технологи ашиглан өргөжүүлж, олон улсад туршигдаж, үр дүнгээ өгсөн арга туршлагыг нэвтрүүлж, бэлчээрийг үе шаттайгаар нөхөн сэргээх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		80.0 мянган га-аас доошгүй бэлчээрийн талбайд ургамал хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Бэлчээрийн хортон мэрэгчидтэй талбайд байгаль орчинд халгүй аргаар тэмцэх ажлыг 2016 онд Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Орхон, Могод, Рашаант, Сайхан, Хишиг-Өндөр сумын 40.0 мян га-д, 2018 онд Баян-Агт, Баяннуур, Булган, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Орхон, Рашаант, Сайхан, Хишиг-Өндөр сумын 50.0 мянган га, 2019 онд Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Рашаант, Сайхан, Хишиг-Өндөр сумын бэлчээрийн 40.8 мянган га, нийт 130.8 мянган га талбайд зохион байгууллаа. Бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх ажлыг 82.0-83.8% буюу сайн хэрэгжүүлсэн үр дүнтэй байна.	100

31	хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар бэлчээрийн даацыг нэмэгдүүлнэ.	148	2.2.2.2. Бэлчээрийн даац, төлөв байдлын судалгаанд тулгуурлан, эдийн засгийн оновчтой хөшүүргийг ашиглан малын тоо, төрөл, сүргийн зохистой бүтцийг тогтоох	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэн хөтлөх үйл ажиллагаа сайжирна.	2017 онд аймгийн ИТХ-аар "Бэлчээрийн төлөв байдал, менежментийн талаар баримтлах бодлого"-ыг шинэчлэн батлуулсны зэрэгцээ малын үүлдэр угсаа, ашиг шимийг сайжруулах бүсийг тогтоосон. Хойд бүсэд хонин сүргийг "Дархад" омгийн хуцаар, ямааг "Эрчмийн хар" ухнаар, үхэр сүргийг "Сэлэнгэ" үүлдрийн бухаар сайжруулах, урд бүсэд хонин сүргийг "Баяд" үүлдрийн хуцаар, ямааг "Өлгийн улаан" ухнаар сайжруулах бодлого баримтлан ажиллаж байна. Бэлчээрийн төлөв байдлын судалгаагаар аймгийн малын тоо зохистой хэмжээнээс 5-7 дахин хэтэрсэн тооцоо гарсан. Иймд жилд ахуйн хэрэглээнээс гадна 1.0 саяас доошгүй толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, бэлчээрийг зохистой ашиглалтыг сайжруулах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч байна.	70
		149	2.2.2.3. Усан хангамж дутагдалтай байгаа бэлчээрт худаг гаргах замаар бэлчээр усжуулалтын хэмжээг нэмэгдүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	25.0 мянган га-аас доошгүй бэлчээр усжуулагдсан байна.	Аймгийн хэмжээнд инженерийн хийцтэй болон энгийн 983 худаг ашиглаж байгаа бөгөөд 2016 оноос хойш бэлчээрийн инженерийн хийцтэй 118 худаг шинээр гаргаж, 160 гаруй мянган га бэлчээрийн талбайг усжуулж, 500-аад мянган толгой малыг усаар хангалаа. Энэ ажилд улсын төсвөөс 109.0 сая, орон нутгийн төсвөөс 1.2 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.	100
32	2.2.3 Хөдөөгийн иргэдийн хөдөлмөр, хөрөнгөөрөө хоршин ажиллаж, орлогоо нэмэгдүүлэх, боломж нөхцлийг бүрдүүлнэ.	150	2.2.3.1. "Хоршоо хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр II"-ийг хэрэгжүүлж, "Хоршоо хөгжүүлэх сан" бий болгох замаар хоршоологчдыг дэмжих	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Хоршоодын үйл ажиллагаа сайжирч, 10-аас доошгүй хоршоо шинээр байгуулагдсан байна.	2018 онд хоршоог биржийн арилжаанд оруулах ажлын хүрээнд ХХААХҮЯ-наас баталсан удирдамжийн дагуу 16 сум 1 тосгоны улсын бүртгэлд бүртгэлтэй 149 хоршоонд хөгжлийн үнэлгээ хийсэн. Хоршоо нь 6800 орчим гишүүнтэй байгаа бөгөөд үүнээс, 2 нь тогтвортой өсөлттэй буюу загвар хоршоо, 30 нь хөгжиж байгаа, 32 нь идэвхжиж байгаа, 14 нь идэвхгүй, 54 хоршоо нь аж ахуйн нэгж болох буюу татан буугдах хүсэлтийг тус тус гаргасан. 2019 онд Хөдөө аж ахуйн хоршоологчдын улсын зөвлөгөөн төр, хоршооллын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулагдаж 13 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.	70
		151	2.2.3.2. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн түүхий эдийн нөөцөд түшиглэсэн боловсруулах үйлдвэр, цехийг аймгийн төв, сумдад бүсчилж хөгжүүлэх /ноос угаах, арьс шир, сүү, сүүн болон мах, махан бүтээгдэхүүн боловсруулах жижиг үйлдвэр цех, айраг савлах, хөхүүр, суран эдлэл хийх, дотор мах, дайвар бүтээгдэхүүн боловсруулах гэх мэт/	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Сүү, сүүн бүтээгдэхүүн, махны болон мах боловсруулах, айраг савлах, хөхүүр, суран эдлэл хийх, бусад бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр цехийг аймгийн төв болон сумдад бий болгосон байна.	Тэшиг суманд бяслагны үйлдвэрлэл, Сэлэнгэ суманд "Халзаадай" нэртэй цех тараг савлаж үйл ажиллагаагаа эхэлсэн. Хутаг-Өндөр суманд "Монголын хуурай сүү" төслийг хэрэгжүүлэгч "МДМ" ХХК-тай хамтран хуурай сүүний үйлдвэр байгуулахаар тоног төхөөрөмжийг суурилуулсан. Канадын элчин сайдын яамнаас "Бялхам үндэс" ТББ-ын сүү, цагаан идээ боловсруулах үйлдвэрийн төсөлд 60.0 сая төгрөгийн дэмжлэг, тоног төхөөрөмж олгосноор үйл ажиллагаагаа эхлүүлсэн. "Шинэ хөдөө Булган" дэд хөтөлбөрийн хүрээнд хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг бий болгох зорилгоор 15 суманд нэг ээлжиндээ 25-аас дээш арьс боловсруулах хүчин чадал бүхий арьс, нэхий элдэх иж бүрэн тоног төхөөрөмж 15 ширхэг, Хутаг-Өндөр, Сайхан, Хангал, Сэлэнгэ, Орхон, Дашинчилэн, Бугат сум тус бүрт 20 тн-ын чингэлэгт суурилуулагдсан 3 тн сүү агуулах хүчин чадалтай шинжилгээний багаж бүхий сүүний хөргөлтийн танк, Сайхан суманд айраг хадгалах 40 тн-ын хөргүүрт чингэлгийг хүлээлгэн өглөө.	70
Мал эмнэлэг:								
		152	2.2.4.1. Малын халдварт, гоц халдварт өвчний тандалт, хяналтыг тогтмолжуулж эрсдэл бүхий бүс нутгийн мал сүргийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулж, эрүүлжүүлэлтийн үр дүнг сайжруулах	2016-2020	ХХААГ, СЗД	Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдвал зохих мал, амьтдыг бүрэн хамруулна.	Сүүлийн 3 жилийн хугацаанд 10-11 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 3.5 сая толгой мал, амьтныг хамруулж, 88.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Жилд дунджаар халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 700-800 мянган толгой мал, амьтан, паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 1.3-1.4 сая мал тогтмол хамрагдаж байна.	70

2.2.4 Мал эмнэлгийн үйлчилгээний олон улсын жишиг, стандартын шаардлагад нийцсэн, үйл ажиллагааны шуурхай, нэгдмэл байдлыг хангасан тогтолцоог бүх шатанд бүрдүүлж, мал эмнэлгийн нэгжүүдийг чадавхижуулж, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагыг өндөржүүлж, халдварт өвчингүй байх нөхцлийг хангана.

153	2.2.4.2. Малын бруцеллэз, адууны ям, халдварт цус багасах өвчин, үхрийн лейкоз, сүрьеэ өвчний тандах, эрүүлжүүлэх шинжилгээг чанартай зохион байгуулж халдвар тархахаас сэргийлж, улмаар халдварлалтын түвшинг бууруулах	2016-2020	ХХААГ, СЗД	Шинжилгээнд хамрагдвал зохих мал, амьтдыг бүрэн хамруулж, халдварт өвчний гаралтыг бууруулсан байна.	Хээлтүүлэгч малыг бруцеллэз өвчний шинжилгээнд бүрэн хамруулж байгаа бөгөөд сүүлийн 3 жилд эрчимжсэн аж ахуй эрхэлж байгаа болон нийтийн хэрэгцээнд мах, сүүн бүтээгдэхүүн нийлүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн 42344 мянган толгой малд бруцеллэз өвчний шинжилгээг хийлээ. Шинжилгээнд хамрагдсан малын халдварлалтын хувь 0.4 хувьтай байна. Адууны ям өвчний тандалт шинжилгээний ажлыг жил бүр зохион байгуулж, эрсдэл бүхий 4 сумыг сонгон 3000 адуу хамруулж байна. Энэ арга хэмжээнд нийт 8434 мянган адуу хамруулсан бөгөөд халдварлалт илрээгүй.	100
154	2.2.4.3. Байгаль орчин, хүн малд сөрөг нөлөөгүй дэвшилтэт технологи нэвтрүүлэн, халдварт өвчний голомтыг устгах, ариутгал халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулж, мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах	2016-2020	ХХААГ, СЗД	Ариутгал халдваргүйжүүлэлтийг чанартай зохион байгуулж, халдварт өвчний голомтыг цаг тухай бүрт нь устгаж мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл сайжирна.	Мал, амьтны гоц халдварт өвчин илэрсэнтэй холбогдуулан малын шилжилт хөдөлгөөнийг хориглох, хяналтыг сайжруулах, малчид иргэдэд сэрэмжлүүлэг, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулж байгаагаас гадна жил бүрийн 5, 6-р сард ариутгалын сарын аяныг тогтмол зохион байгуулж хэвшлээ. Сүүлийн гурван жилд 864779 м.кв хашаа хороо, худаг уст цэг, зоорь, агуулах, бэлчээрийн талбайд ариутгал хийж, 33049 малын сэг зэмийг устгасан. Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйтгэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж, 3 тоннын багтаамжтай ДҮК машин, ариутгалын мананцаржуулагч, гар аргаар ариутгагч зэрэг техник, тоног төхөөрөмж нийлүүлсэн.	100
155	2.2.4.4. “Монгол мал” хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан МЭҮТ-г сум бүрт бэхжүүлж, мэргэжлийн боловсон хүчнээр хангах	2016-2020	ХХААГ, СЗД	Сумдад мал эмнэлгийн ажил үйлчилгээг мэргэжлийн удирдлагаар хангах, зохицуулах, хяналт тавих ажил мэргэжлийн түвшинд чанартай хийгдэнэ.	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, МУ-ын Засгийн газрын 2018 оны 267 дугаар тогтоолоор сумдад Мал эмнэлгийн тасаг байгуулагдаж, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, тархвар зүйч, малын эмч нар ажиллахаар орон тоо батлагдсан. 16 суманд мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч ажиллаж байгаа бөгөөд тархвар зүйчээр ажиллах мэргэжилтнийг Төрийн албаны шалгалтад тэнцсэн иргэдээс сонгон авахаар төлөвлөн ажиллаж байна.	70
156	2.2.4.5. Баг бүрт хувийн мал эмнэлэг, үржлийн нэгжийг үүсгэж, тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, мэргэжилтний хүрэлцээ хангамж, чадавхийг сайжруулах	2016-2020	ХХААГ, СЗД	Мал эмнэлэг, үржлийн нэгжийн өрсөлдөөн үүсч, ажил, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.	Аймгийн хэмжээнд мал эмнэлгийн үйлчилгээний 63 нэгжид малын их эмч 47, малын бага эмч 16, нийт 63 малын эмч ажиллаж байна. Нэг малын эмчид 40-45 мянган мал оногдохоор байдаг бөгөөд манай аймагт нийт 3.3 сая малд 63 малын эмч ажиллаж, 1 малын эмчид 52 мянган толгой мал ногдож байна.	70
157	2.2.4.6. Олон улсын жишигт нийцсэн 2-р зэрэглэлийн шаардлага хангасан мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн өргөтгөл барих	2016-2020	ХХААГ	Мал эмнэлэг ариун цэврийн лабораторийн багаж, тоног төхөөрөмжүүдийг бүрэн суурилуулна.	Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн өргөтгөлийн барилга барихаар төлөвлөж, зураг төсвийг 35.5 сая төгрөгөөр Орхон аймгийн “Билл Конн” ХХК-иар гүйцэтгүүлж, хөрөнгө оруулалтын асуудлыг холбогдох яамдад жил бүр уламжилж байгаа боловч, хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй байна.	ҮБ
158	2.2.4.7. Мал эмнэлгийн ариун цэврийн лабораторийг MNS ISO 17025 стандартын дагуу итгэмжлүүлэх	2016-2020	ХХААГ	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга зүйн дагуу шинжилгээ хийж баталгаажуулна.	Мал эмнэлгийн ариун цэврийн лабораторийг 2017 онд MNS:ISO17025 стандартын дагуу 2 жилийн хугацаатай итгэмжлүүлж, мал амьтны халдварт, паразиттах өвчин, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн магадлан шинжилгээний 46 төрлийн шинжилгээг хийх эрх аван ажиллаж байна. Энэ онд багтаан дахин итгэмжлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.	100

159	2.2.4.8. Мал эмнэлгийн ариун цэврийн лаборатори, хог хаягдлыг ариутган халдваргүйжүүлэх, устгах байр барьж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2016-2020	ХХААГ		Хүрээлэн буй орчинд хохирол учруулахаас сэргийлж био аюулгүй байдлыг хангана.	Мал эмнэлгийн ариун цэврийн лабораторид 111 нэр төрлийн эм, урвалжийг сорилт шинжилгээнд ашиглаж байгаа ба халдварт өвчний шинж тэмдгээр үхэж, хоргодсон малын 40 гаруй мянган ширхэг эд, хэрэглэгдэхүүний хог хаягдлыг халдваргүйжүүлэн шатааж устгалаа. Лабораториос гарч байгаа хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр халдваргүйжүүлэн устгах байр барих, түүнд шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж, хөрөнгийн эх үүсвэрийг судалж байна.	40
160	2.2.4.9. Хутаг-Өндөр сумын Гуртын гүүрний дэргэдэх Мал эмнэлэг, хорио цээр хяналтын цэгийн материаллаг баазыг бэхжүүлж, ажиллах нөхцөлийг сайжруулах	2016-2020	ХХААГ		Ажиллагсдын ажиллах нөхцөл сайжирч, ажлын чанар дээшилнэ.	Хутаг-Өндөр суманд Хорио цээрийн хяналтын цэгийг байгуулж, Хөвсгөл-Булган, Орхон аймаг чиглэлд явж байгаа мал, махны хөдөлгөөнд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг холбогдох байгууллагад мэдээлэн ажиллаж байна. Тус цэгийн хяналтын камераар дамжуулан Мал эмнэлгийн ерөнхий газраас хяналтыг шууд тавин ажиллах боломжтой болсон. Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс Хяналтын цэгийн албан хэрэгцээнд зориулж суудлын автомашин шийдвэрлэж өгөв.	100

Газар тариалан:

161	2.2.5.1. Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй хослон эрхлэх бүс нутгийг тогтоох Үүнд: Үр тариа бүхий сум, багийн бүс нутгийг хамруулах	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Эрчимжсэн суурин МАА-г хөгжүүлэх болон газар тариаланд дэвшилтэт технологи нэвтрүүлэх нөхцөл бүрдэнэ.	Хутаг-Өндөр сумын гурван багийг газар тариалангийн бүс нутгаар тогтоосонтой холбогдуулан 100 км тариалангийн талбайг бүрэн хашаажуулсан. 2019 онд Сэлэнгэ сумыг газар тариалангийн бүс нутгаар тогтоолгох тухай сумын ИТХ-ын тогтоол, дагалдах материалыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн Засгийн газарт уламжлаад байна.	70
162	2.2.5.2. Услалтын системийн ашиглалтыг сайжруулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар усалгаатай тариалангийн хэмжээг нэмэгдүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Усалгаатай тариалангийн хэмжээг 3000 га-д хүргэнэ.	Аймгийн хэмжээнд 1070 га-д усалгаатай тариалалт хийгдэж байна. Үр тарианы хувьд Сэлэнгэ сумын "ИНТОСЭ" ХХК, "Оргил дэлгэр" ХХК-ийн усалгааны систем усны эх үүсвэр дутагдсаны улмаас ашиглагдаагүй байна. Орхон сумын "Орхонмандал" ХХК 50 га талбайг усалгаажуулсан. "Шинэ хөдөө-Булган" төслийн хүрээнд чацарганы тариалалтын усалгааг эрчимжүүлэх зорилгоор 2018 онд 8 иж бүрдэл, 2019 онд 7 иж бүрдэл бүхий 150 га талбайг услах хүчин чадалтай дуслын усалгааны системийг Баян-Агт, Баяннуур, Бугат, Бүрэгхангай, Булган, Дашинчилэн, Могод, Орхон, Сайхан, Тэшиг, Хутаг-Өндөр суманд хүлээлгэн өгсөн. 2019 оны байдлаар нийт 1200 га-д төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг усалгаатай тариалж байна.	70
163	2.2.5.3. Төвлөрсөн ногооны талбай бүхий 10 суманд инженерийн хийцтэй, гүний худаг гаргахад дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Төмс хүнсний ногоо тариалах талбайн хэмжээ, ургац нэмэгдэж хүн амын хэрэгцээ хангагдана.	2016 оноос хойш 10 сумын ногооны талбайд гүн өрмийн худаг гаргаж өгсөн. Мөн "Шинэ хөдөө Булган" төслийн хүрээнд 247.6 сая төгрөгөөр Баян-Агт, Баяннуур, Бугат, Булган, Гурванбулаг, Могод, Орхон, Хангал, Хишиг-Өндөр суманд нарны үүсгүүр бүхий ус өргөгчтэй гүний худаг гаргасны дээр "Чацаргана" төслийн хүрээнд бүх суманд усалгааны эх үүсвэр муутай 10-аас дээш га бүхий талбайд 22 худаг гаргасан.	100
164	2.2.5.4. Тариалангийн зориулалтаар эзэмшүүлсэн талбайг бүрэн эргэлтэд оруулж, таримлын нэр төрлийг нэмэгдүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД		Аж ахуйн нэгж, иргэдийн эзэмшилд байгаа тариалангийн талбайн ашиглалтыг 100 хувьд хүргэнэ.	Аймгийн хэмжээгээр 11978 га тариалангийн талбай бүртгэлтэй байдгаас 91664 га талбайг эзэмшиж, жилдээ 48.0-49.0 мянган га-д тариалан 40-42 мянган га-д уринш хийж ашиглалт 100 хувь байна. 2019 онд 40498 га-д үр тариа, үүнээс буудай 39464 га-д, хоёрдогч үр тариа 1034 га-д, тэжээлийн ургамал 1183 га, тосны ургамал тариалан уринш, үр тариа, тэжээл болон тосны ургамал гэсэн сэлгээгээр ээлжлэн тариалж байна.	100

2.2.5 Газар тариалангийн үйлдвэрлэлд дэвшилтэт шинэ техник, технологи нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж, усалгаатай талбайг нэмэгдүүлэн, эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулах замаар тогтвортой ажлын байр бий болгоно.

165	2.2.5.5. Техник технологи, ажиллах хүч сайтай аж ахуйн нэгжийг сонгож үрийн нөөцийн 2 аж ахуй байгуулах	2016-2019	ХХААГ	Үрийн аж ахуй бэхиж, ганд тэсвэртэй, сайн чанарын нутагшсан үрээр дотоодын хэрэгцээгээ хангана.	ОХУ-ын Красноярск хотын ХАА-н Их сургуультай хамтран 3 бүсэд Сибирийн сортуудыг турших гэрээ хийгдэж, Сэлэнгэ сумын "Ингэт толгой" ХК, Тэшиг сумын "Шинэ амжилт" ХХК 3 сортын буудайг турших тариалалт хийсэн. Мөн Хутаг-Өндөр сумын "Улаан буудайн Эх газар" ХХК, Сэлэнгэ сумын "Ингэт толгой" ХК, "Оргилдэлгэр" ХХК нутагшсан элит үрээр үр үржүүлэх тариалалт хийсэн. Аймгийн тариалж байгаа буудайн үрийн 76 хувийг нутагшсан Дархан-144, Дархан 131, Буриадская остистая, Сэлэнгэ сорт тус тус эзэлж байна. Хутаг-Өндөр сумын "Ургац хангай" ХХК, "Улаан буудайн эх газар" ХХК, Бүрэгхангай сумын "Төлүүжин" ХХК Дархан-Уул аймгийн Ургамал газар тариалан, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс үйлдвэрлэлд нэвтрүүлж байгаа Дархан 166 сортын үрийг үржүүлэн үрэнд нөөцөлсөн.	70
166	2.2.5.6. Үр тарианы үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид нийцсэн өндөр хүчин чадлын техникийн хангамжийг нэмэгдүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Үр тарианы таримлын парк шинэчлэлийг 60 хувьд хүргэнэ.	"Атрын 3" аяны хүрээнд үр тарианы 9 аж ахуйн нэгж, 1 иргэн нийт 12 комбайн, чиргүүл, дүүжин машинаар хангагдсан. 2019 онд Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн хөнгөлөлттэй нөхцөлөөр 6 аж ахуйн нэгжид "Омичка" үрлэгч, 2 аж ахуйн нэгжид хөрс боловсруулах техник олголоо. Газар тариалангийн үйлдвэрлэлийн 70 гаруй хувьд техник шинэчлэлт хийсэн байна.	100
167	2.2.5.7. Өрхийн тариалан эрхлэгчдийг хоршоо, бүлгийн зохион байгуулалтад оруулж дундын үйлчилгээний техникээр хангах	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Төмс хүнсний ногооны үйлдвэрлэлийн 70 хувийг механикжуулна.	"Шинэ хөдөө" төслийн хөрөнгө оруулалтаар Хутаг-Өндөр, Тэшиг, Булган, Бүрэгхангай, Орхон сумдад дундын үйлчилгээний төмс, хүнсний ногоо, хадлангийн зориулалтаар иж бүрэн техник, тоног төхөөрөмж нийлүүлээд байна. Үйлдвэрлэлийн зориулалт бүхий төмс, хүнсний ногооны тариалалт бүрэн механикжсан.	100
168	2.2.5.8. Хүнсний ногоо, жимс жимсгэний нэр төрлийг нэмэгдүүлэн, боловсруулах цех, "Нарлаг" хүлэмж байгуулахад дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Хамгаалагдсан хөрснөөс хүнсний ногооны 10 хувийг хураана.	"Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" төслийн 25.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хутаг-Өндөр суманд 60 м.кв талбай бүхий өвлийн хүлэмжийг барьж ашиглалтад оруулсны зэрэгцээ Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас 32 м.кв нийлэг хальсан хүлэмжийг 8 иргэн, 120 м.кв хүлэмжийг 1 иргэнд хөнгөлөлттэй зээлээр олгосон. Мөн "Шинэ хөдөө Булган" төслийн хөрөнгө оруулалтаар 4*8 хэмжээтэй 101 ширхэг зуны нийлэг хальсан хүлэмжийг иргэдэд олгосон. Булган сумын 4-р багийн иргэн Б.Амгалан өөрийн хөрөнгөөр 120 м.кв-ын нарлаг хүлэмж ашиглалтад оруулан тариалалт хийж байна.	70
169	2.2.5.9. "Чацаргана" хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ	Эдийн засгийн үр өгөөж дээшилж, ажлын байр нэмэгдэнэ.	"Булган жимс жимсгэнэ" дэд хөтөлбөрийн хүрээнд 16 сум, 1 тосгоны 1693 иргэн, 132 бүл, 661 өрхөд суулгац, арчилгаа, хамгаалалтын тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсний үр дүнд аймгийн хэмжээнд жимс жимсгэний талбай 715 га-д хүрч, үүний 98.3 хувийг чацарганын тариалалт эзэлж байна. "Шинэ хөдөө-Булган" төслийн хөрөнгө оруулалтаар 2018 онд 7 суманд 239.2 сая төгрөгөөр тус бүр нь 10 га талбайг услах хүчин чадал бүхий 8 иж бүрдэл дуслын усалгааны систем, 2019 онд 5 суманд 163.7 сая төгрөгөөр тус бүр нь 10 га талбайг услах хүчин чадал бүхий 7 иж бүрдэл дуслын усалгааны системийг тус тус нийлүүлснээр 11 сумын 150 га чацарганын талбайг сүүлийн үеийн дэвшилтэт дуслын усалгааны системээр хангасан. Мөн 247.6 сая төгрөгөөр Баян-Агт, Баяннуур, Бугат, Булган, Гурванбулаг, Могод, Орхон, Хангал, Хишиг-Өндөр суманд нарны үүсгүүр бүхий ус өргөгчтэй гүний худаг гаргах ажлыг тус тус хийсэн. Аймгийн хэмжээнд 15 суманд 31 ширхэг гүний худаг гаргаж усалгааны эх үүсвэрийг шийдвэрлэсэн.	70

170	2.2.5.10. Газар тариалангийн брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг механикжуулан, гарцыг нэмэгдүүлж, баталгаажуулах	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Аймгийн газар тариалангийн брэнд бог будаа, арвай, хөх тарианы бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж импорт бууран, экспорт нэмэгдэнэ.	Брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор арвайн үрийг шинэчлэн "Алаг эрдэнэ" сортыг Ургамал газар тариалан, эрдэм шинжилгээний хүрээлэнгээс авч тариалсан. Сүүлийн жилүүдэд бог будаа 28 га-д, арвай 171.5 га-д, хөх тариа 7 га-д тариалж, жилд дунджаар арвай 120 тн, бог будаа 80 тн, хөх тариа 15 тн-ыг хураан авч байна. Уламжлалт аргаар арвайн гурил, бог будаа үйлдвэрлэх арга технологийг Хангал суманд 8 өрх бүл, Сэлэнгэ суманд 10 өрх, 1 бүл эзэмшин үйлдвэрлэл эрхэлдэг. Хутаг-Өндөр сумын "Гурванборхууд" ХХК жилдээ 100-150 тн арвайн гурил үйлдвэрлэж зах зээлд борлуулж байна. Хэрэглэгчид органик хүнс хэрэглэх сонирхол нэмэгдэж байгаатай уялдан брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор Хангал, Хутаг-Өндөр, Сэлэнгэ суманд сум хөгжүүлэх сангаас 35.0 сая төгрөгийн зээл олгосон. Мөн "Сайхан харзтай" ХХК-ийн "Сэлэнгийн шим" будааны үйлдвэрлэлийг дэмжиж, "Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил" төслөөс 50.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн.	70
171	2.2.5.11. Хутаг-Өндөр суманд 15000 тонны багтаамжтай механикжсан элеватор барих	2016-2018	АЗДТГ, ХХААГ	Хутаг-Өндөр, Тэшиг, Баян-Агт сумын үр тариаг хадгалах боломж бүрдэнэ.	МУ-ын Засгийн газрын хөтөлбөрт тусгуулж, жил бүр санал уламжилж ажилласан хэдий ч, хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй байна.	ҮБ
172	2.2.5.12. Худалдааны төвийг түшиглэсэн 500-1000 тн-ы багтаамжтай механикжсан зоорийг энэ чиглэлийн бизнесийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийг түшиглэн Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Булган суманд байгуулах	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Төмс, хүнсний ногоог боловсруулах хадгалах тээвэрлэх, борлуулах тогтолцоог бий болгож, хүнсний аюулгүй байдал сайжирна.	Булган, Хутаг-Өндөр суманд механикжсан зоорь барих асуудлыг Засгийн газрын хөтөлбөрт тусгуулж, төсвийн саналыг жил бүр улсын төсөвт тусгуулахаар холбогдох яаманд хүргүүлдэг хэдий ч, хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй байна. Төмс, хүнсний ногооны механикжсан 200 тн багтаамжтай зоорь барих төсөл сонгон шалгаруулалтаар Булган сумын иргэн Азийн хөгжлийн банкны батлан даалтын сангийн санхүүжилтээр 250.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг авсан.	ҮБ
173	2.2.5.13. Биологийн гаралтай бордоо, ургамал хамгааллын бэлдмэлийг дотооддоо үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Био бордоо үйлдвэрлэх цехийг хойд, урд бүсэд тус бүр нэгийг байгуулсан байна.	"Чацаргана", "Хүнсний ногоо" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд тариалалттай хамт бордоог бэлтгэж, нөөшлөх талаар гарын авлага бэлтгэн сумдын ногоочин өрхүүдэд хүргүүлсэн. Орхон аймгийн "Мүгээ" хоршоотой хамтран био бордоо үйлдвэрлэлийн сургалт хийж, оролцогчдод 1 бүл /1500ш/ чийгийн хорхой олгосон. Энэ онд хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэл эрхлэгч нарт олгосон чийгийн улаан хорхойны бүлийн үржүүлгээс гарсан бордоог хаврын тариалтад ашигласан. Одоогоор иргэд, аж ахуйн нэгжүүдээс био бордоо үйлдвэрлэх төслийн санал ирүүлээгүй байна.	40
174	2.2.5.14. Хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалах, үржил шимийг сайжруулах зорилгоор сум бүрт тариалангийн талбайн 5-10 хувьд ойн зурвас байгуулах, тариалангийн талбайн хашааг сэргээн засварлах, шинээр барихад дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Эрсдэл бүхий тариалангийн талбайн 40-60 хувийг хашаажуулж, 4-8 мянган га-д ойн зурвас байгуулсан байна.	Хутаг-Өндөр суманд нийт тариалангийн талбайн 60 хувь буюу 22.2 мянган га, Хишиг-Өндөр сум 3515 га, Орхон 2900 га, Бүрэгхангай 4000 га, Бугат 2161 га тариалангийн талбайг хашаажуулсан. Энэ онд Рашаант сумын "Олон жимст төгөл" хоршоо жимсний 10 га талбайдаа хамгаалалтын зурвас тариалсан. 2007-2019 онуудад "Ногоон Ази" Олон улсын ТББ нь Баяннуур суманд 127 га, Дашинчилэн суманд 45 га-д цөлжилтийг бууруулах зорилгоор 200590 ширхэг мод тариалсан.	100
175	2.2.5.15. Мэдлэгт суурилсан, шинжлэх ухааны үндэслэлтэй үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүний нөөцийн чадавхийг сайжруулах	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	ХАА-н салбарын үйлдвэрлэл эрхлэгч нарын мэргэжлийн мэдлэг, ур чадвар нэмэгдэж, эрчимжсэн тариалан эрхлэх боловсон хүчнээр хангагдана.	Аймгийн тариаланчдын зөвлөгөөнийг жил бүр зохион байгуулж, жилд дунджаар 700 гаруй тариаланч, ногоочин, механикжуулагчдыг оролцуулж, төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, зөвлөхүүдээр төрөл бүрийн сэдвүүдээр сургалт хийлгэж, газар тариалан эрхлэгчдийн мэдлэг ур чадварыг нэмэгдүүлж байна. Мөн "Ургамал, түүний гаралтай бүтээгдэхүүнд гарал үүсэл олгох" сургалтыг Булган суманд 2 удаа, Орхон, Хангал сум, Хялганат тосгонд 1 удаа тус тус зохион байгуулж, нийт 156 өрхийн тариаланчдыг хамрууллаа.	100

2.3 Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ:

“Булган” үйлдвэрлэл, технологийн төвийг байгуулж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарыг төрөлжүүлэн хөгжүүлж, орон нутгийн үйлдвэрлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг хэрэглэх боломжийг бүрдүүлж, төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, аж ахуйн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

176	2.3.1.1. “Булган” үйлдвэрлэл, технологийн төв байгуулж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах, бизнес эрхлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Байгаль орчинд сөрөг нөлөөгүй, шинэ дэвшилтэт техник, технологи бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болно.	Булган, Орхон сумын хилийн зааг “Домын дэвсэг”-д 140.4 га газарт үйлдвэрлэлийн бүсийг төлөвлөж, “Техник технологи, инноваци нутагшуулах үйлдвэрлэлийн бүсийн ТЭЗҮ боловсруулах” ажлыг “Эс ай си эй” ХХК-иар гүйцэтгүүллээ. Тус бүсэд байрлаж буй “Бүрэн луу” ХХК-ийн “Мах бэлтгэх, хөргүүртэй зоорь”-ийн барилга, тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг дуусгаж, шинээр өргөтгөлийн барилга бариад байна.	40
177	2.3.1.2. Ойн нөөцөд түшиглэн мод боловсруулах, модоор эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх эко үйлдвэр байгуулах санал санаачлагыг дэмжих	2016-2020	АЗДТГ, БОАЖГ	Ойг цэвэрлэж шахмал түлш, модон эдлэлийн үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжиж, ажлын байр нэмэгдэнэ.	“Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан”-гаас Булган сумын тавилгын үйлдвэрлэлийн төсөлд 50.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. “Билгүүн Дэлгэрэх” ХХК-ийн шахмал түлшний үйлдвэр жилд дунджаар 40-50 тн шахмал түлш үйлдвэрлэж, иргэдийн хэрэгцээнд нийлүүлж байна. Сэлэнгэ сум “Ингэт дөл” ОНӨААТҮГ байгуулж, 8.0 сая төгрөгийн хөрөнгөөр ашиглалтгүй байсан барилга объектыг засаж, шахмал түлшний үйлдвэрийн байр болгон ашиглаж байна. Аймгаас үйл ажиллагааг нь дэмжиж 192.9 сая төгрөгийн өртөг бүхий шахмал түлшний үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлсэн боловч, эвдрэл, гэмтлийн ойн улмаас үйл ажиллагаа нь зогсоод байна. НҮБ-ын Ойн төслөөс Булган аймгийн ойн нөхөрлөлүүдийн холбоонд ойн арчилгаанаас гарсан унанги модыг ашиглан хорголжин түлш бэлтгэх болон хусны нүүрс үйлдвэрлэх бага оврын тоног төхөөрөмжүүд олгож, үйл ажиллагаа явуулж байна. Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Сайхан, Булган, Бугат зэрэг суманд модон эдлэлийн үйлдвэрлэл эрхлэгчид тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.	70
178	2.3.1.3. Аймагт түгээмэл тархсан барилгын материалын түүхий эдийг боловсруулах, цемент, барилгын бетон хийц, өнгөлгөөний тоосго, улаан тоосго, хөнгөн блок, зуурмагны үйлдвэр зэрэг барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх	2016-2020	АЗДТГ, ГХБХБГ, СЗД Хувийн хэвшил	Иргэдийн эрэлт хэрэгцээг хангаж, зардлыг хэмнэнэ.	ЖДҮХС-аас барилгын бетон хийц, барилгын тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэхэд 175.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээл олголоо. “Булган барилга” ХХК Бугат сумын нутагт хүрмэн чулууны ашиглалтын, “Нарангийн бугат” ХХК хайрга олборлолтын чиглэлээр хайгуулын тусгай зөвшөөрөл аваад байна. Аймгийн ИТХ-ын тогтоолоор 2017 онд барилгын материалын үйлдвэрлэлийн бүсийг тогтоосны дагуу тус бүсэд ЦДАШ, дэд станцыг барьж ашиглалтад оруулсан. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын материалын лабораторийн бетон шоо шахах прессийн ажиллагааг хийж гүйцүүллээ.	40
179	2.3.1.4. Аймгийн төвд шахмал түлшний үйлдвэр байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулах	2016-2020	АЗДТГ, ХХААГ, БОАЖГ	Ойг цэвэрлэж шахмал түлшний үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжиж, ажлын байр нэмэгдэнэ.	Булган сумын “Билгүүн Дэлгэрэх” ХХК-д шахмал түлшний үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэхэд “Сум хөгжүүлэх сан”-аас 50.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, жилд дунджаар 40-50 тн шахмал түлш үйлдвэрлэж, иргэдийн хэрэгцээнд нийлүүлж байна. Мөн “Булган мээж” ОНӨХХК-ийн үйл ажиллагааг өргөтгөж, шахмал түлшний үйлдвэрлэл эрхлэх эдийн засгийн үр өгөөжийн судалгааг хийж байна.	70
180	2.3.1.5. Аймгийн хэмжээнд орчин үеийн эко технологи бүхий ноос, ноолуур, арьс ширний анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр байгуулах	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Үйлдвэрлэлийн аргаар бэлтгэсэн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо өссөн байна.	“Шинэ хөдөө Булган” хөтөлбөрөөс 15 суманд нэг ээлжиндээ 25-аас дээш арьс боловсруулах хүчин чадал бүхий арьс, нэхий элдэх иж бүрэн тоног төхөөрөмж нийлүүлэгдэж байна. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас арьс шир боловсруулах чиглэлээр Булган сумын “Булган сорлог нэхий” ХХК 20.0 сая төгрөгийн зээлд хамрагдсан. “Тэнгэрийн түмний хийморь” ХХК-ийн “Булган кашимер” сүлжмэлийн цех тогтвортой ажиллаж байна. Арьс нэхий боловсруулах тоног төхөөрөмж худалдаж авахад Баян-Агт сум 10.0 сая, Дашинчилэн сум 15.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэгийг Сум хөгжүүлэх сангаас үзүүлсэн. “Техник технологи, инноваци нутагшуулах үйлдвэрлэлийн бүс”-д орон нутгийн нөөцөд түшиглэсэн 2.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий ноос боловсруулах, 836.0 сая төгрөгийн арьс, ширний боловсруулах үйлдвэр байгуулахаар ТЭЗҮ боловсруулагдаад байна.	70

2.3.1 Орон нутгийн түүхий эд, нөөцөд түшиглэсэн дэвшилтэт технологи бүхий нэмүү өртөг шингээсэн жижиг, дунд үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

181	2.3.1.6. Орон нутгийн экологийн цэвэр брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэр төрлийг нэмэгдүүлэн, стандартын шаардлага хангасан улсын хэмжээнд өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Үндэсний болон орон нутгийн үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг хэрэглэх боломж бүрдэж, төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа өргөжинө.	Булган сумын "Хатан Мээж хайрхан" ХХК өөрийн хөрөнгө болон ЖДҮХС-ийн хөнгөлттэй зээлийн нийт 940.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хуучин барилга объектыг засварлан, хоногт 20 тн-ын хүчин чадалтай, технологийн уурын болон объектын халаалтын систем бүхий сүүний үйлдвэр байгуулж, үйлдвэрийн тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулаад байна. Хялганат тосгоны "Сүргийн нуга" ХХК-ийн Зөгийн балны үйлдвэр тогтворжиж, Булган сумын "Тунамал Өгөөж" ХХК-ийн цай, Сэлэнгэ сумын бог будаа үйлдвэрлэлд хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүлснээр үйл ажиллагаагаа өргөжүүлэн тогтвортой ажиллаж байна. Орон нутгийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтыг дэмжиж, "Намрын ногоон өдрүүд-Булганд үйлдвэрлэв", "Цагаан сар-Булган түншлэл" үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, шилдэг үйлдвэрлэгчдээ шагнаж урамшуулж хэвшлээ. Мөн орон нутгийн брэнд үйлдвэрлэгч 5 аж ахуйн нэгжийг Хүнсний аж үйлдвэрийн салбарын 90 жилийн ойг угтсан "Хүн ба хүнс" сэтгүүлд мэдээлэл сурталчилгааг нь бэлтгүүлж нийтлүүллээ. Монгол, Орос, Хятад улсын хамтарсан "Газар зүйн заалт ба бүс нутгийн хөгжил" бага хуралд "Айраг" үйлдвэрлэгч малчны төлөөллийг оролцуулж, олон улсын туршлага судлууллаа.	70
182	2.3.1.7. Орон нутагт жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдэд бизнесийн тэгш боломж олгох, зээл тусламжид хамруулах, бүтээгдэхүүний борлуулалтад дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, Хувийн хэвшил	Аж ахуйн нэгж иргэд ажилтай орлоготой байна.	Сум хөгжүүлэх сангаас 2017-2019 онуудад 632 төсөлд 3.9 тэрбум төгрөгийн зээл олгосноор 823 ажлын байр шинээр бий болж, 624 ажлын байр хадгалагдан үлдсэн байна. "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам"-ын дагуу төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж, 17 зээлдэгч 891.5 сая төгрөгийн санхүүжилт авч, 4 зээл хүсэгчийн материалыг банк судалж байна. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Эх үүсвэртэй зээлийн батлан даалтын сан"-аас 3 аж ахуйн нэгж, иргэн 500.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээлд хамрагдсан байна. ХХААХҮЯ-ны ЖДҮХС-аас 1 иргэн 678.0 сая төгрөгийн зээлд хамрагдсан. Үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид болон орон нутгийн онцлог брэнд бүтээгдэхүүнийг улс, бүс, орон нутгийн хэмжээнд сурталчлах зорилгоор "Монголд үйлдвэрлэв", "Намрын ногоон өдрүүд", "Булганд үйлдвэрлэв", "Хөдөлмөрийн яармаг" зэрэг үзэсгэлэн худалдаануудад нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар ханган оролцуулж хэвшлээ. Жижиг, дунд үйлдвэрлэл, аялал жуулчлал, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхжуулах сургалт, инновацийн төсөлд буцалтгүй дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Германы ОУ-ын хамтын ажиллагааны нийгэмлэгийн "ЭТИС" хөтөлбөрийг аймагт хэрэгжүүлж эхэлсэн.	100
183	2.3.1.8. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх бүтээн байгуулалтад орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагууд, бизнес эрхлэгчдийг оролцуулах бодлого барьж ажиллах	2016-2020	АЗДТГ, ОНӨГ	Аж ахуйн нэгж байгууллага, бизнес эрхлэгчид чадавхижна.	Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд хуулийн дагуу орон нутгаас хамгийн их ажиллах хүч авсан аж ахуйн нэгжид дотоодын давуу эрх тооцон ажиллаж байна. Сүүлийн гурван жилийн байдлаар нийт 4.0 тэрбум төгрөгийн 53 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр орон нутгийн аж ахуйн нэгжүүд шалгарч, аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй ажилгүй 520 гаруй хүнийг түр ажлын байраар хангасан байна.	100
184	2.3.1.9. Булган, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Орхон сумдын гурилын үйлдвэрүүдийг тогтвортой үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, ХХААГ	Аймгийн хүн амын болон бүсийн аймгуудын гурилын хэрэгцээг хангаж, мал, амьтны тэжээлийн үйлвэрүүдийг байгуулна.	"Хангайн гурил" ХХК гурилын үйлдвэрийн тоног төхөөрөмж, технологийг сайжруулж, дээд гурил үйлдвэрлэх дамжлагатай болж, үйлдвэрлэл жигдэрсэн. "Хонгор-Агро" ХХК-ийн гурилын үйлдвэрээс бусад үйлдвэрүүд нөөцөлсөн будааныхаа хэмжээгээр үйлдвэрлэл явуулж байна.	40

185	2.3.1.10. Хүн, амын хүнсний хангамжийг хэмэгдүүлэх зорилгоор “Мах”, “Сүү” аяныг зохион байгуулах	2016-2020	АЗДТГ, ХХААГ	Аймгийн хүн амын болон бүсийн аймгуудын мах, сүүний хэрэгцээг хангаж, үйлдвэрүүд, цехүүд бий болно.	ЖДҮХС-аас мах, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйг дэмжиж 5 төсөлд 202.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээл олголоо. "Буман сүхэс" ХХК-д орон нутгийн өмчийн барилга объектийг гэрээний дагуу ашиглуулж, ажлын байртай болгосон. "Хатан Мээж хайрхан" ХХК хоногт 20 тн сүү боловсруулах хүчин чадалтай үйлдвэр байгууллаа. Хутаг-Өндөр, Сайхан, Хангал, Сэлэнгэ, Орхон, Дашинчилэн, Бугат суманд 20 фит-ын контейнерт суурилагдсан 3 тн сүү агуулах хүчин чадалтай шинжилгээний багаж бүхий сүүний хөргөлтийн танк, Сайхан суманд айраг хадгалах 40 тн-ын хөргүүрт чингэлгийг тус тус хүлээлгэн өгөөд байна. "Хутаг-Өндөр сумын мах маркет" ХХК үйлдвэрийн байранд капитал засвар хийж, өргөтгөлийн барилга шинээр барьж, махны үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тогтворжууллаа. Тэшиг суманд бяслагны үйлдвэрлэл, Сэлэнгэ суманд "Халзаадай" нэртэй цех тараг савлаж үйл ажиллагаагаа эхэлсэн. Хутаг-Өндөр суманд хуурай сүүний үйлдвэр байгуулахаар тоног төхөөрөмжийг суурилуулсан. Канадын элчин сайдын яамнаас "Бялхам үндэс" ТББ-ын сүү, цагаан идээ боловсруулах үйлдвэрийн төсөлд 60.0 сая төгрөгийн дэмжлэг, тоног төхөөрөмж олгосноор үйл ажиллагааг эхлүүлээд байна.	70
186	2.3.1.11. Орхон голын зүүн эргийн базальтын ордод түшиглэсэн барилгын дулаалгын материал болон шилэн хөвөнгийн үйлдвэр байгуулах санал санаачлагыг бодлогын түвшинд дэмжих	2016-2020	АЗДТГ, ГХБХБГ, ХХААГ	Аймаг, орон нутгийн иргэд барилгын чанартай материалаар хангагдана. Ажлын байр нэмэгдэнэ.	Орхон голын зүүн эргийн базальтын орд газрыг 2004 оноос "Бэрэн групп" ХХК эзэмшиж, өнөөдрийг хүртэл ашиглалтгүй байгаа бөгөөд энэ онд тус ордтой хил залгаа талбайд "Хөх хайрга" ХХК-аас хөнгөн бетоны түүхий эдийн хайгуулын тусгай зөвшөөрөл авахыг хүсч, аймгийн Засаг даргад ирүүлсэн холбогдох материалыг судалж байна.	40
187	2.3.1.12. Хүнсний зориулалтын сав, Цэвэр усны үйлдвэр байгуулахыг дэмжих	2016-2020	АЗДТГ, ХХААГ	Хүнсний зориулалтын бус савны хэрэглээ буурна. Иргэдийн цэвэр усны хэрэглээг бүрэн хангагдана.	Ус хадгалах сав, хүнсний зориулалтын бус хуванцар савны тэмдэг тэмдэглэгээ, хэрэглээний талаар Булган, Бугат, Хутаг-Өндөр сумын 200 гаруй иргэдэд 8 төрлийн 1600 гаруй гарын авлага бэлтгэн тарааж ажилласны дүнд иргэдийн хэрэглээ багасаж байна. Аймгийн Засаг даргын захирамжаар энэ онд удирамжийн дагуу 16 сум, 1 тосгоны 309 малчин өрхийн 694 малчин, 2 төрийн байгууллагын 30 ажиллагсад, 60 гаруй тариаланч, 200 төлчин эмэгтэй, 150 орчим хоол, хүнс үйлдвэрлэгч, иргэдэд ус хадгалах сав, хүнсний зориулалтын бус хуванцар савны тэмдэг тэмдэглэгээ, хэрэглээний талаар 4 төрлийн 4000 гаруй гарын авлага бэлтгэж, ухуулан сурталчиллаа.	40
188	2.3.2.1. Бизнес эрхлэгчдийн мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах	2016-2020	АЗДТГ	Хувийн хэвшлийн салбарт ажиллагсдын мэргэжлийн үр чадвар дээшилнэ.	Аймаг, орон нутгийн бизнесийн орчныг сайжруулах, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээний хөгжилд дэмжлэг үзүүлэхээр Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн "Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага" хөтөлбөрийг аймгийн Засаг даргын дэргэд "Тогтвортой хөгжил-түншлэлийн зөвлөл" байгуулан хэрэгжүүлж эхлээд байна. "Аялал жуулчлалын үр чадварын төв"-тэй хамтран Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулах 10 мэргэжлийн сургалтад 230 гаруй иргэнийг сургалаа. Улс, бүс, аймаг орон нутгийн тогооч, зөөгч бармен, нарийн боовчны үр чадварыг дээшлүүлэх сургалт нэгдсэн арга хэмжээ, "Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх нь" форум, "Хангинахын шугуйн шагайн тойром", "Мөсний шагай", "Эв мод-бага алтаргана" зэрэг эвэнт арга хэмжээнүүдийг мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгууллаа. Хутаг-Өндөр суманд Тогооч нарын холбоотой хамтран хойд бүсийн тогооч нарын бүсчилсэн сургалт, "Монгол хатад гэрэлтүүлэхүй" ТББ болон бусад мэргэжлийн холбоодтой хамтран "Бизнесийн шинэ боломж-2019" Булган хангайн эмэгтэйчүүдийн зөвлөлдөх уулзалтыг тус тус зохион байгууллаа.	100

2.3.2 Худалдаа, үйлчилгээний салбарыг төрөлжүүлэн хөгжүүлж, эрүүл ахуйн орчин нөхцлийг сайжруулж, шударга өрсөлдөөнийг бий болгоно.

189	2.3.2.2. Ахуйн үйлчилгээний төвүүдийг бий болгож, явуулын үйлчилгээ эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх	2016-2020	АЗДТГ, Хувийн хэвшил	Худалдаа, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлнэ.	"Тэнгэрийн түмний хойморь" ХХК сурагчийн дүрэмт хувцас, ноос ноолууран сүлжмэл бүтээгдэхүүн, ажлын хувцас, аранз үйлдвэрлэж, Орхон, Бүрэгхангай, Баяннуур, Дашинчилэн, Гурванбулаг, Хишиг-Өндөр зэрэг суманд явуулын үйлчилгээгээр хүргэж байна. "ХАА-н нэмүү өртгийн сүлжээг дэмжих техник тусалцааны төсөл"-ийн хүрээнд "Хувцасны худалдаа-зах зээлийн боломж" сэдэвт сургалтад аймгийн оёдлын салбарын төлөөллийг хамрууллаа. Сайхан сумын ЗДТГ-т орон нутгийн өмчийн байранд ажиллаж буй ахуйн үйлчилгээний цэгийн үйл ажиллагааг байгаа зориулалтаар үргэлжлүүлэх чиглэл өглөө. "Монполимент" ХХК Дашинчилэн сумын Засаг даргын Тамгын газарт ахуйн үйлчилгээний цогцолборын барилгыг хүлээлгэж өгсөн. Сэлэнгэ сум "Зах зээл бэлчээрийн удирдлагын менежмент" төслөөр хуучин Тамгын газрын байранд засвар хийж, Хутаг-Өндөр сум ахуйн үйлчилгээний байранд засвар тохижилт хийж иргэдийг ажлын байраар хангаад байна.	40
190	2.3.2.3. Бизнесийн жишигт нийцсэн "Худалдааны битүү зах" барих, бөөний худалдааны сүлжээг өргөтгөхөд хувийн хэвшлийн санал санаачлагыг дэмжих	2016-2020	АЗДТГ, ХХААГ, Хувийн хэвшил	Бөөний болон жижиглэнгийн худалдааны төв байгуулж, хүнсний бүтээгдэхүүний борлуулалтын оновчтой сүлжээг бий болгосон байна.	Аймгийн Засаг даргын захирамжаар 2017 онд Булган сумын 6-р баг "НИК" ШТС-ийн урд 1350 м.кв газарт Бизнесийн жишигт нийцсэн худалдааны төв барихаар шийдвэрлэсэн. "Их Азар" ХХК-ний төрөнгө оруулалтаар орчин үеийн шаардлагад нийцсэн "Ханжаргалант" худалдааны төвийг ашиглалтад оруулж, 50 гаруй худалдаа эрхлэгчид үйл ажиллагаа явуулж байна.	100
191	2.3.2.4. Үйлчилгээний ажилтнуудын мэргэжлийн түвшинг дээшлүүлж, үйлчилгээний стандарт хангалтыг сайжруулахад бодлого, үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ СХХ Хувийн хэвшил	Худалдаа, үйлчилгээний чанар сайжирч хүртээмж нэмэгдэнэ.	"Аялал жуулчлалын ур чадварын төв"-тэй хамтран аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулах 10 мэргэжлийн сургалтад 230 гаруй иргэнийг сургалаа. Улс, бүс, аймаг орон нутгийн тогооч, зөөгч бармен, нарийн боовчны ур чадварыг дээшлүүлэх сургалт нэгдсэн арга хэмжээ, "Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх нь" форум, "Хангинахын шугуйн шагайн тойром", "Мөсний шагай", "Эв мод-Бага алтаргана" зэрэг эвент арга хэмжээг мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгууллаа. Хутаг-Өндөр суманд Тогооч нарын холбоотой хамтран хойд бүсийн тогооч нарын бүсчилсэн сургалт, "Монгол хатад гэрэлтүүлэхүй" ТББ, болон бусад мэргэжлийн холбоодтой хамтран "Бизнесийн шинэ боломж-2019" Булган хангайн эмэгтэйчүүдийн зөвлөлдөх уулзалтыг тус тус зохион байгууллаа. Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран 3 удаагийн гадаад худалдаа, 2 удаа дотоодын үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, аж ахуйн нэгж, иргэдийг хамруулахад дэмжин ажиллалаа.	70
192	2.3.2.5. Бараа ажил үйлчилгээний худалдан авалтад орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн стандартын шаардлагад нийцсэн бараа, бүтээгдэхүүнийг авч ашиглах нөхцөлийг бий болгох	2016-2020	АЗДТГ, СХХ, Хувийн хэвшил	Аж ахуйн нэгж, иргэд ажилтай орлоготой байна.	Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулахаар 16 сум, 1 тосгонд ажиллаж, 10 төрлийн 130 үйлчилгээ, 12 нэрийн бүтээгдэхүүнд тохирлын үнэлгээ хийж, гэрчилгээг олгож баталгаажууллаа. Үйлдвэрлэл, үйлчилгээний салбарыг борлуулалтаар дэмжих зорилгоор 2016 оноос аймгийн Засаг даргын захирамжаар орон нутгаасаа худалдан авалт хийж байх УРИАЛГА гарган, хэрэгжилтийг 7 хоног бүрээр тооцон ажиллаж байна. Төр, төсвийн байгууллагууд сүүлийн 3 жилд аймгийн төвийн үйлдвэрлэл, үйлчилгээний газруудаас нийт 6.2 тэрбум төгрөгийн худалдан авалт хийж, зарим төрлийн эм эмнэлгийн хэрэгсэл, автомашины сэлбэгээс бусад хэрэгцээт бараа ажил үйлчилгээгээ орон нутгаасаа авч хэвшлээ.	100
193	2.3.2.6. Орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтыг худалдааны сүлжээ бий болгох замаар дэмжих	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Үйлчилгээ эрхэлж буй газруудын орчин нөхцөл сайжирч, борлуулалт нэмэгдэнэ.	Засгийн газраас 2019 оныг "Эх оронч худалдан авалтыг дэмжих жил" болгон зарласныг аймгийн Засаг дарга дэмжиж нийт иргэд, төрийн албан хаагч, төрийн байгууллагууд, бизнес эрхлэгчдэд хандаж орон нутгийнхаа үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг ажил, үйлчилгээг дэмжих Уриалгыг шинэчлэн гаргаж, иргэд олон нийтэд сурталчиллаа. Аймаг, сумын төрийн болон төрийн өмчит байгууллагууд нийт 6.2 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг орон нутгийн бизнес эрхлэгчдээс худалдан авчээ.	70

194	2.3.2.7. Томоохон зах, худалдааны төв болон олон нийт ихээр цуглардаг газруудад эрүүл ахуйн шаардлага хангасан нийтийн боловсон бие засах газар /эко 00/ байгуулж, орчин нөхцөлийг нь сайжруулах	2016-2020	АЗДТГ, ХХААГ, СЗД	Үйлчилгээ эрхэлж буй газруудын орчин нөхцөл сайжирна.	2018 онд аймгийн "Хүүхэд, залуучуудын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн"-д боловсон бие засах газар ашиглалтад оруулж, орчныг тохижуулсан. "Шинэ хөдөө Булган" хөтөлбөрийн хүрээнд 2019 онд Бугат сумын "Төлүүгийн даваа"-нд авто зам дагуу худалдааны цэг, нийтийн боловсон бие засах газар, Булган сумын 1-р багт худалдааны цэг, Хутаг-Өндөр сумын "Дондогийн булаг"-т нийтийн бие засах газар шинээр байгуулах ажлыг эхлүүлээд байна.	70
195	2.3.2.8. Шинээр ашиглалтад орж буй аж ахуйн нэгж байгууллагын хэмжих хэрэгслийг баталгаажуулах эталон тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийхэд дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, СХХ	Шинэ техник, технологи бүхий хэмжих хэрэгслүүдийг шалгаж баталгаажуулах боломжтой болно.	2018 онд дулаан, даралтын шинэ эталон төхөөрөмжийн шинэчлэлт хийснээр дулааны манометрүүд /ДЦСтанц/, цусны даралтын электрон аппаратыг шалгаж баталгаажуулан, баталгаажуулалтын түвшин өмнөх оноос 41 хэмжих хэрэгслээр нэмэгдсэн дүнтэй байна. 2019 онд хэмжил зүйн лабораторийн ажлын эталон төхөөрөмжийг нэмэгдүүлэн уртын хэмжүүрийг шалгаж баталгаажуулах 0.2% нарийвчлалтай 10 м туузан метр, гялгар уутны зузаан хэмжигч, секундомер зэрэг багаж хэрэгслийг авч бэлтгэсэн. График төлөвлөгөөний дагуу ээлжит баталгаажуулалтаар 1 ба 3 фазын тоолуур 1593, эзэлхүүний 254, массын 440, даралтын 148, нийт 2435 хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулан хэмжлийн үнэн зөв нэгдмэл байдлыг хангаж ажиллалаа.	100
196	2.3.2.9. Орчин үеийн шийдэл бүхий стандартын шаардлагад нийцсэн нийтийн хоолны үйлчилгээний газар байгуулах, хувийн хэвшлийн санаачлагыг дэмжих	2016-2020	АЗДТГ, СХХ	Хоолны газруудын орчин, нөхцөл сайжирч, хэрэглэгчдийн сэтгэл ханамж нэмэгдэнэ.	16 сум, 1 тосгоны 53 цэгт "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага" MNS 4946:2019 шинэчилсэн стандартаар мэдээлэл хийж, 42 цэгийн үйл ажиллагааг баталгаажуулан тохирлын үнэлгээ хийж, дэмжлэг үзүүллээ.	100

2.4 Байгаль орчин, ногоон хөгжил:

Байгаль дэлхийгээ хайрлан хамгаалж, хүрээлэн буй орчны доройтлыг бууруулан, агаарын бохирдлоос урьдчилан сэргийлж, эрүүл, аюулгүй, ногоон хөгжлийг бий болгон, байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлж, байгаль хамгаалах үүргийг бүх нийтийн үйл хэрэг болгоно.

197	2.4.1.1. "Ногоон хөгжлийн хэтийн зорилт" бодлогын бичиг баримтыг боловсруулж, хэрэгжүүлэх	2016-2020	АЗДТГ, БОАЖГ, СЗД	Ногоон Эдийн засаг хөгжих чиг хандлага тодорхой болно.	"Ногоон хөгжлийн хэтийн зорилт"-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 57 дугаар тогтоолоор батлуулсан. 2017-2018 оны төлөвлөгөөний биелэлт 86.3 хувьтай үнэлэгдсэн. 2019 онд байгаль орчин, ногоон хөгжлийн чиглэлээр 53 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 5.4 тэрбум төгрөгийн хөрөнгө төлөвлөж ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна.	70
198	2.4.1.2. Хүүхэд, залуучуудад экологийн боловсролыг олгох хөтөлбөр боловсруулж, байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах зан үйлийг хэвшүүлж, байгальд ээлтэй сургуулиудыг бий болгох	2016-2020	АЗДТГ, БОАЖГ, БСГ	Экологийн боловсролыг нэмэгдүүлнэ.	"Хүүхэд, залуучуудад экологийн боловсролыг олгох хөтөлбөр"-ийг 2017 онд аймгийн ИТХ-аар батлуулж, "Эко сургууль", "Эко цэцэрлэг" шалгаруулах болзолт уралдаан, байгаль орчныг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, байгальд ээлтэй үр ашигтай хэрэглээний соёлыг төлөвшүүлэх чиглэлээр оюутан, залуучуудын дунд явуулах төслийн уралдаан, Хүүхдийн өөрөө удирдах байгууллагуудыг дэмжсэн төслийн уралдааныг зарлаж, амжилттай зохион байгуулсан. Хөтөлбөрийн хүрээнд 2018, 2019 онд "Эко сургууль" болзолт уралдаанд тэргүүлсэн Тэшиг сумын сургууль, Эрдмийн өргөө сургуулийн "Эко зөвлөл"-ийн багш, сурагчдыг урамшуулан НҮБ-ын Ойн төсөлтэй хамтран Рашаант сумын "Хөгнө тарна"-ын цогцолборт газар, Дашинчилэн сумын "Хар бухын балгас"-ын чиглэлд эко аялалд хамрууллаа. Экологийн боловсрол олгох сургалтыг Хишиг-өндөр, Хутаг-Өндөр, Хангал, Дашинчилэн суманд бүсчлэн зохион байгуулж, сургагч багш нарыг бэлтгэлээ.	100

37

2.4.1. Байгалийн нөөц, түүний нөхөн сэргэх чадвар, хувьсал, өөрчлөлтийн чиг хандлага, нийгмийн дэвшлийг түргэтгэх шаардлагатай уялдуулан дасан зохицох, нөөц баялгийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, орчны бохирдлыг арилгах үйл ажиллагааг хэрэгжүүлэх

199	2.4.1.3. Агаар, хөрсний бохирдлын судалгаа шинжилгээг тогтмолжуулж, бохирдлоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэх	2016-2020	БОАЖГ, УЦУОША	Агаарын бохирдлыг бууруулж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	"Булган сумын агаарын чанарыг сайжруулах бүс"-ийг тогтоож, бүсэд мөрдөх журмыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Засаг даргын хамтарсан 2018 оны А/364, А/548 дугаар тушаал, захирамжаар батлууллаа. "Агаарын бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр"-ийн 1-р шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж, 76.25 хувьтай үнэлүүллээ. Булган аймгийн төвд агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар ислийн шинжилгээг хийж, агаарын чанарын MNS4585:2016 стандарттай харьцуулахад агаарын бохирдол хүлцэх хэмжээнээс давсан тохиолдол гараагүй. 2019 онд Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийг явуул судалгааны агаараас дээж авах мини памп, хөрсний шинжилгээний боловсруулалтад хэрэглэгдэх багаж, цаг агаарт зориудаар нөлөөлөх ажилд дэмжлэг үзүүлэх тусгай зориулалтын автомашинаар хангалаа.	100
200	2.4.1.4. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах, шингэрүүлсэн хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагыг бодлогоор дэмжих	2016-2020	АЗДТГ, БОАЖГ, СЗД	Агаарын бохирдлыг бууруулж, эрчим хүчийг тодорхой хэмжээгээр хэмнэнэ.	Хишиг-Өндөр суманд сэргээгдэх эрчим хүчний зориулалтаар 145 га газрыг "Булган солар энерги" ХХК-д эзэмшүүллээ. Аймгийн хэмжээнд хийн түлшний шатахуун түгээх 3 станц байгуулагдан ажиллаж байна.	70
201	2.4.1.5. Иргэдийн байгаль орчныг хамгаалах талаар мэдлэг, боловсролыг нэмэгдүүлэх, уламжлалт зан үйл, зөв дадал зуршлыг сэргээн хөгжүүлэх сургалт сурталчилгааг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, байгаль орчныг хамгаалах үүргийг бүх нийтийн үйл хэрэг болгох	2016-2020	НБХ, БОАЖГ, СЗД	Байгаль орчноо хайрлан хамгаалах дадал зуршлыг бий болгоно.	2017 онд "Усны нөөцийн ашиглалт, хамгаалалт", "Усны сав ба эрүүл мэнд", "Усны бохирдол", "Ус хэмнэх аргууд", "Сургуулийн усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуй", "Ойд арчилгааны огтлолт хийх", "Ойн хортонтой механик болон гэрлэн урхиар тэмцэх" зэрэг сэдвээр ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчид, ойн нөхөрлөлийн гишүүдэд сургалт зохион байгуулсан. 2018 онд Сэлэнгэ суманд зохион байгуулсан "Ойн харилцаанд оролцогчдын зөвлөлдөх уулзалт"-д аж ахуйн нэгж, нөхөрлөлүүдийн төлөөлөл 70 гаруй хүнийг оролцуулж, аймгийн "Ойн талаар баримтлах бодлого"-ыг танилцууллаа. "Мөнх ногоон жодоо" ХХК-иас Тэшиг, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Хангал сумын ойн нөхөрлөлүүдийн ойн санд ой зохион байгуулалтыг хийж, нөхөрлөлүүдийн гишүүдэд ой зохион байгуулалтын материал дээр ажиллах, ойг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх сургалтыг зохион байгуулсан. 2019 онд Ойн тухай хуулийг хэрэгжүүлэхэд "Орон нутгийн өөрөө удирдах байгууллагын оролцоо" сэдэвт хэлэлцүүлэг сургалтыг сумын удирдлага, БОХУБ, байгаль хамгаалагч, цагдаа, прокурор болон ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлүүдийг оролцуулан Булган, Хутаг-Өндөр, Бүрэгхангай сум, Хялганат тосгонд бүсчлэн зохион байгуулж, нийт 268 хүн оролцлоо. Баян-Агт, Булган суманд "Байгальд эвсэг аялал жуулчлал" зөвлөгөөнийг зохион байгуулж, Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын "Нийлэг хальсан уутыг хориглох тухай" 189 дүгээр тогтоолыг танилцуулж, аймгаас хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр хийж буй ажлын талаар мэдээлэл хийлээ.	100
202	2.4.1.6. Аливаа төслийг хэрэгжүүлэхийн өмнө байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгүүлсний үндсэн дээр дараагийн шатны үйл ажиллагааг хэрэгжүүлж хэвшүүлэх	2016-2020	БОАЖГ, СЗД	Орчны сөрөг нөлөөлөл багасна.	2016-2019 онд төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 147 төсөлд Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ. Төсөл хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагааны явцад байгаль орчинд сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй гэж үзэн эрсдлийг багасгах, арилгах арга хэмжээг төлөвлөн тодорхой нөхцөл, болзолтойгоор хэрэгжүүлж байна.	100

		203	2.4.1.7. Орчны бохирдлыг бууруулах, хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, байгальд халгүй аргаар устгах дэвшилтэт арга технологи нэвтрүүлж, аймгийн төвийн гэр хорооллын айл өрхийг хог төрөлжүүлэн хийх хогийн савтай болгон хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэлийг эхлүүлэх	2016-2020	АЗДТГ, БОАЖГ, СЗД		Орчны бохирдлыг бууруулан, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. 4-өөс доошгүй хүнийг ажлын байраар хангана.	Булган сумын гэр хорооллын айл өрхөд хог төрөлжүүлэн хийх 2658 ширхэг хогийн сав байрлуулах ажлыг "Булган барилга", "Өвөлжөөн булаг", "Хурмастын хүлэг", "Тана Орд" ХХК-аар гүйцэтгүүлээ. Мөн сумдын төвийн нийтийн эзэмшлийн талбайд нийт 204 ширхэг хог төрөлжүүлэн хийх хогийн сав байрлуулсан. Хог ангилан ялгах цехийн үйл ажиллагааг жигдрүүлж, хаягдал ясаар малын хүчит тэжээл, хуучирсан хашин тосыг ашиглан саван, хуванцарыг хайлуулан хашааны шон хийж эхлээд байна. Мөн тус цехийн хашаанд Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр гүний худаг гаргаж өгсөн.	100
		204	2.4.1.8. Аймгийн төвийн цэвэрлэх байгууламж барих	2017-2020	АЗДТГ, БОАЖГ, ГХБХБГ		Орчны бохирдлыг бууруулан, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	Аймгийн төвийн цэвэрлэх байгууламжийг Азийн хөгжлийн банкны 8.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Заг инженеринг" ХХК гүйцэтгэхээр шалгарч, барилга угсралтын ажил 60 хувьтай явж байна.	70
38	2.4.2 Усны нөөцийг хэмнэх, хуримтлуулах, зохистой ашиглах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн	205	2.4.2.1. Гидрогеологийн дунд масштабтай зураглал хийлгэж, Хишиг-Өндөр, Баяннуур, Баян-Агт, Гурванбулаг сумдын газрын доорх усны ашиглалтын нөөцийг нарийвчлан тогтоох	2017-2020	АЗДТГ, БОАЖГ, СЗД		Газрын доорх усны нөөцийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтвортой ашиглана.	Сумдын усан хангамжийн эх үүсвэрийн газрын доорх усны ашиглалтын нөөцийг тогтоох хөрөнгийн эх үүсвэрийг судалж байна. 2020 оны төсөвт Могод сумын Хульжийн рашааны нөөцийн судалгааг Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэхээр төлөвлөөд байна.	ҮБ
		206	2.4.2.2. Хүн амын усан хангамжийн 40 худагт эрүүл ахуйн шаардлага хангасан ус нөөцлөх сав суурилуулах	2017-2020	БОАЖГ, СЗД		Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангана.	2019 онд Баяннуур, Бүрэгхангай, Дашинчилэн, Орхон, Сэлэнгэ сум тус бүрт 1, Булган сумын 3 худагт эрүүл ахуйн шаардлага хангасан ус нөөцлөх сав суурилуулах ажлыг "Агро эрдэнэ" ХХК, "Булган Мээж" ХХК-ууд 26.4 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэлээ.	40
		207	2.4.2.3. Рашаант, Дашинчилэн суманд хур бороо, цасны усыг хуримтлуулах, хөв цөөрөм шинээр байгуулах, Могодын хөв, цөөрмийг сэргээн засварлах	2017-2020	БОАЖГ, ХХААГ, СЗД		Бэлчээр, газар тариалангийн усан хангамжийг шийдвэрлэх замаар газрын доорх усыг хэмнэж, цөлжилтийг сааруулна.	Дашинчилэн, Могод, Рашаант, Сайхан суманд хөв цөөрөм байгуулах зураг, төсөл боловсруулах ажлыг 29.3 сая төгрөгийн хөрөнгөөр "Жишиг проект" ХХК-аар гүйцэтгүүлж, Дашинчилэн сумын Цагаан үзүүр, Рашаант сумын Өлзийтийн арын хөв цөөрөм барих ажлыг "Вэлмот" ХХК, Сайхан сумын Жаргалант, Могод сумын Нарангийн булгийн хөв цөөрөм барих ажлыг "Аригшан" ХХК хийж гүйцэтгэлээ.	100
		208	2.4.2.4. Хануй, Хульж, Цагаан гол, Их булаг зэрэг рашааны ордуудын нөөцийг тогтоож, хамгаалалтын асуудлыг оновчтой шийдвэрлэх	2017-2020	АЗДТГ, БОАЖГ, СЗД		Рашааны найрлага, нөөцийг тодорхойлон шинжлэх ухааны үндэслэлтэй эмчилгээ сувилгаанд хэрэглэнэ.	Могод сумын Хульжийн халуун рашааны ордын нөөцийг тогтоох ажлын саналыг 2020 оны төсвийн саналд тусгаж, батлуулахаар ажиллаж байна. Бусад рашааны ордуудын нөөцийг тогтоох ажлын хөрөнгийн эх үүсвэрийг судалж байна.	ҮБ
		209	2.4.2.5. Хүн амын усан хангамжинд зориулж 20-оос доошгүй худаг шинээр гаргах	2017-2020	БОАЖГ, СЗД		Хөдөөгийн хүн ам, бэлчээрийн усан хангамж нэмэгдэнэ.	2016 онд Баяннуур, Дашинчилэн, Могод сумдад "Ногоон хэрэм" хөтөлбөрийн туслах зурвасын дагуу ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар 52.5 сая төгрөгийн хөрөнгөөр 3 худаг шинээр гаргалаа. 2017-2019 онд хүн ам, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зориулалтаар нийт 44 худгийг улс, орон нутгийн төсвийн 664.3 сая төгрөгийн хөрөнгөөр шинээр гаргалаа.	100

	усаар хангана.	210	2.4.2.6. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн хил заагийг тэмдэгжүүлж, дэглэмийг мөрдлөг болгох	2017-2020	БОАЖГ, СЗД		Усны сан бүхий газрыг бохирдлоос хамгаална.	2016 онд усны сан бүхий газрын 787 цэгт онцгой, энгийн болон эрүүл ахуйн бүсийг шинэчлэн тогтоолоо. 2017 онд усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийн дагуу 100 ширхэг самбар суурилуулж, дэглэмийг сурталчлан таниулах ажлыг 12.0 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжүүллээ. 2018 онд усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн хилийн заагт 200 ширхэг тэмдэгжүүлэлт суурилуулах ажлыг 26.0 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэлээ. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн хилийн заагийг тэмдэгжүүлэх ажлын гүйцэтгэгчээр "Найчрал састайнэблэ" ХХК ажиллалаа.	100
		211	2.4.2.7. Татарсан нуур, цөөрөм, гол, горхины усны түвшинг нэмэгдүүлэх судалгаа, шинжилгээ хийх	2017-2020	БОАЖГ, СЗД		Нуур, цөөрөм, гол, горхины ус багасаж ширгэж байгаа шалтгаан болон усны түвшинг нэмэгдүүлэх арга зам тодорхойлогдсон байна.	2018 онд Баян-Агт сумын Цэгээн, Хагийн нуур, Баян гол, Баяннуур сумын Баян нуур, Далын гол, Булган сумын Ачуутын гол, Хишиг-Өндөр сумын Хонхор нуур, Могод сумын Загаст нуурыг сэргээх судалгааны ажлыг 15.0 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэлээ.	100
		212	2.4.2.8. Ачуут, Дал, Баян, Тал булаг зэрэг голууд, 40-өөс доошгүй булаг, шандны эхийг хашиж хамгаалах	2016-2020	ХБХ, БОАЖГ, СЗД		Усны нөөцийг нитрат, нитрит, аммиак, нян, вирусээр бохирдохоос хамгаалж, урсац нэмэгдсэн байна.	2016-2019 онд аймгийн хэмжээнд нийт 57 булаг шандын эхийг хашиж хамгаалах ажлыг 214.9 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэлээ. 2018 онд булаг шандын эхийг хашиж хамгаалах ажлын зураг төсөв боловсруулах ажлыг 3.5 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжүүллээ.	100
39	2.4.3. Ойн нөөцийн менежментийг сайжруулж, зохистой ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.	213	2.4.3.1. Ойжуулалтыг 300 га-аас доошгүй талбайд зураг төсвийн дагуу хийж, дэвшилтэт технологи бүхий бортоготой тарьцаар ойжуулалт хийх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх	2016-2020	БОАЖГ, СДОАнги		Нөхөн сэргээлтийг шаардлагатай газарт хийж, ойн сан нэмэгдсэн байна.	Аймгийн хэмжээнд 2017-2019 онд Бүрэгхангай, Могод, Хишиг-Өндөр, Хангал, Сэлэнгэ, Бугат сумын 900 га талбайд ойжуулалтын ажлыг хийснээр 3 жилийн мод бэлтгэсэн 6489 га талбайн 13.8%-ийг нөхөн сэргээгээд байна. 2019 онд Могод сумын Дулааны Хугархайн ард 50 га, Бугат сумын Түлүүгийн давааны ард 50 га, Бургааст булагт 50 га, Сэлэнгэ сумын Харлагт 50 га, Хангал сумын Ажнайн даваанд 100 га талбайд ойжуулалтын ажлыг тус тус гүйцэтгэж, 76-82%-ийн амьдралттай хүлээж авлаа.	100
		214	2.4.3.2. Ойг цэвэрлэх, арчлах, хамгаалах санаачлагыг өрнүүлж, уг ажлыг гүйцэтгэсэн иргэн, нөхөрлөлийг бодлогоор дэмжих	2016-2020	АЗДТГ, БОАЖГ, СЗД		Ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг идэвхжинэ.	2017-2019 онд "Мөнх ногоон жодоо" ХХК 60 нөхөрлөлийн 240000 га талбайд 70.2 сая төгрөгөөр ой зохион байгуулалт хийлээ. Сум дундын ойн ангиудаар Бугат, Хангал, Баян-Агт суманд 80 га талбайд арчилгааны огтлолтыг гүйцэтгүүлсний зэрэгцээ Бугат, Хангал, Хутаг-Өндөр сумын 5 ойн нөхөрлөл 10.0 сая төгрөгөөр ойн хортонтой тэмцэх гэрлэн урхи тавих болон механик аргаар тэмцлээ. Сум дундын ойн ангиудад ойн арчилгааны ажлыг гүйцэтгэх, сургалт явуулахад нь зориулж 7.0 сая төгрөгийн өртөгтэй 6 ширхэг моторт хөрөөг нийлүүллээ. Мөн хуурайшилтын үед идэвхтэн байгаль хамгаалагч морин эргүүлийг Бугат, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Хангал, Тэшиг, Орхон суманд ажиллуулж, 12960.0 мянган төгрөгөөр санхүүжүүлж ажилласны дүнд ой хээрийн түймрийн гаралт багассан.	100
		215	2.4.3.3. Ойн сан бүхий сумдад ойн хуурайшилт хортон шавжаас хамаарсан сөрөг үзэгдлийг нарийвчлан судалж, шаардлагатай тохиолдолд модлогийн таваарлаг чанар алдахаас өмнө ашиглах	2016-2020	АЗДТГ, БОАЖГ, СДОАнги		Ойн хортны голомтыг багасгаж, ой эрүүлжинэ.	Ойн хортны судалгааны ажлыг 2016-2019 онд "Байгаль орчин, тогтвортой хөгжлийн санаачлага" ТББ ой бүхий сумдад 928811 га талбайд 64951.5 мянган төгрөгөөр судалгаа явуулж, ойн хортон шавжийн амьдралын цикло бүрт хугацаа алдалгүй тэмцлийн ажлыг хийж байна.	70

		216	2.4.3.4. Ойн хортон шавжаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг үргэлжлүүлж, жил бүр 40000-аас доошгүй га талбайд биологийн болон байгальд сөрөг нөлөөгүй аргаар тэмцэх	2016-2020	БОАЖГ, СЗД		Ойн хэв шинж хадгалагдана.	Судалгааны ажлыг үндэслэн 2017-2019 онд Баян-Агт, Хутаг-Өндөр, Тэшиг, Сайхан, Орхон, Бугат, Сэлэнгэ, Хангал сумын 66170 га талбайд ойн хортон шавжтай тэмцэх ажлыг явуулж, ойн хомсдол, доройтлыг 27.5%-иар буурууллаа. 2020 онд ашиглалтад эрчимтэй өртөж буй 5 сумын нутагт 30000 га талбайд тэмцлийг ажил хийхээр төлөвлөсөн.	70
		217	2.4.3.5. Модыг орлох түлш, барилгын материал, бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих	2016-2020	АЗДТГ, БОАЖГ, СЗД		Модон бүтээгдэхүүний хэрэглээ зохистой хэмжээнд байж, нөөц хамгаалагдана.	Булган сумын "Билгүүн дэлгэрэх" ХХК иргэдийн хэрэгцээнд жил бүр 40-50 тн шахмал түлш үйлдвэрлэж, иргэдийн хэрэгцээнд нийлүүлж байна. "Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлын хамгаалал, ойн тогтвортой менежмент, нүүрстөрөгчийн хуримтлалыг нэмэгдүүлэх" төслөөс шахмал түлш үйлдвэрлэх бага оврын тоног төхөөрөмж, хусны нүүрс шатаах зуухыг байгуулахаар хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж, БОАЖГ-ын мэргэжилтэн, сумын дундын ойн дарга, Хөдөө аж ахуйн Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн сургуулийн багш нарыг 7 хоногийн хусны нүүрс шатаах сургалтад хамруулан дадлагажууллаа.	40
		218	2.4.3.6. Ойн үрийн аж ахуйг өргөжүүлж, сайн чанарын үрийн нөөцийг бий болгох	2016-2020	БОАЖГ, СДОАнги		Сайн чанарын тарьц суулгацаар хангана.	2017, 2018 онд Баян-Агт, Орхон, Хангал суманд нийт 47 га талбайд үрийн талбайг тусгаарлан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зурвас татаж, модонд тэмдэг, тэмдэглэгээ хийж бордон, арчлан хамгаалах ажлыг хийсэн. Аж ахуйн нэгж, ойн ангиуд өөрсдөө үр бэлтгэн, тарьц суулгацаа ургуулж байна.	70
40	2.4.4. Цөлжилтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлж, бэлчээрийн доройтлыг бууруулах, хортон мэрэгчидтэй тэмцэх, усжуулах, байгалийг аясаараа нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлнэ.	219	2.4.4.1. "Ногоон хэрэм" байгуулах болон "Цөлжилт"-ийг бууруулах зорилгоор ойн зурвасыг жил бүр 10-аас доошгүй га газарт байгуулах	2016-2020	БОАЖГ, СДОАнги		Цөлжилт, элсний нүүдэл, хөрсний доройтол тодорхой хэмжээгээр буурсан байна.	2016-2017 онд цөлжилтийг сааруулах, ногоон хэрмийн туслах зурвас байгуулах ажлыг Дашинчилэн суманд 15 га-д хийж, 78%-ийн амьдралттайгаар хүлээн авсан. 2018 онд тус талбайд нөхөн тарилт хийж, харуул хамгаалалт, хашааг сайжрууллаа. 2019 онд Орхон, Хутаг-Өндөр, Сэлэнгэ суманд элсний нүүдлийг тогтоон барих зорилгоор 10 га-д тус бүр 5.0 сая төгрөгийн зурвасын ажлыг сумын бүлэг, нөхөрлөлөөр хийлгэлээ.	70
		220	2.4.4.2. Төв суурин газрыг цэцэрлэгжүүлэх ажлыг жил бүр зохион байгуулж, ногоон байгууламжийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлж, арчлалт, хамгаалалтын дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	2016-2020	БОАЖГ, СДОАнги, СЗД, ТҮА		Ногоон байгууламжийн хэмжээ 3 дахин нэмэгдүүлсэн байна.	Бүх нийтээр мод бут тарих ажлыг жил бүр төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, хавар, намрын тарилтааар 483884 ширхэг мод, бут тарьж, 2094.2 м.кв талбайд цэцгийн мандал байгуулж, 14842 м.кв талбайг зүлэгжүүлж 233.2 сая төгрөг зарцуулан ногоон байгууламжийг нэмэгдүүллээ. "Булган жимс, жимсгэнэ" чацаргана хөтөлбөрөөр 72030 ширхэг нийт 86079 ширхэг мод бутыг тарин 34802.0 мянган төгрөгийн зардал гарган ажлыг хийж гүйцэтгэлээ. "Ногоон паспорт-Ногоон төгөл" аяны хүрээнд Булган сумын Ачуутын голд 3.5 га "Бичил цэцэрлэгт хүрээлэн" байгуулахад ерөнхий боловсролын сургуулийн 800 хүүхэд оролцон 11 төрлийн мод бутыг тарьж, арчлан хамгаалж байна. Эдгээр ажлын үр дүнд ногоон байгууламжийн хэмжээ 3.2 дахин нэмэгдлээ.	100
		221	2.4.4.3. Цөлжилт, бэлчээрийн талхлалтыг сааруулах, гол горхи, булаг шандны урсацыг нэмэгдүүлэх зорилгоор мод тарих хөдөлгөөн өрнүүлэх	2016-2020	ХБХ, БОАЖГ, ХААЖДҮГ		Бэлчээрийн даац нэмэгдэж, цөлжих үйл явц саарсан байна.	Тайлант хугацаанд цөлжилтийг сааруулах, элсний нүүлтийг тогтоон барих ажлыг Дашинчилэн, Орхон, Хутаг-Өндөр, Сэлэнгэ суманд нийт 45 га-д хийж, хамгаалалтын ойн зурвас байгуулсан.	70
		222	2.4.5.1. Баян-Агт сумын Хануй, Цагаан гол, Шаргын нуур, Сайхан сумын Хунтын рашаан, Могод сумын Хульжийн рашаан, Хутаг-Өндөр сумын Их булгийн рашааны орчимд хамгаалалтын бүс тогтоож, орон нутгийн хамгаалалтад авах	2017-2018	БОАЖГ, СЗД, Сав газрын захиргаа		Байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалж, хамгаалалтын горим мөрдөгдөж эхэлсэн байна.	Сайхан сумын Хунт, Баян-Агт сумын Хануй, Шаргын нуур, Цагаан голын рашаан, Могод сумын Хульж, Хутаг-Өндөр сумын Их булгийн рашаан орчимд онцгой хамгаалалтын бүс тогтоож, хамгаалалтын дэглэмийг сахиулах арга хэмжээг хэрэгжүүлж байна.	100

41	2.4.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөж, газар болон газрын хэвлийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	223	2.4.5.2. Түүх, соёл, байгалийн цогцолбор газрын судалгааг гаргаж, улсын болон орон нутгийн хамгаалалтад авч, мэдээллийн сүлжээнд хамруулах	2016-2020	БОАЖГ, СЗД	Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдсэн байна.	2016 онд Бүрэгхангай сумын 3-р багийн нутаг дэвсгэрт 67.64 га талбайг орон нутгийн хамгаалалтад авсан. Мөн 2017 онд Бүрэгхангай сум 85.79 га, Дашинчилэн сум 1388.25 га, 2018 онд Бүрэгхангай сум 123.58 га, Могод сум 103440.39 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. 2019 онд Хутаг-Өндөр сумын Эгийн гол-Хантай орчмын 176096.61 га, Хануй гол-Цагаан арал орчмын 48080.52 га, Тэшиг сумын 215292 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын бүртгэлд оруулахаар ажиллаж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Де Нейче Консерванси /TNC/ байгууллагатай хамтран хамгаалах шаардлагатай экологийн хувьд чухал ач холбогдолтой 6 сум /Хангал, Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Баян-Агт, Бүрэгхангай, Могод/-ын 1322337.6 га талбайн судалгааг гаргаж, холбогдох сум, байгууллагад хүргүүлсэн.	100
		224	2.4.5.3. Улсын болон орон нутгийн хамгаалалтад авсан газар нутгийн хамгаалалтын дэглэмийг мөрдүүлж, тэмдэг, тэмдэглэгээ, мэдээллийн самбартай болгох	2017-2020	БОАЖГ	Орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын мэдээллийн санг бүрдүүлж, хууль бус үйл ажиллагаа хязгаарлагдсан байна.	Баян-Агт, Бугат, Могод, Сайхан, Сэлэнгэ, Хутаг-Өндөр сумын орон нутгийн тусгай хамгаалалттай газруудад суурилуулах 30 ширхэг хилийн багана, 23 ширхэг мэдээллийн самбарыг “Өвөлжөөн булаг” ХХК-аар гүйцэтгүүлж, сумдад суурилууллаа.	100
		225	2.4.5.4. Эвдэрсэн газрын тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулж, төв суурин газрын болон уул уурхайн олборлолт, зам, барилгын ажилд ашигласан, эзэнгүй орхигдсон газрыг ээлж дараатайгаар нөхөн сэргээх, хамгаалах	2017-2020	БОАЖГ	Эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээж, байгалийн унаган төрхөд ойртсон байна.	2016-2018 онд Бүрэгхангай, Дашинчилэн сумын нутаг дэвсгэрт уул уурхайн олборлолтод өртсөн 256.16 га талбайд техникийн нөхөн сэргээлт, 301.7 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг тус тус хийлээ. Бугат, Бүрэгхангай, Дашинчилэн, Хишиг-Өндөр, Орхон, Сайхан, Сэлэнгэ, Тэшиг сумын нутаг дэвсгэрт олгогдсон ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 48 аж ахуйн нэгжийн уул уурхайн ашиглалтын улмаас эвдрэлд орсон 1961.2 га талбайн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны эвдэрсэн газрын мэдээллийн санд орууллаа.	100
42	2.4.6. Амьтан, ургамлын удмын санг хамгаалж, нөхөн сэргээх замаар өсгөн үржүүлэх, үр өгөөжийг дээшлүүлнэ.	226	2.4.6.1. Агнуурын бүс нутагт биотехникийн арга хэмжээ авч, ан амьтдын өсөж, торних нөхцөлийг бүрдүүлэх	2016-2020	БОАЖГ	Биотехникийн арга хэмжээг чанартай, үр дүнтэй зохион байгуулна.	Тайлант хугацаанд нэн ховор, ховор амьтан тархсан газар нутаг болох Хутаг-Өндөр сумын Хайлантай, Уураг, Бүгсийн голын эх, Тэшиг сумын Нуравын мараа, Эрээн тоовч голын эх, Сэлэнгэ сумын Таръяахтайн эх, Шавар, Хайлантай, Цүүцийн баруун зүүн салаа, Рашаант сумын Хөгнөхан, Дашинчилэн сумын Хараат уул, Бүдүүн, Эрээн ухаа, Өрхтий, Буурал хаан, Лах, Гозгорын ам зэрэг газарт 1185 боодол өвс, 12 тонн давс, 10.5 тонн хужир, 2 тонн улаан буудай, 4 тонн хорголжин, 3 тонн тэжээлийн будааг тавьж, биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэн амьтдын идэш тэжээлийн хомсдоллоос урьдчилан сэргийлж, өсөн үржих нөхцөл боломжоор хангалаа.	100
		227	2.4.6.2. Гол мөрөн, нуур, цөөрмийг түшиглэсэн загас, шувуу, бусад төрлийн амьтдыг өсгөн үржүүлэх аж ахуй байгуулах санаачлагыг дэмжих	2016-2020	БОАЖГ, СЗД	Тодорхой нэр төрлийн амьтдын нөөц хамгаалагдсан байна.	Сайхан сумаас 50 толгой тарвага, Төв аймгийн Хустайн нурууны байгалийн цогцолборт газраас 20 толгой бугын илийг Хангал сумын Сэлэнгэ амралтын баазад, Хутаг-Өндөр сумын Сэлэнгэ голын дагуу Баатарван амралтын газарт Төв аймгийн Хустайн нурууны байгалийн цогцолборт газраас 8 толгой бугын илийг авчирч сэргээн нутагшуулсан.	100
		228	2.4.6.3. Ургамлын тооллого, судалгаанд үндэслэн 2-оос доошгүй ховор, нэн ховор ургамлыг орон нутгийн хамгаалалтад явах	2016-2020	БОАЖГ, СЗД	Ховор ургамал хамгаалагдсан байна.	2016 онд Баян-Агт, Тэшиг суманд Заан хүж, Бүрнүс, Дүмбэрэй, 2017 онд Бугат суманд Чихэр өвс, 2018 онд Хишиг-Өндөр, Бүрэгхангай суманд Чихэр өвс, Гандигар, Эгэл годил зэрэг ховор ургамлыг орон нутгийн хамгаалалтад авсан.	100

		229	2.4.6.4. Ашиглалтын нөөцтэй зарим ургамлыг зохистой ашиглах, нэн ховор, ховор ургамлыг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх	2016-2020	ХБХ, БОАЖГ, СЗДТГ		Нэн ховор, ховор ургамлыг нөхөн сэргээх, үржүүлэх арга хэмжээ авагдсан байна.	Тайлант хугацаанд Баян-Агт суманд ургаж буй нэн ховор ургамал болох "Заан хүж"-ийг хамгаалах зардлыг тусгаж, идэвхтэн байгаль хамгаалагч ажиллуулсан. Энэ хугацаанд Баян-Агт суманд "Заан хүж"-ийг хамгаалах 7 самбар байршуулсан. Мөн Бугат сумын Дундатын эхэнд Баян-Агт сумаас Заан хүж ургамлыг 7 ширхэгийг авчирч нутагшуулсан. 2019 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын судалгааг БОАЖЯаманд хүргүүлснээр Сэлэнгэ сумын "Сэлэнгэ-Анар" ХХК-д 500 кг тэхийн шээг ургамлыг бэлтгэх зөвшөөрөл ирж, Сэлэнгэ голын дагуу түүж бэлтгэсэн байна.	70
		230	2.4.6.5. Сумдад байгаль орчны хэсэг байгуулж, байгаль хамгаалагчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулж, тоног төхөөрөмжөөр хангах	2016-2020	БОАЖГ, СЗД		Хяналт шалгалтын ажил эрчимжиж, үр дүнд хүрсэн байна.	2016-2019 онд сумын байгаль хамгаалагч нарт мотоцикль, өвөл, зуны иж бүрэн дүрэмт хувцас, аяны хөнжил, гал түймэр унтраах 83 ширхэг рело, 12 ширхэг зөөврийн компьютерийг ээлж дараатай хүлээлгэн өгсөн. Байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөл боломжийг хангаснаар мэдээ тайланг түргэн шуурхай ирүүлэх, хяналт шалгалтыг тогтмол хийж ажиллаж байна.	100
43	2.4.7. Ус, цаг уурын урьдчилсан мэдээний чанар шуурхай байдал, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг сайжруулна.	231	2.4.7.1. Сумдад цаг уурын автомат станцыг ээлж дараатайгаар сууриллуулах	2017-2018	УЦУОША		Цаг уурын ажиглалтын давтамж нэмэгдэж хүнээс шалтгаалах алдаа багасна.	Баян-Агт, Сайхан, Бугат, Хангал, Орхон, Хишиг-Өндөр, Бүрэгхангай, Баяннуур суманд цаг уурын ажиглалтын талбайг томсгон, цахилгаан татаж, цаг уурын автомат станцууд суурилуулах ажлыг 2018 онд БНСУ-ын 400.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэсэн. Үүний үр дүнд цаг уурын ажиглалт хэмжилтийн давтамж нэмэгдэж, мэдээллийн чанар сайжирсан. Энэхүү ажилд Байгаль хамгаалах сангаас 25.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, ажиглалтын талбайн хашааг шинэчилж, цахилгаан татах ажлыг хийсэн.	100
		232	2.4.7.2. Ажиглалтын талбайн тусгай хэрэгцээний газрыг тодотгож, 100 метрийн радиуст хамгаалалтын бүс тогтоох	2016-2020	УЦУОША, ГХБХБГ		Монгол улсын УЦУОХШ-ний тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлсэн байна.	2017-2018 онд бүх сумдын цаг уурын ажиглалтын талбайн тусгай хэрэгцээний газрыг тодотгон, 100 метрийн радиуст хамгаалалтын бүсийг тогтоож дуусгасан. Мөн 7 сумын ус судлалын талбайн тусгай хэрэгцээний газрыг тодотгосон.	100
		233	2.4.7.3. Байгаль орчны шинжилгээний лабораторийг итгэмжлэлд хамруулж, шаардлагатай багажаар хангах, барилгын өргөтгөл барих, цэвэр бохирын шугамд холбох	2017-2020	ГХБХБГ, УЦУОША		Лабораторийн хүчин чадал нэмэгдэж, шинжилгээний үр дүн, чанар дээшилнэ.	2019 онд багтаан байгаль орчны шинжилгээний лабораторийг итгэмжлэлд оруулахаар итгэмжлэлийн баримт бичгүүдийг боловсруулж байна. Аймгийн Байгаль хамгаалах сангийн 10.0 сая төгрөгийн хөрөнгөөр тус лабораторид шаардлагатай минипамп, колбо сэгсрэгчийг тус тус худалдан авч шинжилгээний ажилд ашиглаж байна.	40
		234	2.4.7.4. Тэшиг сумын Ус, цаг уур шинжилгээний өртөө, Орхон сумын Ус, цаг уурын харуулын ажлын байр барих, Сэлэнгэ сумын УЦУШ-ний өртөөний барилгад их засвар хийх	2017-2020	ГХБХБГ, УЦУОША		Ажилчдын ажлын нөхцөл сайжирна.	Сэлэнгэ сумын Ус цаг уурын шинжилгээний өртөөний барилгад 2018 онд 3.0 сая төгрөгийн их засварыг хийсэн.	40
		235	2.4.7.5. Шаардлагатай тохиолдолд Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх арга хэмжээ авах	2017-2020	АЗДТГ, УЦУОША		Таримал болон бэлчээрийн ургамлын ургалтыг сайжруулж, ой хээрийн түймэр гарахгүй байх нөхцлийг бүрдүүлнэ.	2017 онд аймгийн нутаг дэвсгэрт цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг таримал болон бэлчээрийн ургамлын ургацыг нэмэгдүүлэх зорилгоор 17 удаа, ой хээрийн түймрийг унтраах зорилгоор 4 удаа нийт 21 удаа явуулснаас 14 нь үр дүнтэй, 7 нь үр дүн муу болсон. 2018 онд аймгийн нутаг дэвсгэрт цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 15 удаа явуулж 14 нь үр дүнтэй болсон. 2019 онд цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээг 3 экспедицээр 12 удаа явуулж, таримал болон бэлчээрийн ургамлын ургацыг нэмэгдүүлэх, ой хээрийн түймрийг унтраах зорилгоор ажилласан.	100

2.5 Аялал жуулчлал:
Аялал жуулчлалыг эдийн засгийн үр өгөөжтэй, байгальд ээлтэй салбарын нэг болгон хөгжүүлнэ.

44	2.5.1. Аялал жуулчлалын менежментийг сайжруулж, аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх арга замыг судлан тогтоож, жуулчдын сонирхол, хэрэгцээг хангахуйц арга барилыг нэвтрүүлнэ.	236	2.5.1.1. Аймгийн хэмжээнд аялал жуулчлалын мэдээллийн төвийг байгуулж, жуулчдад мэдээлэл өгөх, сургалт, зуулчлалын цогц үйлчилгээ үзүүлэх	2017-2018	АЗДТГ, БОАЖГ	Жуулчдыг мэдээллээр хангаж орон нутгаа олон улсын хэмжээнд сурталчилна.	“Аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд “Аяллын хөтөч”-ийн мэргэжлийн сургалтад 16 хүнийг хамруулж, сертификат олголоо. 2018 онд байгуулагдсан “Аялал жуулчлалын цогцолбор”-т аймгийн аялал жуулчлалын маршрут болон газрын зургийг байрлуулахаар төлөвлөөд байна. Аймгийн Музей, БОАЖГ, Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон нийслэлийн аялал жуулчлалын мэдээллийн төвүүд, шуурхай мэдээллийн лавлахуудаар дамжуулан жуулчдад аймгийн аялал жуулчлалын талаарх мэдээллийг өгч байна.	70
		237	2.5.1.2. Аялал жуулчлалын салбарын зөвлөгөөнийг зохион байгуулж, салбарын тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх	2017-2020	АЗДТГ, БОАЖГ	Салбарын бодлого, зорилт тодорхойлгодоно.	2017 онд “Хөгжлийн хөтөч” форумын Соёлын үйлдвэрлэл ба аялал жуулчлал дэд хуралдааныг Үндэсний хөгжлийн газартай хамтран зохион байгуулж, цаашид баримтлах бодлого, чиглэлээ тодорхойллоо. 2018 онд аялал жуулчлалын салбарын “Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх нь” сэдэвт зөвлөгөөнийг зохион байгуулж, улсын болон орон нутгийн бодлого, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах талаар хэлэлцүүлэг зохион байгууллаа. 2019 онд Баянхонгор аймагт зохион байгуулагдсан “Орон нутаг аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх боломж, тулгамдаж буй асуудал” сэдэвт сургалт зөвлөгөөнд холбогдох мэргэжилтнүүдийг хамрууллаа. Аймгийн ИТХ-ын хуралдаанаар “Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө”-г хэлэлцүүлж, батлууллаа.	100
		238	2.5.1.3. Тусгай хамгаалалттай газар нутгийг түшиглэн, эко аялал жуулчлалыг хөгжүүлэх	2017-2020	БОАЖГ, СЗД, ТХГНХЗ	Тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент сайжирч, аялал жуулчлал хөгжинө.	Хойд бүсийн сумдыг Эко-аялал, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх бүс нутгаар тодорхойлж, Булган аймгийг зорин ирэх гадаад, дотоодын жуулчдад зориулан “АНХДАГЧДЫН ӨЛГИЙ БУЛГАН НУТГААР” авто аяллын талаарх цуврал нэвтрүүлгийг бэлтгэж, телевиз болон цахим хуудсаар нэвтрүүлж, орон нутгаа сурталчлан ажиллалаа. Хөгнө Тарнын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын 10 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулан гадаад, дотоодын жуулчдад үйлчилж байна. Мөн хувийн хэвшлүүд өөрсдийн үйл ажиллагааг сурталчлан бэсрэг наадам, морин болон явган, авто аяллыг зохион байгуулж хэвшээд байна.	100
		239	2.5.1.4. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг тэмдэгжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох	2017-2020	БОАЖГ, СЗД, Музей	Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож, жуулчдын тоог нэмэгдүүлсэн байна.	2018 онд аймгийн төсвөөс 8.0 сая төгрөг зарцуулж, Баян-Агт, Хутаг-Өндөр, Булган, Дашинчилэн зэрэг сумын 6 дурсгалыг сонгон, тэмдэгжүүлэх ажлыг гүйцэтгэлээ. 2019 онд ТХГНЗ болон аялал жуулчлалын аж ахуйн нэгж байгууллагуудыг дайчлан тэмдэг тэмдэглэгээг засаж сэргээх, шинээр тэмдэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.	70
		240	2.5.1.5. Улсын болон орон нутгийн авто зам дагуу аялагчдад зориулсан стандартад нийцсэн түр буудаллах цэгийг байгуулах, хувийн хэвшлүүдийг бодлогоор дэмжих	2016-2020	АЗДТГ, БОАЖГ, СЗД	Аялагчдын тав тухтай аюулгүй орчин бүрдсэн байна.	“Шинэ хөдөө” төслийн 280.0 сая төгрөгийн хөрөнгөөр Бугат сумын “Түлүүгийн даваа”, Булган сумын 1-р багт ХАА-н бүтээгдэхүүн борлуулах худалдаа, үйлчилгээний цэг байгуулах ажил хийгдэж байна. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар улсын чанартай авто замын дагуу Дашинчилэн суманд “Чин хайрхан” үйлчилгээний цогцолбор, Хутаг-Өндөр суманд “Янзтай”, “Три жем” зоогийн газар, “Хангайн зоог” түр буудаллах цэг шинээр байгуулагдлаа. Рашаант суманд Хаан буузны салбар түр буудаллах цэгийг барьж ашиглалтад оруулсан бол 2 цэгт цогцолбор байгуулахаар газар олгогдож, барилга угсралтын ажил хийгдэж байна. Мөн тус суманд БОАЖ-ын сайдын багцын хөрөнгө оруулалтаар Бугат сумын Түлүүгийн даваа, Хутаг-Өндөр сумын Дондогийн булагт зорчин явагчдад зориулсан 00 барих ажлыг эхлүүлээд байна.	100
		241	2.5.1.6. Амралт, рашаан сувиллын газруудын байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалан хамгаалах, аж ахуйн нэгжүүдийн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлж, орчныг бохирдлоос хамгаалах	2017-2020	АЗДТГ, БОАЖГ, СЗД, ТХГНЗ	Байгаль орчны сөрөг нөлөөллийг багасгана.	Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, жуулчны бааз, амралт, рашаан сувиллын нийт 159 аж ахуйн нэгж байгууллагад холбогдох хууль, стандартуудын хэрэгжилтээр хяналт үнэлгээ хийлээ. Хануй голын сав газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төвтэй хамтран Баян-Агт сумын Хануй, Цагаан голын амралт, рашаан сувиллын 27 газрын хөрс, усанд бохирдлын хэмжээг тодорхойлох шинжилгээ хийлээ.	40

		242	2.5.1.7. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг гадаад, дотоодын зах зээлд тогтмол сурталчилж, жуулчдын тоог жил бүр нэмэгдүүлэх	2017-2020	ЗДТГ, БОАЖГ, СЗД	Гадаад, дотоодын жуулчдын тоо нэмэгдэж, салбарын хөгжил эрчимжинэ.	Жил бүр "ITM" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулан ажиллаж, үйл ажиллагааг нь сурталчилж байна. "ITM-2019" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд 8 аж ахуйн нэгжтэй хамтран оролцож, аймаг орон нутгаа сурталчиллаа. Аж ахуйн нэгжүүд давхардсан тоогоор гадаад болон дотоодын 120 гаруй тур операторуудтай хамтран ажиллах гэрээ хэлэлцээрийг байгуулан жуулчдыг хүлээн авч байна. Сүүлийн гурван жилд гадаадын 27570, дотоодын 168300 жуулчин Булган аймагт ирсэн байна.	100
45	2.5.2. Байгалийн үзэсгэлэнт болон түүх, соёлын дурсгалт газар, рашаан сувилал, дэд бүтэц зэрэг давуу талаа түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлж, салбарын үйлчилгээний чанар стандартыг сайжруулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.	243	2.5.2.1. Орон нутгийн онцлог, зан заншлыг харуулсан бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, нутгийн иргэдийг татан оролцуулж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх	2017-2020	БОАЖГ, СЗД, ТХГНХЗ	Иргэдийн орлого нэмэгдэж, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээний тоо нэмэгдэнэ.	Орон нутгийн иргэдэд тулгуурласан адал явдалт аяллыг Эг, Тарвагатайн гол /Спорт загасчлал/, Зэд, Хантайн нуруу /Морин аялал, фото сафари, ан агнуур/-нд төрөлжүүлэн хөгжүүлэхээр нөөцийг тодорхойлж, нутгийн иргэдийг татан оролцуулж, ашиг орлогыг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг хийж байна. Хутаг-Өндөр сумын "Хангинахын шугуйн шагайн тойром", "Бага Алтаргана" арга хэмжээг зохион байгуулж, нутгийн зон олныг өргөнөөр татан оролцууллаа. Мөн Улаанбаатар хотод "Айрагны баяр"-ыг зохион байгуулж, Могод, Сайхан, Орхон, Баян-Агт, Хишиг-Өндөр, Дашинчилэн, Бүрэгхангай, Хангал сумынхан брэнд бүтээгдэхүүнээр оролцсон. Тус арга хэмжээнд 9 сумын 160 гаруй малчид, үйлдвэрлэгчдийн 55.2 тн айраг борлуулагдлаа.	100
		244	2.5.2.2. Салбарын мэргэжлийн боловсон хүчний тоог нэмэгдүүлэх, ур чадварыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах	2017-2020	БОАЖГ, СЗД	Аялал жуулчлалын салбарын үйлчилгээ, ажилчдын ур чадвар сайжирна.	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, "Аялал жуулчлалын ур чадварын төв"-тэй хамтран аялал жуулчлалын зочлох үйлчилгээний сургалтыг 2017-2019 онуудад 10 мэргэжлээр зохион байгуулж, 320 гаруй иргэнийг хамрууллаа. 2019 онд Баянхонгор аймагт зохион байгуулагдсан "Орон нутаг аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх боломж, тулгамдаж буй асуудал" сэдэвт сургалт зөвөлгөөнд холбогдох мэргэжилтнүүдийг хамрууллаа. Мөн БОАЖЯ-наас Улаанбаатар хотод зохион байгуулсан "Аялал жуулчлалын маркетинг, сурталчилгаа" сургалтад холбогдох мэргэжилтэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөллүүдийг хамрууллаа.	100
		245	2.5.2.3. Аяллын маршрутыг тодотгож, тусгай сонирхлын аяллыг төрөлжүүлэн хөгжүүлэх, энэ чиглэлээр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх	2017-2020	АЗДТГ, БОАЖГ, СЗД, ТХГНХЗ	Тусгай сонирхлын аялал жуулчлал хөгжинэ.	Аялал жуулчлалын дотоодын 10 маршрутыг тогтоож, адал явдалт аялал жуулчлал /Эг, Сэлэнгэ, Орхон голын усан аялал, ан агнуур, фото сафари, загас/-ыг орон нутгийн иргэдэд тулгуурлан хөгжүүлж байна. Эг, Тарвагатайн гол дагуу спорт загасчлалыг дотоодын 12 аялагч, Зэд, Хантайн нуруунд морин аялалд гадаад, дотоодын 25 аялагч аялсан. "Нью жуулчин" ХХК, "Хутаг-Өндөр" жуулчны баазууд Баяннуур, Хутаг-Өндөр сумын нутагт хаврын улиралд Герман, Францын 12 жуулчинд усны шувуу ажиглах аяллыг зохион байгуулсан. "Хөвсгөл трейвэл", "Инголзолота" ХХК-ууд Эг, Сэлэнгийн голуудад Европын жуулчдад загасны аялал зохион байгуулдаг болсон. Ихэвчлэн Итали, Чех, Германы жуулчид ирж байна.	70
		246	2.5.2.4. Булган сумын "Цагаан суварга-Диваажин сүм"-ийг түшиглэсэн аялал жуулчлалын үйлчилгээ бий болгох	2017-2020	АЗДТГ, БОАЖГ, СЗД	Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож, үйлчилгээ өргөжсөн байна.	БСШУСЯ-аас Булган сумын "Диваажин сүм"-ийг сэргээн засварлах 180.0 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэж, "Зэндмэнэ суварга" ХХК-аар сэргээн засварлах ажлыг гүйцэтгүүлсэн. Цагаан суваргыг сэргээн босгох хөрөнгийн эх үүсвэрийг судалж байна.	40
		247	2.5.2.5. Хутаг-Өндөр сумын "Хангинахын шугуй"-н шагайн тойрмын эвент арга хэмжээг зохион байгуулах	2016-2020	НБХ, БОАЖГ	Үндэсний спортыг хөгжүүлж, жуулчдын тоог нэмэгдүүлэх, орон нутгаа сурталчилна.	"Хангинахын шугуй"-н шагайн тойрмын эвент арга хэмжээг Хутаг-Өндөр суманд жил бүр зохион байгуулж, аймгийн төсвөөс 3.0-5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж байна. Шагайн тойромд 2017-2019 онд нийт 86 багийн 560 гаруй харваачид цэц мэргэнээ сорьсон.	100
248	2.5.2.6. "Айрагны баяр" уламжлалт арга хэмжээг эвент болгон хөгжүүлэх	2016-2020	НБХ, БОАЖГ	Жуулчдын тоог нэмэгдүүлэх, орон нутгаа сурталчилна.	2019 онд "Айрагны баяр"-ыг анх удаа Нийслэл Улаанбаатар хотод зохион байгууллаа. Сайхан, Могод, Хишиг-Өндөр, Орхон, Бүрэгхангай, Дашинчилэн сумын малчид нийт 50 гаруй тн айраг худалдаж, 250.0 гаруй сая төгрөгийн борлуулалт хийлээ. Булган, Баяннуур, Гурванбулаг, Хангал сумын үйлдвэрлэгчид орон нутгийн брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа гаргаж 5.0 сая төгрөгийн борлуулалт хийлээ.	100		

249	2.5.2.7. ОХУ-ын Буриад улсын Закамень аймагтай хамтран Эв модны наадмыг зохион байгуулах	2016-2020	ЗДТГ, БОАЖГ		Хил орчмын улстай соёлын аялал жуулчлал өргөжсөн байна.	Тэшиг суманд "Бага Алтаргана-Эв мод" наадмыг зохион байгуулж, аймгаас 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ. Эв модны наадамд Булган, Хөвсгөл, Дорнод, Хэнтий аймгийн 700-аад буриад үндэстэн оролцлоо.	100
250	2.5.2.8. Баян-Агт сумын Шаргын нууранд мөсний шагайн харвааг түшиглэн жуулчдыг татах арга хэмжээг жил бүр зохион байгуулах	2017-2020	НБХ, БОАЖГ, БСГ		Өвлийн аялал жуулчлал хөгжсөн байна.	2017 онд Шаргын нуурны мөсний бүтэц шаардлага хангаагүй тул Тэшиг сумын Харгал нууранд Мөсний шагайн харвааг зохион байгуулсан. 2018 онд Хутаг-Өндөр суманд зохион байгуулж, 17 багийн 104 хараач цэц мэргэнээ сорилоо. 2019 онд гоц халдварт гахайн мялзан өвчин гарч хорио цээр тогтоосон учир зохион байгуулаагүй.	100
251	2.5.2.9. Бугат, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Тэшиг, Булган сумдад өвлийн амралтын төв, цанын бааз байгуулах хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих	2017-2020	АЗДТГ, БОАЖГ, СЗД		Өвлийн аялал жуулчлал хөгжих нөхцөл бүрдэнэ.	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд сурталчлан таниулах ажлыг хийж байна. Хишиг-Өндөр суманд мөсөн гулгуурын талбай, Булган, Бугат сумын залгаа нутаг /Булган-Мөрөн чиглэлийн зам дагуу/-т цанын бааз байгуулахаар газрын асуудлыг шийдвэрлээд байна. Хангал сумын Сэлэнгэ амралтын цанын бааз өвлийн улиралд амрагч, жуулчдад үйлчлэн ажиллаж байна.	40
252	2.5.2.10. Аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүний нөөц, үйлчилгээний газрын мэдээллийг шинэчилж, тохирлын үнэлгээг жил бүр хийж тогтмол хяналт тавих	2016-2020	БОАЖГ, СХЗХ, МХГ, СЗД		Аялал жуулчлалын бүтээгдэхүүний тоо нэмэгдэж үйлчилгээний чанар сайжирна.	Салбарын мэдээллийн санг шинэчилж, баяжилт хийн ажиллаж байна. 2017 оны судалгаанд аялал жуулчлалын чиглэлээр газар авсан 326 иргэн, аж ахуйн нэгж бүртгэгдэж, 125 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийсэн. 2019 онд амралт сувилал, аялал жуулчлалын үйл ажиллагааг холбогдох хууль, журам, стандартын дагуу эрхлэхэд зөвлөн туслах зорилго бүхий мэргэжлийн байгууллагуудын хамтарсан багийг Засаг даргын захирамжаар томилж, үйл ажиллагаатай газар дээр нь танилцан, хяналт үнэлгээ хийж, мэдээллийн санг баяжуулсан. Аттестатчлалд нийт 159 цэг хамрагдсанаас 12 жуулчны бааз, 130 амралтын газар, гэр буудал, 3 зочид буудал, 10 дэн буудал, 4 сувилал хамрагдсан байна.	70

2.6 Төсөв, санхүүгийн бодлого:

Аймгийн төсөв, санхүүг хариуцлагатай, ил тод, үр ашигтай удирдаж, орон нутгийн хөгжлийг дэмжинэ.

253	2.6.1.1. Хуулиар тогтоосон эрхийн хүрээнд зарим төрлийн татварын хувь хэмжээг орон нутгийн онцлогт тохируулан тогтоож, татварын бааз суурийг нэмэгдүүлэн стандарт түвшинг хангаж ажиллах	2016-2020	АЗДТГ, ТХ		Татвар төлөгчийн тоог жил бүр 3 ба түүнээс дээш хувиар нэмэгдүүлж, төсвийн орлогын төлөвлөгөөг ханган ажиллана.	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа хийн 16 сумын АТБӨЯХАТатвар төлөгч 1624 хувь хүн, хуулийн этгээдээс, үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөгч 621 татвар төлөгчөөс тус тус санал авч аймгийн иргэний танхимаар хэлэлцүүлэг зохион байгуулсан ба үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулан аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар хурлаар хэлэлцүүлж, "Булган аймгийн Татварын хэлтэст салбар хуулийн этгээдээр бүртгэлтэй, үл хөдлөх хөрөнгийн татвар төлөгч хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн албан татварыг Монгол Улсын үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан үнэлгээнээс 1.0 хувиар ногдуулах" гэж хувь хэмжээг шинэчлэн тогтоож, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр батлууллаа. Үүний үр дүнд аймгийн төсвийн орлого 2020 оноос жил бүр 170.0 сая төгрөгөөр нэмэгдэж байна. 2016 онд улс орон нутгийн төсөвт 20.7 тэрбум төгрөг төвлөрүүлж 101.0 хувь, 2017 онд 23.1 тэрбум төгрөг төвлөрүүлж 111.6 хувь, 2018 онд 26.0 тэрбум төгрөг төвлөрүүлж 116.1 хувиар биелүүлж ажиллалаа. 2019 оны 10 сарын байдлаар улс, орон нутгийн төсөвт 19.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 19.5 тэрбум төгрөг төвлөрүүлж биелэлт 98.2%-тай байна. Татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх татварын бааз суурийг нэмэгдүүлэхийн тулд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулах, сумдад төлбөр хураах эрх бүхий албан тушаалтан томилуулах, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэх, сумын татварын байцаагч, хураагч нарт хугацаатай үүрэг даалгаврыг өгөх, биелэлтийг хангуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.	100
-----	--	-----------	-----------	--	---	---	-----

2.6.1 Татварын бааз

46	суурийг өргөтгөх, татвар ногдуулах, хураах үйл ажиллагааг шинэ шатанд хүргэн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.	254	2.6.1.2. Орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан цахим тайлан, цахим мэдээлэл, лавлагааг бүрэн нэвтрүүлж, татвар төлөгч бүрт хүрсэн татварын цогц үйлчилгээ үзүүлж татвар төлөлтийг цахимжуулах	2016-2020	АЗДТГ, ТХ	Цахим татварын үйлчилгээ нэвтэрсэн байна.	“Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн хугацаанд нийт 13 нэр төрлийн 75629 цаасан болон цахим тайланг хүлээн авснаас 60802 тайланг цахим хэлбэрээр хүлээн авсан байна. 2019 оны 3 дугаар улирлын байдлаар болон эхний 9 сарын НӨАТ-ын нийт 9 төрлийн 9383 тайланг цахимаар хүлээн авч баталгаажуулсан ба шинээр үүсгэн байгуулагдаж байгаа хуулийн этгээдэд татварын хуулийн болон цахим тайлангийн систем, татварын цахим төлөлтийн талаарх мэдээ мэдээллээр тухай бүр нь мэдээлэл өгч 1488 татвар төлөгчдөд цахим тодорхойлолт гаргаж өгсөн. Татварын удирдлагын нэгдсэн систем 2019 оноос хэрэгжиж эхэлсэн ба татварын нэхэмжлэлд суурилсан цахим төлөлтийг нэвтрүүлж, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлээд байна.	100
		255	2.6.1.3. Эрсдлийн удирдлагад суурилсан хяналтын тогтолцоог боловсронгуй болгосноор хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх	2016-2020	АЗДТГ, ТХ	Далд эдийн засаг бууран, төсвийн орлого нэмэгдэнэ.	2016-2019 онуудад нийт 430 татвар төлөгчийн 3-5 жилийн албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийлээ. Шалгалтын үр дүнгээр 101 татвар төлөгчид илтгэх хуудас бичиж, 329 татвар татвар төлөгчөөс 10942737.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 798155.1 мянган төгрөгийн нөхөн татвар, торгууль, алдангийг Татварын улсын байцаагчийн акт, шийтгэлийн хуудсаар ногдуулж, Прокурорт хянууллаа. Сүүлийн жилүүдэд татварын хяналт шалгалтаар илэрч байгаа зөрчил нэмэгдэж байгаа нь татварын хяналт шалгалтад эрсдлийн удирдлагыг оновчтой нэвтрүүлж эрсдэл бүхий татвар төлөгчдөд хяналт шалгалтыг хийж байгаатай холбоотой байна. Мөн НӨАТ-ын тухай хууль шинэчлэн батлагдаж цахим бүртгэлийн систем, цахим төлбөрийн баримт /И-баримт/ нэвтэрснээр татвар төлөгчдийн борлуулалт, худалдан авалтын бүртгэл нэгдсэн системд бүртгэгдэж нуун дарагдуулдаг орлогыг ил болгох боломжтой болоод байна. 2019 оны сүүлийн хагас жилээс эхлэн татварын албанаас татвар төлөгчийг эрсдэлээс сэргийлэх зорилгоор татвар төлөгчийн хяналт шалгалтын үр дүнд үндэслэн ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг татвар төлөгчөөр бүлэглэн сургалт хийж, зөрчлийг гаргуулахгүй байх талаар соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж байна. 2019 оны 10 дугаар сард “Найман нэрийн дэлгүүрт татварын хяналт шалгалт хийхэд гарсан нийтлэг зөрчил ба түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөл бүхий 29 татвар төлөгчдөд зохион байгуулж зөвлөгөө өгч ажиллалаа.	100
2.6.2 Орон нутгийн		256	2.6.2.1. Төсвийн төсөл боловсруулах, хэлэлцэн батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, хянаж үнэлэхэд иргэд, олон нийтийн оролцоог хангаж ажиллах	2016-2020	АЗДТГ	Төсвийн үр ашиг дээшилж, төсөв ил тод болсон байна.	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтөд иргэд, олон нийт, төрийн бус байгууллагуудаас санал авч, ач холбогдлоор нь эрэмбэлэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг боловсруулан аймгийн цахим хуудас болон хурлын байгууллагын нэгдсэн цахим хуудсанд байршуулан иргэд, олон нийтэд танилцуулж хэвшсэн. Төсвийн төсөл, батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, худалдан авах ажиллагааны үр дүн, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудас www.shilendans.gov.mn , аймгийн цахим хуудас www.bulgan.gov.mn , мэдээллийн самбарт тогтмол мэдээлж байна.	100
		257	2.6.2.2. Төсвийн төлөвлөлтийн нэгдсэн мэдээллийн систем нэвтрүүлэх	2016-2020	АЗДТГ	Төсвийн үр ашиг дээшилж, төсөв тунгалаг болсон байна.	2017-2020 оны төсвийн төсөл, дунд хугацааны төлөвлөгөөний төслийг орон нутгийн төсвийн байгууллагуудаас хүлээн авч нэгтгэхэд төсвийн төлөвлөлтийн нэгдсэн системийг ашиглаж байна. 2020 оны төсвийн жилээс төсвийн төлөвлөлтийн фискаль програмын онлайн хувилбарыг ашиглаж эхлэхээр Сангийн яам бэлтгэл ажлыг хангаж байна.	100
		258	2.6.2.3. Төсвийн үр ашиггүй зардлыг танаж, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	2016-2020	АЗДТГ	Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулна.	Монгол улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд төсвийн үр ашиггүй зардлыг танаж, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөн хэрэгжүүлж ирлээ. 2017-2019 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг жил бүр нэмэгдүүлэх бодлого баримталж 2017 онд 9.1 тэрбум, 2018 онд 9.8 тэрбум, 2019 онд 10.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөн хэрэгжүүлэн ажиллалаа.	100

47	төсвийн эх үүсвэрийг хамгийн оновчтой, үр ашигтай хуваарилж хэрэгжүүлэх, төсвийн ил тод байдлыг ханган ажиллана.	259	2.6.2.4. Тендер шалгаруулалтын ил тод байдлыг ханган, цахим мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх	2016-2020	АЗДТГ	Төсвийн үр ашиг дээшилж, төсөв ил тод болно.	Худалдан авах ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангах зорилгоор 2016-2019 онд нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 79, харьцуулалтын аргаар 96, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журмаар 27, шууд гэрээ байгуулах аргаар 42 төсөл арга хэмжээг зохион байгууллаа. 2016-2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний 85.4 хувийг цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу Засгийн газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn сайтад байршуулан ажиллав. Цахим систем нь тендерийн баримт бичиг, техник эдийн засгийн үндэслэл, урилга, тендерийн нээлт, тендерийн үр дүнг иргэн бүр харах боломжийг бүрдүүлж, тендерт оролцогчдыг тэгш мэдээллээр хангаж, өрсөлдөх тэгш боломжийг бүрдүүлсэн. Тендер шалгаруулалтын урилга, үр дүнг худалдан авах ажиллагааны нэгдсэн систем www.tender.gov.mn, Булган аймгийн албан ёсны цахим хуудас www.bulgan.gov.mn, www.shilendans.gov.mn, өдөр тутмын Монголын үнэн сонинд тухай бүр нийтлэн тендер шалгаруулалтын ил тод байдлыг ханган ажилласан. Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас томилсон иргэнийг төсөл тус бүрийн үнэлгээний хороонд тойргийн журмаар оруулж, тендерийн баримт бичиг боловсруулах, тендер зарлах, нээх, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд оролцуулж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж байна.	100
		260	2.6.2.5. “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг бүх шатанд хангаж ажиллах	2016-2020	АЗДТГ	Төсвийн үр ашиг дээшилж, төсөв ил тод болно.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, байршуулах ёстой мэдээллүүдийг цаг хугацаанд нь иж бүрэн үнэн зөв оруулж байгааг тогтмол хянаж байна. Шилэн дансны хяналтаар илэрсэн зөрчил цаашид анхаарах асуудлаар жил бүр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд мэдээлж, хурлын тэмдэглэлээр үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангаж байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжүүлэх чиглэлээр албан хаагчдын чадавхжуулах, сургалт мэдээллээр хангах, хугацаатай шаардлагыг байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт хүргүүлэн ажилласны үр дүнд 2019 оны 3 дугаар улирлын биелэлт 99.3 хувьд хүрлээ.	100
		261	2.6.3.1. ААНБ-д НББ-ийн хуулийн хэрэгжилтийг хангуулж, НББОУС нэвтрэлтийг эрчимжүүлж, бүртгэлийн ажилтны чадавхийг сайжруулна	2016-2020	АЗДТГ, СТСХ	НББ-ээр тавих хяналт сайжирна.	Аймгийн хэмжээнд 2016 онд 740, 2017 онд 880, 2018 онд 1022 аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авч 88-94 хувийн гүйцэтгэлтэйгээр хянан баталгаажуулан Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлж ажиллав. Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналтын олон улсын стандартын хэрэгжилтийг сайжруулж, удирдлага, нягтлан бодогч, эд хариуцагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, туршлагыг нэвтрүүлэх, үүрэг хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор “Зөв бүртгэл” хөтөлбөрийг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн бүртгэл санхүүгийн ажилтнуудад зориулсан сургалт семинарыг Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, аймгийн Статистикийн хэлтэс, Боловсрол, соёл урлагийн газар, Си Ти Эс ХХК, Тод санхүү нягтлан бодох бүртгэлийн зөвлөх үйлчилгээний төв, Орхон аймаг дахь “Ариунсаруул бат” НҮТББ-тай хамтран зохион байгуулж, давхардсан тоогоор 350 гаруй хүн хамрагдлаа. 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авах явцад зөрчилтэй 4 аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох албан тушаалтанд торгох шийтгэл оногдуулж, орон нутгийн төсөвт 1040.0 мянган төгрөг төвлөрүүлжээ. 2019 онд зохион байгуулагдсан нягтлан бодох бүртгэлийн улсын үзлэгээр анхан шатны баримт хөтлөлт 88.1 хувь, нягтлан бодох бүртгэл хөтлөлт 85.9 хувьтай байсан ба нягтлан бодогч, аж ахуйн нэгжийн удирдлагуудад арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.	100

48	2.6.3 Нягтлан бодох бүртгэл, аудит, дотоод хяналтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл хөтлөлт, тайлан гаргалтыг сайжруулах замаар төсвийн орлогын бүрдүүлэлт, зарлагын хэмнэлтэд эерэг нөлөө үзүүлэх, бүх шатны удирдлагад санхүү эдийн засгийн оновчтой шийдвэр гаргахад арга зүйн туслалцаа үзүүлнэ.	262	2.6.3.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	2016-2020	АЗДТГ, СХАА	Төсвийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад тавих хяналт сайжирна.	Төсвийн хөрөнгө оруулалт, түүний бүртгэл, үр ашигтай байдал, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдал, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлангийн үнэн зөв, найдвартай байдал, иргэд байгууллагаас үзүүлсэн хандив, тусламж болон төсвөөс олгосон санхүүгийн тусламж дэмжлэгийн зарцуулалт, хүний нөөцийн сонголтын үр нөлөөтэй байдлыг шалгаж цаашид анхаарч ажиллах шаардлагатай, хэрэгжүүлбэл зохих зөвлөмжийг хүргүүлж ажилласан. 2016 онд 104.2 сая төгрөг, 2017 онд 268.8 сая төгрөг, 2018 онд 56.8 сая төгрөг, 2019 онд 25.0 сая төгрөгийн зөрчил илрүүлэн холбогдох арга хэмжээг авлаа.	100
		263	2.6.3.3. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг ашиглан, хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, мэдээллийн ил тод байдлыг хангах	2016-2020	СТСХ, ОНӨГ	Нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сайжирна.	Төрийн болон орон нутгийн өмчийн цахим мэдээллийн санд үндсэн хөрөнгийн мэдээллийг бүрэн оруулж, үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайланг жил бүр орон нутгийн өмчит 155 байгууллагаас авч нэгтгэн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн. 2016-2019 онуудад 23 удаагийн дуудлага худалдаа зохион байгуулж, 96.0 сая төгрөгийг аймгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд төвлөрүүлээ. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 439 дүгээр тогтоолын дагуу үндсэн хөрөнгийн үзлэг, тооллогыг 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар тасалбар болгон 2016 онд зохион байгуулсан. 2016-2019 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 94 удаагийн хурлаар орон нутгийн өмчит байгууллагын хөрөнгийн асуудлыг хэлэлцүүлэн, 873.5 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэх, 2499.6 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасах, 3236.8 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, 27296.4 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд авах, 99.5 сая төгрөгийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах, бусад 3074.5 сая төгрөгийн хөрөнгөтэй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудыг өөрчлөн байгуулах шийдвэр гаргуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Монгол улсын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүнгээр тасалбар болгон орон нутгийн өмчит 116 байгууллагын эзэмшиж ашиглаж байгаа газар, үл хөдлөх хөрөнгийг Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан аргачлалын дагуу үнэлж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор дүнг баталгаажуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт нэгтгүүлээ.	100
		264	2.6.3.4. Төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах	2016-2020	АЗДТГ	Нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сайжирна.	“Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналт хийх” журмын дагуу 16 сум, 1 тосгоны төрийн сангийн үйл ажиллагаанд жил бүр эрсдлийн үнэлгээ хийж ажиллаж байна. Санхүүгийн албаны дарга, төлбөр тооцооны мэргэжилтнүүдэд “Орон нутгийн чадавхийг бэхжүүлэх” болон “Freebalance программ”-ийн V7 хувилбарын сургалтыг зохион байгууллаа. Сумдад гардаг нийтлэг алдаа, зөрчлийг арилгах, төрийн сангийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад чиглэсэн хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмж чиглэл хүргүүлэн биелэлтийг хангуулан ажилласны үр дүнд жил бүр эрсдлийн түвшин 2.71-4.71 хувиар буурсан байна.	100

49	2.6.4 Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд бүх талын зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, бодлогын удирдамжаар хангана.	265	2.6.4.1. Арилжааны даатгалын компаниудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд учирч болох эрсдлийг бууруулах, даатгалын ач холбогдлыг сурталчлан даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх ажлыг өргөжүүлэх	2016-2020	АЗДТГ	Аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд учирч болох эрсдэл буурч, даатгуулагчдын тоо нэмэгдсэн байна.	Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг даатгалын компанийн 5 салбар нь жил бүр 8 төрлийн даатгал хийж, 2016-2019 онд давхардсан тоогоор 47479 иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлж 1843.2 сая төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлж, 973 иргэн, хуулийн этгээдэд 254.4 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон. Санхүүгийн зохицуулах хорооноос "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалт зохион байгуулж арилжааны даатгалын компани, төрийн албан хаагч 66 иргэнийг хамруулж даатгалын компаниудын үйл ажиллагаанд эрсдлийн үнэлгээ хийж, заавар зөвлөгөө өгч ажиллалаа. 2018 онд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд даатгал, санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр эсээ бичлэг, гар зургийн уралдаан, мэтгэлцээний тэмцээн зохион байгуулан, 2203 сурагчийг хамруулан мэдлэг, мэдээллээр ханган ажиллалаа. Албан журмын даатгагчдын холбоотой хамтран сум тус бүрт ажиллан, тээврийн хэрэгслийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах ажил жил бүр хийж хэвшсэн.	100
		266	2.6.4.2. Брокерийн компани, бичил санхүүгийн /банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо/ үйл ажиллагааг дэмжин ажиллах	2016-2020	АЗДТГ	Санхүүгийн зах зээл тодорхой хэмжээгээр хөгжсөн байна.	Аймгийн хэмжээнд хадгаламж зээлийн 3 хоршоо, банк бус санхүүгийн байгууллага 1 үйл ажиллагаа явуулж байна. ББСБ нь 2016 онд 163 харилцагчид 121.5 сая төгрөгийн зээл олгож байсан бол сүүлийн 3 жилийн хугацаанд харилцагчийн тоогоо 245-д хүрч, 17.0-25.2 сая төгрөгийн хүүгийн орлоготой, 5.2-7.5 сая төгрөгийн ашигтай ажиллаж, байгууллагын санхүүгийн чадварыг нэмэгдүүлэн ажиллаж байна. Орон нутгийн хадгаламж зээлийн хоршоод нь гишүүнчлэлийн тоог өсгөх, зээлийн багцыг нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчдээ шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилт тавин ажиллаж байна"Хан намнан хан хөгжил" ХЗХоршоо нь 2016 онд 310 гишүүнтэй байсан бол 2019 онд 375 гишүүнтэй болж 192.1 сая төгрөгийн зээлийг олгож 3.2 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. "Хөгнө хан хөгжил" ХЗХоршоо нь 2016-2018 онуудад 170 гаруй гишүүнтэйгээр 15.8-16.9 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгээр 11-25 зээлдэгчид 31.6-54.1 сая хүртэлх төгрөгийн зээл олгож, 2.6-3.2 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. "Цогтын хишиг" ХЗХоршоо нь 2016-2017 онуудад 93 гишүүнтэйгээр 17.1 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 24-48 хадгаламж эзэмшигчтэй, 31-35 зээлдэгчдэд 18.3-18.4 сая төгрөгийн зээл олгож 2.6-2.8 сая төгрөгийн ашигтай ажиллаж байна. Монгол улсын Засгийн газраас зарласан "Хуримтлалтай-Хувьцаатай иргэн" аяны хүрээнд 2019 оны 10 дугаар сард "Эрдэнэс таван толгой" хувьцаат компанийн 1072 Мэдээллийн төв, "Булган брокерын пүүс"-тэй хамтран 16 сум, 1 тосгоны 1540 иргэнд хөрөнгийн зах зээл, үнэт цаас, хувьцаа, "Эрдэнэс таван толгой" ХК-ийн үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг сурталчлах ажлыг зохион байгууллаа. "Булган Брокерын пүүс" ХХК нь тайлант онд 745356 ширхэг хувьцаа арилжиж, 60.4 сая төгрөгийн борлуулалт хийж, анхдагч зах зээлээс 441952 ширхэг хувьцаа худалдан авсан байна.	100
ГУРАВ. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ								
Зам, тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбоо, барилгын салбарыг хөгжүүлж, орон нутгийн иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.								
Зам, тээврийн чиглэлээр:								
		267	3.1.1.1. Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх	2018-2020	АЗДТГ	Босоо тэнхлэгийн авто зам, замын байгууламж барилга угсралтын ажил эхэлсэн байна.	Булган, Орхон, Хишиг-Өндөр, Гурванбулаг чиглэлийн босоо тэнхлэгийн замаас эхний ээлжинд Булган-Орхон чиглэлийн 22 км хатуу хучилттай замын ажлыг "НКВ" ХХК 2018-2019 онд 20.9 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж, улсын комисст хүлээлгэн өглөө. 2019 онд тухайн замын үргэлжлэл Орхон-Хишиг-Өндөр чиглэлийн 12.8 км авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажлыг "Наранбулаг" ХХК 60 хувийн гүйцэтгэлтэйгээр ажиллаж байна.	100

50	3.1.1. Авто замын сүлжээг сайжруулж, зарим сумын төвийн авто замыг хатуу хучилттай болгоход улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөс гадна гадаадын хөрөнгө оруулагчид, дотоодын хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжинэ.	268	3.1.1.2. Аймаг, орон нутгийн авто замын сүлжээг сайжруулж, зарим сумын төвийн болон бусад чиглэлийн авто замыг ээлж дараатайгаар хатуу хучилттай болгох	2017-2020	АЗДТГ, СЗД	Авто зам, замын байгууламж сайжирч, замын хөдөлгөөний аюулгүй байдал хангагдана.	Булган сумын Нэгдсэн эмнэлгийн урд талаас “НИК-петровис” шатахуун түгээх станц хүртэлх 482 метр, Биеийн тамир, спортын газрын урд талаас Нэгдсэн эмнэлгийн баруун хойд талын уулзвар хүртэл 453 метр, 3 дугаар багийн А-Б хэсгийн хооронд 550 метр авто замыг шинээр барьж, Булган сумын төв замын 925 метр урттай өргөтгөлийн ажлуудыг тус тус гүйцэтгэлээ. Булган сумын 4-р баг, Зүүн түрүү чиглэлийн 3 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл 1.8 км авто замын барилга угсралтын ажлыг “Жи Пи Экспресс Финанс” ХХК эхлүүлээд байна.	100
		269	3.1.1.3. Тэшиг сумын далан багт Эгийн гол, Хутаг-Өндөр сумын Тээл багийн Далангийн аманд гатлага онгоц байрлуулах, Сэлэнгэ сумын Сэлэнгэ мөрний 437.02 метр урт төмөр бетон гүүрийг ашиглалтад оруулах	2016-2017	АЗДТГ, СЗД	Гатлага онгоц суурилуулж, төмөр бетон гүүр ашиглалтад орсон байна.	Тэшиг сумын Энтийд Эгийн голын гатлага онгоц барих ажлыг 105.6 сая төгрөгөөр “Өлзий хутагийн наран” ХХК-иар гүйцэтгүүлж, ашиглалтад хүлээн авсан. Хутаг-Өндөр сумын Тээл багийн далангийн аманд гатлага онгоц шилжүүлэн суурилуулах ажлыг сум хөгжүүлэх сангийн 25.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж, ашиглаж байна. Мөн Сэлэнгэ мөрний 437.02 у/м төмөр бетон хийцийн гүүрийн барилга угсралтын ажлыг “Хотгор зам” ХХК гүйцэтгэж, ашиглалтад хүлээлгэн өгөв.	100
		270	3.1.1.4. Эрдэнэт-Хялганатын чиглэлийн авто замыг хатуу хучилттай болгох асуудлыг уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэртэй хамтран шийдвэрлэх	2016-2020	АЗДТГ, СЗД	Тухайн чиглэлийн авто зам, замын байгууламж сайжирч замын хөдөлгөөний аюулгүй байдал хангагдана.	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.2.4-т уг асуудлыг хэрэгжүүлэхээр тусгасан боловч хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүйгээс хойшлогоод байна. Зураг төслийг хийлгэсэн, төсөвт өртөг 32.5 тэрбум төгрөг.	ҮБ
51	3.1.2. Аймгийн төвийн авто зам, замын байгууламжийг сайжруулах, нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх, автомашины зогсоолыг шинээр барих ажлыг үргэлжлүүлнэ.	271	3.1.2.1. Авто замын зураг төсөв бүхий ажлуудыг үргэлжлүүлэн хийх	2016-2020	АЗДТГ, СЗД	Булган сумын авто замын нэвтрэх чадвар сайжирч, замын байгууламж, уулзвар, авто зогсоолын талбай нэмэгдэнэ.	Булган, Орхон, Хишиг-Өндөр, Гурванбулаг чиглэлийн босоо тэнхлэгийн замаас эхний ээлжинд Булган-Орхон чиглэлийн 22 км хатуу хучилттай замын ажлыг 100% гүйцэтгэж, Орхон-Хишиг-Өндөр чиглэлийн 12.8 км авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажил 60 хувийн гүйцэтгэлтэй байна. Булган сумын 3 цэгт нийт 1485 метр урттай авто замыг шинээр барьж, төв замын 925 метр урттай өргөтгөлийн ажлыг гүйцэтгэлээ. Зүүн түрүү чиглэлийн 3 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл 1.8 км авто замын барилга угсралтын ажлыг энэ онд эхлүүлээд байна. Баян-Агт сумын Хануйн голын Ангархайн 1.5 км авто замын засвар шинэчлэлтийн ажлыг “Жавхлан Харгуй” ХХК гүйцэтгэж байна.	100
		272	3.1.2.2. Дашчойнхорлин хийд-Цагаан суваргатай холбох авто зам шинээр барих	2017-2020	АЗДТГ, СЗД	Аялагч, жуулчдын ая тухтай зорчих нөхцөл бүрдэнэ.	Цагаан суварга хийдийн 1 км замын ажлын зургийн судалгааны ажил /инженер геологи, дэвсгэр зураг/-ыг “Эко гидро гео” ХХК-иар 18.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлээд байна. Цагаан суваргын барилгыг ашиглалтад оруулахтай хамт зам, талбай, орчны тохижилтын ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.	ҮБ
		273	3.1.2.3. Булган хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу авто зогсоолын хүчин чадлыг ээлж дараатай нэмэгдүүлэх	2016-2020	АЗДТГ, АТТ	Аймгийн төвийн хөдөлгөөний нэвтрэх чадвар нэмэгдсэн байна.	Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг угтан Булган хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 2017-2018 онд нийт 30 байршигд 14999.5 м.кв талбай бүхий авто зогсоол, 3148.6 метр урттай явган хүний замуудыг байгуулсан.	100
		274	3.1.2.4. Булган хотын төв зам дагуух орц, гарцууд дээр “Хүндэтгэлийн хаалга” хийх	2016-2020	АЗДТГ, Булган сум	Шинээр 2 хаалга барьж, 1 хаалгыг сэргээн засварлана.	Булган-Мөрөн чиглэлийн улсын чанартай авто зам дагуу “Эвсэг сайхан” ХХК-ийн 280.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Анхдагчдын өлгий нутаг” хаалгыг барьж ашиглалтад хүлээлгэн өгсөн. Тээвэрчдийн гэр бүл, үр хүүхдүүдийн санаачлагаар “Цагаан хаалга”-ыг 12.5 сая төгрөгийн хандивын хөрөнгөөр сэргээн засварлав. Мөн Булган-Эрдэнэт чиглэлийн зам дагуу “Зоон даваа”-ны орчимд аялал жуулчлалын цогцолбор барих 1 дүгээр шатны ажлыг “Модерн хас” ХХК-аар гүйцэтгүүлээд байна.	100
		275	3.1.3.1. Нийтийн зорчигч тээврийн “Авто вокзал”-ын барилга барих	2016-2019	АЗДТГ, ГХБХБГ	“Нийтийн зорчигч үйлчилгээний цогцолбор” ашиглалтад орсон байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгуулах саналаа Зам, тээврийн хөгжлийн яаманд жил бүр хүргүүлсэн боловч, хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй байна. Аймгийн концессын зүйлийн жагсаалтад “барих-ашиглах-өмчлөх” төрлөөр Авто вокзал барих асуудлыг тусгаж, батлуулсан.	40

52	3.1.3. Булган суманд нийтийн тээврийн үйлчилгээг тогтмолжуулж, алсын сумдад хүргэх шуудангийн үйлчилгээний тоог нэмэгдүүлнэ.	276	3.1.3.2. Хөвсгөл-Булган-Улаанбаатар хооронд зорчих урсгалыг нэмэгдүүлэх	2016-2020	АЗДТГ, АТТ		Шинээр маршрут нээгдэж, үйл ажиллагаа тогтворжсон байна	Хөвсгөл-Булган-Улаанбаатар хооронд зорчих урсгалыг нэмэгдүүлэх, маршрут нээх чиглэлээр Автотээврийн үндэсний төвд удаа дараа хандсаны үр дүнд Булган-Улаанбаатар чиглэлд том оврын автобусны зэрэгцээ такси үйлчилгээг нэвтрүүлсэн. Мөн Улаанбаатар-Мөрөн чиглэлийн том оврын автобусаар Хутаг-Өндөр сумын зорчигчдыг бүртгэхийг зөвшөөрч, тээврийн үйлчилгээг үзүүлж байна.	100
		277	3.1.3.3. Булган суманд нийтийн тээврийн автобусны үйлчилгээг тогтмолжуулах	2016-2020	АЗДТГ, СЗД, АТТ		Нийтийн тээврийн автобусны үйлчилгээ тогтмолжсон байна.	Булган суманд нийтийн тээврийн автобусны үйлчилгээг тогтмолжуулах асуудлаар Авто тээврийн төв, Булган сумын ЗДТГ-т чиглэл болгов. Тус үйлчилгээг тогтмолжуулах талаар сонирхогч этгээдээс санал ирээгүй байна. Аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн арга хэмжээнд хандиваар ирсэн дунд оврын автобусыг Булган сумын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд шилжүүлж, парк шинэчлэл хийлээ.	70
		278	3.1.3.4. Алсын сумдад хүргэх шуудангийн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх	2016-2020	АЗДТГ, СЗД, АТТ, ШҮГ		Алсын сумдад хүргэх шуудангийн үйлчилгээний тоо нэмэгдсэн байна.	Сумдад хүргэх шуудангийн үйлчилгээг хувийн өмчийн "Монгол шуудан" ХК-ийн Булган салбар хариуцан ажиллаж байгаа бөгөөд тус компанид үйлчилгээний давтамжийг нэмэгдүүлэх талаар чиглэл өгсөн. Тус компани аймаг дахь салбарт парк шинэчлэлт хийгдээгүйгээс шуудан үйлчилгээний давтамжийг нэмэгдүүлэх боломжгүй байна.	40

Эрчим хүчний чиглэлээр:

53	3.1.4. Аймгийн төв болон сумдад бий болох шинэ сууршлын бүсүүдэд эрчим хүчний асуудлыг шат дараатайгаар шийдвэрлэж, эрчим хүчний хангамж муутай, доголдолтой газруудад шинэчлэл хийж, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг бий болгоно.	279	3.1.4.1. Булган сумын Дулааны станцыг үргэлжлүүлэн барьж, ашиглалтад оруулах	2016-2017	АЗДТГ, ГХБХБГ		Байгаль орчны бохирдлол буурч, иргэдийн ая тухай амьдрах нөхцөл сайжирсан байна.	Дулааны станцын барилга болон техник угсралтын ажил нь дуусч, улсын комисс ашиглалтад хүлээн авсан. 2019-2020 оны халаалтын улиралд тус станцаас дулаанаар хангахаар тооцож, галлагааг 9 дүгээр сарын 15-аас эхлүүлсэн. Одоогоор туршилт, тохируулгын ажил хийгдэж байна.	100
		280	3.1.4.2. Аймгийн төв, сумдын эрчим хүчний хуучирсан, шугам сүлжээ, эрчим хүчний хангамж муутай, доголдолтой газруудад шинэчлэл хийх	2016-2020	АЗДТГ, ГХБХБГ		Эрчим хүчний найдвартай ажиллагаа хангагдана.	2017 онд Хангал, Хишиг-Өндөр сум, Хялганат тосгоны цахилгаан дамжуулах агаарын шугамыг төмөр бетон тулгуур бүхий СИП кабельд шилжүүлэхэд 319.6 сая, Булган, Орхон, Могод, Орхон, Тэшиг, Дашинчилэн, Хутаг-Өндөр, Сайхан, Гурванбулаг, Рашаант сумын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засварт 917.5 сая, 2018 онд Хишиг-Өндөр сум, Хялганат тосгоныг СИП кабельд шилжүүлэхэд 110.4 сая, эрчим хүчний хуучирсан шугам, сүлжээ, эрчим хүчний хангамж муутай, доголдолтой газруудад шинэчлэл, засвар хийхэд 418.9 сая, 2019 онд Хишиг-Өндөр, Сэлэнгэ, Рашаант сумыг төмөр бетон тулгуурт шилжүүлэхэд 251.5 сая, Могод, Баян-Агт, Булган, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Сайхан, Булган, Гурванбулаг, Рашаант сум, Хялганат тосгоны цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын засварт 593.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Мөн энэ онд Азийн хөгжлийн банкны 4.6 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Булган сумын төвийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг СИП кабельд шилжүүлэх ажлыг 2019-2020 онд гүйцэтгэхээр шийдвэрлүүлж, энэ онд хийгдэх төлөвлөгөөт ажлыг бүрэн хэрэгжүүлээд байна.	100
		281	3.1.4.3. Дулааны станцын цахилгаан хангамжийг сайжруулан, нэг хэлхээ газрын кабелиар аваарын нөөц цахилгаан эх үүсвэртэй болгох	2016-2017	АЗДТГ, ЭБЦТС, ТӨХК		Дулааны цахилгаан станцын хэвийн үйл ажиллагаа хангагдана.	Дулааны станцын цахилгааны нөөц эх үүсвэрийг 170.0 сая төгрөгөөр гүйцэтгэж байгаа бөгөөд барилга угсралтын ажил 70 гаруй хувьтай байна. 2019 оны 12 дугаар сард ашиглалтад оруулна.	100
		282	3.1.4.4. Зарим сумдын цахилгаан дамжуулах агаарын шугамыг бетонон тулгуур бүхий СИП кабельд шилжүүлэх	2017-2020	АЗДТГ, ЭБЦТС, ТӨХК		Эрчим хүчний найдвартай ажиллагаа сайжирна.	2017 онд Хангал, Хишиг-Өндөр сум, Хялганат тосгоны ЦДАШ-ыг төмөр бетон тулгуур бүхий СИП кабельд шилжүүлэхэд 319.6 сая, 2018 онд Хишиг-Өндөр сум, Хялганат тосгоны ЦДАШ-ыг төмөр бетон тулгуур бүхий СИП кабельд шилжүүлэхэд 110.4 сая, 2019 онд Хишиг-Өндөр, Сэлэнгэ, Рашаант сумын ЦДАШ-ыг төмөр бетон тулгуурт шилжүүлэхэд 251.5 сая төгрөг зарцуулсан байна.	100

		283	3.1.4.5. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг гудамж хорооллын гэрэлтүүлэгт ашиглаж, зарим төвлөрсөн багийг цахилгааны эх үүсвэртэй болгох	2017-2020	АЗДТГ, ЭБЦТС, ТӨХК		Гэр хорооллын амьдрах орчин сайжирч, цахилгааны эх үүсвэр нэмэгдэнэ.	Булган сумын "Домын дэвсэг"-т сэргээгдэх эрчим хүчний зориулалтаар газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулах журмын дагуу 84 га газрыг "Авзага энержи" ХХК, Хишиг-Өндөр суманд 145 га газрыг "Булгансолар энержи" ХХК-д олгоод байна.	40
		284	3.1.4.6. Булган сумын орон сууцны айл өрхүүдийг ээлж дараатайгаар хэрэглээний халуун устай болгох	2016-2020	АЗДТГ, ГХБХБГ		Хэрэглэгчдийн сэтгэл ханамж нэмэгдэж, найдвартай ажиллагаа хангагдана.	Булган сумын орон сууцны айл өрх, байгууллагуудыг хэрэглээний халуун устай болгох ажлын зөвлөх үйлчилгээг "Урбан девелопмент консалтинг групп" ХХК-иар 2017-2018 онд гүйцэтгүүлсэн. 2020 оноос Булган суманд хэрэглээний халуун усны шийдэл бүхий шинээр баригдсан барилга, объектуудыг хэрэглээний халуун устай болгохоор төлөвлөөд байна.	40

Мэдээлэл, холбооны чиглэлээр:

54	3.1.5. Хэрэглэгчдэд дэвшилтэт технологийн гурвалсан болон шилэн кабелийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.	285	3.1.5.1. Өндөр хурдны сүлжээнд холбогдсон сумдын төрийн байгууллагууд болон аж ахуйн нэгж, айл өрхөд шилэн кабель хүргэж, интернетэд холбогдох боломжийг бүрдүүлэх	2016-2020	МТШХХГ, ХХЗХ		Шилэн кабельд холбогдоогүй сумдын холбогдох хэрэглэгчид үйлчилгээ авсан байна.	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт 2017, 2018 оны бүх нийтийн үүргийн сангийн хөрөнгө оруулалтаар зайлшгүй шаардлага бүхий газруудад үүрэн телефоны сүлжээ оруулах, шилэн кабельд холбогдоогүй сумдыг холбох саналаа хүргүүлсний үр дүнд бүх сумд шилэн кабельд холбогдоод байна. Хэрэглэгч хүсэлт гарган шилэн кабельд холбогдох боломж бүрдсэн. Шинээр ашиглалтад орж буй барилгыг шилэн кабельд холбож байна.	100
		286	3.1.5.2. Аймаг, сумын төвүүдэд болон томоохон суурин газрууд, нийтийн эзэмшлийн талбай, олон нийтийн газарт интернетэд холбогдох WI-FI орчныг нэмэгдүүлэх	2016-2020	МТШХХГ, ХХЗХ		Аймаг, сумын төвүүдэд болон томоохон суурин газрууд, нийтийн эзэмшлийн талбай, олон нийтийн газарт интернетэд холбогдох WI-FI орчин нэмэгдсэн байна.	Аймгийн төв, сумын төв, томоохон суурин газрууд утасгүй интернетийн WI-FI орчинд холбогдсон. Аймгийн хэмжээнд нийт 35 ширхэг WI-FI төхөөрөмж суурилагдсан. Тухайлбал: Баян-Агт суманд 3, Баяннуур суманд 1, Бугат суманд 1, Бүрэгхангай суманд 3, Дашинчилэн суманд 3, Гурванбулаг суманд 2, Хишиг-Өндөр суманд 2, Рашаант суманд 3, Могод суманд 2, Сайхан суманд 1, Орхон суманд 1, Хутаг-Өндөр суманд 3, Тэшиг суманд 3, Сэлэнгэ суманд 3, Хангал суманд 2, Хялганат тосгонд 1, Булган суманд 1-ийг тус тус суурилуулан ашиглаж байна.	100
		287	3.1.5.3. Өндөр хурдны телевизийн дохио дамжуулах "IPTV" технологи нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх, сүүлийн үеийн дэвшилтэт технологийн гурвалсан үйлчилгээ нэвтрүүлэхийг дэмжих	2016-2020	МТШХХГ, ХХЗХ		Сүүлийн үеийн дэвшилтэт технологийн гурвалсан үйлчилгээ нэвтрүүлэх боломж бүрдсэн байна.	"Юнивишн" ХХК иргэдийн ая тухтай ажиллах амьдрах боломжийг бүрдүүлэх, мэдээллийг цаг алдалгүй, хүртээмжтэй авч байх хэрэгцээнд тулгуурлан гурвалсан үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн ба аймгийн төв, сумдын хэрэглэгчид хүсэлтээ гаргаж тус үйлчилгээнд холбогдох бүрэн боломжтой болсон.	100
		288	3.1.5.4. Үүрэн холбооны оператор компаниудад 4G технологи нэвтрүүлэх ажлыг дэмжих	2016-2020	МТШХХГ, ХХЗХ		4G технологи нэвтэрсэн байна.	Үүрэн телефоны "Юнивишн" ХХК, "Мобиком" ХХК-ууд 4G технологийг нэвтрүүлээд байна.	100

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр:

		289	3.1.6.1. Аймгийн төв болон сумдад баригдаж байгаа дуусаагүй барилга, байгууламжийг үргэлжлүүлэн барьж, ашиглалтад оруулах	2016-2020	АЗДТГ, ГХБХБГ		Дуусаагүй барилгууд ашиглалтад орсон байна. 68	Булган сумын 3 дугаар сургууль, 2 дугаар цэцэрлэгийн барилгыг 2017 онд, 1-р сургуулийн барилгыг 2018 онд ашиглалтад оруулсан. Булган сумын 5-р багт дутуу баригдсан "Авзага Трейд" ХХК-ийн зочид буудлын барилгын ажил үргэлжилж байна. Тэшиг сумын сургуулийн өргөтгөл 240 суудалтай хичээлийн байрны барилга угсралтын ажлын дуусгалд 828.7 сая төгрөгийг Улсын төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлээ.	70
--	--	-----	---	-----------	---------------	--	---	---	----

3.1.6. Баригдаж дуусаагүй барилга байгууламжуудыг дуусгахад анхаарал хандуулж, орон сууцны хорооллыг байгуулж, иргэдийн амьдрах орчинг сайжруулна.

290	3.1.6.2. Орон сууц барихад дэмжлэг үзүүлж, 200-аас доошгүй айлын орон сууц ашиглалтад оруулах	2016-2020	АЗДТГ, ГХБХБГ	200-аас доошгүй айлын орон сууц баригдсан байна.	Иргэн Д.Энхтайваны 25 айлын орон сууцны барилга /2020 онд дуусаах ба хэсэгчилсэн байдлаар 5 айл, үйлчилгээний хамт/-ыг ашиглалтад оруулсан бол Булган суманд "Нүнжигт Өргөө" ХХК-ийн 10 айлын орон сууцны барилгын ажлыг 2019 онд ашиглалтад өгөхөөр ажиллаж байна. Мөн "Төмөр транс" ХХК-ийн 10 айлын орон сууцны барилгын ажил 80 хувийн гүйцэтгэлтэй байна. Булган сумын 6-р багт 320 айлын орон сууцны хотхоны дулаан, цэвэр, хэрэглээний халуун ус, цахилгаан хангамжийн зураг төсөл боловсруулах даалгаврыг боловсруулан "Аслаан" ХХК-д захиалаад байна. Хялганат тосгонд 24 айл, Бүрэгхангай суманд 12 айл, Сайхан суманд 20 айлын орон сууцны барилга барихаар ажлын даалгаврыг боловсруулж хүргүүлсэн ба сумын удирдлагуудыг мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж байна.	70
291	3.1.6.3. Аймаг, сумын төвүүдийн гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн талбайг иргэдийн санаачилга, оролцоонд тулгуурлан гэрэлтүүлэг, тоглоомын талбайтай болгож, хаягжуулах, тохижилтын асуудлыг цогцоор шийдвэрлэх	2017-2020	АЗДТГ, ГХБХБГ	Гэр хорооллын гудамжны өнгө үзэмж, хаягжилт сайжирч, иргэдийн санаачилга, оролцоонд тулгуурлан жишиг гудамж бий болгоно.	Булган сумын 2, 3 дугаар багийн гэр хороолол дунд, 1 дүгээр сургуулийн хойно, Хийдийн зүүн талд гэсэн 4 байршилд хүүхдийн тоглоомын талбай байгууллаа. Булган сумын төвийн гэрэлтүүлгийн өргөтгөл шинэчлэлтийн ажлыг улс, орон нутгийн төсвийн нийт 890.3 төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж ашиглалтад оруулав. Мөн Булган сумын 2, 3, 5, 6 дугаар багийн хорооллын дунд хатуу хучилттай авто замын гэрэлтүүлгийн ажлыг сумын төсвийн 69.9 сая төгрөгөөр гүйцэтгэлээ. 2018 онд Баян-Агт сум 2.5 сая, Бугат сум 3.8 сая, Гурванбулаг сум 40.0 сая, Дашинчилэн сум 2.4 сая, Тэшиг сум 15.0 сая, Рашаант сум 9.3 сая төгрөгөөр, 2019 онд Могод сум 15.0 сая, Орхон сум 30.0 сая, Сайхан сум 12.5 сая, Хутаг-Өндөр сум 7.0 сая, Тэшиг сум 18.0 сая, Рашаант сум 21.2 сая төгрөгөөр гудамж зам талбай, гэр хороололд гэрэлтүүлэг тавьж, байнгын ашиглалтад оруулаад байна. Булган сумын хаягийн тэмдгийг байрлуулах ажлыг 49.9 сая төгрөгөөр гэр хорооллын гудамжны 494 дугаар, хашааны 3396 дугаар, 230 барилга, 24 өргөн чөлөө, 52 орц, 8 объектын байрлал заасан, 8 газар ус, түүх, соёлын газрын байрлал заасан хаягийн тэмдэг, Хангал сум 30 гудамж, 506 хашаа, Могод сум 82 гудамж, 287 хашаа, Бүрэгхангай сум 645 хашаа, барилга, үл хөдлөх хөрөнгө, Гурванбулаг сум 672 хашаа, барилга, Тэшиг сум гэр хорооллын гудамж, үл хөдлөх хөрөнгийн 613 дугаар, Хялганат тосгон 709 хашаа барилгын дугаар, Сэлэнгэ сум 459 гудамж, суурин газрыг хаягжуулах ажлыг гүйцэтгэж, хаягжуулалтын тухай хууль, журмын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллалаа.	100
292	3.1.6.4. Аймгийн төвийн цэнгэлдэх хүрээлэнг шинэчлэх	2017-2019	АЗДТГ, ГХБХБГ	Өнгө үзэмж, багтаамж нэмэгдсэн байна.	Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойд зориулж Цэнгэлдэх хүрээлэнг засварлах, шинэчлэх ажлын зураг төслийн дагуу аймгийн төсөв болон "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн нийт 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэн ашиглалтад хүлээн авлаа.	100
293	3.1.6.5. Сумын төвүүдийг төвлөрсөн инженерийн байгууламж буюу дулаан хангамж, цэвэр, бохир усны сүлжээтэй болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2016-2019	АЗДТГ, ГХБХБГ	Иж бүрэн инженерийн шугам сүлжээтэй болж, оршин суугчдын ажиллаж, амьдрах орчин сайжирна.	Хялганат тосгоны цэвэр усан хангамж, дулааны сүлжээ, 25 м3/хоног хүчин чадалтай биологийн цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулсан. Рашаант суманд цэвэрлэх байгууламжийн шинэчлэлт, дулааны нэгдсэн төв байгуулсан. Дашинчилэн Баяннуур, Гурванбулаг, Орхон, Бугат, Могод, Хишиг-Өндөр, Хангал сумын инженерийн шугам сүлжээний ажлыг концессийн зүйлийн жагсаалтад оруулж, зургийн даалгаврыг бэлтгэн хүлээлгэн өгсний дагуу Баяннуур, Дашинчилэн, Хишиг-Өндөр сумд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаад байна. Баян-Агт сумын төвийн халаалтын нэгдсэн системд шилжүүлэх ажлыг "Долоон бар" ХХК концессийн гэрээгээр гүйцэтгэж ашиглалтад оруулсан. Сайхан суманд Байгаль хамгаалах сангийн 496.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар цэвэр усны шугам сүлжээний эхний үе шатны ажлыг гүйцэтгэн хүлээн аваад байна.	100
294	3.1.6.6. Үйлдвэржилтийн болон шинэ суурьшлын бүсүүдэд инженерийн дэд бүтэц байгуулах	2017-2020	АЗДТГ, ГХБХБГ	Үйлдвэржилтийн болон шинэ суурьшлын бүсүүдийн цахилгаан, цэвэр усны хэрэгцээ хангагдана.	Дэлхийн банкны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төслийн хүрээнд Булган сумын төлөвлөгдсөн суурьшлын бүсэд /Хуучин морь бариа/ эрчим хүчний шугам сүлжээг барих санал тавьсан боловч хүн суурьшаагүй бүсэд шинэ шугам сүлжээ тавих боломжгүй гэсэн хариу өгсөн. Энэ онд Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх ажлын хүрээнд тус газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийлгэхээр тооцоолж байна. "Домын дэвсэг" дэх үйлдвэржилтийн бүсийн ТЭЗҮ-ийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн бөгөөд үүнд инженерийн дэд бүтцийн асуудлыг бүрэн тусгасан.	40

		295	3.1.6.7. Булган сумын үерийн ус зайлуулах суваг, даланг шинэчлэх	2016-2020	АЗДТГ, ГХБХБГ, ОБГ		Үерийн усны учирч болох эрсдлээс иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамгаална.	Булган сумын үерийн сувгийн цогц тооцоо зураглалыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн. 2017 онд 1-р багийн шинэ хороо, 6-р багийн Б хэсгийн зүүн талаар үерийн даланг 628.0 сая төгрөгөөр барьж ашиглалтад оруулсан. 2018 онд 6-р багийн А хэсгийн баруун талын үерийн сувгийн ажлыг 74.06 сая төгрөгөөр “Энх шилтгээн” ХХК барьж эхэлсэн боловч, чанарын шаардлага хангаагүй тул ашиглалтад хүлээн аваагүй байна. 2019 оны улсын төсөвт туссан Булган сумын 2-р багийн Б, В хэсгийн дунд үерийн сувгийн ажлыг 539.1 сая төгрөгөөр гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өглөө.	100
56	3.1.7. Иргэдийн оролцоотой газар зохион байгуулалтын төлөвлөлт хийж, газрын нөөцийг шинжлэх ухааны үндэслэлтэй зөв зохистой ашиглана.	296	3.1.7.1. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах	2017-2020	АЗДТГ, ГХБХБГ		Газар, ашиглах, хамгаалах асуудлыг оновчтой зохион байгуулна	2019 онд “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө” хийлгэх 300.0 сая төгрөгийн /эхний санхүүжилт/ санхүүжилтийг шийдвэрлүүлж, гүйцэтгэгч сонгох худалдан авах ажиллагаа 2 удаа амжилтгүй болж, дахин зарлаад байна. Үүний зэрэгцээ Орхон, Бугат, Хутаг-Өндөр, Тэшиг, Хишиг-Өндөр, Дашинчилэн, Хангал сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажилд 294.0 сая зарцуулж, Дашинчилэнгээс бусад сумдын төлөвлөгөөг батлуулсан. Дашинчилэн сумын нутаг дэвсгэрт хээрийн тодруулалтыг хийж, сумын иргэд, багийн Засаг дарга нараас санал авч, суурин боловсруулалтын ажлыг дуусгасан. Сумдууд нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй болсноор газрыг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөн иргэд, аж ахуйн нэгжид олгох боломж нээгдэж байна.	40
		297	3.1.7.2. Газрын шинэтгэлийн ажлыг эрчимжүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад газар эзэмшүүлэх ажлыг 20 хувиар, газрыг иргэн бүрт үнэ төлбөргүй өмчлүүлэх ажлыг 25 хувиар өсгөж, эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг бий болгох	2017-2020	АЗДТГ, СЗД, ГХБХБГ		Газар эзэмшүүлэх ажил 20 хувиар, өмчлүүлэх ажил 25 хувиар өссөн байна.	2016 оноос хойш аймгийн хэмжээнд 2461 иргэнд газар өмчлүүлж 19.8 хувиар, 2991 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлж 17.8 хувиар өсгөж ажиллалаа. 2019 оны 3 дугаар улирлын байдлаар өссөн дүнгээр 14872 иргэнд 2443.65 га газрыг өмчлүүлж, нийт хүн амын тоонд харьцуулахад газар өмчлөлийн ажил 24.06%-тай явагдаж байна. Сумдаар авч үзвэл Баяннуур 6 иргэнд 1.09 га, Бугат 9 иргэнд 0.95 га, Булган 68 иргэнд 8.19 га, Бүрэгхангай 7 иргэнд 0.7 га, Сайхан 2 иргэнд 0.21 га, Орхон 6 иргэнд 0.48 га, Сэлэнгэ 21 иргэнд 5.9 га, Хангал 7 иргэнд 0.79 га, Хутаг-Өндөр 9 иргэнд 1.79 га газрыг тус тус өмчлүүлсэн байна. Бусад сумд газар өмчлөх шийдвэр гаргаагүй байна.	70
		298	3.1.7.3. "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбилцлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлж, "Лэнд менежер" программ хангамжийг нэвтрүүлэх	2017-2018	ГХБХБГ		Газрын мэдээллийн сангийн баяжилтыг цаг алдалгүй хийж, иргэдэд нээлттэй болгоно.	Газрын кадастрын мэдээллийн сангийн "Лэнд менежер" программ хангамжийг аймгийн хэмжээнд 100 хувь нэвтрүүлж, 3831 ширхэг нэгж талбарыг идэвхтэй болгож, 3685 өмчлөгч, 6426 газар эзэмшигч, нийт 10111 нэгж талбарыг мэдээллийн санд нөхөн оруулж, өмчлөх 11841, эзэмших 12261, ашиглах 47 иргэн аж ахуйн нэгж байгууллагыг нэмж бүртгэлээ.	100
		299	3.1.7.4. Төвлөрсөн зам дагуух аймгийн хилийн цэсийг баталгаажуулж, Булган аймгийн газар нутгийг илэрхийлсэн самбаруудыг босгох, газрыг аялал жуулчлал, худалдаа үйлчилгээ, фермерийн зориулалтаар олгох асуудлыг шийдвэрлэх	2017-2019	АЗДТГ, ГХБХБГ		Аялагч, жуулчид мэдээлэл авах, тэдний түр амрах нөхцөл бүрдэхээс гадна фермерийн аж ахуй хөгжинө.	Хилийн цэсийг баталгаажуулах ажил 100 хувь хэрэгжсэн. Улсын чанартай авто зам дагуух газруудад хаягийн самбар байршуулахад 23.17 сая төгрөгийг зарцуулж, 64 ширхэг хаягийн самбарыг байршууллаа. Булган аймгийн нутаг дэвсгэрээр 3 чиглэлээр дайран өнгөрч буй улсын чанартай авто замын дагуу Архангай, Өвөрхангай, Орхон, Төв, Хөвсгөл аймгийн хилийн заагт хаягийн самбарыг байрлуулахаар төлөвлөж, эхний ээлжинд 60.8 сая төгрөгөөр Орхон аймагтай хил залгаа газарт хаягийн тэмдэг, самбарыг байрлуулахаар 2020 оны төсвийн төсөлд тусгалаа. Бугат сумын Зоон давааны орчимд барьж буй аялал жуулчлалын цогцолбор байгуулах газрыг Булган сумын ЗДТГ-т эзэмшүүлээ. Мөн Төлүүгийн даваа, Булган сумын 1 дүгээр багийн нутагт шинээр баригдаж буй худалдаа, үйлчилгээний цэгийн газрыг тухайн сумын ЗДТГ-т нь эзэмшүүлэхээр төлөвлөсөн. Рашаант суманд улсын чанартай авто замын дагуу 2 нэгж талбарт газар олголт хийж, зорчигч, жуулчдад зориулсан үйлчилгээний цэг байгуулж байна.	70

		300	3.1.7.5. Газрын төлбөрийн орлогын зохих хувийг газрыг хамгаалах, нөхөн сэргээх болон газар зохион байгуулалтын бусад арга хэмжээнд зарцуулах асуудлыг жил бүр төлөвлөн баталгаажуулж, хэрэгжилтийг ханган ажиллах	2017-2020	АЗДТГ, ГХБХБГ		Хуулийн хэрэгжилт хангагдана.	2017 онд аймгийн төсөвт сумдын даамлуудад нэг бүр нь 428.0 мянган төгрөгийн өртөгтэй 14 ширхэг GARMIN маркийн гар GPS-г хүлээлгэн өгсөн. 2018 онд Улсын чанартай авто зам дагуух газруудад 64 ширхэг хаягийн самбар байршуулахад 23.17 сая төгрөг, Бэлчээрийн фотомониторинг хийхэд 4.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. 2019 онд баг, хорооны хилийн заагийг тодорхойлох, баталгаажуулах ажилд 13.8 сая, газрын зураг хэвлэгч плоттер авахад 17.4 сая төгрөгийг тусгуулан хэрэгжүүлсэн. Үүний дээр жил бүр бэлчээрийг доройтлоос хамгаалах, ашиглалтыг сайжруулах, усан хангамжийг нэмэгдүүлэх, нөхөн сэргээх ажилд 800.0-950.0 сая төгрөгийг зарцуулж байна.	100
--	--	-----	---	-----------	---------------	--	-------------------------------	---	-----

ДӨРӨВ. ЗӨВ ЗАСАГЛАЛ

Төрийн албаны уламжлал шинэчлэлийг хослуулан, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хяналт шинжилгээ, дотоод аудит тогтмолжсон, эдийн засгийн үр өгөөжтэй гадаад харилцааг бэхжүүлэн, ИРГЭНДЭЭ ОЙР, МЭРГЭШСЭН, ТОГТВОРТОЙ ТӨРИЙН АЛБЫГ ТӨЛӨВШҮҮЛНЭ.

57	4.1.1. Зөв бодлогыг үр дүнд хүргэхийг зорьж ажиллана.	301	4.1.1.1. Иргэдийн санал, санаачилгаар дэмжигдсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулах төслийн баг томилж ажиллуулах	2016-2020	АЗДТГ		Иргэдийн санал, санаачлагыг байнга сонсдог түүнийг хэрэгжүүлдэг төслийн баг ажиллаж хэвших	Аймгийн Засаг даргын шийдвэрээр аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан төслийн нэгжийг 2 жилийн хугацаатай байгуулсан. Тус төслийн нэгжид иргэд, аж ахуйн нэгж төсөл ирүүлснийг хянаж, шаардлага хангасан төслийг холбогдох газруудад хүргүүлсэн. Төслийн нэгжийн хийсэн чацаргана тариалах суурь судалгаа, тооцоог үндэслэн "Чацаргана" хөтөлбөрийг боловсруулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулсан. Тус төсөлд аймгийн төсвөөс 1.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Мөн аймгийн Засаг даргын "Хөгжлийн хөтөч" хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх "Оюунлаг Булган", "Амжилтын галт тэрэг", "Монгол нум сум", "Уртын дуу Морин хуур", "Эрүүл мэндийн хөтөч", "Эрүүл ирээдүй", "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих", "Булган жимс жимсгэнэ", "Хүүхэд залуучуудад экологийн боловсрол олгох", "Зөв бүртгэл" хөтөлбөрүүдэд иргэдийн саналыг тусган, батлуулсан.	100
		302	4.1.1.2. Орхон аймагтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, үр дүнг тооцож ажиллах	2016-2020	АЗДТГ		Гэрээнд тусгагдсан ажлыг бүрэн хэрэгжүүлсэн байна.	Орхон аймагтай хамтран ажиллах гэрээг 2016 онд байгуулсан. Тус гэрээнд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид, Засаг даргын Тамгын газрын зүгээс нэмэлт өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг томилон, аймгийн Засаг даргын харьяа агентлаг, хэлтэс, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газарт хүргүүлээ. Мөн Орхон аймгийн "Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газартай 2018 онд 1.0 тэрбум төгрөгийн гэрээ байгуулж, аймаг байгуулагдсаны 80 жилийн ойд зориулж, Булган сумын цэнгэлдэх хүрээлэнгийн иж бүрэн засварыг хийж гүйцэтгэсэн. 2019 онд 500.0 сая төгрөгийн хамтран ажиллах гэрээ байгуулж, Орхон аймгийн хил залгаа байрлах Сэлэнгэ, Бугат, Хангал, Орхон сумын бүтээн байгуулалт, байгаль орчин, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах зэрэг үйл ажиллагаанд зарцууллаа. Он дуусахад хамтран ажиллах гэрээний төлөвлөгөөний биелэлт 95 хувьтай байна.	100
		303	4.1.1.3. Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулах	2016-2020	АЗДТГ		Тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдаж, ой тэмдэглэн өнгөрүүлсэн байна.	Аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг тэмдэглэх аймгийн хороог Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2016 оны 107 дугаар тогтоолоор байгуулан иргэд, олон нийтээс бүтээлч ажлын саналыг авч, 80 бүтээлч ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөгөө гарган ажилласны үр дүнд аймгийн төвийн барилга байгууламж, гэрэлтүүлэг, зам, зогсоол, ногоон байгууламж зэрэг Булган сумын өнгө төрхийг нэмсэн олон ажлууд хийгдэж төлөвлөсөн ажлаа 85 хувьтай гүйцэтгэсэн. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2018 оны 70 дугаар тогтоолоор баяр наадмыг зохион байгуулах аймгийн хороог 11 салбар хороотойгоор байгуулан Засгийн газрын 2018 оны 167 дугаар тогтоолоор 2018 оны 07 дугаар сарын 27-29-ний өдөр аймгийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн.	100

		304	4.1.1.4. Анхдагч алдартнуудын ойг тэмдэглэн өнгөрүүлэх /Чин ван Ханддорж - 150, мэргэн сайд А.Амар – 130, Төр, нийгмийн зүтгэлтэн Д.Дамба – 110 жил, Ардын Хатанбаатар Магсаржав - 140 жил г.м/	2016-2020	АЗДТГ	Анхдагч алдартнуудаар бахархсан ажил зохион байгуулагдсан байна.	2016 онд Монгол улсын Ерөнхий сайд асан А.Амарын мэндэлсний 130 жилийн ой, Монгол улсын Дархан аварга, Үндэсний спортын ууган гавьяат мастер Б.Түвдэндоржийн мэндэлсний 100 жилийн ойг Булганхангай бөхийн дэвжээ, Улаанбаатар дахь нутгийн зөвлөлтэй хамтран тэмдэглэсэн. 2017 онд Монгол улсын баатар, хурандаа генерал Ж.Лхагвасүрэнгийн мэндэлсний 105 жилийн ой, 2018 онд Ардын Хатанбаатар С.Магсаржавын мэндэлсний 140 жил, Төр, нийгмийн нэрт зүтгэлтэн Д.Дамба 110 жилийн ойг улс, аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлсэн. 2019 онд Эрдэнэ дайчин хошой Чин Ван М.Ханддоржийн 150 жилийн ойг улс, орон нутгийн хэмжээнд тэмдэглэж, эрдэм шинжилгээний хурал, баримтат кино бүтээх, сурагчдын дунд түүхийн олимпиад, эсээ бичлэгийн уралдаан, номын үзэсгэлэн гаргах үйл ажиллагааг тус тус зохион байгуулж, анхдагч алдартнуудын ойг тэмдэглэн өнгөрүүллээ.	100
58	4.1.2. Төрийн албанд, ахмад үеийнхээ мэдлэг чадвар, дадлага туршлага, арга барил, хандлагыг тусган авч, ахмад, дунд, залуу үеийн 3 цагийн хэлхээсэнд хамтран ажиллана.	305	4.1.2.1. Төрийн албанд ажиллаж байсан ахмад, дунд үе, залуучуудын төлөөллийн уулзалтыг жил бүр хийж, гарсан санал зөвлөмжийг хэрэгжүүлэх	2016-2020	АЗДТГ, ТАЗ	Мэдлэг, чадвар, арга туршлага нэмэгдсэн байна.	Төрийн албанд ажиллаж байсан ахмад, дунд, залуу үеийн төлөөллүүдийн уулзалтыг нийт 108 байгууллага 127 удаа зохион байгуулжээ. Булган аймгийн “Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн”, Төрийн албанд ажиллаж байсан ахмад, дунд үе, залуучуудын төлөөллийн уулзалтыг зохион байгуулж, уламжлал шинэчлэлийг хослуулан, төрийн албаны шинэтгэлийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэхээр хэлэлцүүлэг өрнүүлж, ХУРДТАЙ, ХАРИУЦЛАГАТАЙ, ХЯНАЛТТАЙ төрийн албыг төлөвшүүлэх уриалгыг батлан хэрэгжүүллээ. Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзоригор ахлуулсан ажлын хэсэг Булган аймагт ажиллах үеэр төрийн албанд ажиллаж байсан ахмад үеийн төлөөллүүдтэй уулзалт зохион байгуулж, төрийн албаны сахилга, хариуцлагыг дээшлүүлэх талаар саналаа солилцлоо. Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн аймгийн зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд төрийн албанд ажиллаж байсан ахмад үеийн төлөөлөл, манлайлагч эмэгтэйчүүдийг урилгаар оролцуулан, санал, зөвлөмжийг нь сонссон. "Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ" төслийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэмжлэгтэйгээр 8 байгууллагад хэрэгжүүлсэн. Ахмад үеийнхний зөвлөгөө, зөвлөх үйлчилгээг авснаар, дунд залуу үеийнхний сахилга, хариуцлага, ажилдаа хандах хандлагад ахиц өөрчлөлт гарч, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилсэн зэрэг үзүүлэлттэй байна.	100
		306	4.1.2.2. Төрийн албанд шинэ бүтээлч санаачлагыг уламжлалт арга барилтай хослуулан хэрэгжүүлэх	2016-2020	АЗДТГ	Төрийн албан хаагчийн шинэ, бүтээлч санааг дэлгэрүүлж, орон нутагт хэрэгжүүлсэн байна.	Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар нь Иргэдэд үйлчлэх нэгдсэн байр нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж, иргэдэд хүргэх үйлчилгээг боловсронгуй болгох, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн байгууллага бүр “Угтах үйлчилгээ”-г бий болгосон. Төрийн байгууллага бүр үйл ажиллагааны үр дүнг сайжруулах талаар санаачилга гарган ажиллаж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын бүтээлч хандлагыг нэмэгдүүлж, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор “Шинэ санаачлага-Тэргүүн туршлага” болзлыг зарлан хэрэгжүүлсэн. Төрийн албан хаагчид өөрийн эрхэлж буй ажлын чиглэлээр сүүлийн 5 жилийн судалгааг гаргаж, “Чанарын удирдлагын тогтолцоо”-г нэвтрүүлэхээр бэлтгэж байна. Төрийн албанд шинэ бүтээлч санаачлагыг уламжлалт арга барилтай хослуулснаар төрийн албан хаагчдын бүтээлч сэтгэлгээ хөгжиж, ажлын үр дүн нэмэгдсэн. Төрийн захиргааны албан хаагчдын өдрийг аймгийн Засаг даргын 2016 оны А/500 дугаар захирамжаар жил бүр уламжлал болгон тэмдэглэн өнгөрүүлж байна. Тус өдрийг угтан 1-3 сарын аяныг зарлан, төрийн албан хаагчдыг чадваржуулах сургалт, илтгэл лекцийг үе шаттайгаар зохион байгууллаа. Төрийн албаны чанар, үйлчилгээг сайжруулах зорилгоор төрийн албан хаагчдын дунд "Хөгжилд хөтлөхөд миний оролцоо" эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа.	70

		307	4.1.2.3. Аймгийн Засаг даргын дэргэд орон тооны бус ахмадын зөвлөлийг байгуулах	2016	АЗДТГ	Ахмадуудын санаа бодлыг үйл ажиллагаандаа тусгасан байна.	Аймгийн Засаг даргын шийдвэрээр О.Мэдэхгүй, П.Дамба нарыг орон тооны бус зөвлөхөөр томилон ажиллуулж байна. Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойд зориулсан "Бага нэвтэрхий толь", "Булган аймгийн түүх" 1, 2 дугаар боть, "Төрд зүтгэсэн он жилүүд" номын боловсруулалтад орон тооны бус зөвлөх П.Дамба, БСУГ-ын даргаар ажиллаж байсан ахмад багш Л.Эгиймаа нар болон төр, захиргааны ахмад ажилтан Ц.Дагвадаш, Ж.Мөнх-Очир, С.Даваасамбуу зэрэг ахмадаас зөвлөгөө авч, саналыг тусган ажиллалаа.	100
59	4.1.3. Засаг, захиргааны анхан шатны нэгж багийн хөгжлийг бүх талаар дэмжиж, бэхжүүлнэ.	308	4.1.3.1. Хангал, Баяннуур, Рашаант, Булган сумын зарим багийг "Багийн хөгжлийн төв"-тэй болгох	2016-2020	Аймаг, сумын ЗДТГ	Мэдлэг, чадвар, арга туршлага нэмэгдсэн байна.	Булган сумын 1, 4, 6 дугаар баг багийн хөгжлийн төвөөр дамжуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Тэшиг сум 2016 онд, Могод сум 2017 онд, Бүрэгхангай сум 2018, 2019 онуудад шинээр "Багийн хөгжлийн төв"-тэй болж иргэдэд үйлчилж, мэдээ мэдээллийг хүргэж байна.	40
		309	4.1.3.2. Багийн ИНХ-ыг жилд 4-өөс доошгүй удаа зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	2016-2020	Сумын ЗДТГ	Төрийн албан хаагчийн шинэ, бүтээлч санааг дэлгэрүүлж, орон нутагт хэрэгжүүлсэн байна.	Сумдын ЗДТГ-аас төсөвт байгууллагуудтай хамтран иргэдийн идэвх, санаачлагыг нэмэгдүүлэх, мэдээ мэдээллээр хангах зорилгоор улирал тутам багийн ИНХ-ыг зохион байгуулж байна. Багийн Иргэдийн нийтийн хурлуудад аймаг, сумын удирдлагууд, холбогдох агентлаг, хэлтсийн мэргэжилтнүүд иргэдэд цаг үеийн ажлын талаар мэдээлэл өгч, мэдээллийн хуудас, гарын авлага, "Хөгжлийн хөтөч" сонинг түгээн, үйл ажиллагаагаа сурталчлан, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх, цаашдын үйл ажиллагаандаа тусгах талаар анхааран ажиллаж байна. Нийт сумд БИНХ-ыг зохион байгуулж, 2020 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтад саналаа хүргүүлээд байна. Багийн иргэдийн нийтийн хуралд иргэд 50-75 хувийн ирцтэй оролцож байна.	100
		310	4.1.3.3. Багийн Засаг дарга, эмч, ИНХ-ын дарга, байгаль хамгаалагч нарын зөвлөгөөнийг жил бүр хийж, гарсан санал, уриалгыг анхан шатанд хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажиллах	2016-2020	АЗДТГ	Ахмадуудын санаа бодлыг үйл ажиллагаандаа тусгасан байна.	"Удирдлагын академи", аймгийн ИТХ-ын ажлын алба, "Тогтвортой амьжиргаа 3" төсөл, Статистикийн хэлтэс, Байгаль, орчин аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар хамтран жил бүр багийн Засаг дарга, эмч, ИНХ-ын дарга, байгаль хамгаалагч нарын сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, аймгийн 75 багийн Засаг дарга нарыг албан хэрэгцээний зөөврийн компьютероор хангалаа. "Удирдлагын академи"-тай хамтран багийн Засаг дарга нарыг чадавхжуулах сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулж 75 багийн Засаг дарга хамрагдсан. Мөн "Тогтвортой амьжиргаа 3" төслийн хүрээнд багийн Засаг дарга, багийн ИНХ-ын дарга, иргэдийн төлөөллийг хамруулсан сургалтыг 10 хоногийн турш Булган суманд зохион байгуулж 75 багийн 141 хүнийг хамрууллаа. Мэргэжлийн хяналтын газраас сумдын 26 байгаль хамгаалагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор сургалт, зөвлөгөөн, сумдын ЭМТ-ийн удирдах ажилтнууд болон багийн эмч нарын сургалт, зөвлөгөөнийг тус тус зохион байгуулж, гарсан санал, уриалгыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
		311	4.1.4.1. Төрийн албан хаагчдын "Хүний нөөцийн бодлого"-ыг боловсруулан, хэрэгжүүлэх	2017-2020	АЗДТГ	Бодлого боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	"Булган аймгийн Төрийн албан хаагчдын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр /2019-2022/"-ийг боловсруулан аймгийн Засаг даргын 2019 оны А/296 дугаар захирамжаар батлуулаад байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж 20.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс баталсан. 2016-2019 онд төрийн албан хаагчдыг чадавхжуулахад анхаарч, богино хугацааны болон гадаад, дотоодын мэргэшүүлэх сургалтад хамруулах ажлыг шат дараатай зохион байгуулж байна. Тус зорилтын дүнд: АНУ, Япон, Солонгос, Хятад, Энэтхэг зэрэг гадаад улсад 46, төрийн захиргааны асуудал эрхэлсэн төв байгууллага, дээд шатны мэргэжлийн байгууллагаас зохион байгуулсан сургалтад давхардсан тоогоор 2612, мэргэшүүлэх сургалтад 278, орон нутагт мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан сургалтад давхардсан тоогоор 8864 албан хаагч тус тус хамрагдсан байна.	100

60	4.1.4. Төрд тангараг өргөж, хариуцлага хүлээсэн бүх шатны төрийн албан хаагчдаа үнэнч шударга, ёс зүйтэй, тогтвор суурьшилтай, сэтгэл хангалуун ажиллаж, амьдрах орчин нөхцлийг бүрдүүлж, хүний нөөцийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, байгууллагын соёл, хандлагыг төлөвшүүлнэ.	312	4.1.4.2. Төрийн албанд мэргэшсэн албан хаагчдыг бүрдүүлэх зорилгоор ажлын байрны үзлэг шалгалт хийж, ажил үүргийн хуваарийг оновчтой болгох	2016-2017	АЗДТГ	Төрийн албаны үйл ажиллагааны үр нөлөө нэмэгдсэн байна.	2017-2019 онд ажлын байрны үзлэг шалгалтыг 3 удаа зохион байгуулж, төрийн жинхэнэ албаны томилгоог хуульд нийцүүлэх, төрийн албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авч ажиллалаа. Үзлэг шалгалтын дүнгээр төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын 8, гүйцэтгэх 57 албан тушаалд түр орлон гүйцэтгэгч ажиллаж байсан зөрчлийг арилгуулж, төрийн албаны тухай хуулийн хүрээнд томилгоог хийсэн. Төрийн албаны тухай хуулийн дагуу байгууллага бүр ажлын байрны шинжилгээ хийж албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, аймгийн ИТХ, ЗДТГ, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 7 агентлагийн 135 албан тушаалд хамаарах 104 тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр хянуулан батлах зөвшөөрлийг авч, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр баталгаажууллаа. Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгтэй холбогдуулан нийт төрийн байгууллагуудын төрийн ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. Ажлын байрны үзлэг шалгалтын жил бүр зохион байгуулж ажилласнаар төрийн байгууллагуудын ажил үүргийн хуваарь оновчтой болж, давхардал хийдэл арилсан, ажлын байрны эмх цэгц, албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилт сайжирсан үр дүнтэй байна.	100
		313	4.1.4.3. Төрийн байгууллага ажил, үйлчилгээний онцлогт тохирсон соёл, хандлагыг тодорхойлох	2016-2017	АЗДТГ	Төрийн байгууллагын үйлчилгээний соёл тодорхойлогдсон үйлчилгээг эрхэмлэсэн төрийн алба бий болсон байна.	Булган аймгийн Засаг даргын Тамгын газар нь Иргэдэд үйлчлэх нэгдсэн байр нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж, иргэдэд хүргэх үйлчилгээг боловсронгуй болгох, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор "Угтах үйлчилгээ"-г бий болголоо. Угтах үйлчилгээг бий болгосноор төрийн үйлчилгээний шуурхай байдал нэмэгдэж, иргэдийн сэтгэл ханамж дээшилж байна. Булган аймгийн цахим хуудас /www.bulgan.gov.mn/-аар дамжуулан үйл ажиллагааны үнэлгээг иргэдээс авч, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж байна. Аймгийн Засаг даргын 2018 оны А/125 дугаар захирамжаар 2018 оныг "Хариуцлагын жил" болгон, "Ёс зүйг дээдэлсэн хамт олон шалгаруулах болзол"-ыг зарлан дүгнэсэн. Төрийн байгууллага бүр төрийн албан хаагчийн хувцаслалт, харилцаанд тавигдах шаардлагын стандартын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, 3 байгууллага шинэчлэн боловсруулсан. Малчдад төрийн мэдээлэл, үйлчилгээг ойртуулах зорилгоор "Нүүдлийн тамгын газар малчны хотонд" арга хэмжээг сумдын Засаг даргын Тамгын газраас санаачлан хэрэгжүүллээ. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын удирдлага, албан хаагчид 75 багт ажиллаж, төрийн үйлчилгээг хүргэж, "Хөгжлийн хөтөч" хөтөлбөрийг сурталчиллаа.	100
		314	4.1.4.4. Алслагдсан сумдад ажиллаж байгаа мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор, суурьшилтай ажиллуулах үүднээс гэрээ байгуулж, ажиллах нөхцөл боломжийг ханган, ажлын байр болон дотоод, гадаадын сургалтад хамруулж, мэдлэг боловсролоо дээшлүүлэх боломж нөхцөлийг дэмжих	2017-2020	АЗДТГ	Чухал шаадлагатай мэргэжлийн судалгаатай болж, гэрээ байгуулах нөхцөлийг бий болгосон байна.	Булган аймгийн алслагдсан Тэшиг, Рашаант зэрэг суманд төрийн тусгай болон төрийн захиргаа, эрүүл мэнд, боловсролын салбарт нийт 400 гаруй албан хаагч ажиллаж байна. Дээрх албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, сургах асуудлыг "Төрийн албан хаагчдын хүний нөөцийн бодлого"-д тусгаад байна. Дээрх албан хаагчдын амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор аймаг, орон нутгийн зүгээс 7.2 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүллээ. Алслагдсан сумдад ажиллаж буй 5 багшийг ОХУ-д мэргэжлийн чиглэлээр уралдаан, тэмцээнд оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлж, 2 багшийг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймагт, 1 багшийг БНСУ-д мэдлэг мэргэжил дээшлүүлэх сургалтад тус тус хамруулаад байна.	70

		315	4.1.4.5. Сумдын Засаг даргын Тамгын газрын барилгад урсгал болон их засварыг үе шаттайгаар хийх	2017-2020	АЗДТГ, ГХБХБГ		Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирна.	2016 оноос эхлэн сумдын Засаг даргын Тамгын газарт урсгал болон их засвар хийх, шинээр барих ажлыг үе шаттай төлөвлөн, жил жилийн төсөвт тусгаж байна. Булган сумын ЗДТГ хэсэгчилсэн дотор засал, Баяннуур, Бугат, Сэлэнгэ, Хангал, Орхон, Дашинчилэн, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгоны ЗДТГ-т урсгал засвар хийж, Бүрэгхангай сумын ЗДТГ-т 36.0 сая төгрөгийн их засварын ажлыг хийж гүйцэтгэлээ. 2019 оны улсын төсөвт Могод сумын ЗДТГ-ын шинэ барилгын ажлыг тусган 823.0 сая төгрөгөөр барьж ашиглалтад хүлээн авахаар ажиллаж байна. 2020 оны улсын төсөвт Баян-Агт сумын ЗДТГ-ын шинэ барилгын ажлыг эхлүүлэхээр тусгалаа. 2019 оны орон нутгийн төсвөөс сумдын Засаг даргын Тамгын газрын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажилд сум тус бүрт 10.0 сая төгрөгийг олгож, техник, тоног төхөөрөмжийг шинэчиллээ.	100
61	4.1.5 Нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, иргэдэд хүргэх мэдээллийг өргөжүүлж, цахим хэлбэрээр мэдээлэл, үйлчилгээ авах бололцоо, нөхцлийг сайжруулна.	316	4.1.5.1. Төрийн байгууллагуудын цахим үйлчилгээг нэмэгдүүлэх, цахим мэдээллийг иргэдэд хүргэдэг шинэ арга барилыг бий болгох	2016-2017	АЗДТГ, төр, захиргааны байгууллага		Иргэд мэдээллийг хурдан шуурхай авдаг болно.	Булган аймгийн албан ёсны вэб сайт /www.bulgan.gov.mn/-ыг Засгийн газрын www.zasag.mn сайттай холбож, татвар, улсын бүртгэл, газрын харилцаа, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн чиглэлийн үйлчилгээ авахдаа бүрдүүлэх материалын дэлгэрэнгүй мэдээллийг тус сайтаас авах боломжтой болгон шинэчилж, мэдээллийн баяжилтыг шуурхай хийж байна. Мөн тус сайтад аймгийн хэмжээнд вэб сайт ажиллуулж буй сум, байгууллагуудын вэб холбоосыг холбосноор иргэдэд илүү хялбар болж шинэчлэгдсэн. Албан ёсны вэб сайтгүй Баян-Агт, Баяннуур, Бугат, Гурванбулаг, Могод, Орхон, Рашаант, Сайхан, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгоныг сайттай болгохоор Үндэсний дата төвд мэдээллээ хүргүүлсэн. Дээрх хуудсуудыг серверт байршуулж байна. Булган аймгийн Засаг даргын Тамгын газар нүүр хуудас ажиллуулж, иргэдэд мэдээллийг цаг тухайд нь хүргэж байна. Сум, агентлагуудын мэдээллийн ажилтнуудыг нэгтгэсэн мэдээллийн групп нээн мэдээлэл солилцох, түгээх ажлыг хялбарчиллаа.	100
		317	4.1.5.2. Төр, захиргааны байгууллагын удирдлагууд иргэддээ улирал тутам хийсэн ажлаа тайлагнаж, санал хүсэлтийг сонсдог графикт тогтолцоог хэвшүүлэх	2016-2020	АЗДТГ, төр захиргааны байгууллагууд		Төр нь иргэддээ ажлаа тайлагнадаг тогтолцоо хэвшинэ.	Аймгийн Засаг дарга болон холбогдох хэлтэс, байгууллагын удирдлагууд Булган сумын ТББ, иргэд, байгууллага аж ахуйн нэгжүүд, сонирхлын бүлгүүдтэй уулзалт зохион байгуулж хийсэн ажлаа тайлагнадаг арга хэлбэрт шилжээд байна. "Сайхан Монгол" орон нутгийн телевизтэй хамтран Булган аймгийн ЗДТГ-аас аймгийн удирдлагууд, хэлтэс, агентлагийн дарга нар оролцон, 7034-7034 дугаарын утсаар "Иргэдээ сонсьё" шууд нэвтрүүлгийг Пүрэв гараг бүр 19.00 цагаас, Булган сум Мягмар гараг бүр "Иргэнд ойр төрийн үйлчилгээ" шууд нэвтрүүлэг, Хууль хяналтын байгууллагын ажилтнууд оролцсон "Хуулийн цаг" зэрэг нэвтрүүлгүүдийг бэлтгэн, үзэгчдэд хүргэж хэвшлээ. 2018 онд 17, 2019 онд 32 дугаарыг бэлтгэн иргэдийн санал шүүмжлэлийг үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна. Мөн аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2018 онд Булган сумын 6 багийн нийт өрхүүдээр, 2019 онд 16 сумын 75 багийн нийт өрхүүдээр аймгийн удирдлагууд болон, хэлтэс, агентлагийн дарга, мэргэжилтнүүдээс бүрдсэн ажлын хэсгийг томилж иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэх, санал хүсэлтийг нь сонсох чиглэлээр ажиллалаа.	100
		318	4.1.5.3. Аймгийн албан ёсны цахим хуудсыг шинэчилж, баяжуулах журмын хэрэгжилтийг сар бүр хангаж ажиллах	2016-2020	АЗДТГ, төр захиргааны байгууллагууд		Мэдээллийн хүртээмж сайжирна.	Аймгийн албан ёсны веб сайтыг /bulgan.gov.mn/ иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй байлгах зарчмаар дэд цэсүүдийг нэмж, шинэчлэн ашиглалтад оруулж, цаг үеийн мэдээ мэдээллийг байршуулан, баяжилт шинэчлэл хийж байна. Авлигатай тэмцэх газраас 2017-2019 онд өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор вэб сайтын бүтэц, мэдээллийг шинэчлэн ажиллаж байна. Цагдаагийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Боловсрол, соёл урлагийн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Мэргэжлийн хяналтын газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Онцгой байдлын газар зэрэг агентлаг, байгууллагууд цахим үйлчилгээг өргөнөөр ашиглан төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай нээлттэй хүргэж байна.	100

		319	4.1.5.4. Төрийн үйлчилгээний “Нэг цэг”-үүдийг тогтворжуулж, Угтах үйлчилгээг нэвтрүүлэх	2017-2018	АЗДТГ		Иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай хүргэнэ.	Бугат, Булган, Гурванбулаг, Орхон, Сэлэнгэ, Хангал, Хишиг-Өндөр сум “Нэг цэг”-ээр иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж байна. 2017 онд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор “Инээмсэглэн угтаж баярлуулан үдье” аяныг зохион байгуулж, сум байгууллагууд угтах үйлчилгээг нэвтрүүлэн тогтмолжуулсан. Тус ажлын хүрээнд иргэд төрийн үйлчилгээний мэдээллийг шуурхай авдаг болсноор аймгийн удирдлагууд, аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга, мэргэжилтнүүдтэй уулзах хүсэлт, хүлээлт багассан.	100
		320	4.1.5.5. Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын үүсэл санаачлагыг дэмжин хамтран ажиллаж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлж, сурталчлах мэдээллийн багтаамж, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	2016-2017	АЗДТГ, төр захиргааны байгууллага		Мэдээллийн хүртээмж нэмэгдэнэ.	Орон нутгийн “Сайхан Монгол” телевиз Юнивишн IPTV, ДДИШ ТВ-ээр орон даяар сувгаа түгээж, нэмэлт тоног төхөөрөмж суурьлуулан сайжруулж байна. Орон нутгийн хэрэглэгчид сувгаа хайлгаснаар ДДИШ ТВ-ээр аймгийнхаа телевизийг үнэгүй үзэх боломжтой боллоо. “Сайхан Монгол” телевизийн үйл ажиллагааг дэмжих, иргэдэд төрийн мэдээллийг шуурхай хүргэх зорилгоор гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Тус телевиз сум, байгууллагуудын зорилтот мэдээ мэдээллийг шууд дамжуулах, орон нутгийн мэдээллийн хөтөлбөр болон цэнгээнт нэвтрүүлгүүдийг бэлтгэн телевизийн эфир, цахим хуудас, радио долгионоор үзэгчдэд хүргэж байна. 2018 онд 15.0 сая, 2019 онд 15.0 сая төгрөгийг хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэхээр тусгасан. “Сайхан Монгол” телевиз үйл ажиллагаагаа явуулж эхэлснээр 6 иргэн байнгын ажлын байртай болж, иргэд орон нутгийнхаа мэдээллийг түргэн шуурхай хүлээн авч үздэг боллоо. Мөн “Булганы мэдээ” сонинтой 2017 онд 1.5 сая төгрөгөөр хамтран ажиллах гэрээ байгуулан, “Тамгын газраас мэдээлж байна” нүүр бэлтгэн уншигчдад хүргэсэн. 2018, 2019 онд цаг үеийн мэдээ мэдээлэл, зар мэдээ, мэндчилгээ байршуулахдаа тухай бүр хамтран ажиллах гэрээг байгуулаад байна.	100
62	4.1.6 Аливаа шийдвэр гаргахдаа иргэд, олон нийтийн саналыг авч, нийгмийн бүлгүүдийн оролцоонд тулгуурлаж, олонхийн эрх ашгийг дээдэлсэн зөв бодлого гаргаж, хэрэгжүүлнэ.	321	4.1.6.1. Хөтөлбөр, төсөл боловсруулахдаа иргэний танхимаар хэлэлцүүлж хэвшүүлэх	2016-2020	АЗДТГ, Төрийн байгууллагууд		Шийдвэр гарах түвшинд иргэдийн оролцоо нэмэгдэнэ.	Төсөл хөтөлбөр, дүрэм, журам боловсруулахад иргэдийн санал хүсэлтийг тусгах, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор иргэний танхимаар 2016 онд 46 хэлэлцүүлэгт 2482 иргэн, 2017 онд 41 хэлэлцүүлэгт 1080 иргэн, 2018 онд 46 хэлэлцүүлэгт 2086, 2019 онд 41 хэлэлцүүлэгт 2387 иргэнийг хамруулж, гарсан санал хүсэлтийг бодлогын баримт бичигт тусган ажиллаж байна. Ингэснээр аливаа шийдвэр гаргахад олон нийтийн саналыг авч, олонхийн эрх ашгийг дээдэлсэн бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна.	100
		322	4.1.6.2. Иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, иргэдийн сайн дурын нөхөрлөл, бүлгүүдийн үүсгэл санаачилгыг дэмжиж, төрийн зарим чиг үүргийг тэдгээрээр төлөөлүүлэн гүйцэтгүүлэх замаар төвлөрлийг сааруулах	2016-2020	Төр, иргэний нийгмийн байгууллагууд		Төр, иргэний түншлэл сайжирсан байна.	Иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, иргэдийн сайн дурын нөхөрлөл, бүлгүүдийн үүсгэл санаачилгыг дэмжиж, төрийн зарим чиг үүргийн дагуу төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэхээр 2016 онд 27, 2017 онд 55, 2018 онд 59, 2019 онд 53 ажлын жагсаалтыг баталсан. Аймгийн хэмжээнд 35 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна.	100

63	4.1.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг бодлого боловсруулах, төлөвлөлтийн явцад тусгах, ашиглах чадавхийг бүх шатны байгууллагад бий болгон олон нийтийн оролцоог хангах, санхүүжүүлэх арга замыг тодорхойлон, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмолжуулж, үр нөлөөг дээшлүүлнэ.	323	4.1.7.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг бодлого төлөвлөлтийн шатанд тусгах, бодлогын нөлөөллийн үнэлгээ хийх, ашиглах чадавхийг бүх шатны байгууллагад бий болгох	2016-2020	АЗДТГ, Төрийн байгууллагууд	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, төлөвлөсөн бодлогын хэрэгжилт сайжирна.	Сумын ЗДТГ болон газар, хэлтэс, байгууллагуудын үйл ажиллагааны тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнгийн талаар сумдын Засаг дарга, Тамгын газрын дарга, байгууллагуудын дарга нарт танилцуулж тайлангийн бүтэц, агуулгад анхаарч цаашид төлөвлөлтийн шатанд хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг зөв тодорхойлж, гүйцэтгэл, үр дүнд ач холбогдол өгч ажиллахыг зөвлөн ажилласан. 2018 онд Удирдлагын академийн Мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулсан "Бодлогын хэрэгжилтийг үнэлэх арга зүй" сэдэвт сургалтад аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудын Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүд, аймгийн ЗДТГ-ын ТЗУХ болон ХШҮДАХ-ийн мэргэжилтнүүд, 2019 оны 03 дугаар сард ЗГХЭГ, Дэлхийн банкны хамтарсан "Харилцан суралцах арга зүй" сургалтад ХШҮДАХ-ийн мэргэжилтнүүд, 2019 оны 06 дугаар сард Архангай аймагт зохион байгуулагдсан "Төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний уялдааг хангах нь" хангайн болон төвийн бүсийн аймгуудын сургалтад хэлтэс тус бүрийн тайлан, мэдээ нэгтгэдэг мэргэжилтнүүдийг тус тус хамрууллаа. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр болон тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удаашралтай заалт, арга хэмжээг эрчимжүүлэх талаар аймгийн Засаг даргын захирамжаар сум, агентлагийн дарга нарт үүрэг чиглэл өгч ажиллав. Сум, агентлагууд үүний дагуу хэрэгжилт нь удаашралтай заалт, арга хэмжээг эрчимжүүлэх гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган ажиллаж байна.	100
		324	4.1.7.2. Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга ажиллагааг төр, төсвийн байгууллагуудад нэвтрүүлэх, цахим тайлангийн үйл ажиллагааг жигдрүүлэх	2016-2020	АЗДТГ, Төрийн байгууллагууд	Төрийн бодлогын чанар хүртээмж сайжирна.	Бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сум, байгууллагуудаас АБЛЕ программаар авч хэвшсэн. 16 сум, 1 тосгон, аймгийн төр, төсвийн байгууллагуудад ажиллаж, "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ын дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилт бичиж, тооцох чиглэлээр зөвлөн тусалж, зөвлөгөө өгсөн.	100
		325	4.1.7.3. Бодлого төлөвлөлт, хэрэгжилт, хяналтын бүх үе шатанд олон нийтийн оролцоог хангах, хэлэлцүүлэг зохион байгуулах, санхүүжүүлэх арга замыг тодорхой болгох	2016-2020	АЗДТГ, Төрийн байгууллагууд	Төрийн бодлого олон нийтэд нээлттэй болж, төрийн бодлогод олон нийтийн гүйцэтгэх үүрэг, оролцоо сайжирч, итгэл үнэмшил нэмэгдсэн байна.	Аймгийн хэмжээний бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулахдаа иргэний танхимаар хэлэлцүүлж иргэдийн саналыг тусгаж байна. Аймгийн Засаг даргын "Хөгжлийн хөтөч" хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийг аймгийн Засаг даргын 2017 оны А/50 дугаар захирамжаар холбогдох газар, хэлтэс, сум байгууллагуудад хуваарилан өгч үүрэгжүүлсэн ба аймгийн Засаг даргын 2017 оны А/280 дугаар захирамжаар баталсан журмын дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг үнэлж дүгнэх, тайлагнах ажлыг хийж хэвшиж байна. Булган аймгийн Нутгийн захиргааны байгууллагын үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар 2017 онд 8 сумын 834 иргэнээс хэрэглэгчийн үнэлгээний судалгааг авахад 6.4 сая төгрөг зарцуулсан бөгөөд үнэлгээний дүн 55.4, 2018 онд 10 сумын 825 иргэнээс тус судалгааг авахад 7.8 сая төгрөг зарцуулсан ба хэрэглэгчийн үнэлгээний дүн 53 хувьтай гарсан байна.	100
		326	4.1.7.4. Аймаг, сумын хэмжээнд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх хэрэглэгчийн үнэлгээг цахим хэлбэрээр авах, хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнг иргэд олон нийтэд хүргэх арга зүйг сайжруулах	2016-2020	АЗДТГ, Төрийн байгууллагууд	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, төлөвлөсөн бодлогын хэрэгжилт сайжирна.	Сумдын ЗДТГ-ууд болон агентлаг, байгууллагууд өөрсдийн цахим хуудсандаа үйл ажиллагааныхаа талаар иргэдийн саналыг авах, үр дүнг цаашдын төлөвлөлтөд тусгах ажлыг хийж байна.	70

		327	4.1.7.5. Хэрэглэгчийн үнэлгээг судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажилладаг мэргэжлийн болон төрийн бус байгууллагаас ажлын туршлага, хүний нөөцийн хүчин чадал зэргийг харгалзан сонгон шалгаруулж хийлгэх	2016-2020	АЗДТГ, Төрийн байгууллагууд		Төрийн бодлого олон нийтэд нээлттэй болж, төрийн бодлогод олон нийтийн гүйцэтгэх үүрэг, оролцоо сайжирна.	2017, 2018 онд Хэрэглэгчийн үнэлгээний судалгааг аймгийн Залуучуудын холбооны дэргэдэх "Булган Манлайлал Шийдэл" ТББ шалгаран гүйцэтгэсэн бөгөөд 2019 оны аймгийн Хэрэглэгчийн үнэлгээний судалгааг ЗГХЭГ-аас авахаар болоод байна.	100
		328	4.1.8.1. ОХУ-ын Буриад улсын Улаан-Үд хот, Закамень аймагтай боловсрол, эрүүл мэнд, спорт, хөдөө аж ахуй, байгаль орчин, нийгмийн аюулгүй байдлын чиглэлээр хамтран ажиллах	2016-2020	АЗДТГ, БСУГ, ЭМГ, ХХААГ		Эдийн засгийн үр ашигтай гадаад харилцааг хөгжүүлнэ.	ОХУ-ын Буриад Улсын Закамень аймагтай уламжлалт харилцаагаа боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй зэрэг чиглэлээр хөгжүүлсээр байна. 2016 онд Закамень аймгийн төлөөлөгчдийг Булган аймагт хүлээн авч, ажил хэргийн уулзалт зохион байгуулан өмнөх жилүүдэд байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг дүгнэн, цаашид хөдөө аж ахуй, нийгэм, соёлын салбарт хамтын ажиллагааг эрчимжүүлэх талаар санал солилцож, шинээр байгуулах гэрээний төсөлд санал хүргүүлсэн. Булган аймгийн төлөөлөгчид Закамень районы 90 жилийн ойн баярын арга хэмжээ болон Сур харбан наадамд жил бүр оролцож байгаа бол Закамень аймгийн төлөөлөгчид аймгийн баяр наадамд жил бүр ирж байна. Мөн Булган аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн баярын арга хэмжээнд Буриад улсын Засгийн газрын ХАА-н сайдаар ахлуулсан төлөөлөгчид оролцлоо. ОХУ-ын Буриад улсын Улаан-Үүд хотын багшийн коллежид дуу хөгжмийн багш болон биеийн тамирын багш мэргэжлээр 4 дэх жилдээ оюутан сургаж байгаа бөгөөд тус сургуулийг төгсөгчдөөс 6 хүүхэд сургууль, соёлын байгууллагад ажиллаж байна. Закамень аймгийн Боловсролын хэлтэс Булган аймгийн БСУГ хамтран Закамень аймагт ажиллаж байсан монгол хэл бичиг, дуу хөгжмийн багш нарын тухай ном хэвлүүлсэн. Улаан-Үүд хотод зохион байгуулагддаг Монгол хэл бичгийн багш нарын ур чадварын уралдаанд манай аймгийн 4 багш 2 удаа оролцож 1 багш нэгдүгээр, 1 багш 3-р байр эзэлж 2 багш тусгай байранд шалгарсан. Аймгийн Хөгжимт жүжгийн театр, Номын сан, Булган сумын Соёлын ордны ажилтнуудыг 2018 онд, сумдын соёлын төвийн ажилтнуудыг 2019 оны 09-р сард ОХУ-ын Буриад улсын Улаан-Үдэ хотын дуурийн театр, номын сан, соёлын сургуулиудад туршлага судлууллаа. "Ялалтын баяр"-т зориулсан "День победы" тоглолтыг ОХУ-ын Буриад улсын Улаан-Үүд хот, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул аймгаар аялан тоглож олны хүртээл болгосон ба ОХУ-ын Буриад улсын Улаан-Үдэ хотын соёлын сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд тус сургуульд сурч буй оюутан, багш нарын хамтарсан "Трубадор ба түүний нөхөд" дуулалт жүжгийг орос хэл дээр тавьж үзэгчдийн хүртээл болгосон. Буриад улсын Соёлын сайд, Засгийн газартай тохиролцсоны дагуу Тэшиг суманд 2019 оны 7 дугаар сарын 2-3-нд "Бага Алтаргана" болон "Эв мод"-ны наадмыг зохион байгуулж, ОХУ-ын Буриад улс, Улаанбаатар хот, Булган, Хөвсгөл, Дорнод, Хэнтий аймгийн буриад ястан 700 гаруй хүн оролцлоо. Аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг 2019 оны 3 сард Улаан-Үүд хотод ажлын айлчлал хийж Буриад Улсын Засгийн газрын орлогч, ХАА, БШУ, Соёлын сайд нартай ажил хэргийн уулзалт хийснээс гадна газар тариалангийн 2 компани, нэг жижиг үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцлаа. Жимс жимсгэний хүрээлэнтэй суулгац үржүүлэх талаар хамтран ажиллаж, тус аймгийн ХАА-н Агропаркид 8 нэр төрлийн жимс, жимсгэний суулгац үржүүлж байна.	100

329	4.1.8.2. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Улаанхад хоттой Хөдөө аж ахуй, байгаль орчны салбарт хамтран ажиллах	2016-2020	АЗДТГ, ХХААГ		Хамтын ажиллагаа хөгжсөн байна.	<p>2016 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хоттой хамтран ажиллах бодлогын хүрээнд ӨМӨЗО-ны улс төрийн зөвлөлдөх бага хурал, Хонконг, Макао, Тайваний хоорондын болон гадаад хэргийн холбооны дарга Ю ДАЛАЙ / WU, DALAI/ тэргүүтэй албаны хүмүүс, хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдийн төлөөлөл Булган аймагт айлчилсан. Хоёр талын зүгээс мал аж ахуй, газар тариалан, боловсрол, соёл, ноос ноолуур, үйлдвэрлэл, аялал жуулчлал, бүтээн байгуулалтын чиглэлээр хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийллээ. 2017 онд аймгийн Засаг дарга Монгол улсын Засгийн Газрын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй хамт БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хот, Бугат хотод албан хэргээр айлчиллаа. Айлчлалын үеэр Бугат хотын удирдлагатай уулзаж, хамтын ажиллагааны талаар санал солилцсон. Мөн аймгийн Засаг дарга ӨМӨЗО-ны Бугат хотын “Гу Шун Юань Хүнс” ХХК-ийн ТУЗ-ын дарга Лю Юү Лонг тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзалт хийн дулааны аргаар мах боловсруулах үйлдвэр байгуулах гэрээний санамж бичигт гарын үсэг зурлаа. Аймгийн Засаг даргын Тамгын газар болон ӨМӨЗО-ны Бугат хоттой байгуулсан гэрээний хүрээнд Өвөр Монголын Олон Улсын Эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нар Булган аймагт ажиллаж, мэдрэл, нүд, хавдар, хүүхэд зэрэг 10 чиглэлээр үнэ төлбөргүй үзлэг оношилгоо хийж, тан барьсан байна. 2018 онд ӨМӨЗО-ны Засгийн газар болон Монгол улсын Засгийн газрын хамтарсан “Хэт талхлагдсан бэлчээрийг зайнаас тандан судлах ба нөхөн сэргээлт хийх туршилт” төслийн хүрээнд Булган аймгийн төрийн албан хаагчид, мал зүйч, малчдын төлөөллөөс бүрдсэн төлөөлөгчид ӨМӨЗО-ны Хөх хотод айлчилж, уг төслийн хөрөнгө оруулалтаар Булган аймгийн Гурванбулаг суманд бэлчээрийн менежментийн суурин судалгааны байрыг байгуулахад дэмжлэг үзүүлж туршилтын талбайг сонгож, хашаажуулан, цаг уурын тоног төхөөрөмжөөр хангаад байна. 2019 онд БНХАУ-ын Ляонин мужтай хамтын ажиллагаа тогтоож худалдаа, эдийн засаг, аж үйлдвэр, хөдөө аж ахуй зэрэг салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах саналыг хүргүүлжээ. “Монгол-Хятадын Эсспо” гурав дахь удаагийн арга хэмжээ ӨМӨЗО-ны Хөх Хот, Улаанцав, Тунглио хотод зохион байгуулагдаж Монгол улсын шадар сайд Ө.Энхтүвшингийн ахалсан төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд манай аймгийн төлөөлөгчид оролцоод ирлээ.</p>	100
330	4.1.8.3. БНСУ-ын Дэгү хотын Дунгу дүүрэгтэй боловсрол, эрүүл мэнд, спорт, хөдөө аж ахуй, байгаль орчны чиглэлээр хамтран ажиллах	2016-2020	АЗДТГ, БСУГ, ЭМГ, ХХААГ		Хамтын ажиллагаа хөгжсөн байна.	<p>БНСУ-ын Дэгү хотын Дунгу дүүрэгтэй тогтоосон хуучин харилцааг сэргээхээр судалж байна. Тус улсын Жоннам мужийн захиргааны байгууллагын төлөөллүүд 2018 оны 8 дугаар сард Булган аймагт ажиллаж малын чанар, үүлдэр угсааг сайжруулах, малын эрүүл мэндийг хамгаалах, эрчимжсэн аж ахуй, туслах аж ахуй эрхлэлтийг нэмэгдүүлэх, бэлчээрийн талхлалтыг сааруулах талаар харилцан санал солилцлоо. Мөн Жоннам мужийн удирдлагад боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын чиглэлээр харилцаа тогтоохоор санал хүргүүлсэн.</p> <p>2019 онд аймгийн удирдлагууд БНСУ-ын Байгаль хамгаалах нэгдсэн холбооны Жэжү дэх салбарын захирал Ли Жэ Хёон тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Тус уулзалтаар талуудын цаашдын харилцаа, байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах чиглэлээр хийгдэх хамтын ажиллагааны талаар харилцан санал солилцлоо. БНСУ-ын Жоннам мужид зохион байгуулагдсан Хөдөө аж ахуй, газар тариалангийн экспод аймгийн төлөөлөгчид орролцоноос гадна газар тариалангийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгч, бизнесменүүдийг холбох, 2 аймгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх санамж бичиг үйлдэхээр тохиролцож энэхүү арга хэмжээнд Койка олон улсын байгууллагыг татан оролцуулах, хүлэмжийн аж ахуй эрхлэлтийг хөгжүүлэх, тариалангийн талбайн соёл нэвтрүүлэх /суралцах/ чиглэлээр ярилцав. Тус мужтай хамтын ажиллагааны хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлгийн дүрс оношилгооны эмч БНСУ-д судалгаа эрдэм шинжилгээний олон улсын бага хуралд оролцлоо. Монгол улсын Засгийн газар БНСУ-ын КОИСО олон улсын байгууллага хооронд байгуулсан "Гадаадад сайн дурын ажилтан томилох" хөтөлбөрт хамрагдах хүсэлтээ илэрхийлж, Булган аймагт 12 сайн дурын гишүүн ажиллуулах хүсэлтийг Сангийн ямаар дамжуулан хүргүүлээд байна.</p>	100

64 4.1.8. Гадаад харилцааг өргөжүүлж шинэ шатанд гарган, бизнес эрхлэгчдийг холбож өгнө.

331	4.1.8.4. Турк улстай эдийн засаг, нийгэм, хөдөө аж ахуй, байгаль орчны салбарын чиглэлээр хамтран ажиллах	2016-2020	АЗДТГ, БСУГ, ЭМГ, ХХААГ	Хамтын ажиллагаа хөгжсөн байна.	2018 онд Монгол улсаас БНТУ-д суугаа Ерөнхий консул Э.Мөнх-Очирын урилгаар аймгийн Засаг дарга З.Батзориг тэргүүтэй төлөөлөгчид Турк улсад ажлын айлчлал хийлээ. Тус айлчлалаар мах, сүүний чиглэлийн үхрийн ферм, мал нядалгаа, боловсруулах үйлдвэр, үхэр үржүүлэх, зохиомол хээлтүүлэг хийх, малын вакцин, эм үйлдвэрлэлийн компани зэрэг хөдөө аж ахуйн чиглэлийн үйлдвэрлэгч, хөрөнгө оруулагчидтай уулзалт хийж, туршлага судалсан. Айлчлалын үр дүнд аймагт мах боловсруулах үйлдвэр, сүү боловсруулах үйлдвэр байгуулах зэрэг ажлын эхлэл тавигдсан. Турк улстай ХАА-н чиглэлээр хамтран ажиллах хүрээнд "ТИКА" байгууллагын тусламжаар тус аймгийн 14 суманд 325 тн буюу 13000 шуудай 136.5 сая төгрөгийн тэжээлийг малчдад үнэгүй олгож хаваржилтыг даван туулсан. Мөн Хангал сумын "Эко хан буян" хоршоонд даршны ургамлын хөнгөлөлттэй үр олгож тариалалт хийсэн. Туркийн олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай /ТИКА/ хамтран ажиллаж, Булган сумын 6-р цэцэрлэгийн барилгад 76.0 сая төгрөгийн их завсар, соёлын чиглэлээр Монгол улсын БСШУ-ны яамтай хамтран хэрэгжүүлж буй "Улаан хэрмийн шороон бумбагар Түрэгийн үеийн бунхант булшийг сэргээн засварлах, авран хамгаалах төсөл"-ийг Баяннуур сумын нутагт хэрэгжүүлж эхэлсэн. 2019 онд Баяннуур сумын Эрүүл мэндийн төвд их засвар хийх талаар хүсэлтийг ТИКА олон улсын байгууллагад хүргүүлээ.	100
332	4.1.8.5. Гадаад харилцааг өргөжүүлэх чиглэлээр Зүүн хойд Азийн бүс нутгийн засаг захиргааны холбоотой хамтран ажиллах	2016-2020	АЗДТГ	Хамтын ажиллагаа хөгжсөн байна.	Зүүн хойд Азийн бүс нутгийн засаг захиргааны холбоотой нягт хамтран ажиллаж байна. 2018 онд Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулагдсан "Гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал 2018"-д аймгийн ЗДТГ-аас 1 төлөөлөгч, "Залуу удирдагч-форум"-д Булган аймгаас 1 оюутан, 1 залуу бизнес эрхлэгч, 9 дүгээр сард БНХАУ-д зохион байгуулагдсан "Боловсон хүчний хорооны хурал"-д аймгийн ЗДТГ-аас 2 төлөөлөгч тус тус оролцлоо. 2019 онд БНСУ-ын Гёнсанбүг мужийн Гёнжү хотод NEAR-ын гишүүн орнуудын "Гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал 2019"-д аймгийн ИТХ-аас 1, ЗДТГ-аас 1 төлөөлөгч, "Зүүн хойд Азийн Залуу удирдагч форум-2019"-д Булган аймгийн шилдэг оюутан, залуусын төлөөлөл болох тус бүр 1 хүн оролцлоо. Зүүн хойд Азийн бүс нутгийн засаг захиргааны холбооны хэрэг эрхлэх газраас "2020 онд гишүүн орон нутгуудад зохиогдох олон улсын арга хэмжээний төлөвлөгөөг батлах" хүрээнд Булган аймагт 2020 онд зохион байгуулагдах олон улсын арга хэмжээний төлөвлөгөөг хүргүүлээ.	100
333	4.1.8.6. ОХУ-ын Красноярск мужтай эдийн засаг, нийгэм, хөдөө аж ахуй, байгаль орчны салбарын чиглэлээр хамтарч ажиллах	2016-2020	АЗДТГ, БСУГ, ЭМГ, ХХААГ	Эдийн засгийн үр ашигтай гадаад харилцааг хөгжүүлнэ.	2016 онд Монгол улсаас ОХУ-ын Красноярск мужид суух өргөмжит консул Е.А.Кузьмин, "Нано болон шинэ технологи нэвтрүүлэх ОХУ-ын Красноярск дахь Зүүн сибирийн төв" ХХК-ийн ерөнхий захирал И.А.Гайдук, Красноярскийн ХААИС-ийн Менежментийн сургуулийн захирал Н.В.Антонова нар манай аймагт ажиллаж Булган аймагт цаг агаарын ширүүн уур амьсгалд тэсвэртэй, өндөр үржил шим бүхий үр тариаг нутагшуулахаар эрдэм шинжилгээний ажлыг эхлүүлэх санамж бичиг байгууллаа. Энэхүү ажлын хүрээнд ОХУ-ын Красноярск мужийн Хөдөө аж ахуйн их сургууль, "Нано болон шинэ технологи нэвтрүүлэх ОХУ-ын Красноярск дахь Зүүн сибирийн төв" ХХК-тай хамтран Булган аймагт өндөр үржил шим бүхий үр тариаг нутагшуулахаар эрдэм шинжилгээний ажлыг явуулж, Сэлэнгэ, Орхон, Тэшиг сумын газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг 3 аж ахуйн нэгжтэй хамтран өндөр үржил шим бүхий буудайн туршилтын тариалалт хийж эхний ээлжийн ургацаа хураан авсан. 2019 онд Аймгийн Засаг дарга, ХХААГ, 11 сумын Засаг дарга нар Красноярск хотод зохион байгуулагдсан Олон улсын Эдийн засгийн форумд оролцож, Красноярскийн хязгаарын Засгийн газартай эрүүл мэнд, хөдөө аж ахуй, боловсролын чиглэлээр хамтран ажиллах саналыг хүргүүлээд байна.	100

334	4.1.8.7. Европын өндөр хөгжилтэй Холбооны бүгд найрамдах Герман, Бүгд найрамдах Австри улсуудтай эдийн засаг, нийгэм, байгаль орчны салбарт хамтран ажиллах, нөхцөлийг судлах	2016-2020	АЗДТГ, ХХААГ		Эдийн засаг, Нийгмийн салбарын хамтын ажиллагаанд ахиц гарсан байна.	2016 онд Бүгд найрамдах Чех улсаас Монгол улсад суугаа Бүрэн эрхт элчин сайдын Худалдааны зөвлөх ноён Ладислав Хораак, Чехийн Эдийн засгийн танхимын Чех-Монголын зөвлөлийн дарга Д.Жаргалсайхан нарыг аймгийн Засаг дарга хүлээн авч уулзаж, Чех улсын талаас хөдөө аж ахуй, мал аж ахуй болон аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах, хөдөө аж ахуй, байгаль орчны салбарын төслүүдэд зуучилж хөрөнгө оруулалтыг хийх боломжийг судлан хэрэгжүүлэх талаар санал солилцлоо. 2018 онд Аймгийн Засаг дарга тэргүүтэй төлөөлөгчид Бүгд Найрамдах Польш Улсад айлчилж, мах, махан бүтээгдэхүүн, даршилсон ногоо, жимс жимсгэнэ, механикжсан зoorь үйлдвэрлэгч, хөрөнгө оруулагчидтай уулзалт хийн, туршлага судалж, Булган суманд Польшийн хөрөнгө оруулалтаар махны үйлдвэр барих, махны нөөц хамтран бэлтгэхээр харилцан тохиролцов. 2019 онд Аймгийн Засаг дарга З.Батзоригийн тавьсан хүсэлтийн дагуу Холбооны бүгд найрамдах Герман Улсын олон улсын хамтын ажиллагааны /GIZ/ нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөртэй манай аймаг хамтын ажиллагаа эхлүүлээ. Тус хөтөлбөрийн удирдагч Карин Райнпрехтэй уулзалт хийж хамтын ажиллагааны хөтөлбөрийн 9 дэх аймаг болон Тогтвортой хөгжил-Түншлэлийн зөвлөлийг байгуулж иргэдэд танилцууллаа. Энэхүү хөтөлбөр нь 1 аймагт жилд дунджаар 140 мянган еврог /420 сая төгрөг/ жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зориулж буцалтгүй хэлбэрээр санхүүжүүлдэг онцлогтой юм.	70
335	4.1.8.8. Азийн өндөр хөгжилтэй Япон улстай хөдөө аж ахуй, эрүүл мэнд, боловсрол, байгаль орчны салбарын чиглэлээр хамтарч ажиллах	2016-2020	АЗДТГ, БСУГ, ЭМГ, ХХААГ		Эдийн засаг, Нийгмийн салбарын хамтын ажиллагаанд ахиц гарсан байна.	2016 онд Япон улсын ОИСКА байгууллага Монгол улстай хамтран ажилласны 10 жилийн ойг Сэлэнгэ суманд зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр Сэлэнгэ суманд ОИСКА байгууллагаас түргэн тусламжийн автомашин, гал унтраах бүрэн тоноглогдсон автомашиныг гардуулсан бол 2017 онд Зүүн хойд Азийн бүс нутгийн засаг захиргааны холбоотой хамтран ажиллах ажлын хүрээнд тус холбооны Япон улс дахь Гамшгаас сэргийлэх хорооны 15 дугаар хуралд аймгийн Засаг дарга, Онцгой байдлын газрын даргын хамт оролцож, орон нутгийн гамшгийн сургалтад хамрагдлаа. Япон улстай хөдөө аж ахуй, эрүүл мэнд, боловсрол, байгаль орчны салбарын чиглэлээр хамтран ажиллах ажлын хүрээнд Япон улсын Ибараки мужийн Морияа хотод аймгийн ЗДТГ болон бусад холбогдох байгууллагын төлөөлөл нийт 18 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллаж, хөдөө аж ахуй, нийгмийн салбарт туршлага судаллаа. Япон улсын ОИСКА Олон улсын байгууллагатай хамтран Булган, Бугат, Хангал, Сайхан, Сэлэнгэ сум, Хялганат тосгонд “Хүүхдийн ойжуулах” хөтөлбөрийг хэрэгжүүлэн 5000 орчим мод тарьж ургуулаад байна. Сэлэнгэ суманд Хитачи группын санхүүжилтээр хүүхдийн экологийн боловсролыг нэмэгдүүлэх зорилготой “Хитачи” төслийг ЕБС-ийн дэргэд хэрэгжүүлж байна. Баян-Агт сумын 1 эмчийг Япон улсын Токио хотод нярайн асаргаа чиглэлээр сургалтад хамрууллаа. 2018 онд "Аймгийн зөгий үржүүлэгчдийн холбоо" Япон улсад туршлага судлан зөгийн балаа нийлүүлэх гэрээ хэлэлцээр байгуулж, “Осака тоёото” компанийн хөрөнгөөр 2 жилийн хугацаатай төсөл хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн Хялганат тосгонд чацаргана хуурайшуулах тоног төхөөрөмжийг нийлүүлж, бүтээгдэхүүний дээжийг Япон улсад шинжилгээнд хүргүүлээд байна. Япон улсын “Халуун сэтгэл” ТББ-аас сумын ЭМТ-үүдэд "E70 тариурын зүү устгагч аппарат", хүүхдийн жин хэмжигчийг хандивлалаа. Япон улсын Азийн эмч нарын холбоо “AMDA”, Монголын нүдний эмч нарын холбоотой хамтран хүүхдийн харааны гажиг заслын үзлэг оношилгоог Булган суманд зохион байгуулж, 212 хүүхдэд үзлэг оношилгоо хийлээ. 2019 онд Аймгийн Засаг даргын урилгаар Япон улсаас Монгол улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд М.Такоака манай аймагт айлчиллаа. Тус айлчлалаар "Өвсний үндэс-Хүнсний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөр"-ийн хүрээнд "Эрдмийн өргөө" цогцолбор сургуулийн гадна засварын ажлыг санхүүжүүлэх 231.2 сая төгрөгийн гэрээнд гарын үсэг зурлаа.	100

	336	4.1.8.9. АНУ-тай боловсрол, эрүүл мэнд, байгаль орчны салбарын чиглэлээр хамтарч ажиллах	2016-2020	АЗДТГ, БСУГ, ЭМГ	Эдийн засаг, Нийгмийн салбарын хамтын ажиллагаанд ахиц гарсан байна.	<p>2017 онд АНУ-тай боловсрол, эрүүл мэнд, байгаль орчны салбарын чиглэлээр хамтарч ажиллах тухай хүсэлтийг АНУ-ын Элчид сайдын яаманд хүргүүлж түүний зөвлөмжийн дагуу АНУ-ын "Эгч дүү" хотуудын олон улсын байгууллагад аймгийн мэдээллийг хүргүүлэн цахим мэдээллийн санд нь байршууллаа.</p> <p>2017-2019 онд АНУ-ын Юта мужтай тогтоосон хуучин харилцааг сэргээх, "Монтана" их сургуулийн багш нартай хамтран төр, эдийн засаг, нийгмийн салбарт хамтран ажиллах чиглэлээр аймгийн ЗДТГ болон ИТХ-ын төлөөлөгчид АНУ-д 3 удаа айлчилсан. Булган аймагт АНУ-ын ЭСЯ-ны Иргэн-Цэргийн харилцааг дэмжих нэгжийн төлөөлөгчид болон Сиэтл хотын "Кинг Каунти" нийтийн аж ахуйн байгууллагын төлөөлөгчид айлчилж аймгийн удирдлага, ОБГ, БСУГ, ЭМГ, Нийтийн аж ахуйн байгууллагын төлөөлөлтэй уулзаж хамран ажиллах талаар санал солилцлоо.</p> <p>2019 онд АНУ-д хөтөлбөрт арга хэмжээний хүрээнд "Анхан шатны тусламж үйлчилгээг сайжруулах" чиглэлээр туршлага судлах сургалтаар 2 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж энэхүү хөтөлбөрийг давтан хэрэгжүүлснээр орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагын инженер, техникийн ажилтнуудыг сургах, орон нутгийн иргэдэд сургалт семинар зохион байгуулах зэрэг өргөн хүрээтэй ажлын эхлэл тавигдаад байна.</p>	70
--	-----	--	-----------	------------------	--	---	----

ТАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, БАТЛАН ХАМГААЛАХ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, нийтийн албаны ёс зүйг өндөржүүлэн, олон нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх замаар төрийн албаны сахилга хариуцлагыг дээшлүүлнэ. Хууль хяналтын болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлж, иргэний аюулгүй АМЬДРАХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ зорилгоор эрсдэлд суурилсан удирдлага, шуурхай бэлэн байдлыг хангана.

	337	5.1.1.1. Сум, байгууллагуудад төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтнийг эрх зүйн ажилтнаар, багийн иргэдийн нийтийн хурлын дарга нарыг "Эрх зүйн хөтөч"-өөр бэлтгэх	2016-2020	ХЭЗХ	Иргэнд хууль зүйн тусалцааны үйлчилгээ ойртоно.	<p>Аймгийн Засаг даргын 2017 оны А/266 дугаар захирамжаар байгуулагдсан эрх зүйн багийн гишүүд 16 сум, 1 тосгоны иргэн, төрийн алба хаагчдыг хамруулан "Иргэдэд ойр эрх зүйн үйлчилгээ" хууль сурталчлах ажлыг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Шүүх, Прокурор, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Татварын хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Онцгой байдлын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Стандартчилал хэмжил зүйн газар, Биеийн тамир, спортын газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Цэргийн штаб, Шүүх шинжилгээний алба, Насан туршийн боловсролын төв, Хууль зүйн тусалцааны төв, Иргэний зөвлөл зэрэг 16 байгууллага хамтран ажиллаж эрх зүйн багийн болон байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг танилцуулж, иргэдийн сонирхсон асуултад хариулж, зөвлөгөө өгч, гарын авлага материал тараалаа. "Иргэдэд ойр эрх зүйн үйлчилгээ" сэдэвт өдөрлөгийн эрх зүйн үйлчилгээнд 892 иргэн, төрийн албан хаагч хамрагдаж, 8000 ширхэг гарын авлага, материалыг хүргэсэн байна. Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс ирүүлсэн иргэдийн эрх зүйн боловсролд зориулан гаргасан богино хэмжээний кино, шторжийг 24 удаагийн давтамжтайгаар орон нутгийн телевиз, лед дэлгэцээр дамжуулан олон нийтэд хүргэсэн.</p> <p>Аймгийн Насан туршийн боловсролын төвтэй хамтран аймгийн хэмжээнд "Эрх зүйн хөтөч" бэлтгэх сургалтыг 2 удаа, Хууль, зүйн үндэсний хүрээлэнтэй хамтарч эрх зүйн хөтөч нарыг чадавхжуулах зорилгоор 2 өдрийн гэрчилгээтэй сургалтыг 1 удаа зохион байгуулсан. Тус сургалтад аймгийн хэмжээнд агентлагийн мэргэжилтнүүдээс бүрдсэн "Эрх зүйн баг"-аас гадна 16 сум, 1 тосгоны ИТХ-ын дарга, түүний ажилтан, төрийн захиргааны мэргэжилтэн, насан туршийн боловсролын багш, нийгмийн ажилтан зэрэг 100 "Эрх зүйн хөтөч" хамрагдсан. 2019 оны 11 сарын байдлаар аймгийн хэмжээнд 100 эрх зүйн хөтөч ажиллаж байна.</p>	100
	338	5.1.1.2. Тусгайлан бэлтгэсэн гарын авлага, сэдвийн дагуу сум, баг, байгууллагад эрх зүйн зайны сургалтыг зохион байгуулах	2016-2020	Сумын ЗДТГ, ХЭЗХ	Нэгэн зэрэг олон оролцогчтой сургалтыг зохион байгуулдаг болно.	<p>"Эрх зүйн хөтөч"-өөр бэлтгэгдсэн сумын ИТХ-ын ажлын албаны ажилтан, багийн ИНХ-ын дарга, Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтэн, насан туршийн боловсролын төвийн багш, нийгмийн ажилтнуудаар дамжуулан тусгайлан бэлтгэсэн гарын авлага, шторк, богино хэмжээний киног сургалтад ашиглуулахаар хүргүүлж, үр дүнг улирал бүр тооцон ажилласан.</p>	70

65	5.1.1 “Бүх нийтийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлж, сум байгууллагад эрх зүйч мэргэжилтэн, иргэний эрх зүйн хөтөч бэлтгэн, хууль зүйн туслалцааг иргэд, байгууллагад үзүүлэх	339	5.1.1.3. Сонин, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинг ашиглан хууль сурталчлах	2016-2020	ХЭЗХ	Эрх зүйн мэдээлэл иргэдэд ойр болно.	Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс ирүүлсэн иргэдийн эрх зүйн боловсролд зориулан гаргасан богино хэмжээний кино, шторкийг 24 удаагийн давтамжтайгаар орон нутгийн телевиз, Булган сумын төвд байрлах лед дэлгэцээр дамжуулан олон нийтэд хүргэсэн. 2017-2019 онд Булган аймгийн ЗДТГ-ын bulgan.gov.mn, Цагдаагийн газрын bulgan.police.gov.mn цахим хуудас, Булган аймгийн Засаг даргын Тамгын газар, Булган аймгийн Цагдаагийн газар нүүр хуудсанд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд эрх зүйн боловсрол олгох цахим мэдээ, мэдээлэл, ажил арга хэмжээ, үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол байршуулан, үүрэн холбооны цахим сүлжээ болох “SMS” үйлчилгээг ашиглан Цагдаагийн газрын үйл ажиллагаатай холбоотой сэрэмжлүүлэг, зарлалын шинжтэй мэдээ, мэдээллийг тогтмол захидал хэлбэрээр аймгийн удирдлага, агентлаг, байгууллагын дарга, төрийн албан хаагч, малчдад хүргэж байна. Мөн “Сайхан Монгол” телевизтэй аймгийн ЗДТГ 2018 оноос, Булганы мэдээ сонин, Гэр бүлийн FM 106.5 радиотай аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс 2016 оноос хойш жил бүр гэрээ байгуулан, хууль сурталчлах ажлыг тогтмол хийж байна. Мөн www.e-khutuch.mn цахим хуудсаар дамжуулан шинээр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг сурталчилж байна.	100
		340	5.1.1.4. “Хэрэглэгчийн боловсрол” төвийн үйл ажиллагааг хэрэглэгчийн шийдвэрлэх дэмжин, гомдлыг	2016-2020	ХЭЗХ, ТББ	Хэрэглэгчийн боловсрол дээшилсэн байна.	“Хэрэглэгчийн боловсрол” төв Стандарт, хэмжил зүйн хэлтэст байрлан ажилладаг бөгөөд аймгийн хэмжээнд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Үндэсний хөтөлбөр”, төрийн болон төрийн бус байгууллагуудын идэвхтэй хамтын ажиллагааг сайжруулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр ажиллаж байна. 2016 оноос эхлэн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын орон нутаг дахь орон тооны бус улсын ахлах байцаагч 1, улсын байцаагч 2 томилогдон ажиллаж байна. 2018 онд “Хүүхэд хэрэглэгч”, 2019 онд “Ахмад настан-хэрэглэгч” өдрийг Булган аймагт тэмдэглэн өнгөрүүлэх удирдамжийг батлуулж, хэрэгжүүллээ. Мөн “Та хүүхэддээ заавал хэлж өгөөрэй” сэдэвт мэдээллийг аймгийн удирдах ажилтнууд болон ЕБС-ийн багш нарт хийж, 200 ширхэг зөвлөмж тараасан. “Сайхан Монгол” орон нутгийн телевизтэй хамтран бэлтгэсэн зөвлөмж, танин мэдэхүйн хүрээнд “АХА” нэвтрүүлгийг ЕБС-ийн 9-12 дугаар ангийн 50 сурагчдыг хамруулан амжилттай зохион байгуулж тэргүүн, дэд байранд шалгарсан сурагчдыг дурсгалын зүйлээр шагнаж, урамшууллаа. Булган сумын худалдаа, нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгч 40 аж ахуйн нэгж, иргэнд шинэчлэгдсэн стандартууд, үйлчилгээний байгууллагын соёл, харилцаа хандлага, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль, Ахмад настны тухай хуулиар сургалт хийж нийгмийн хариуцлагаараа ахмад настнуудад үйлчилгээг очер дугааргүй шуурхай хүргэхээс гадна хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх талаар ярьж зөвлөлөө. Шударга Өрсөлдөн Хэрэглэгчийн Төлөө газраас зарласан “ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭ БА ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ-2019” жилийн ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг хангаж “Аялах дэвтэр”-ийг 16 сум, 1 тосгон, аймгийн төвийн 39 байгууллагад аялуулах ажлыг жилийн турш зохион байгуулж байна.	100

341	5.1.1.5. Хуульчийн мэргэжлийн холбоо, өмгөөлөгчдийн зөвлөлтэй хамтран, иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй тусалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах	2016-2020	Сумын ЗДТГ ХЭЗХ		Иргэд хууль зүйн тусалцаа авах боломж бүрдэнэ.	Аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс жил бүр Хуульчийн мэргэжлийн холбоотой хамтран 16 сум, 1 тосгоны иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулан ажилладаг бөгөөд Нутгийн удирдлагын ордонд байрлах Хууль зүйн тусалцааны төвөөр дамжуулан иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх, төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тус төвөөс жилд дунджаар 250-350 иргэн хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө мэдээлэл авч, 80-120 төлбөрийн чадваргүй иргэн өмгөөллийн үйлчилгээ авч байна. Мөн Монголын хуульчдын холбооны 2019 оны 2/363 дугаартай албан бичгийн дагуу нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан хууль зүйн тусалцаа, иргэний эрх зүйн боловсролыг дэмжих үйл ажиллагааг сурталчлах зорилгоор 2019 оны 05 дугаар сард “Хуульчийн нийгмийн хариуцлага-Про Боно” арга хэмжээг Булган аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллалаа. Тус өдөрлөгт аймгийн Шүүх, Прокурор, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Шүүх шинжилгээний алба, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Хуульчдын холбоо, Нотариатчдын холбоо, Хууль зүйн тусалцааны төв зэрэг байгууллага оролцож 674 иргэнд эрх зүйн үйлчилгээг үзүүлээ.	100
342	5.1.1.6. Хүний эрхийн боловсрол олгох сургалт, судалгаа, мэдээллийн арга хэмжээг төрийн болон ТББ-тай хамтран зохион байгуулах		ХЭЗХ		Хүний эрхийн мэдлэг хандлага нэмэгдэнэ.	Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан “Эрх зүйн баг” жил бүр хүний эрхийн боловсрол олгох сургалтыг сумдад зохион байгуулахаас гадна 2017 оноос Монголын хуульчдын холбоо, Хуульч эмэгтэйчүүдийн холбооны Булган аймаг дахь салбар, Булганы өнгө, Гэрэлт-Ирээдүй оршихуй, Ухаарлын жимээр зэрэг ТББ-тай хамтран ажиллаж байна. “Гэрэлт- Ирээдүй оршихуй” төрийн бус байгууллагатай хамтран нийгмийн салбаруудад хүний эрх хэрхэн зөрчигдөж байгаа талаар иргэд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдаас 3 асуулга бүхий судалгааг авахад ажлын байран дахь бэлгийн дарамт хүйс давамгайлсан байгууллагад 20 хувь, гэр бүлийн орчинд үл хайхрах, бие махбодийн хүчирхийлэл 60 хувь, сургууль орчин дахь үе тэнгийн дарамт 40 хувь байгаа талаар санал асуулгад оролцогчид хариулсан байна. Дээрх судалгаанд тулгуурлан аймгийн эрх зүйн баг эрх зүйн чиглэлээр төрийн алба хаагч, иргэдэд сурталчлах, зөвлөгөө өгөх зорилгоор 16 сум, 1 тосгоны 892 төрийн алба хаагч, иргэнд “Иргэдэд ойр эрх зүйн үйлчилгээ” нээлттэй өдөрлөгийг зохион байгуулсан.	100
343	5.1.2.1. Сум, байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлтүүдийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх	2016-2020	ХЭЗХ		ТБ-ын шударга байдлын үнэлгээ өссөн байна.	Төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах замаар авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн байгууллагын оролцоог дэмжин ажиллаж байна. Сум, байгууллагууд жил бүр авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, Авлигатай тэмцэх газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт зэргийг гаргаж аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэст ирүүлж хэвшсэн. Түүнчлэн Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг 2017, 2018, 2019 онуудад ирж ажиллан, сум байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, түүний хэрэгжилтийг шалган, заавар зөвлөгөө өгч ажиллалаа.	100
344	5.1.2.2. Сум, байгууллагын шударга түвшний үнэлгээ олон нийтийн оролцоотой хийх	2016-2020	ХЭЗХ		Хөндлөнгийн үнэлгээ хийгдэж хэвшинэ.	Сум, байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гаргуулах, хэрэгжилтийг тооцохоор аймгийн ЗДТГ-аас үнэлгээ хийж, байр эзлүүлдэг байсныг өөрчлөх зорилгоор 2018, 2019 онд “Булганы өнгө” ТББ-тай гэрээ байгуулан “Төрийн байгууллага дахь авлигын эрсдлийн үнэлгээ, ил тод байдал, хууль сурталчлах ажилд хяналт, үнэлгээ”-г хийлгэлээ.	100

5.1.2 Байгууллагын

66	5.1.2. Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулж хяналт тавих, байгууллагын шударга түвшний үнэлгээг нэмэгдүүлэх	345	5.1.2.3. Олон нийтэд авлига, ашиг сонирхлын зөрчил болон авлигын шалтгаан нөхцөлд хийсэн судалгааны дүнд үндэслэсэн сургалт мэдээллийг хийх	2016-2020	ХЭЗХ	Олон нийт авлигын эсрэг ойлголт хандлагатай болно.	<p>Авлигатай тэмцэх газраас гаргасан зөвлөмж, видео мэдээллүүдийг орон нутгийн телевиз, аймгийн болон сумын Засаг даргын Тамгын газрын цахим хаяг, нүүр хуудсуудаар сурталчлан ажиллаж байна.</p> <p>2019 оны 10 дугаар сард "Авлигагүй Булганыг бүтээхэд иргэдийн оролцоо" сэдэвт 7 хоногийн аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд 320 төрийн алба хаагч, 400 иргэнд "Авлигын эсрэг хууль тогтоомж", "Авлигын эсрэг иргэдийн хяналт" сэдвээр мэдээллийг хүргэн Булган сумын 6 багийн иргэдийн дунд "Авлигагүй Булганы төлөө" сэдэвт дэвжээ тэмцээнийг зохион байгуулсан.</p> <p>Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх үүднээс Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоолыг орон нутагт хэрэгжүүлэх зорилгоор "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" дэд хөтөлбөрийг батлуулж, аймгийн хэмжээнд 100 "Эрх зүйн хөтөч" бэлтгэсэн. 2019 онд дээрх эрх зүйн хөтөч нарт 3 удаагийн сургалтыг нэгдсэн журмаар зохион байгуулж, сургалтын агуулгад Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах талаар оруулж, энэ чиглэлээр сургалт, сурталчилгааг сум орон нутагаа зохион байгуулах үүрэг өгч ажиллаж байна.</p>	70
		346	5.1.2.4. Нутгийн удирдлагын байгууллагын шийдвэрт судалгаа хийж, шийдвэрийн системчлэл хийх	2016-2017	ХЭЗХ	Шийдвэрийн уялдаа холбоо сайжирна	<p>2019 онд аймгийн Засаг даргын 520 захирамж, сумын Засаг даргын 825 захирамж, Тамгын газрын даргын 502 тушаалын эрх зүйн үндэслэлийн хянаж зөвлөмж өгсөн байна. Аймгийн Засаг даргын 2016-2019 онд гарсан нийт 42 захирамжийн эх хувьд өөрчлөлтийг тусгалаа. Мөн аймгийн Засаг даргын 2012 оноос хойш баталсан захирамжийн эх хувийг судалж, холбогдох хэлтэс, агентлагаас санал авсны үндсэн дээр цаашид дагаж, мөрдөх шаардлагагүй болсон захирамжуудыг хүчингүй болгох ажлыг зохион байгууллаа.</p>	100
		347	5.1.3.1. Булган сумын нийтийн эзэмшлийн зам талбай, уулзвар гарц болон улсын чанартай авто замын хяналтын постуудыг камераар тоноглох	2017 - 2020	ХЭЗХ, ЦГ	Гэмт хэргийг шуурхай илрүүлэх боломж бүрдэнэ.	<p>2017 онд Байгаль хамгаалах сангийн 150.0 сая төгрөгөөр Тэшиг сумын Эгийн голын гүүрэн гарцад камер суурилуулан, шилэн кабель татах ажлын нээлттэй тендерийг зохион байгуулж "Мон-Кабель системс" ХХК шалгарч гэрээ байгуулан 2017 оны 09 дүгээр сард аймаг, улсын комисс хүлээн авч ашиглалтад орсон. 2018 онд Улсын чанартай авто зам дагуух 5 постод 2.7 сая төгрөгөөр нарны эрчим хүчээр ажиллах туузан гэрлийг байршуулан хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавьж ажиллаж байна. Улсын чанартай авто зам дагуу Рашаант, Баяннуур сум, Булган сумын зоон давааны хяналтын постуудыг 2017-2018 онд бүрэн камержуулж, Тээврийн цагдаагийн албаны шуурхай удирдлагын төвтэй шууд холбогдож замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүрэн хянаж, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.</p> <p>Булган суманд үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны аюулгүй байдлыг хангах, гал түймэр, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2018 оны А/674 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулан Булган сумын төвд үйл ажиллагаа явуулж байгаа 29 төрийн байгууллага, 86 аж ахуйн нэгжийн камерын үйл ажиллагаа, стандарт шаардлага хангаж байгаа талаар шалгалт хийж нийтлэг алдаа дутагдал зөрчлийг илрүүлэн 60 аж ахуйн нэгж байгууллагад албан мэдэгдэл хүргүүлэн, 26 аж ахуйн нэгж байгууллагаас албан мэдэгдлийн хариуг авч биелэлтийг шалган ажилласан.</p> <p>Аймгийн төвийн гудамж талбайд 33 цэгт 86 камер суурилуулснаас 27 камер гэмтэж, ажиллагаагүй болсныг 2018 онд 10.2 сая, 2019 онд 10.0 сая төгрөг тус тус шийдвэрлүүлж, шаардлагатай засвар үйлчилгээг хийсэн.</p> <p>Сэлэнгэ сумын төвд теле хяналтын камерыг нэмэгдүүлэх зорилгоор 4.5 сая төгрөгөөр 2019 оны 05 дугаар сард эргэдэг 1, чиглэлийн 3, нийт 4 камер суурилуулсан.</p> <p>Бугат сумын төвийг камержуулахаар 63.0 сая төгрөгийг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан, ажлыг гүйцэтгэж байна.</p> <p>Бугат сумын төв камертай болсоноор Булган аймгийн 16 сум, 1 тосгон бүрэн камертай болж байна.</p>	100

348	5.1.3.2. Шатахуун түгээх станц болон онцгой барилга объектууд, олон нийтийн үйлчилгээний заал бүхий аж ахуйн нэгжүүд, төр, төсвийн байгууллагуудын дунд орчин тойрноо хяналтын камераар тоноглох хөдөлгөөн өрнүүлэх	2017	ЦГ, СХЗХэлтэс, иргэн, ААН	Урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдэнэ.	Булган суманд үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны аюулгүй байдлыг хангах, гал түймэр, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 34 шатахуун түгээх станц болон тусгай зөвшөөрөлтэй цэгүүд, төр, төсвийн байгууллагууд хяналтын камераар бүрэн тоноглогдсон. Аймгийн Засаг даргын 2018 оны А/674 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулан Булган сумын төвд үйл ажиллагаа явуулж байгаа 29 төрийн байгууллага, 86 аж ахуйн нэгжийн камерын үйл ажиллагаа, стандарт шаардлага хангаж байгаа талаар шалгалт хийн нийтлэг алдаа дутагдал зөрчлийг илрүүлэн 60 аж ахуйн нэгж байгууллагад албан мэдэгдэл хүргүүлэн 26 аж ахуйн нэгж байгууллагаас албан мэдэгдлийн хариуг авч биелэлтийг шалган ажилласан. Байгууллагуудад гарч байгаа нийтлэг зөрчлийн тоо жил бүр буурч байна.	100
349	5.1.3.3. Зарим сумдыг хяналтын камерын системтэй болгох	2017-2020	ЦГ, Сумын ЗД	Бүх сумын төв камерын хяналтын системтэй болно.	2017 онд Гурванбулаг сумын төсвийн 29.8 төгрөгийн хөрөнгөөр сумын төвд 24 ширхэг камер суурилуулсан. 2019 онд Сэлэнгэ сум эргэдэг 1, чиглэлийн 3, нийт 4 теле хяналтын камерыг сумын орон нутгийн хөгжлийн сангийн 4.5 сая төгрөгөөр авч, байрлуулсан. Бугат сумын төвийг камержуулахаар сумын төсвөөс 63.0 сая төгрөг шийдвэрлэж, гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, ажлыг гүйцэтгүүлж байна. Дашинчилэн сум камерын урсгал засварын зардалд сумын төсвөөс 2.0 сая, Булган сумын камерын засварын зардалд 10.0 сая төгрөгийг аймгийн төсвөөс шийдвэрлэн засвар үйлчилгээг тус тус хийлээ.	100
350	5.1.3.4. Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хөршийн хяналт”, “Урамшилт эргүүл” зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх	2017-2020	ЦГ, Сумын ЗД	Тухайн төрлийн гэмт хэрэг буурна.	Жил бүр аймгийн төвд гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаагийн газраас тухайн жилд ажиллуулах шаардлагатай урамшуулалт эргүүлийн зардлыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө, Эрүүл ирээдүй хөтөлбөр зэргээс санхүүжүүлж ирсэн бөгөөд 2017 онд 10, 2018 онд 20, 2019 онд 10 урамшуулалт эргүүлийг 5-30 хоногийн хугацаатай ажиллуулаад байна. 2019 оны хувьд аймгийн Засаг даргын баталсан “Уураар биш ухаалгаар шийдвэрлэе” 1 сарын нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөөний хүрээнд урамшилт эргүүлийг 6 багт 18 иргэнийг сарын 50000 төгрөгөөр, нийт 2.7 сая төгрөгөөр ажиллуулахаар зардлыг шийдвэрлүүлэн ажиллууллаа. “Сайн хөрш” хөтөлбөрийн хүрээнд олон нийтийн эргүүлд гаргах ажлыг зохион байгуулан батлагдсан хуваарийн дагуу олон нийтийг хамарсан Улсын баяр наадам, Булган аймгийн түүхт 80 жилийн ойн баяр, Хичээлийн шинэ жил арга хэмжээний хүрээнд давхардсан тоогоор 56 удаа, 218 хүнийг олон нийтийн эргүүлд ажиллуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан. Олон нийтийн эргүүлд ажиллах хугацаанд 86 зөрчил илрүүлэн холбогдох албан тушаалтанд мэдэгдэж, 177 аж ахуйн нэгж, байгууллага, 184 иргэнд зөвлөгөө өгч, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн хуудсыг иргэдэд тараан өгч сурталчлах, гудамж талбайд гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулсан. Булган сумын 6 багт “Сайн хөрш”-ийн холбооны үйл ажиллагаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд архидан согтуурах, гэр бүлийн хүчирхийлэл, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 10 төрлийн 2000 ширхэг санамж, зөвлөмжийг аймаг, сумын ГХУСАЗС3-ийн санхүүжилтээр хэвлүүлэн үйл ажиллагаандаа хэрэглэсэн. Хөтөлбөрийн хүрээнд иргэдийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, хөрш айлуудын хамтыг ажиллагааг сайжруулах зорилгоор аймаг, сумын Иргэний танхимтай хамтарч “Гэр бүлийн хүчирхийлэл, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдал”, “Хяналтын камерын ашиглалт, ач холбогдол”, “Уураар биш ухаалгаар шийдвэрлэе”, “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоо” сэдэвт хэлэлцүүлгүүдийг зохион байгуулан ажиллалаа.	100

67	5.1.3 Нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагын оролцоонд түшиглэн зохион байгуулж, хяналт, хамгаалалтын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэхийн зэрэгцээ тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	351	5.1.3.5. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд “Хяналт шийдвэрлэлт” арга хэмжээ болон бүсийн хамтарсан уулзалт, зөвлөгөөнийг зохион байгуулах	2016-2020	ХЭЗХ, ГХУСАСЗ, сумын Засаг дарга		Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт өснө.	Жил бүр аймгийн Засаг даргын захирамжаар аймгийн нутаг дэвсгэрт хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, хулгайлах гэмт хэрэг, хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор “Хяналт-Шийдвэрлэлт” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж хэвшүүлсэн. 2017 онд “Хяналт-Шийдвэрлэлт” хэсэгчилсэн арга хэмжээнд 8.6 сая төгрөг шийдвэрлүүлэн арга хэмжээг зохион байгуулж үр дүнг тооцон аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулан ажилласан. Багийн Засаг дарга, байгаль хамгаалагч нартай хамтран Сэлэнгэ, Бугат, Хангал сумын нутаг дэвсгэрт хууль бус мод бэлтгэх, ан, загасчлалыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл шалгалтад ажиллаж, 8 зөрчлийг илрүүлэн торгуулийн арга хэмжээ авлаа. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил, мал хулайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх таслан зогсоох, ирүүлэх ажлыг эрчимжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн захирамжаар Орхон сумын Халиун баг, Бугат сумын “Зосын даваа”, Сэлэнгэ сумын “Говилын эх”, Хангал сумын “Хуурайн хөтөл”, Бүрэгхангай сумын “Туулын гүүр”, Баяннуур сумын хяналтын постод 24 цагийн үйл ажиллагаатай үндсэн пост, Дашинчилэн, Гурванбулаг, Хишиг-Өндөр, Могод, Булган суманд хөдөлгөөнт эргүүл ажиллуулан, мэргэжлийн удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласан. 2019 оны 10 дугаар сарын байдлаар “Хяналт шийдвэрлэлт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд нийт 21850 иргэн, 13560 тээврийн хэрэгслийг шалгаж, 1960 зөрчил илрүүлэн 2012 иргэнд 72.8 сая төгрөгийн торгууль ногдуулж, нийт 28 гэмт хэргийг илрүүлэн шийдвэрлэсэн. Мөн экологи эдийн засагт учруулсан хохирлыг үнэлгээг тогтоолгохоор аймгийн төсвөөс 30.0 сая төгрөгийг шийдвэрлэсэн.	100
		352	5.1.3.6. Мал хулгайлах гэмт хэрэг, Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн эрсдэл ихтэй “Нэг сум”, “Нэг баг”-ийг сонгон иргэд, малчдын оролцоотой урьдчилан сэргийлэх аргачлалыг нэвтрүүлж үр дүнг тооцох	2016-2018	ХЭЗХ		Иргэд, малчдын оролцоотойгоор үр дүнд хүрсэн туршлага, аргачлал бий болно.	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хуулийн хэрэгжилтийг хангах, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагуудын үүрэг оролцоог "Малчдын бүлэг"-т чиглүүлэн “Нэг сум”, “Нэг баг”-ийг сонгон иргэд, малчдын оролцоотой урьдчилан сэргийлэх аргачлалыг нэвтрүүлж үр дүнг тооцох зорилгоор Гурванбулаг сумын 1-р багт малчдын бүлэг байгуулан багийн ЗД-д зааварчилга өгч Төв аймгийн Баянчандмань сумын Малчдын бүлгийн туршлагыг судалж нэвтрүүлэх ажлыг хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн. 2018 онд Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг ихээр үйлдэгддэг мөн үйлдэгдэх эрсдэл бүхий Булган аймгийн Бүрэгхангай сумын 3-р багийг сонгон авч, сумын ГХУСЗ-тэй хамтран тус багт оршин суудаг, алт олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 84 иргэнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тэр дундаа хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хамтын ажиллагаа сэдэвт сургалтыг хийсэн. 2018 оны 10-р сарын байдлаар нийт хууль бусаар ашигт малтмал олборлосон 4 гэмт хэргийг илрүүлэн шалгалтын ажиллагааг явуулж, 2 гэмт хэргийг яллагдагчаар татаж хэргийг прокурорт шилжүүлээ. 2019 оны 10 дугаар сарын байдлаар Булган аймгийн 16 суманд “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт, малчдын бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагаа цаашид анхаарах асуудал” сэдэвт мэдээллийг 468 малчин иргэдэд хүргэж, сумдын ГХУСАЗСЗ-ийн дарга, багийн дарга нарт 56 зөвлөмжийг хүргүүлсэн. Мал хулгайлах гэмт хэрэг 2017 онд 33 бүртгэгдсэнээс 16 хэрэг илэрсэн нь 57.1 хувь, 2018 онд 37 хэрэг бүртгэгдсэнээс 33 хэрэгт хэрэг бүртгэлт нээж, 8 хэрэг илэрсэн нь 24.2 хувьтай, 2019 оны 3 дугаар улирлын байдлаар мал хулгайлах гэмт хэрэг 89 бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 74 хэргээр буюу 4.3 хувиар өссөн. Мал хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт 46.4 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 25.0 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна. Уг хэргийн илрүүлэлтийг ахиулах, мал, малын гаралтай бүтээгдэхүүний тээвэрлэлтэд хяналт тавих чиглэлээр Рашаант, Баяннуур, Дашинчилэн, Хишиг-Өндөр, Орхон, Хутаг-Өндөр, Баян-Агт, Бугат сумын нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх томоохон голын гүүрэн гарцууд, 3 трассын зам дагуух зам тээврийн хяналтын пост, хөдөлгөөнт пост, эргүүлээр “Сар шинэ”, “Илрүүлэлт-Шийдвэрлэлт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд тогтмол хяналт тавьж, Хишиг-Өндөр, Дашинчилэн, Бүрэгхангай, Хутаг-Өндөр, Рашаант, Булган суманд байрлах 6 нядалгааны түр цэгүүдэд болон мал мах худалдан борлуулдаг 3 цэгт тогтмол хяналт тавьж ажиллаж байна.	70

353	5.1.3.7. Хутаг-Өндөр суманд Замын хяналтын постыг барьж, шаардлагатай сумдыг хурд хэмжигч багажтай болгох	2017-2018	ЦГ	Зам тээврийн хэрэг, ослын гаралт буурсан байна.	2019 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Булган аймгийн Хутаг-Өндөр, Рашаант сум дахь замын хөдөлгөөний байнгын постын барилгын ажил гүйцэтгэх ЦЕГ/201901001-2 дугаартай гэрээг Цагдаагийн ерөнхий газар, "Роял алтай констракшн" ХХК-тай байгуулан нэг бүр нь 72.6 сая, нийт 145.2 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилгын ажлын гүйцэтгэлийн гэрээг хийж, Хутаг-Өндөр суман дахь замын хөдөлгөөний байнгын постын барилгын ажлыг 2019 оны 09 дүгээр сард, Рашаант суман дахь замын хөдөлгөөний байнгын постын барилгын ажлыг 2019 оны 10 дугаар сард улсын комисс ажиллаж хүлээн авсан. 2019 оны 05 дугаар сард Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 15.0 төгрөгөөр COM LASER маркийн хурд хэмжигч /1 ширхэг/-ийг шийдвэрлэн өгснийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2019 оны эхний 10 сарын байдлаар хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашигалтын журмын гэмт хэрэг 23 бүртгэгдэж, 6 хэргээр буюу 20.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	100
354	5.1.3.8. Орон нутгийн чанартай авто замын уулзваруудад тэмдэг, тэмдэглэгээ тавьсан ажлыг үргэлжлүүлэх, боловсронгуй болгох	2017-2018	ЦГ, Сумын Засаг дарга	Иргэдэд эрсдэл учрахаас сэргийлнэ.	2017 онд орон нутгийн шороон болон хайрган хучилттай замын тэмдэг, тэмдэглэл, замын байгууламжид үзлэг шалгалт хийх тухай аймгийн Засаг даргын А/121 дүгээр захирамжаар аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсгийг байгуулан газар дээр нь шалгалтыг явуулан засварлах шаардлагатай гүүр, замын хэсэг, тэмдгийн судалгааг гаргасан. Энэхүү ажлын хүрээнд Могод суманд орон нутгийн хөгжлийн сангаас 2.0 сая төгрөгөөр 25 тэмдэг, тэмдэглэгээг, Бугат сум 350000 төгрөгөөр 6 тэмдэг, тэмдэглэгээг хийж суурилуулах ажлыг зохион байгуулсан. Зам тээврийн осол, хэрэг ихээр үйлдэгддэг Булган аймгаас Хутаг-Өндөр сум руу зорчих "Дондогийн булаг"-т 2, Булган аймгаас Орхон аймаг зорчих "Оросын булаг" гэх газар 2, Рашаант сум "Үнэгт" гэх газарт 2 ширхэг, нийт 6 ширхэг "Аюултай цэг" гэсэн тэмдэглэгээг 1.8 сая төгрөгөөр хийлгэн хоёр талаас зорчих хэсгүүдэд байрлуулж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан. Энэ нь орон нутгийн замд зорчиж буй жолооч нарыг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой ажил болсон. Булган сумын 5 дугаар баг, төв замыг 2 эгнээтэй болгохоор өргөтгөлийн ажлыг эхлүүлэн хатуу хучилттай зам тавьж буй компанийн зардлаар 50 ширхэг замын тэмдэг, тэмдэглэгээг шинээр тавиулахаар шийдвэр гаргуулан хэрэгжүүлсэн. 2018 онд Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2.7 сая төгрөгийг шийдвэрлэн өгснөөр хөдөө орон нутагт ашиглах зориулалт бүхий нарны энергиэр цэнэглэгдэх 6 ширхэг туузан гэрэл, 6 гэрэлтүүлэг /Прожуктор/-ийг орон нутгийн замд хяналт, шалгалтыг хөдөлгөөнтөөр зохион байгуулахад ашиглаж байна. 2019 онд "Булган АЗЗА" ТӨХК-тай хамтран Булган-Хөвсгөл чиглэлийн А0902 дугаарын замын Булган аймгаас 3 км-ийн зайд замын зорчих хэсгийн хажууд тус бүр нь 800.0 мянган төгрөгийн өртөгтэй 8 ширхэг шар дэвсгэртэй 2.0x1.0 хэмжээтэй 8 ширхэг самбарыг зам тээврийн осол хэрэг давтамжтайгаар үйлдэгдэг "Хар" цэгүүдэд байрлуулан ажилласан.	100
355	5.1.3.9. Булган сумын 6-р баг дахь Шунхлай ШТС-ын гурван замын уулзварт хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио суурилуулах	2017-2018	ЦГ	Эрсдэлгүй орчин бүрдэнэ.	2018 онд "Шунхлай" шатахуун түгээх станц байрлах гурван замын уулзварыг өөрчлөн стандартын шаардлага хангасан гэрлэн дохио суурилуулах ажлыг зохион байгуулах зорилгоор гэрлэн дохионы мэргэжлийн байгууллага болох "Сүлжээт зам" ХХК-иас үнийн судалгааг хийсэн боловч аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээний төлөвлөгөөтэй холбогдуулан тухайн замын зорчих хэсгийг өргөтгөж 10 метр болгож, хөдөлгөөнийг 3.1 /гол зам/, 3.4 /зам тавьж өг/ тэмдэг байрлуулан дарааллыг тогтоон зохицуулж байна. Булган сумын 6-р баг дахь Шунхлайн ШТС-ын гурван замын уулзварт хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохио суурилуулах ажил нь Аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн төлөвлөгөөтэй уялдуулан өөрчлөлт орсноор хэрэгжээгүй болно.	100

356	5.1.3.10. “Эрүүл ирээдүй” дэд хөтөлбөрийг баталж, ТББ-ын оролцоотойгоор хэрэгжүүлнэ. Гүйцэтгэгчийн урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлын үр дүнг хөндлөнгийн үнэлгээгээр үнэлэх	2016-2020	ХЭЗХ	Хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх арга хэмжээ хийгдсэн байна.	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлын 2017 оны 33 дугаар тогтоолоор “Эрүүл ирээдүй” дэд хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор 2018 онд 12.0 сая, 2019 онд 15.0 сая төгрөгийг тус тус батлуулан, төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг зохион байгууллаа. Хөтөлбөрийн 2018 оны хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар “Эрүүл ирээдүй”, “Бүх нийтийн эрх зүйн боловсрол” хөтөлбөрийг хамтатган “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хийж буй ажлын мэдээлэл” сэдвээр мэдээлэл бэлтгэн танилцуулсан. “Эрүүл ирээдүй” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2018 онд “Ухаарлын жимээр” ТББ-тай хамтран Булган сумын ЕБС-ийн 458 сурагч, 157 төрийн албан хаагч нарт “Өсвөр насныханд тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, гарах арга зам”, “Хувь хүний хандлага” сэдвээр сургалт зохион байгуулсан. Мөн “Амьдрах ухаан аз жаргалын үндэс” хөтөлбөрийг Шинжлэх ухааны доктор Д.Дарьсүрэн багштай хамтран 8 сарын хугацаанд хэрэгжүүлсэн. Хөтөлбөрт Булган сумын зорилтот бүлгийн өөрсдийн амьдралаа сайжруулах хүсэл эрмэлзэлтэй 17 гэр бүлийн 76 гишүүнийг хамруулан, 288 цагийн онол, 1440 цагийн дадлага ажил хийсэн байна. Аймгийн хэмжээнд идэвхтэй АА бүлэг Булган, Тэшиг, Бугат, Дашинчилэн, Хутаг-Өндөр суманд ажиллаж байна. АА бүлгийг дэмжих зорилгоор эрх зүйн багт хамруулан 16 сум, 1 тосгоны архины хамааралтай иргэдтэй уулзах уулзалтыг зохион байгуулсан. Орхон аймгийн “Оюу” сэтгэц наркологийн эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулж 11 иргэнийг архины хордлого тайлах эмчилгээнд хамруулсан. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт албадан эмчилгээнд 9, сайн дураар 2 иргэн хамрагдсан байна. Булган сумын АА бүлэг нь Цагдаагийн газрын эрүүлжүүлэх, баривчлах байранд хүмүүжиж буй иргэдтэй 7 хоногийн 2 өдөр уулзалт хийж, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулан ажиллаж байна.	100
357	5.1.3.11. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг ТББ-аар гүйцэтгүүлэх	2016-2020	ХЭЗХ	Урьдчилан сэргийлэх ажил үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2016 оноос хойш “Бялхам үндэс”, “Гэрэлт ирээдүй оршихуй”, Гэр бүлийн 106.5 FM радио, “Оюу” зэрэг төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрээгүй 8 охин Бялхам үндэс төрийн бус байгууллагын үйлчилгээг авч, сурч боловсрох нөхцөлөөр хангагдлаа. Мөн Цагдаагийн газрын эрүүлжүүлэх, баривчлах байранд хүмүүжиж байгаа иргэдэд эерэг хандлага төлөвшүүлэх зорилгоор Булган сумын АА цуглаантай хамтран 7 хоногийн 2 өдөр уулзалт зохион байгуулж байна.	100
358	5.1.3.12. Хүний эрхийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, арилгах арга хэмжээг зохион байгуулах	2016-2020	ХЭЗХ	Хүний эрхийн нөхцөл байдал сайжирна.	Хүний эрхийн үндэсний комисс, Прокурорын газар, Мэргэжлийн хяналтын газраас хяналт шалгалтыг зохион байгуулж, Цагдаагийн газрын Албадан эрүүлжүүлэх байрыг хүний эрх зөрчигдсөн гэж дүгнэлт гаргаж, үйл ажиллагааг зогсоох албан шаардлага өгсний дагуу тус байрны асуудлыг шийдвэрлэхээр орон нутгийн төсвөөс 18.4 сая төгрөг олгож, зураг төсвийг хийлгэсэн. Хүний эрх зөрчигдсөн талаарх гомдол мэдээлэл иргэдээс ирээгүй байна.	70
359	5.1.4.1. Хууль зүйн салбарын байгууллагуудын нээлттэй хэлэлцүүлэг, хамтарсан эрх зүйн сургалтыг сум, багт зохион байгуулах	2016-2020	ХЭЗХ	Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэг сайжирна.	Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан “Эрх зүйн” багаар дамжуулан хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг 16 сум, 1 тосгонд жил бүр зохион байгуулж хэвшсэн. Уг сургалтаар жилд 4000-8000 иргэнийг хамруулан ажиллаж байна. “Гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэхэд төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа”, “Хуулийн байгууллагуудын хамтарсан зөвлөгөөн”, “Эрүүгийн хуулийн хэрэглээ”, “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх нь” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг жил бүр зохион байгуулан ажиллалаа. Уулзалтад аймаг, Булган сумын удирдлагууд болон аймгийн ЗДТГ, ГХУСАЗСЗ, Шүүх, Прокурорын газар, Цагдаагийн газар, Тагнуулын хэлтэс, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Мэргэжлийн хяналт, Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн төлөөллүүд оролцон санал бодлоо илэрхийлж, тухай жилд хамтран ажиллах чиглэлээ тодорхойлон ажиллаж байна.	100

360	5.1.4.2. Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй аж ахуй нэгжийн үйл ажиллагааг тогтмол хянаж шалгах	2016-2020	МХГ	Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багасна.	<p>2017 онд Бүрэгхангай сумын 3 иргэнээс ирүүлсэн өргөдлийн дагуу тус сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Монголросцветмет” ХХК, “Монполимет” ХХК, “Ориентмайнинг инвестмент” ХХК-д хяналт шалгалт хийж, “Монголросцветмет” ХХК-ийн үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар зөрчлийг арилгатад түр зогсоож, “Монполимет” ХХК-д улсын байцаагчийн албан шаардлага өгсөн. Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтаар байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй Бугат, Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хутаг-Өндөр сум, Хялганат тосгонд үйл ажиллагаа явуулж байгаа ойн мэргэжлийн 12 байгууллага, Гурванбулаг, Дашинчилэн, Рашаант, Сайхан, Хангал суманд үйл ажиллагаа явуулж байгаа 6 шатахуун түгээх станц, Рашаант сум, Хялганат тосгоны цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа, сумдын хог хаягдлын нэгдсэн цэгүүдэд болон сумдын газар олголтын байдалд хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар үйл ажиллагаа явуулж буй ойн мэргэжлийн байгууллагууд, шатахуун түгээх станцууд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг бүрэн биелүүлээгүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан мөрдөж ажилладаггүй зөрчил дутагдал 2016-2018 онд нийтлэг илэрч байсан.</p> <p>2019 онд Тагнуулын хэлтэс, аймгийн Цагдаагийн газрын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Бүрэгхангай суманд бичил уурхайгаар ашигт малтмал олборлож буй нөхөрлөлүүдэд хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтаар 5 зөрчил илрүүлж, 3 зөрчлийг нь харьяаллын дагуу Цагдаагийн газар шалгаж, 1 зөрчлийг газар дээр нь арилгуулсан ба 1 зөрчил дээр зөрчлийн хэрэг бүртгэлт хийж байна. Нөхөрлөлийн нэрээр хууль бусаар ашигт малтмал олборлож буй иргэний үйл ажиллагааг улсын байцаагчийн 5 актаар зогсоож, гэрээг хучингүй болгох, тоног төхөөрөмжийг албадан гаргуулах талаар сумын Засаг даргад мэдэгдэж, зөрчлийг таслан зогсоолоо.</p>	100
361	5.1.4.3. Хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангаж, орон тооны бус зөвлөлийг чадавхжуулж, үйл ажиллагааг өргөжүүлэх	2016-2020	МХГ	Хүнсний аюулгүй байдал хангагдана.	<p>Аймгийн Засаг даргын 2018 оны А/658 дугаар захирамжийн дагуу Сумдын хүнсний аюулгүй байдлын орон тооны бус зөвлөлийг чадавхжуулах чиглэлээр сургалт, мэргэжил, арга зүйн зөвлөгөө тогтмол зохион байгуулж хэвшсэн ба сургалтыг 16 сум 1 тосгонд хийсэн.</p> <p>2018 онд Булган аймгийн хэмжээнд хүнсний худалдааны 150, хоол үйлдвэрлэлийн 20, хүнсний үйлдвэрлэлийн 12, ургамлын гаралтай түүхий эд худалдан борлуулж буй 10, мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүн борлуулж буй 38, баярын өдрүүдэд түр хугацаагаар хэвийн боов, еэвэн борлуулж буй 20 иргэн, нийт 250 объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн. 2017 онд Цагаан сарын баярыг угтан хүнсний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр аймгийн хэмжээнд худалдааны 153, хоол үйлдвэрлэлийн 58, хүнсний үйлдвэрлэлийн 6 цех, 2 хүнсний зах, 4 цэцэрлэг, 2 сургууль нийт 225 объектод хяналт шалгалт хийв. Шалгалтын явцад нийт илэрсэн зөрчлийн 74.6 хувийг арилгуулж, улсын байцаагчийн 43 заалттай 6 зөвлөмжийг үйлдэв. Мөн 2018 онд сумдын “Хүнсний аюулгүй байдлын орон тооны бус зөвлөл”-ийн ажлыг эрчимжүүлэх, үйл ажиллагааг жигдрүүлэх чиглэлээр зөвлөлийн ажлын чиг үүрэг, тайлан мэдээний загварыг 01/132 албан тоотоор хүргүүлж, мэдээ тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, цаг хугацаанд нь тогтмол ирүүлж байхыг мэдэгдэв. Баян-Агт, Бугат, Сайхан, Сэлэнгэ сумдын зөвлөлийн ажлын хэсгийн ахлагч Засаг даргын орлогчтой хамтран хяналт шалгалт хийж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэв.</p>	70
362	5.1.4.4. Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааг бэхжүүлж, лабораторийн байр, шуурхай албанд хэрэглэгдэх тусгай зориулалтын техник хэрэгсэлтэй болоход дэмжлэг үзүүлэх	2017	ХЭЗХ, ШША	Ажлын орчин нөхцөл сайжирсан байна.	<p>Тусгай шинжилгээний лабораторийг стандартад нийцүүлэн тохижуулах, шинжилгээний орчин үеийн жишиг, стандартад нийцсэн ажлын байрны нөхцөлийг бүрдүүлэх, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор зөөврийн тусгай техник, тоног төхөөрөмж бэлтгэх, лабораторийн өрөөг засварлан тохижуулахад шаардагдах хөрөнгийн асуудалд орон нутгаас дэмжлэг хүсч, 2018 онд орон нутгийн хөгжлийн сангаас 38.8 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлүүлж, шуурхай албаны автомашин, зөөврийн лабораторийн техник хэрэгсэл, бодис урвалж, үнэлгээний дээж авах материал, хамгаалах хэрэгсэл, бусад шаардлагатай эд зүйлсийг бэлтгэсэн.</p>	100

5.1.4 Хууль хяналт, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг хуулийн дагуу дэмжиж /шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, ажиллах нөхцөл/, хууль сурталчлах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллаж иргэдийн "АЮУЛГҮЙ АМЬДРАХ ОРЧИН"-ыг бүрдүүлнэ.	363	5.1.4.5. Хаягжуулалтын тухай хуулийг хэрэгжүүлж, иргэний бүртгэлийн хаягийн өөрчлөлт хийх	2016-2017	УБХ	Иргэний хаягийн бүртгэлийн давхардал, хийдэл арилна.	2018 онд сумын улсын бүртгэгч нар болон газрын даамлуудтай хамтран сумын ИТХ-ын тогтоолыг үндэслэн шинэ хаягийн судалгааг гарган ажилласан. 2018 оны жилийн эцсийн байдлаар шинэ хаягаараа эд хөрөнгийн бүртгэл хийгдсэн 650 иргэн, иргэний бүртгэлийн мэдээллийн санд 2100 иргэн бүртгэгдсэн. 2019 оны эхний 11 сарын байдлаар эд хөрөнгийн бүртгэл 230 иргэн, иргэний бүртгэлийн мэдээллийн санд 995 иргэн бүртгэгдсэн байна.	100
	364	5.1.4.6. Зарим байгууллагуудын байрны асуудлыг шийдвэрлэж, үйлчилгээний нөхцөлийг сайжруулах	2016-2017	УБХ, ШША, ЦГ, МХГ	Хөдөлмөр хамгаалал, хүний эрхийн нөхцөл сайжирна.	Улсын бүртгэлийн хэлтэс нь ажлын байрныхаа нөхцөл байдлыг сайжруулахын тулд сумын ЗДТГ-ын 1 давхарт нүүн орж, аймгаас 10.0 сая төгрөгийн дэмжлэг авч өөрсдийн нөөц бололцоог ашиглан засвар хийсэн. Шүүхийн шинжилгээний албаны конторын шинэ барилгыг улсын төсвөөр барихтай холбоотойгоор шинэ байр баригдах газрын асуудлыг шийдэж холбогдох материалыг яам болон дээд газарт хүргүүлсэн. Цагдаагийн газрын засварын ажилд орон нутгийн төсвөөс 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Цагдаагийн газрын байрны их засвар болон өргөтгөл барих, албадан эрүүлжүүлэх байрны зураг төсвийг хийлгэж, шаардагдах санхүүжилтийг 2020 оны орон нутгийн төсөвт тусгахаар санал хүргүүлсэн.	70
	365	5.1.4.7. Улсын бүртгэлийн үйлчилгээнд мэдээллийн технологи, программ хангамжийг нэмэгдүүлж, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивыг цахим архивт шилжүүлэх	2017-2018	УБХ	Улсын бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээний шуурхай байдал нэмэгдэнэ.	Засгийн газрын "Ухаалаг засаг" төслийн хүрээнд Дэлхийн банкны санхүүжилтээр Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн архивыг цахимжуулах ажлыг "ЭС ТИ ЭКС СИТИНЕТ" ХХК хариуцан Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран ажиллаж 2017 оны 10 дугаар сараас 2018 оны 3 дугаар сарын хооронд 13815 хувийн хэргийн 365884 хуудас материалыг цахимжуулан мэдээллийн нэгдсэн санд оруулж дууссан. Төслийн хүрээнд эд хөрөнгийн ажилтнуудын техник, тоног төхөөрөмж шинэчлэгдэж ажиллах нөхцөл сайжирсан. Эд хөрөнгийн бүртгэл цахим бүртгэлд шилжиж "Ergs" программаар бүртгэлийн үйлчилгээ хийгдэж байгаа нь бүртгэлийн үйл ажиллагаа сайжран, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ түргэн шуурхай, хүнд сурталгүй болж, статистик тоо мэдээ богино хугацаанд үнэн зөв гарах, бүртгэлийн хяналтын тогтолцоо сайжрах, шаардлагатай мэдээллийг төрийн байгууллагуудад олгох зэрэг олон талын ач холбогдолтой болж байна. Төрийн үйлчилгээний ТҮЦ машинаас цахим үнэмлэх болон гарын хурууны хээгээр эд хөрөнгийн лавлагаагаа авах боломж бүрдсэн нь иргэдийн цаг зав, эдийн засгийн зардлыг хэмнэж байна. Улсын бүртгэлийн ерөнхий газар, Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд иргэний бүртгэлийн үйлчилгээг сумаас шууд үзүүлэх ажлыг 8 суманд, орон нутгийн дэмжлэгээр 5 суманд хэрэгжүүлсэн бөгөөд иргэдэд улсын бүртгэлийн хэлтсээс авдаг лавлагааг сумандаа авах боломжтой болсон. Уг үйлчилгээнд холбогдоогүй Бүрэгхангай, Дашинчилэн, Могод сум, Хялганат тосгоныг энэ ондоо багтаан холбохоор ажиллаж байна.	100
	366	5.1.4.8. Цагдаагийн газрын төв, хөдөөгийн тасгуудыг ажлын шаардлага хангасан автомашинаар хангахад дэмжлэг үзүүлэх	2017	ЦГ, Сумын Засаг дарга	Цагдаагийн албаны шуурхай байдал хангагдана.	2017 онд Хялганат тосгоны захирагчийн нөөц хөрөнгөөс эргүүлийн Приус-10 маркийн автомашиныг албан хэрэгцээнд хүлээлгэн өгсөн байна. 2018 онд УАЗ фургон маркийн автомашиныг аймгийн Засаг даргын Тамгын газраас 38.0 сая төгрөгийг шийдвэрлэн, авто машинд тусгай дуут дохио GPS төхөөрөмж, машины станц, лед гэрэл, шөнийн дуран, мөрдөгчийн хэргийн газрын үзлэгийн цүнх, машины доторлогоо хийж тус Цагдаагийн газарт хүлээлгэн өгсөн. Мөн Булган сумын Засаг даргын Тамгын газраас "Хүлэг" маркийн ашиглагдаж байсан мотоциклийг Булган сумын 6 дугаар багийн хэсгийн байцаагчид шилжүүлж өгсөн. 2019 оны 11 дүгээр сарын байдлаар тус Цагдаагийн газрын алба хаагч нарын албан хэрэгцээнд 1 мотоцикль, 5 автомашиныг 90.7 сая төгрөгөөр шийдвэрлэж өгсөн байна.	100

367	5.1.4.9. Цагдаагийн газрын өргөтгөл, гадна фасад, сантехникийн их засвар, нийтийн байрны сантехникийг засварлах ажлыг дэмжих	2017-2020	ЦГ	Ажлын орчин нөхцөл сайжирсан байна.	2018 онд тус Цагдаагийн газрын түүхт 80 жилийн ой тохиосонтой холбогдуулан Цагдаагийн газрын барилгын гадна фасадыг иж бүрэн шинэчлэн засварлахад 5.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэж өгсөн. 2019 онд Булган сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Цагдаагийн газрын нийтийн байрны урсгал засвар, сантехник, цахилгааныг иж бүрэн засварлах ажлыг гүйцэтгэх БУЦГ/201902001 дугаартай гэрээг Цагдаагийн газрын дарга, "Шүүдэр гранд" ХХК-ийн захиралтай 2019 оны 03 дугаар сард байгуулснаар улсын төсвийн 156.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барилгын ажлыг гүйцэтгэж, 2019 оны 10 дугаар сард 3 өрөө 4 байр, 1 өрөө 8 байр, нийт 12 байрыг улсын комисс ажиллаж хүлээн авснаар 12 алба хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн.	100
368	5.1.4.10. Цагдаагийн хэсгийн байцаагч болон мөрдөн байцаагч нарыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах	2017-2018	ЦГ	Хэргийн илрүүлэлт болон ажиллах нөхцөл сайжирна.	2017 онд Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс тус газрын Мөрдөн байцаах тасагт "Epson" маркийн 3 үйлдэлтэй принтерийг 400000 төгрөгөөр шийдвэрлэж өгсөн. 2018 онд Булган сумын Засаг даргын тамгын газраас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад үйлдвэрлэсэн "Хүлэг" маркийн ашиглагдаж байсан мотоциклийг Булган сумын 6 дугаар багийн хэсгийн байцаагчид шилжүүлэн өгсөн.	100
369	5.1.4.11. ШШГБ-уудад хүмүүжиж байгаа иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор дэмжих, үйлдвэрлэлд ажиллуулах	2016-2020	ХЭЗХ, ШШГА, Хорих анги	Хөдөлмөр эрхлэх боломж нэмэгдэж хүний эрх хангагдана.	Хорих 0439 дүгээр ангийн дотоод үйлдвэрлэлд 50 гаруй хүмүүжигч ажиллаж, 20 гаруй төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд нийлүүлж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудад хүмүүжиж байгаа иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор дэмжих, үйлдвэрлэлд ажиллуулах ажлын хүрээнд тус газрын аж ахуйн үйлчилгээнд 13 хоригдлыг ажлын байраар хангаж, шагналын хоног олгон хорих ял эдлэх хугацаанаас шагналаар авсан хоногийг хасаж, сар бүр ялын тооцоог тухайн хоригдолд танилцуулан ажиллаж байна. Мөн тус газрын аж ахуйн үйлчилгээнд хорих ял эдэлж байгаад хугацааны өмнө тэнсэн суллагдсан 59 настай хоригдол С.Жаргалсайхан нь хөдөлмөр алдалтын тэтгэмжийн хугацааг 2019 оны 06 дугаар сард нэг жилээр сунгуулсан.	100
370	5.1.4.12. Хилчдийн ажиллах нөхцөлийг сайжруулах, хил хамгаалалтын үйл ажиллагааг дэмжих	2016-2020	ХЭЗХ	Хилчдийн ажиллах нөхцөл сайжирна.	Хилчдийн амьдрах нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд заставын хүн эмнэлгийн байрыг шинэчлэн засварлаж, мөн хүүхдийн тоглоомын талбайг шинээр байгуулж ашиглалтад оруулсан байна. Дээрх зардалд орон нутгийн болон өөрсдийн зардлаар 25.0 сая төгрөг зарцуулсан. Хил хамгаалах байгууллагын алба хаагчид, хилчдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор аймгийн ЭМГ болон сумын Эрүүл мэндийн төвтэй хамтран эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 2 удаа зохион байгуулж алба хаагчид болон тэдний ар гэрийнхнийг бүрэн хамруулсан. Аймгийн Засаг даргаас Хилийн цэргийн 0286 дугаар ангийн тусгай бүлэгт иж бүрэн тоноглол бүхий автомашиныг худалдан авч өгөхөөр 2019 оны улсын төсөвт тусгуулж, худалдан авах ажиллагааг Хил хамгаалах ерөнхий газраас зохион байгуулан тоноглогдсон автомашиныг тус ангид хүлээлгэн өгсөн. Хил хамгаалалтыг сайжруулах хил орчмын тэмдэг, тэмдэглээг сайжруулах ажлын хүрээнд "Булган Азза" ТӨХК-иас 39 ширхэг тэмдэг, тэмдэглээг шинээр хийж хүлээлгэн өгсөн. Мөн Хилийн заставуудад байршилтай хүүхдийн цэцэрлэгүүдэд шаардлагатай байгаа эд зүйлийг худалдан авахад шаардлагатай 10.0 сая төгрөгийг шийдвэрлэн өгч ажиллалаа.	100
371	5.1.4.13. Төрийн архивын тасгийн байрыг стандартад нийцүүлэн тохижуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах	2016-2017	Төрийн архивын тасаг	Ажиллах нөхцөл, хөмрөгийн аюулгүй байдал хангагдана.	2017 онд Төрийн архивын тасаг шинэ байранд нүүж орсонтой холбогдуулан тус архивын байранд шаардлагатай камер, галын дохиолол, ус мэдрэгч шинээр байрлуулж, цонхонд төмөр сараалж бэхлэгээг хийсэн. Архивын байрыг стандартад нийцүүлэн тохижуулах, шаардлагатай тоног, төхөөрөмж, техник хэрэгслээр хангахад аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс болон ЗДТГ-ын төсвийн хөрөнгөөс нийт 2.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Архивын уншлагын танхим болон бусад өрөөг тохижуулах ажлыг зохион байгууллаа. Төрийн архивын тасаг нь 2019 онд баримт үдэгч 1 ширхэг, шат 1 ширхэг, нийт 550000 төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдсан.	100

		372	5.1.4.14. Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлж, цахим архивт шилжүүлэх	2016-2020	Төрийн архивын тасаг		Цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлж дуусна.	2016-2019 онуудад удирдлагын баримтнаас 10 хөмрөг буюу 22 байгууллагын 1954-2013 оны 418 хадгаламжийн нэгжийн 28485 хуудас баримтыг AMS программд тодорхойлон бичиж, цахим архив үүсгэлээ. Цахимжуулалт 2019 онд 100 хувьтай байна.	100
69	5.1.5 Төрийн цэргийн бодлогын хүрээнд батлан хамгаалах нутагт хэрэгжүүлж, эцэг-эх, цэрэг-дайчид, төр захиргааны байгууллагын холбоог нэмэгдүүлж, ирээдүй болсон хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлнэ.	373	5.1.5.1. Цэргийн жинхэнэ алба болон гэрээт цэрэг, цэргийн дүйцүүлэх албаны үйл ажиллагааг зохион байгуулах	2016-2020	ЦШ		Монгол Улсын Үндсэн Хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ биелүүлнэ.	Цэргийн жинхэнэ албыг 600 гаруй залуучууд биеэр хааж, одоо 270 орчим залуучууд Зэвсэгт хүчин болон Хилийн цэргийн анги байгууллагуудад цэргийн албыг хааж байна. Зэвсэгт хүчинд 12, Хилийн цэрэгт 16 залуучууд өөрсдийн саналаар гэрээт цэргийн албанд элсэн алба хааснаас 5 нь ахлагчийн бүрэлдэхүүнд орж байнгын ажлын байртай болсон байна. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн 70 иргэн гэрээ байгуулан алба хааснаас ой хээрийн түймэр, малын гоц халдварт цэцэг, шүлхий зэрэг өвчнүүдийн үед давхардсан тоогоор 340 хоног ажиллаж үүрэг гүйцэтгэсэн байна. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж, хугацаа дуусаж, холбогдох тогтоол болзлыг хангасан иргэдийг аймгийн Засаг даргын захирамжаар цэргийн дүйцүүлэх албанаас бэлтгэлээр халлаа.	100
		374	5.1.5.2. Аймгийн дайчилгаа удирдлагын байрыг тохижуулж, дайчилгааны даалгаврыг хэрэгжүүлэн, бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг орон нутагт зохион байгуулах	2016-2020	ЦШ		Аймгийн дайчилгааны төлөвлөгөөний хэрэгжих нөхцөл бүрдэнэ.	Батлан хамгаалах яамнаас зохион байгуулсан "Цэрэг-стратегийн бэлтгэл" сургалтад ИТХ-ын дарга бэлтгэл дэд хурандаа М.Оюунбат, аймгийн Засаг дарга бэлтгэл хошууч З.Батзориг, ЗДТГ-ын дарга, улсын дайчилгааны төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтны "Цэргийн бэлтгэл" сургалтад дэслэгч Г.Баасанжаргал тус тус хамрагдсан. 2017, 2019 онд БХЯ-аас зохион байгуулсан төвийн бүсийн аймгуудын сумдын Тамгын газрын дарга нарын "Цэргийн бэлтгэл" сургалтад 16 сумын Тамгын газрын дарга нарыг бүрэн хамруулж цэргийн хэргийн мэдлэгийг дээшлүүлсэн. ЗХЖШ-аас өгсөн дайчилгааны даалгавар, ЗХ-ний анги, байгууллагыг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах аймгийн дайчилгааны төлөвлөгөө, дайчилгааны даалгавар бүхий ЗХ-ний 186-р ангитай хамтран хийсэн тодотголын мөрөөр нэн шаардлагатай чухал 8 мэргэжлээр дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнээс 120 бэлтгэл үүрэгтэнг шинээр болон шилжүүлэн мэргэжил эзэмшүүлэх сургалтыг Зэвсэгт хүчний 186 дугаар ангитай хамтран зохион байгуулж, тус ангийн багшлах бүрэлдэхүүн, сургалтад шаардагдах зэвсэглэл техник, үзүүлэн таниулах материал хэрэгслийг түшиглэн явуулав. Аймгийн дайчилгаа удирдлагын байрыг тохижуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	70
		375	5.1.5.3. Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлж, хүүхэд залуучуудын дунд цэрэгжсэн тоглолт, спорт урлагийн тэмцээн зохион байгуулж, цэрэг, эх оронч үзэл төлөвшүүлэх	2016-2020	ЦШ		Цэрэг эх оронч үзэл төлөвшиж, цэргийн алба хаах сонирхол нэмэгдэнэ.	Зэвсэгт хүчний болон хилийн цэргийн анги байгууллагуудад цэргийн албаа үлгэр жишээ, нэр төртэй хааж байгаа нэр бүхий 40 цэргийн албан хаагчдын ар гэрт талархлын захидал тавгийн идээ гардуулан өгсөн. Цэрэг татлагын товчоо, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх ажлын хүрээнд ЗХ-ний 110, 032, 013 дугаар анги, ХЦ-ийн 0243, 0277-р анги дээр эцэг эх, цэрэг дайчид, төр захиргааны байгууллагын гурвалсан уулзалтыг зохион байгууллаа. Залуу жанжин Ж.Лхагвасүрэнгийн 105, Халх голын байлдааны ялалтын 80, МУ-ын хилчин баатар С.Лхагвадоржийн 100, Монгол цэргийн өдөр, зэвсэгт хүчний ойн баярыг тусгай төлөвлөгөө гарган тэмдэглэн өнгөрүүлсэн. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулдаг Марш тактик-тусгай бэлтгэлийн тэмцээнийг 2018 онд Тэшиг суманд, 2019 онд Хялганат тосгонд хөдөө орон нутагт зохион байгуулж төрийн тусгай байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааг сурталчиллаа. "Монгол цэрэг-дэлхийн цэрэг" сэдэвт Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, Энхийг сахиулах ажиллагааны зорилго, ач холбогдлыг сурталчлах ажлыг хөтөлбөрийн дагуу 7 суманд зохион байгууллаа. БХТН-тэй хамтран хүүхэд залуучуудын дунд аймгийн аварга шалгаруулах "Буудлага спорт"-ын тэмцээнийг 3 удаа амжилттай зохион байгуулсан. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд цэрэг спортын "Дөл" тэмцээнийг зохион байгуулж, улсын аварга шалгаруулах тэмцээнд Булган аймгийн баг амжилттай оролцож 21 аймаг 7 дүүргээс 7 дугаар байр эзэлсэн.	100

70	5.1.6 Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшиг тандан судлах, урьдчилан мэдээлэх тогтолцоог орон нутагт бүрдүүлж, гамшигийн эрсдэл, эмзэг байдал, хохирлыг бууруулах зорилгоор олон нийтэд тулгуурласан удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлнэ.	376	5.1.6.1. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхийг сайжруулж сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах	2016-2020	ОБГ	Гамшгаас хамгаалах бэлэн байдал хангагдана.	2016-2019 онуудад жил бүр аймгийн Засаг дарга, сумын Засаг даргатай байгуулах гэрээнд аймаг, орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг сайжруулах зорилгоор гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, ангиллын сургалтыг сумдад зохион байгуулахаар төлөвлөн хэрэгжүүлээ. Удирдах албан тушаалтны сургалтыг 82, гүйцэтгэх албан тушаалтны сургалтыг 240, оюутан, сурагчдын сургалтыг 95, иргэний сургалтыг 99, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн сургалтыг 78 удаа тус тус зохион байгуулж нийт 21765 хүнийг хамруулсан байна. Аймгийн хэмжээнд Гамшгаас хамгаалах команд штабын сургууль МУШС, Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр 2018 онд Булган суманд 1, аймгийн Засаг дарга, сумын Засаг даргатай байгуулсан гэрээнд туссанаар 8 суманд гамшгаас хамгаалах болон команд штабын сургуулийг зохион байгуулсан. Мөн 1 суманд бэлэн байдлын үзлэг, 16 суманд аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалтыг 4 удаа тус тус зохион байгуулж, орон нутгийн чадавхыг сайжруулах сургууль дадлага, сургалтуудыг тус тус зохион байгууллаа. Жил болгоны 3 дугаар сард орон нутагт "Газар хөдлөлтийн гамшигийн үед амжиж анхааруулах зарлан мэдээллийн дуут дохио"-оор ажиллах дадлага сургууль зохион байгуулагдаж нийт 171 байгууллага, 242 аж ахуй нэгжийн 6427 хүн хамрагдсан байна. Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг зохион байгуулснаар сүүлийн 3-н жилд удирдах бүрэлдэхүүний сургалт 36 хувь, гүйцэтгэх албан тушаалтны сургалт 45 хувь, сурагчдын сургалт 3.7 хувь, мэргэжлийн ангийн сургалт 34 хувь, иргэний сургалт 26 хувиар тус тус нэмэгдсэн байна.	100
		377	5.1.6.2. Сумдын объектын гал унтраах техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, галын сайн дурын бүлгэмийг томилгоожуулан ажиллах	2016-2020	ОБГ	Орон нутагт гарсан объектын гал түймрийн хохирлын хэмжээ багасна.	2016-2019 онуудад сумдын объектын гал унтраах техник тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн зүгээс 174 сая төгрөгийн санхүүжилтийг олгож нийт сумдыг объектын гал унтраах техник тоног төхөөрөмжөөр ханган аймгийн Онцгой комисс, Онцгой байдлын газраас орон нутгийн гал унтраах чадавхыг сайжруулахаар сум тус бүрд усны савтай чиргүүл, ус сорж шахах мотопомп, хоолой, хошуу бэлтгэн, ажиллах хүчийг томилгоожуулан сургалтыг зохион байгуулсан. 2017 оны 1 дүгээр сард 16 сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт бага оврын гал унтраах зориулалт бүхий автомашинтай болох талаар төсөл танилцуулж, хөтөлбөрийн хугацаанд өөрсдийн нөөц боломжид тулгуурлан бэлэн байдлыг хангуулах үүрэг чиглэл өгсний дагуу 6 сум бага оврын автомашинтай болсон нь гамшиг, аюулт үзэгдэлд ажиллах бэлэн байдлыг хангаад байна. Мөн аймгийн 16 сум, 1 тосгонд галын сайн дурын бүлгэмийг томилгоожуулан ажиллуулж байгаа ба хөдөлмөр хамгааллын хувцас, гал унтраах техник тоног төхөөрөмжөөр бүрэн ханган ажиллаж байна. Хутаг-Өндөр суманд эрэн хайх, аврах бүлэг байгуулахаар ОБЕГ-ын удирдлагуудыг Хутаг-Өндөр суманд ажиллуулж, бүлэг байгуулах байршил, байр, газрыг танилцуулан 2018 оны 10 дугаар сард Хутаг-Өндөр сум, аймгийн Засаг даргын албан бичгийг ОБЕГ-т хүргүүлж ОБЕГ-аас Засгийн газарт асуудлыг танилцуулан шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулж байна.	100
		378	5.1.6.3. Гал сөнөөгч, аврагч нарын ажил үүрэг гүйцэтгэх нөхцлийг сайжруулах зорилгоор спорт, сургалтын төвийн барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлэх	2016-2017	ОБГ	Гал сөнөөгч, аврагч нарын ур чадвар сайжирч, бэлэн байдал сайжирна.	Онцгой байдлын газрын нийт албан хаагчдын ажил үүрэг гүйцэтгэх нөхцөлийг сайжруулах зорилгоор спорт, сургалтын төвийн барилга байгууламжийн ажлыг орон нутгийн төсөв болон ОБЕГ-ын санхүүжилтээр 2016 онд эхлүүлэн 2017 оны 9 дүгээр сард ашиглалтад хүлээн авсан. Спорт сургалтын төв байгуулагдсанаар гал сөнөөгч, аврагч нарын бие бялдар, ажлын ур чадвар сайжирч, бэлэн байдал дээшлэн, нийтийн биеийн тамирын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, байгууллагууд чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, нийтийг хамарсан спортын арга хэмжээ тодорхой хүрээнд нэмэгдэж байна. 2019 оноос алба хаагчдаас гадна нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг дэмжих зорилгоор төрийн байгууллагуудыг 7 хоног бүр хуваарийн дагуу спорт зааланд тоглуулах, байгууллагуудаас зохион байгуулж байгаа тэмцээн уралдаанд спорт заалаар хангах зэрэг дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.	100

		379	5.1.6.4. Аймгийн Онцгой комиссын чадавхийг сайжруулж, хүч хэрэгслийн нөөцөд техник тоног төхөөрөмж авч, болзошгүй гамшгийн үед бэлэн байдлыг хангах	ОБГ	Аймгийн Онцгой комиссын болзошгүй эрсдлийн үед ажиллах чадвар сайжирна.	Аймгийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2016-2019 онуудад аймгийн онцгой комиссоос тухайн жилийн ажлын төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлж үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан цаг үеийн асуудлаар нийт 54 удаа хуралдсан байна. 2018 онд Байгаль хамгаалах сангийн 25.0 сая төгрөгөөр болзошгүй гамшгийн үед бэлэн байдлыг хангах, гал түймэр унтраах чадавхийг сайжруулах зорилгоор сум, багт үүргийн ус шүршигчийг олгосон. Аймгийн Онцгой комиссын нөөцөд 27 нэр төрлийн 206 ширхэг 95.2 сая төгрөгийн эд зүйл бэлэн байдалд хадгалагдаж байна. Тус Онцгой комиссын чадавхийг сайжруулах, хүч хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлэх /туулах чадвар сайтай урал автомашин, газар ухаг, түрдэг, ачдаг ковши, өргөх, тээвэрлэх автокран шийдэж бэлэн байдлыг хангах/ зорилт тавин Улсын Онцгой комиссоос туулах чадвар сайтай бүхий 33.0 сая төгрөгийн Зил 131 маркийн автомашин, ОБЕГ-аас туулах чадвар сайтай, чиригч 119.0 сая төгрөгийн трактор шийдсэн байна. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд болзошгүй гамшиг, аюулт үзэгдлийн үед шуурхай хариу арга хэмжээ авч, сэргээн босгох чадавх сайжирсан.	70
--	--	-----	---	-----	---	---	----

БИЕЛЭЛТ ТООЦСОН:
ХШУДАХ-ИЙН ДАРГА

Ш.БОЛДБААТАР

ХЯНАСАН:
ЗДТГ-ЫН ДАРГА

О.НАРАНЖАРГАЛ

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА

З.БАТЗОРИГ